



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



ХҮН АМ, ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
СУРГАЛТ, СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН



# МОНГОЛ ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ӨӨРЧЛӨЛТ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН



УЛААНБААТАР ХОТ  
2025 ОН



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



ХҮН АМ, ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
СУРГАЛТ, СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН

# МОНГОЛ ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ӨӨРЧЛӨЛТ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ  
2025 ОН



## СУДАЛГААГ ГҮЙЦЭТГЭСЭН:

Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэн

## СУДАЛГААНЫ ТАЙЛАН БИЧСЭН:

ХАГБХСС-ын эрхлэгч  
ХАГБХСС-ын ЭШАА  
ХАГБХСС-ын ЭШАА

Г. Уянгаа  
М. Хонгорзул  
М. Мөнгөнтуул

## СУДАЛГААНЫ ЗӨВЛӨХ:

Монгол Улсын их сургуулийн Социологи,  
нийгмийн ажлын тэнхимийн доктор  
(Ph.D), профессор

Т. Бүрэнжаргал

## СУДАЛГААГ ХЯНАСАН:

ХАХНХССХ-ийн захирал  
ХАХНХССХ-ийн эрдэмтэн нарийн  
бичгийн дарга, доктор (Ph.D)

М.Батгэрэл  
Н.Түмэн-Өлзий

## ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭСЭН:

ИӨМТГ-ын өгөгдлийн инженер

Б. Хос-Эрдэнэ

## ХАЯГ:

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Нарны зам, 55-р  
байр 2 давхар 3 тоот  
Утас: 77111331

## ВЕБ ХУУДАС:

<https://e-mongolia.mn/org/triplsp>



## АГУУЛГА

|                                                           |     |
|-----------------------------------------------------------|-----|
| ӨМНӨХ ҮГ .....                                            | 5   |
| ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР .....                             | 14  |
| НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР .....                                | 15  |
| НЭГ. УДИРТГАЛ.....                                        | 20  |
| 1.1. Үндэслэл .....                                       | 20  |
| 1.2. Судалгааны зорилго, зорилт .....                     | 21  |
| 1.3. Гэр бүлийн талаарх онол, үзэл баримтлал .....        | 22  |
| 1.4. Судлагдсан байдал .....                              | 25  |
| 1.5. Судалгааны арга зүй.....                             | 28  |
| 1.5.1. Судалгааны аргачлал .....                          | 28  |
| 1.6. Судалгааны түүвэрлэлт ба хамрах хүрээ .....          | 30  |
| 1.6.1. Түүврийн хамрах хүрээ.....                         | 30  |
| 1.6.2. Түүврийн хуваарилалт .....                         | 31  |
| 1.7. Судалгааны төлөвлөлт, зохион байгуулалт .....        | 34  |
| 1.8. Судалгааны хязгаарлагдмал байдал.....                | 35  |
| 1.9. Судалгааны ёс зүйн асуудал .....                     | 36  |
| ХОЁР. ГЭР БҮЛ, ХҮН АМ ЗҮЙ, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ... | 38  |
| 2.1. Өрхийн шинж, хүн ам зүйн мэдээлэл .....              | 38  |
| 2.2. Өрхийн амьжиргаа .....                               | 46  |
| БҮЛГИЙН ДҮГНЭЛТ .....                                     | 55  |
| БҮЛГИЙН ЗӨВЛӨМЖ .....                                     | 57  |
| ГУРАВ. ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....         | 60  |
| 3.1. Гэр бүл төлөвлөлт .....                              | 60  |
| 3.1.1. Гэр бүлийн амьдралд бэлтгэх нь .....               | 60  |
| 3.1.2. Хүүхэдтэй болох төлөвлөгөө .....                   | 65  |
| 3.2. Гэр бүлийн үүрэг, хариуцлага .....                   | 70  |
| 3.3. Гэр бүлийн харилцаа, хандлага .....                  | 84  |
| 3.3.1. Эхнэр нөхрийн хоорондын харилцаа.....              | 84  |
| 3.3.2. Хүүхэд ба түүний хүмүүжлийн асуудлууд.....         | 90  |
| 3.3.3. Хүүхдийн бэлгийн боловсрол .....                   | 95  |
| 3.3.4. Хүүхдийн цахим сүлжээ хэрэглээ .....               | 97  |
| 3.3.5. Садан төрлийн харилцаа.....                        | 102 |



|                                                                       |            |
|-----------------------------------------------------------------------|------------|
| 3.4. Гэр бүлийн үнэт зүйлс .....                                      | 105        |
| 3.4.1. Гэр бүлийн эрхэмлэн дээдэлдэг зүйлс .....                      | 105        |
| 3.4.2. Гэр бүлийн ургийн бичиг, овог .....                            | 107        |
| 3.4.3. Гэр бүлийн талаарх үзэл хандлагууд .....                       | 109        |
| БҮЛГИЙН ДҮГНЭЛТ .....                                                 | 112        |
| БҮЛГИЙН ЗӨВЛӨМЖ .....                                                 | 114        |
| <b>ДӨРӨВ. ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦААНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД</b>           | <b>118</b> |
| 4.1. Гэр бүлийн зөрчил, маргаан .....                                 | 118        |
| 4.2. Гэр бүл цуцлалт, шалтгаан, үр дагавар .....                      | 128        |
| 4.3. Гэр бүлээс гадуурх харилцаа, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс ..... | 136        |
| 4.4. Гэр бүлд нөлөөлж буй нийгмийн хүчин зүйл .....                   | 138        |
| БҮЛГИЙН ДҮГНЭЛТ .....                                                 | 145        |
| БҮЛГИЙН ЗӨВЛӨМЖ .....                                                 | 147        |
| <b>ТАВ. ХИЛИЙН ЧАНАД ДАХЬ ГЭР БҮЛҮҮДИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ</b>    | <b>150</b> |
| 5.1 Хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн шинж байдал .....               | 150        |
| 5.2. Хилийн чанад дахь гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал ..       | 155        |
| 5.2.1. Гэр бүл дэх эрх мэдлийн хуваарилалт .....                      | 155        |
| 5.2.2. Гэр бүлийн үнэт зүйлс, ураг төрлийн харилцаа .....             | 157        |
| 5.3. Гэр бүлийн зөрчил, цуцлалт .....                                 | 160        |
| 5.3.1. Гэр бүлийн зөрчил, маргаан .....                               | 160        |
| 5.3.2. Гэр бүл цуцлалт .....                                          | 163        |
| 5.3.3. Гэр бүлээс гадуурх харилцаа, нөлөөлдөг хүчин зүйлс ..          | 163        |
| 5.4. Шилжин суурьшилт, ирээдүйн төлөвлөгөө .....                      | 165        |
| 5.4.1. Ирээдүйн төлөвлөгөө .....                                      | 165        |
| БҮЛГИЙН ДҮГНЭЛТ .....                                                 | 167        |
| БҮЛГИЙН ЗӨВЛӨМЖ .....                                                 | 168        |
| <b>НЭГДСЭН ДҮГНЭЛТ .....</b>                                          | <b>170</b> |
| <b>НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ .....</b>                                          | <b>172</b> |
| <b>ЭХ СУРВАЛЖ, АШИГЛАСАН МАТЕРИАЛУУД .....</b>                        | <b>175</b> |



## ӨМНӨХ ҮГ

“Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, өөрчлөлт” судалгаа нь 2004, 2010, 2019 онуудад хийгдэж байсан бөгөөд 6 жилийн дараа Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэн Монгол Улсын хэмжээнд дахин хийж Та бүхэнд толилуулж байна.

Судалгааны хүрээнд Монгол гэр бүлийн харилцаа, төлөвшил, түүнд нөлөөлөх хүчин зүйлс, тулгамдаж буй асуудал, гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн үүрэг хариуцлага, харилцаа хандлага, гэр бүлийн үнэт зүйлс, ургийн бичиг хөтлөлт, гэр бүл цуцлалт, түүний шалтгаан үр дагавар, өрхийн эдийн засгийн байдал, амьдралын чанар, төрийн бодлогын дэмжлэгийн талаар тандан судалж, өмнөх онуудад хийгдсэн судалгааны үр дүнтэй харьцуулалт хийж, зөвлөмж, дүгнэлтийг гаргалаа.

Гэр бүл нь нийгмийг бүрдүүлэгч үндсэн нэгжийн хувьд ажилгүйдэл, ядуурал, архидалт, шилжих хөдөлгөөн, хөдөлмөрийн зах зээлийн хомсдол, ёс суртахууны доройтол зэрэг нийгэмд тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэхэд гэр бүлийн харилцаа, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг судалж, төрийн зүгээс бодлогын түвшинд шийдвэрлэх нь нийгэмдээ эргэж эергээр нөлөөлөх учиртай.

Нийгмийн хөгжлийн хурд, мэдээллийн технологийн хөгжил, даяаршил, соёлын глобалчлал, нийгмийн сэтгэл зүй зэрэг нь цаашид Монгол гэр бүлийн хэв шинж, үнэт зүйл, харилцаанд эерэг, сөрөг олон зүйлсийн нөлөөллийг бий болгож гэр бүлийн эрх зүйн шинэчлэлийн хэрэгцээ шаардлагыг бий болгож байна.

Бидний энэхүү судалгааны үр дүн нь төрөөс Монгол гэр бүлийн талаар баримтлах бодлого, гэр бүлийн тогтвортой, таатай орчныг бүрдүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэхэд тус нэмэр болно гэдэгт итгэж байна.

ЗАХИРАЛ

М.БАТГЭРЭЛ



## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

|                                                                                                           |     |
|-----------------------------------------------------------------------------------------------------------|-----|
| Хүснэгт 1.1. Түүврийн хуваарилалт, гэр бүлийн хэлбэрээр.....                                              | 32  |
| Хүснэгт 1.2. Түүврийн хуваарилалт, байршлаар .....                                                        | 33  |
| Хүснэгт 2.1. Судалгаанд хамрагдсан өрхийн орлогын эх үүсвэр, хувиар ...                                   | 48  |
| Хүснэгт 2.2. Судалгаанд хамрагдсан иргэдийн орлогын зарцуулалт, өрхийн төрөл, давхардсан тоо, хувиар..... | 50  |
| Хүснэгт 2.3. Орлогоос давсан зардал нөхсөн байдал, өрхийн төрөл, давхардсан тоо, хувиар.....              | 51  |
| Хүснэгт 2.4. Судалгаанд оролцогчдын амьдралаа сайжруулах төлөвлөлт, насны бүлэг, хувиар .....             | 54  |
| Хүснэгт 3.1. Өрхийн тэргүүн хэн байвал зохимжтой эсэх, хувиар .....                                       | 72  |
| Хүснэгт 3.2. Өрхийн тэргүүний гол үүрэг, хувиар .....                                                     | 74  |
| Хүснэгт 3.3. Үүрэг, хариуцлагаа биелүүлж чадахгүй байх шалтгаан, хувиар.....                              | 83  |
| Хүснэгт 3.4. Эхнэр нөхрийн сэтгэл хангалуун байдлын шинжилгээ.....                                        | 85  |
| Хүснэгт 3.5. Орлого ба сэтгэл ханамжийн хамаарал, Tukey test .....                                        | 86  |
| Хүснэгт 3.6. Эхнэр нөхөртэйгөө ярилцаж чаддаг эсэх нь сэтгэл ханамжид нөлөөлөх байдал.....                | 87  |
| Хүснэгт 3.7. Төрөл садантайгаа харилцах харилцаа, хувиар .....                                            | 105 |
| Хүснэгт 3.8. Гэр бүлд нэн шаардлагатай зүйлс, өнгөрсөн он, хувиар .                                       | 106 |
| Хүснэгт 3.9. Гэр бүлийн эрхэмлэн дээдэлдэг зүйлс, өнгөрсөн он, хувиар.....                                | 107 |
| Хүснэгт 3.10. Гэр бүлийн тухай үзэл хандлага, өнгөрсөн он, хувиар ..                                      | 109 |
| Хүснэгт 4.1. Гэр бүлийн зөрчил, маргааны шалтгаан, байршил, давхардсан тоо, хувиар.....                   | 119 |
| Хүснэгт 4.2. Гэр бүлийн зөрчил, маргааны илрэх хэлбэр, байршил, давхардсан тоо, хувиар.....               | 122 |
| Хүснэгт 4.3. Гэр бүлийн амьдралд тохиолдож буй бэрхшээлтэй асуудал, хувиар.....                           | 124 |
| Хүснэгт 4.4. Гэр бүлийн асуудлаа хэнтэй хуваалцдаг эсэх, өрхийн хэлбэр, давхардсан тоо, хувиар.....       | 126 |
| Хүснэгт 4.5. Гэр бүлээ цуцлуулсан шалтгаан, цуцлалт санаачлагч, давхардсан тоо, хувиар.....               | 131 |
| Хүснэгт 4.6. Гэр бүл цуцалснаар амьдралд гарч буй өөрчлөлтүүд, хүйс, байршил, хувиар.....                 | 135 |



|                                                                                                         |     |
|---------------------------------------------------------------------------------------------------------|-----|
| Хүснэгт 4.7. Нийгмээс нөлөөлж буй зүйлс, байршил, давхардсан тоо, хувиар .....                          | 139 |
| Хүснэгт 4.8. Хэрэгжүүлэхийг хүсэж буй бодлого, байршил, давхардсан тоо, хувиар .....                    | 140 |
| Хүснэгт 4.9. Хэрэгжүүлэхийг хүсэж буй бодлого, насны бүлэг, хувиар .                                    | 141 |
| Хүснэгт 4.10. Хэрэгжүүлэхийг хүсэж буй бодлого, гэр бүлийн хэлбэр, хувиар .....                         | 142 |
| Хүснэгт 4.11. Хэрэгжүүлэхийг хүсэж буй үйлчилгээ, байршил, хувиар .                                     | 143 |
| Хүснэгт 4.12. Хэрэгжүүлэхийг хүсэж буй үйлчилгээ, насны бүлэг, хувиар .....                             | 144 |
| Хүснэгт 4.13. Хэрэгжүүлэхийг хүсэж буй үйлчилгээ, гэр бүлийн хэлбэр, хувиар .....                       | 144 |
| Хүснэгт 5.1. Оролцогчдын гадаад улс руу явсан зорилго, хүйс, хувиар ..                                  | 150 |
| Хүснэгт 5.2. Хөдөлмөр эрхлэлтийн байдал, үйл ажиллагааны салбар, хүйс, боловсролын түвшин, хувиар ..... | 152 |
| Хүснэгт 5.3. Өрхийн тэргүүний хамгийн гол үүрэг, хүйс, давхардсан тоо, хувиар .....                     | 156 |
| Хүснэгт 5.4. Гэр бүлийн эрхэмлэн дээдэлдэг зүйлс, хүйс, давхардсан тоо, хувиар .....                    | 158 |
| Хүснэгт 5.5. Гэр бүлд нэн хэрэгцээт зүйлс, давтамж, давхардсан тоо, хувиар .....                        | 159 |
| Хүснэгт 5.6. Гэр бүлийн зөрчил, маргааны шалтгаан, хүйс, давхардсан тоо, хувиар .....                   | 161 |
| Хүснэгт 5.7. Монгол гэр бүлүүдэд түгээмэл тохиолддог асуудал, хүйс, давхардсан тоо, хувиар .....        | 162 |





## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

|                                                                                                                                           |    |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| Зураг 2.1. Судалгаанд хамрагдсан гэр бүлийн түүврийн хамрах хүрээ, хэмжээ .....                                                           | 38 |
| Зураг 2.2. Судалгаанд хамрагдсан гэр бүлийн хэлбэр .....                                                                                  | 39 |
| Зураг 2.3. Судалгаанд хамрагдсан гэр бүл, байршил, хувиар .....                                                                           | 39 |
| Зураг 2.4. Судалгаанд хамрагдсан иргэдийн өрхийн тэргүүнтэй ямар хамааралтай эсэх, хувиар .....                                           | 39 |
| Зураг 2.5. Судалгаанд хамрагдагсдын насны бүлэг, хүйс, хувиар .....                                                                       | 40 |
| Зураг 2.6. Судалгаанд хамрагдсан иргэдийн боловсролын түвшин, насны бүлэг, хувиар .....                                                   | 40 |
| Зураг 2.7 Судалгаанд хамрагдсан өрхийн эхнэр (нөхөр)-ийн боловсролын түвшний харьцуулалт, хувиар .....                                    | 41 |
| Зураг 2.8. Судалгаанд хамрагдагсдын шашин шүтлэгийн байдал, насны бүлэг, хувиар .....                                                     | 41 |
| Зураг 2.9. Судалгаанд хамрагдсан өрхийн ам бүлийн тоо, хувиар .....                                                                       | 42 |
| Зураг 2.10. Судалгаанд хамрагдсан өрхийн ам бүлийн тоо, насны бүлэг, хувиар .....                                                         | 42 |
| Зураг 2.11. Судалгаанд хамрагдагсдын хөдөлмөр эрхлэлтийн байдал, хувиар .....                                                             | 43 |
| Зураг 2.12. Судалгаанд оролцогчдын гэрлэлтийн байдал, хувиар .....                                                                        | 43 |
| Зураг 2.13. Судалгаанд хамрагдсан эхнэр/нөхөртэй иргэдийн гэрлэлтийн болон хөрөнгийн асуудлаар ямар нэгэн гэрээ хийсэн эсэх, хувиар ..... | 44 |
| Зураг 2.14. Судалгаанд оролцсон гэрлэсэн хосуудын хамт амьдарсан хугацаа, өнгөрсөн он, хувиар .....                                       | 44 |
| Зураг 2.15. Гадаадад амьдарч буй иргэдийн оршин суугаа улс, хувиар .                                                                      | 45 |
| Зураг 2.16. Өрхийн гишүүдийн гадаадад амьдарч буй шалтгаан, хувиар .....                                                                  | 45 |
| Зураг 2.17. Судалгаанд хамрагдагсдын сууцны төрөл, байршил, хувиар .....                                                                  | 46 |
| Зураг 2.18. Судалгаанд оролцогчдын сууцны эзэмшлийн хэлбэр, насны бүлэг, хувиар .....                                                     | 47 |
| Зураг 2.19. Судалгаанд хамрагдсан өрхийн сарын дундаж орлого, төгрөг, хувиар .....                                                        | 47 |
| Зураг 2.20. Судалгаанд хамрагдсан өрхийн орлогын эх үүсвэр, насны бүлэг, нэмэлт орлоготой эсэх, хувиар .....                              | 48 |



|                                                                                                                               |    |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| Зураг 2.21. Судалгаанд оролцогчдын орлогын зарцуулалт, давтагдсан тоо, хувиар .....                                           | 49 |
| Зураг 2.22. Судалгаанд хамрагдсан иргэдийн өрхийн амьжиргааг үнэлсэн байдал, байршил, хувиар .....                            | 50 |
| Зураг 2.23. Зээлтэй иргэд, байршил, насны бүлэг, хувиар .....                                                                 | 52 |
| Зураг 2.24. Судалгаанд оролцогчдын авсан зээлийн төрөл, байршил, давхардсан тоо, хувиар .....                                 | 52 |
| Зураг 2.25. Өрхийн дундаж орлогын өөрчлөлт, байршил, насны бүлэг, хувиар .....                                                | 53 |
| Зураг 2.26. Судалгаанд оролцогчдын амьдралаа сайжруулах төлөвлөлт, давхардсан тоо, хувиар.....                                | 53 |
| Зураг 3.1. Өнөөгийн залуучууд гэр бүлийн амьдралд бэлтгэгдсэн эсэх, насны бүлэг, хувиар .....                                 | 60 |
| Зураг 3.2. Залуучуудыг амьдралд бэлтгэх нь, давхардсан тоо, хувиар .                                                          | 61 |
| Зураг 3.3. Гэр бүл зохиоход тохиромжтой нас, хүйс, насны бүлэг, хувиар .....                                                  | 61 |
| Зураг 3.4. Тогтвортой гэр бүл болохын үндэс, нас, давтагдсан тоо, хувиар .....                                                | 62 |
| Зураг 3.5. Залуучуудыг амьдралд бэлтгэх нь, давхардсан тоо, хувиар .                                                          | 63 |
| Зураг 3.6. Ганц бие хүмүүсийн гэр бүл болоход шаардлагатай бэлтгэл, хувиар .....                                              | 63 |
| Зураг 3.7. Судалгаанд оролцогчдын гэр бүл болохоос өмнө бэлгийн харилцаанд орох талаарх бодол, нас, хувиар .....              | 64 |
| Зураг 3.8. Судалгаанд оролцогчдын гэр бүл болохоос өмнө бэлгийн харилцаанд орох талаарх бодол, оролцогчдын хүйс, хувиар ..... | 65 |
| Зураг 3.9. Ойрын 3 жилийн хугацаанд хүүхэдтэй болох төлөвлөгөө, хүйс, хувиар .....                                            | 65 |
| Зураг 3.10. Ойрын 3 жилийн хугацаанд хүүхэдтэй болох төлөвлөгөө, гэр бүлийн төрөл, хувиар .....                               | 66 |
| Зураг 3.11. Хүүхэдтэй болохгүй байх шалтгаан, хүйс, давтагдсан тоо, хувиар .....                                              | 67 |
| Зураг 3.12. Жирэмснээс сэргийлэх арга хэрэгсэл ашиглах байдал, хувиар .....                                                   | 67 |
| Зураг 3.13. Гэр бүлийн зохимжит хүүхдийн тоо, нас, хүйс, хувиар .....                                                         | 68 |
| Зураг 3.14. Гэр бүлийн зохимжит хүүхдийн тоо, боловсролын түвшин, хувиар .....                                                | 69 |
| Зураг 3.15. Төрөлт хоорондын зай, хүйс, хувиар.....                                                                           | 69 |



|                                                                                                         |    |
|---------------------------------------------------------------------------------------------------------|----|
| Зураг 3.16. Төрөлт хоорондын зай, боловсролын түвшин, хувиар .....                                      | 70 |
| Зураг 3.17. Өрхийн тэргүүн хэн байвал зохимжтой эсэх, өнгөрсөн он, хувиар .....                         | 72 |
| Зураг 3.18. Өрхийн тэргүүний хамгийн гол үүрэг, хувиар .....                                            | 73 |
| Зураг 3.19. Сурган хүмүүжүүлэх, боловсролд анхаарах үүрэг, хувиар ....                                  | 76 |
| Зураг 3.20. Хөдөлмөрийн хуваарь, хувиар .....                                                           | 77 |
| Зураг 3.21. Гэрийн ажлыг хүйсээр ангилах талаар үзэл бодол, хувиар .                                    | 77 |
| Зураг 3.22. Фокус бүлгийн ярилцлага, гэр бүл дэх үүргийн хуваарилалт, хүйсээр .....                     | 78 |
| Зураг 3.23. Гэр бүл дэх эрх мэдлийн хуваарилалт, хувиар .....                                           | 79 |
| Зураг 3.24. Гэр бүлийн бусад үүрэг, хувиар .....                                                        | 81 |
| Зураг 3.25. Гэр бүлийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэх байдал, хүйс, хувиар .....             | 81 |
| Зураг 3.26. Гэр бүлийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэх байдал, гэр бүлийн төрөл, хувиар ..... | 82 |
| Зураг 3.27. Чухал асуудлыг гишүүдийн саналаар шийдвэрлэдэг байдал, гэр бүлийн төрөл, хувиар .....       | 84 |
| Зураг 3.28. Эхнэр нөхөртөө сэтгэл хангалуун байгаа байдал, хувиар .                                     | 84 |
| Зураг 3.29. Эхнэр нөхрүүд бие биеэсээ хүсдэг шинж чанар, хувиар .....                                   | 86 |
| Зураг 3.30. Ярилцах нь асуудлыг шийдэхэд тусалдаг эсэх, давхардсан тоо, хувиар .....                    | 88 |
| Зураг 3.31. Цаг хугацааны явцад харилцаа өөрчлөгдсөн эсэх, хамт амьдарсан хугацаа, хувиар .....         | 88 |
| Зураг 3.32. Цаг хугацааны явцад харилцаа өөрчлөгдсөн эсэх, нас, хувиар .....                            | 89 |
| Зураг 3.33. Цаг хугацааны явцад дотно байдлаа хадгалж үлдэх нь, хүйс, хувиар .....                      | 89 |
| Зураг 3.34. Гэр бүлийн харилцаан дахь сэтгэл ханамж, хувиар .....                                       | 90 |
| Зураг 3.35. Хүүхэд өсгөж хүмүүжүүлэх эцэг эхчүүдийн үзэл бодол, хүйс, хувиар .....                      | 91 |
| Зураг 3.36. Хүүхэд өсгөж хүмүүжүүлэх эцэг эхчүүдийн үзэл бодол, байршил, хувиар .....                   | 91 |
| Зураг 3.37. Хүүхдэд өвлүүлэх үнэт зүйлс, хүйс, хувиар .....                                             | 92 |
| Зураг 3.38. Хүүхдэд анхаарал илүү тавьдаг гишүүн, гэр бүлийн төрөл, давхардсан тоо, хувиар .....        | 92 |
| Зураг 3.39. Хүүхдэдээ цаг зав гаргаж буй байдал, нас, хүйс, хувиар .....                                | 93 |
| Зураг 3.40. Хүүхэдтэйгээ хийдэг үйл ажиллагаа, хүйс, хувиар .....                                       | 94 |



|                                                                                                 |     |
|-------------------------------------------------------------------------------------------------|-----|
| Зураг 3.41. Хүүхэд хүмүүжүүлэх арга барил, хүйс, хувиар .....                                   | 94  |
| Зураг 3.42. Хүүхдэд бэлгийн боловсрол олгоход зохимжтой нас, хүйс, хувиар .....                 | 95  |
| Зураг 3.43. Хүүхдэд бэлгийн боловсрол олгоход зохимжтой нас, боловсрол, хувиар .....            | 96  |
| Зураг 3.44. Хүүхдэд бэлгийн боловсрол олгоход хангалттай мэдээлэлтэй эсэх, хувиар .....         | 96  |
| Зураг 3.45. Хүүхдэд бэлгийн боловсрол олгоход хангалттай мэдээлэлтэй эсэх, хувиар .....         | 97  |
| Зураг 3.46. Хүүхэдтэй бэлгийн боловсролын талаар ярилцдаг байдал, хувиар .....                  | 97  |
| Зураг 3.47. Хүүхдийн цахим сүлжээний хэрэглээ, хүйс, хувиар .....                               | 98  |
| Зураг 3.48. Цахим сүлжээ хэрэглэж буй хүүхдүүдээс хамгийн бага насны хүүхэд, хувиар .....       | 98  |
| Зураг 3.49. Хүүхдийн цахим сүлжээ хэрэглэж буй цаг хугацаа, эцэг эхийн нас, хувиар .....        | 99  |
| Зураг 3.50. Цахим сүлжээ ашигласнаар гэр бүлд гарч буй эерэг болон сөрөг өөрчлөлт, хувиар ..... | 100 |
| Зураг 3.51. Хүүхдийн цахим сүлжээний хэрэглээг хязгаарлах арга хэмжээ, хувиар .....             | 101 |
| Зураг 3.52. Цахим сүлжээний хэрэглээний нөлөөлөл, хувиар .....                                  | 102 |
| Зураг 3.53. Өндөр настай аав ээж, өвөө эмээгээ эргэж тойрдог байдал, байршил, хувиар .....      | 103 |
| Зураг 3.54. Аав ээж, өвөө эмээдээ тусалдаг байдал, давхардсан тоо, хувиар .....                 | 103 |
| Зураг 3.55. Аав ээж, эмээ өвөөгөөсөө авдаг тусламж, хувиар .....                                | 104 |
| Зураг 3.56. Ургийн бичиг хөтлөх байдал, өнгөрсөн он, хувиар .....                               | 108 |
| Зураг 3.57. Ургийн овгоо зөв тодорхойлсон ба ургийн овоо солих бодолтой эсэх, хувиар .....      | 108 |
| Зураг 3.58. Судалгаанд оролцогчдоос хэдэн үеэ мэддэг эсэх, хувиар ..                            | 108 |
| Зураг 3.59. Фокус бүлгийн ярилцлага, гадаад хүнтэй гэр бүл болох талаар .....                   | 110 |
| Зураг 4.1. Гэр бүлийн зөрчил, маргааны шалгаан, давхардсан тоо, хүйсээр .....                   | 120 |
| Зураг 4.2. Гэр бүлийн зөрчил, маргаан үүсдэг гишүүд, давхардсан тоо, хувиар .....               | 121 |
| Зураг 4.3. Гэр бүлийн зөрчил, маргааны илрэх хэлбэр, хүйс, хувиар ...                           | 122 |



|                                                                                                               |     |
|---------------------------------------------------------------------------------------------------------------|-----|
| Зураг 4.4. Гэр бүлийн амьдралд тулгамдаж буй бэрхшээлтэй асуудал, байршил, хувиар .....                       | 125 |
| Зураг 4.5. Гэр бүлийн амьдралд тулгамдаж буй бэрхшээлтэй асуудал, байршил, насны бүлэг, хувиар .....          | 126 |
| Зураг 4.6. Гэр бүлийн асуудлаа хэнтэй хуваалцдаг эсэх, хүйс, хувиар ..                                        | 127 |
| Зураг 4.7. Бухимдсан үедээ хэрхэн тайвширдаг эсэх, давхардсан тоо, хувиар .....                               | 127 |
| Зураг 4.8. Гэрлэлт, цуцлалтын тоо, жилээр .....                                                               | 128 |
| Зураг 4.9. Гэр бүл цуцлалтын тоо, хамт амьдарсан хугацаагаар .....                                            | 128 |
| Зураг 4.10. Гэрлэлтээ цуцлуулагсдын хүүхдийн тоо, хувиар .....                                                | 129 |
| Зураг 4.11. Гэр бүл цуцлалтад нөлөөлдөг хүчин зүйлс, өрхийн хэлбэр, хувиар .....                              | 129 |
| Зураг 4.12. Гэрлэлт цуцлуулах санаачлагч, хувиар .....                                                        | 130 |
| Зураг 4.13. Гэр бүл цуцлуулснаас хойш эцэг, эхийн анхаарал, халамж, хувиар .....                              | 132 |
| Зураг 4.14. Гэр бүлээ цуцлуулснаас хойш эцэг эх нь хүүхэдтэйгээ холбоотой байдаг эсэх, хүйс, хувиар .....     | 133 |
| Зураг 4.15. Гэр бүлээ цуцлуулснаар амьдралд гарч буй эерэг болон сөрөг өөрчлөлт, давхардсан тоо, хувиар ..... | 134 |
| Зураг 4.16. Дахин гэрлэх бодол байгаа эсэх, хүйс, хувиар .....                                                | 136 |
| Зураг 4.17. Гэр бүлээс гадуурх харилцаанд нөлөөлж буй хүчин зүйлс, хүйс, хувиар .....                         | 137 |
| Зураг 4.18. Гэр бүлээс гадуурх харилцаа байж болох эсэх, насны бүлэг, хувиар .....                            | 137 |
| Зураг 4.19. Гэр бүлээс гадуурх харилцаанд хариуцлага тооцох эсэх, хүйс, хувиар .....                          | 138 |
| Зураг 4.20. Бухимдлаа гэр бүлдээ гаргаж буй байдал, хүйс, хувиар ....                                         | 139 |
| Зураг 5.1. Судалгаанд оролцогчид хүйс, насны бүлэг, хувиар .....                                              | 150 |
| Зураг 5.2. Судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлтийн байдал, хувиар .....                                    | 151 |
| Зураг 5.3. Судалгаанд оролцогчдын өрхийн амьжиргаагаа үнэлсэн байдал, хувиар .....                            | 153 |
| Зураг 5.4. Судалгаанд оролцогчдын сууцны төрөл, эзэмшлийн хэлбэр, хувиар .....                                | 153 |
| Зураг 5.5. Судалгаанд оролцогчдын гэрлэлтийн байдал, хүйс, хувиар ..                                          | 154 |
| Зураг 5.6. Гэрлэлтээ албан ёсоор батлуулсан эсэх, хувиар .....                                                | 154 |



|                                                                                                                                              |     |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|
| Зураг 5.7. Гэрлэлтээ албан ёсоор батлуулаагүй байгаа шалтгаан, хувиар .....                                                                  | 155 |
| Зураг 5.8. Өрхийн тэргүүн хэн байвал зохимжтой эсэх, хүйс, хувиар ..                                                                         | 155 |
| Зураг 5.9. Өнөөгийн залуус гэр бүлийн амьдралд бэлтгэгдсэн эсэх, насны бүлэг, хувиар .....                                                   | 156 |
| Зураг 5.10. Гэр бүл зохиоход тохиромжтой нас, хүйс, насны бүлэг, хувиар .....                                                                | 157 |
| Зураг 5.11. Тогтвортой гэр бүл болохын үндэс, давхардсан тоо, хувиар .....                                                                   | 157 |
| Зураг 5.12. Гэр бүл дэх хүүхдийн зохимжит тоо, хүйс, хувиар ....                                                                             | 159 |
| Зураг 5.13. Хүүхдэд өвлүүлэх үнэт зүйлс, давхардсан тоо, хувиар .....                                                                        | 160 |
| Зураг 5.14. Гэр бүлийн зөрчил, маргаан үүсдэг гишүүд, давхардсан тоо, хувиар .....                                                           | 162 |
| Зураг 5.15. Гэр бүл цуцлалтад нөлөөлдөг хүчин зүйлс, давхардсан тоо, хувиар .....                                                            | 163 |
| Зураг 5.16. Танилын хүрээнд гэр бүлээс гадуурх харилцаатай хүн байгаа эсэх, мөн гэр бүлээс гадуурх харилцаа байж болох эсэх, хүйс, хувиар .. | 164 |
| Зураг 5.17. Гэр бүлээс гадуурх харилцаа үүсэхэд нөлөөлдөг хүчин зүйлс, давхардсан тоо, хувиар .....                                          | 164 |
| Зураг 5.18. Гэр бүлээс гадуурх харилцаанд гуравдагч этгээдэд хариуцлага тооцох нь зөв эсэх, хувиар .....                                     | 165 |
| Зураг 5.19. Эх орон руугаа буцах шийдвэрт нөлөөлсөн хүчин зүйлс, хувиар .....                                                                | 165 |
| Зураг 5.20. Эх орон руугаа буцахгүй байх шалтгаан, хувиар .....                                                                              | 166 |
| Зураг 5.21. Монгол буцах талаар дахин бодоход нөлөөлөх хүчин зүйлс, насны бүлэг, хувиар .....                                                | 166 |



## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ГБХНХЯ  
ХАХНХССХ

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам  
Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт,  
судалгааны хүрээлэн

ХАГБХСС  
НҮБ

Хүн ам, гэр бүлийн хөгжлийн судалгааны сектор  
Нэгдсэн үндэсний байгууллага

ДЭМБ

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

НҮБ ХС

Нэгдсэн үндэсний байгууллагын хүүхдийн сан

ФСЭЗХ

Философи, социологи, эрх зүйн хүрээлэн

НҮБХАС

Нэгдсэн үндэсний байгууллагын хүн амын сан

ҮСХ

Үндэсний статистикийн хороо

УБИС

Улаанбаатар их сургууль

АНУ

Америкийн Нэгдсэн Улс

БНСУ

Бүгд Найрамдах Солонгос Улс

БНЧУ

Бүгд Найрамдах Чех Улс

ФБЯ

Фокус бүлгийн ярилцлага

ХДХВ/ДОХ

Хүний дархлал хомсдолын вирус/Дархлалын  
олдмол хомсдол





## НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

**Гэр бүл:** Гэрлэлтийн үр дүнд буй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг<sup>1</sup>;

**Өрх:** Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүс;

**Ам бүл:** Нэгэн өрхийн доторх хүмүүсийг хэлнэ;

**Өрхийн тэргүүн:** Өрхийн гишүүд өрхийн тэргүүнээ өөрсдөө тогтооно. Өрхийн тэргүүн нь тодорхойгүй тохиолдолд өрхийн тэргүүнээр хэнийг сонгохыг өрхийн гишүүдийн сайн дурын үндсэн дээр шийдвэрлэнэ. Өрхийн тэргүүнээр 16-аас дээш настай, ажил хөдөлмөр эрхэлдэг буюу өрхийн орлогод голлох үүрэгтэй оролцдог, ам бүлийн аль нэг гишүүнийг тодорхойлно;

**Гэр бүлийн үүрэг:** Нийгмийн болон гэр бүлийн гишүүдийн хуулиар хүлээсэн үүргээс гадна гүйцэтгэх үүргээр тодорхойлогдох ёс суртахуун, зан үйлийн хэм хэмжээний нэгдэл;

**Гэрлэлт:** Хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёр, сайн дурын, чөлөөтэй, тэгш эрхийн үндсэн дээр гэр бүл болох зорилгоор хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг;

**Гэр бүлийн үнэт зүйл:** Гэр бүлийн гишүүдийн оюун санааны нэгдмэл байдлыг хангаж, чиглүүлж байдаг гол хүчин зүйлс;

**Ургийн бичиг:** Ах дүү, төрөл төрөгсдийг хүн бүрээр тэмдэглэж, үе улируулан хөтөлдөг баримт бичиг;

**Гэр бүлийн гишүүн:** Гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчилж авсан хүүхэд болон төрөл садны хүмүүс;

**Гэр бүлийн харилцаа:** Гэр бүлийн гишүүдийн хооронд үүсэх олон талт харилцаа;

**Гэр бүлийн хэлбэр:** Олон янзын хэлбэр хэв маяг бүхий гэр бүлүүдийн ялгаатай онцлог шинжийг илэрхийлэх ухагдахуун;

**Дан гэр бүл:** Эхнэр нөхөр дангаар эсвэл эхнэр нөхөр ба тэдний халамжид буй хүүхдүүдээс бүрдэх гэр бүл;

**Нийлмэл гэр бүл:** Өргөжсөн, ургийн хэдэн үеийнхэн хамтдаа амьдардаг гэр бүл;

**Өрөөсгөл гэр бүл:**

- Эцэг ба хүүхдүүд;
- Эх ба хүүхдүүд;
- Бусад /Хүүхдүүд, өвөө эмээ + ач зээ/ бүрдэх гэр бүл.

<sup>1</sup> Гэр бүлийн тухай хууль, 1999.06.11,  
<https://legalinfo.mn/mn/detail/226>





**Гэр бүл төлөвлөлт:** Эхнэр, нөхөр эрүүл мэнд, амьдралын нөхцөл байдалдаа тохируулан төрөлт хоорондын зайг зөв зохицуулах, тохиромжтой насандаа жирэмсэлж, хүссэн үедээ хүүхэд төрүүлэхээр зохицуулах үйл ажиллагаа;

**Гэр бүлийн зөрчил:** Гэр бүлийн гишүүдийн дотоод харилцаанд үүсэх үл ойлголцол, маргаан;

**Гэр бүлийн амьдралын мөчлөг:** Гэр бүл үүсэхээс эхлэн мөхөх хүртэлх нийгэм - хүн ам зүйн үечлэлийг багтаасан он цагийн дэс дараалал ба гэрлэх, анхны хүүхэд төрөх, удаах хүүхэд төрөх, хүүхдүүд гэрлэн өрх тусгаарлах, гэр бүл мөхөх зэрэг үе шатууд хамаарна;

**Гэр бүлийн хүчирхийлэл:** Эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа этгээд сэтгэл санааны дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхүйг учруулахыг нэрлэнэ;

**Гэр бүлийн хохирогч:** Гэр бүлийн хүчирхийллийн улмаас сэтгэл санаа, эдийн засаг, бие махбод, бэлгийн халдашгүй байдлаараа хохирсон хүн;

**Сэтгэл санааны хүчирхийлэл:** Хүсэл зоригийн эсрэг тодорхой үйлдэл хийх, эсхүл хийхгүй байхыг албадах, үл хайхрах, гүтгэх, мөрдөн мөшгөх, заналхийлэх, бусадтай харилцахыг хязгаарлах, гутаан доромжлох болон бусад хэлбэрээр сэтгэл санааны дарамт үүсгэхийг;

**Бие махбодын хүчирхийлэл:** Амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулсан, эсхүл Учруулж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдэхүйг;

**Бэлгийн хүчирхийлэл:** Эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадахыг;

**Эдийн засгийн хүчирхийлэл:** Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах орлого, хуваарьт болон дундын эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах, орлого олох боломжийг нь хязгаарлах, шаардлагатай хэрэгцээг нь хясан боогдуулах, тэжээн тэтгэхээс зайлсхийх болон бусад хэлбэрээр эдийн засгийн хараат байдалд оруулсан, эсхүл эд хөрөнгийн хохирол учруулахыг;

**Бэлэвсэн:** Эхнэр/нөхөр нь нас барсан;



**Гэр бүл цуцлалт:** Гэрлэлтийг цуцалж хууль эрх зүйн хүрээнд эхнэр, нөхрийн эрх үүргийн харилцаагүй болохыг;

**Гэрлэлтээ цуцалсан:** Гэр бүлээ хуулийн дагуу цуцалснаас хойш дахин гэрлэж, хамт амьдраагүй хүнийг хугацаа харгалзахгүйгээр цуцалсан гэж үзнэ;

**Тусгаарласан:** Гэрлэлтээ хуулийн дагуу цуцлаагүй ч өрх тусгаарлан салсан гэр бүлийг хэлнэ;

**Хамтран амьдрагч:** Гэрлэлтээ бүртгүүлээгүй ч харилцан тохиролцсоны үндсэн дээр гэр бүлийн харилцаа үүсгэн хамт амьдарч байгаа хүмүүсийг “батлуулаагүй гэр бүлтэй” буюу хамтран амьдрагч гэж хэлнэ;

**Гэр бүлд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээ:** Гэр бүл, гэр бүлийн гишүүдийн эрүүл, аюулгүй, тогтвортой байдал, хөгжлийг дэмжих, бэхжүүлэх, ахиц, өөрчлөлтийг бий болгох, хамгаалах зорилгоор гэр бүлд үзүүлж байгаа шуурхай тусламжийн, хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх үйлчилгээ.



1

# УДИРТГАЛ

2

ГЭР БҮЛ, ХҮН АМ ЗҮЙ,  
НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

3

ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦААНЫ  
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

4

ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦААНД  
ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДЛУУД

5

ХИЛИЙН ЧАНАД ДАХЬ ГЭР  
БҮЛҮҮДИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ  
БАЙДАЛ



## НЭГ. УДИРТГАЛ

### 1.1. Үндэслэл

Монгол улс “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогодоо хүний хөгжлийг үндсэн сууриа болгож, нийгмийн бүхий л бүлгийн төлөөллөөс бүрдсэн шинэ парламент бүрдэж, хамтарсан Засгийн газар байгуулагдан, түүний бүтцэд “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” байгуулагдаж, гэр бүл төвтэй хүний хөгжлийг дэмжих, гэр бүлд суурилсан зохистой хөдөлмөр эрхлэлтийг бий болгох, гэр бүлд ээлтэй нийгмийн үйлчилгээг нэвтрүүлэх, гэр бүлийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх замаар нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах тэргүүн зорилтыг дэвшүүлж байгаа билээ.

Орчин үеийн нийгмийн хөгжил, эдийн засгийн өөрчлөлт, соёлын нөлөө, технологийн дэвшил, жендерийн эрх тэгш байдлын талаарх ойлголтын өргөжилт зэрэг хүчин зүйлс нь гэр бүлийн уламжлалт бүтэц, үнэт зүйл, амьдралын хэв маяг, харилцааны хэв шинжид гүнзгий нөлөөлж байна.

Монгол улсын хувьд 2000 оноос Монгол гэр бүлийн өөрчлөлт, харилцааны суурь асуудлыг анхаарч, тухайлсан судалгаа, онол, практикийн олон эрдэм шинжилгээний хуралд гэр бүлийн асуудлыг хөндсөн байдаг. Тухайлбал, 2004 онд анх удаа “Монголын гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал” суурь судалгааг хийсэн бөгөөд 2010 онд “Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал” 2019 онд “Монголын гэр бүлийн харилцааны хэв шинж, өөрчлөлт” судалгааг тус тус хийж байв. Эдгээр судалгаанууд тухайн үеийн нийгэм, эдийн засаг, соёлын өөрчлөлттэй уялдуулан гэр бүлийн бүтэц, харилцааны онцлогийг тодорхойлж, бодлогын баримт бичиг боловсруулахад суурь мэдээллээр хангаж байв.

Гэрлэлтийн статистикийн 10 жилийн динамик үзүүлэлтээс харахад, 2019 оноос эхлэн гэрлэлтийн тоо тасралтгүй буурч, харин гэр бүл цуцлалтын тоо өсөх хандлагатай байна. Тухайлбал, 2019 онд 20,043 гэрлэлт бүртгэгдсэн бол 2024 онд энэ тоо 14,225 болж, 29.1 хувиар буурсан үзүүлэлт гарчээ. Харин 2019 онд 4,262 байсан гэр бүл цуцлалтын тоо 2024 онд 4,463 болж, 4.6 хувиар нэмэгдсэн байна.

Түүнчлэн, гэрлэлтийн дундаж насны үзүүлэлт нь жил ирэх тусам хойшилж байгааг Үндэсний статистикийн хорооны хүн амын статистик үзүүлэлтээс тодорхой харж болно. Тухайлбал, 1989 онд гэрлэлтийн дундаж нас эрэгтэйчүүдийн хувьд 23.3, эмэгтэйчүүдийн хувьд 21.1 байсан бол



2000 онд эрэгтэй 25.7 хувь, эмэгтэй 23.7 хувь, 2010 онд эрэгтэй 26.2 хувь, эмэгтэй 24.2 хувь, харин 2020 онд эрэгтэй 28.6 хувь, эмэгтэй 26.7 хувь болж нэмэгджээ. Өөрөөр хэлбэл, 1990 онтой харьцуулахад гэрлэлтийн дундаж нас 5 жилээр хойшилсон байна. Үүнтэй зэрэгцэн төрөх насны эмэгтэйчүүдийн төрөлтийн ерөнхий коэффициент мөн буурах хандлагатай байна. Тухайлбал, 1000 төрөх насны эмэгтэйд ногдох төрөлтийн ерөнхий коэффициент 1990 онд 34.4 хувь байсан бол 2000 онд 20.4 хувь, 2010 онд хувьд 23.1 хувь, харин 2023 оны байдлаар 19 хувь хүртлээ буурсан нь гэрлэлтийн нас хойшилж байгаатай уялдан төрөлт ч буурч байгааг илтгэж байна.<sup>2</sup>

2019 оны сүүлээр дэлхийн дахинд дэгдсэн Ковид-19 цар тахал манай улсын эрүүл мэндийн тогтолцоо, эдийн засаг, боловсрол, нийгмийн бүхий л салбарт гүнзгий нөлөө үзүүлсэн билээ. Тухайлбал, хөл хорионы дэглэмийн үед хүүхдүүдийн танхимын сургалт зогсож, цахим сургалт руу шилжсэн нь боловсролын чанарт сөргөөр нөлөөлсөн бөгөөд цахим төхөөрөмж, интернэтийн хүртээмж муу гэр бүлд хүндрэл үүсгэсэн. Мөн цахим хэрэглээний хэт хамаарал, сэтгэл зүйн дарамт, гэр бүлийн хүчирхийллийн тохиолдол нэмэгдэж, олон гэр бүл орлогогүй болох, ажлын байраа алдах зэрэг эдийн засгийн бэрхшээлтэй тулгарсан.

Монгол Улсад “Гэр бүл”-ийн асуудлыг бодлогын түвшинд хариуцсан яамтай болсон нь гэр бүлийг дэмжих, хамгаалах чиглэлд цогц бодлого хэрэгжүүлэхэд ахиц дэвшил авчрах бөгөөд гэр бүл төвтэй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орон сууцжуулалт, нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх зэрэгт олон талт бодлого, үйлчилгээг шинжлэх ухаанд үндэслэсэн шийдвэрээр хэрэгжүүлэх нь нийгмийн тогтвортой хөгжилд чухал ач холбогдолтой юм.

Иймээс Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгээс “Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, өөрчлөлт” судалгааг хэрэгжүүлж, гэр бүлийн хөгжил, хамгааллын бодлогыг шинэ нөхцөл байдалд нийцүүлэн оновчтой төлөвлөхөд суурь мэдээлэл, судалгааны нотолгоо бий болгох нь энэхүү судалгааны ажлын үндэслэл болно.

## 1.2. Судалгааны зорилго, зорилт

Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, гэр бүлийн бүтэц, хэв маягт гарч буй өөрчлөлт болон түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг судлах, мөн гэр бүлийн харилцаанд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, улмаар гэр бүл төвтэй бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн зөвлөмжийг дэвшүүлэхэд энэхүү судалгааны зорилго оршино. Уг зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн болно.

<sup>2</sup> Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, төрөлтийн коэффициент, 2024 он



1. **Гэр бүлийн бүтэц, хэв маягийн өөрчлөлтийг судлах**
  - Хүн ам, нийгэм, эдийн засгийн үзүүлэлт.
2. **Гэр бүлийн харилцааны өнөөгийн байдлыг судалж, тодорхойлох**
  - Гэр бүл төлөвлөлт;
  - Гэр бүлийн үүрэг хариуцлага;
  - Гэр бүлийн үнэт зүйлс, хандлага;
  - Гэр бүлийн зөрчил, маргаан, гэрлэлт, цуцлалт.

### 1.3. Гэр бүлийн талаарх онол, үзэл баримтлал

Гэр бүл буюу англиар Family гэдэг үг нь Латин хэлний famulus болон familia (гэрийн боолуудын нийтлэг бүлэг) гэх үгнээс гаралтай. Эртний Ромын нийгэмд “familia” гэдэг нь зөвхөн цусан төрөл биш, тухайн айлын эзэнд харьяалагддаг бүх хүн - боол, үйлчлэгч, үр хүүхэд, эхнэр зэргийг хамарсан өргөн хүрээтэй ойлголт байв. Харин хожим Европын феодалын үед “family” нь голчлон цусан төрөлтнүүд болон гэрлэлтээр холбогдсон хүмүүсийн нэгж гэсэн утгаар хэрэглэгдэх болсон.

Дэлхий дахинд “гэр бүл” гэдэг үг (family) нь хэл, соёл, эрх зүйн тогтолцооноос шалтгаалан өөр өөр тодорхойлолттой байдаг ч ерөнхий утгаараа дараах нийтлэг ойлголтууд дээр тулгуурладаг. Тухайлбал, Олон улсын эрх зүйн байгууллагуудын тодорхойлолт:

- НҮБ (Нэгдсэн Үндэстний Байгууллага) - “Гэр бүл бол нийгмийн үндсэн, байгалийн нэгж бөгөөд нийгэм, төрөөс хамгаалагдах ёстой.”
- ДЭМБ (Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага) ‘Хүний эрхийн түгээмэл тунхаглал’<sup>3</sup> - “Гэр бүл бол гишүүд нь цусан төрөл, гэрлэлт эсвэл үрчлэлтээр холбогдсон, харилцан үүрэг хариуцлага, халамжийн сүлжээгээр нэгтгэгдсэн нийгмийн бүлэг мөн.”
- НҮБ ХС (Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан) - “Гэр бүл нь хүүхдийг өсгөн хүмүүжүүлэх, хамгаалах, хөгжүүлэх үндсэн орчин бөгөөд төрөлхийн эсвэл үүсмэл харилцаанд үндэслэнэ.”<sup>4</sup> гэж тус тус тодорхойлогддог.

Монгол бичигт “бүл” гэдэг үг хэрэглэгдэж байсан XX зууны эхэн үеэс Гэр бүл хэмээх нэр томъёо албан ёсоор бүхий л баримт бичигт хэрэглэгдэж ирсэн бөгөөд зах зээлийн харилцаанд орсноос хойш “Гэр бүлийн тухай хууль”-ийг 1999 онд баталж, гэр бүлийн харилцааг нийгмийн шинэ нөхцөл байдалд хууль эрх зүйн хүрээнд зохицуулах болсон.





Уг хуульд: “Гэр бүл”<sup>5</sup> гэж гэрлэлтийн үр дүнд буй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг хэлнэ гэж тодорхойлсон байна.

Социологийн шинжлэх ухаанд

- (Э.Дюрхейм) - *“Гэр бүл бол нийгмийн үндсэн институт бөгөөд хүний нийгэмших анхны орчин юм.”*
- (Э.Гидденс) - *“Ясан болон цусан төрлийн холбоогоор холбогдож, насанд хүрэгчид нь хүүхдүүдийнхээ өмнө хариуцлага хүлээсэн бүлэг хүмүүс.”*
- (Н.Смелзер) - *“Цусан төрлийн холбоо, гэрлэлт болон үрчлэлтэд дулдуйдсан, аж амьдралаа холбож үр хүүхдийн хүмүүжилд харилцан хариуцлага хүлээдэг хүмүүсийн нэгдэл.”* хэмээн олон янзаар тодорхойлсон нь бий. Ийнхүү тодорхойлохдоо гэр бүлийн нийгэмд гүйцэтгэх үүрэг, харилцаа холбоо, хэрэгцээ сонирхол, оршин тогтнох хэлбэрийг чухалчилсан байдаг.<sup>6</sup>

Орчин цагийн “Гэр бүл” хэмээх нэр томъёог хуулийн дагуу гэрлэсэн эхнэр, нөхөр болон тэдний халамжид буй үр хүүхэд, хамтран амьдрагч гэж нийтлэг байдлаар тодорхойлж байна.

Гэр бүлийн судалгаа нь өргөн хүрээтэй судлагдахуун бөгөөд гэр бүлийг нийгмийн бүлэг болон нийгмийн институци болох талаас нь микро болон макро түвшинд судалдаг. Орчин үеийн гэр бүлийн судалгааны хөгжилд түлхэц үзүүлсэн зарим бүтээлүүдийг дурдахын сацуу Монголд хийсэн гэр бүлийн судалгаануудын талаар товч авч үзье.

Социологийн шинжлэх ухаан нь аж үйлдвэржилт түүнийг дагасан нийгмийн өөрчлөлтийг судлах байдлаар хөгжсөн байдаг. Тиймээс ч социологийн сонгодог онолууд эдгээр өөрчлөлтөд тайлбар өгч уламжлалт болон орчин үеийн/modern/ нийгмийн ялгааг тодотгосон байдаг. Үүнд Эмил Дюрхейм, Карл Маркс, Макс Вебер, Фердинанд Тённис, Георг Зиммел зэрэг сэтгэгчдийг дурдаж болно.

Францын социологич Эмил Дюрхейм нь “Нийгэм дэх хөдөлмөрийн хуваарь,”<sup>7</sup> болон “Амиа хорлолт”<sup>8</sup> гэх бүтээлүүддээ нийгмийн механик болон органик нэгдлийг тайлбарлах замаар гэр бүлийн амьдралын өөрчлөлтийг болон гэр бүлийн үүргүүдийг тусгасан байдаг бөгөөд амиа хорлолтын тухай авч үзэхдээ гэр бүлийн нягт холбоо, түүний нөлөөг ч мөн амиа хорлолтод хамааралтай талаар дурдсан байдаг.

<sup>5</sup> Гэр бүлийн тухай хуулийн 3.1.2-т

<sup>6</sup> Т.Бүрэнжаргал, Гэр бүлийн социологи, Улаанбаатар хот, 2005

<sup>7</sup> Émile Durkheim, *The Division of Labor in Society* (New York, N.Y.: Free Press, 1893).

<sup>8</sup> Émile Durkheim, *Suicide: A Study in Sociology* (Routledge, 1897).



Харин Карл Марксын тухайд бол марксист онолын хандлага талаасаа Фредрих Энгелсийн “Өрх гэр, хувийн өмч, төрийн үүсэл” бүтээлд гэр бүлийн үүсэл хөгжлийн үе шат болон хувийн өмчийн үүсэлтэй холбон судалсан байдаг ба эрэгтэй эмэгтэй хүйсийн эрх мэдлийн тухай ч мөн тусгасан байдгаараа онцлогтой.<sup>9</sup>

Фердинанд Тённис “Нийгэмлэг ба нийгэм” (Gemeinschaft und Gesellschaft) бүтээлдээ уламжлалт нийгмийн харилцаа болох нягт харилцаа холбоотой, үнэт зүйлтэй, тогтвортой нийгмийн хэв шинж болон болон орчин үеийн болох албан ёсны харилцаа давамгайлсан, ялгаатай үнэт зүйлстэй, аминч үзэлтэй нийгмийг ялгаруулан судалсан. Үүнд тэрээр уламжлалт болон орчин үеийн нийгмийг судлахдаа гэр бүлийг голлон авч, жишээ болгож тайлбарласан байдаг.<sup>10</sup> Дээрх сэтгэгчид нь бидний цаг үеэс өмнө амьдарч байсан хэдий ч гэсэн тэдний судалгааны ажил, нийгмийг тайлбарлах оюун санааны бүтээлүүд одоо ч гэсэн ач холбогдлоо алдаагүй байна.

Орчин үеийн гэр бүлтэй холбоотой бүтээлүүдээс дурдвал социологич Энтони Гидденсийн “Дотно харилцааны өөрчлөлт”, “Орчин үеийн нийгэм дэх бэлгийн харилцаа, хайр дурлал ба эротизм” (The Transformation of Intimacy: Sexuality, Love, and Eroticism in Modern Societies) бүтээлд хэд хэдэн ойлголтуудыг онцолсон бөгөөд үүнээс “Цэвэр харилцаа” буюу pure relationship, гэх ойлголт нь хосын харилцаа, ёс уламжлал болон мөнгө санхүү гэх нийгмийн бусад үүргүүдээс ангид оршдог, хүмүүст хайр сэтгэл болон өөрийн сонголтоор гэрлэх хандлагыг илэрхийлдэг. Мөн “Хувирамтгай бэлгийн чиг хандлага” (Plastic sexuality) гэдэг ойлголт нь төвлөрсөн бус, нөхөн үржихүйн хэрэгцээнээс ангид бэлгийн харилцаа юм. Бэлгийн амьдрал нь орчин үеийн технологийн тусламжтайгаар нөхөн үржихүйн үүргээ алдаж, бэлгийн дур таашаал, түр зуурын харилцаа зонхилох болжээ. Түүний энэхүү бүтээл нь гэр бүлийн институтын хувьслын талаар авч үзсэн бөгөөд гэр бүл нь тогтмол шинжтэй биш, харин харилцааны чанар, хувь хүний хэрэгцээгээр тодорхойлогддог тухай өгүүлсэн байдаг.<sup>11</sup> Үүнээс орчин үеийн нийгэмд гэр бүл салалт өндөр байгаагийн шалтгаан, мөн алтернатив гэр бүлийн хувилбарууд яагаад бий болсон тухай ойлгож болох юм.

Жүдит Триас, Жаклин Скотт, Мартин Ричардс нарын 2014 онд хамтран туурвисан “Гэр бүлийн социологи” (The Sociology of Families) бүтээл нь гэр бүлийн талаар өргөн хүрээний мэдлэг, мэдээллийг өгөхийн хажуугаар онол, арга зүй, сүүлийн үеийн чиг хандлагуудын талаар өгүүлдэг.

<sup>9</sup> Friedrich Engels, *The Origin of the Family, Private Property and the State (Classic Reprint)* (Forgotten Books, 2017).

<sup>10</sup> Ferdinand Tönnies and Charles P. Loomis, *Community and Society* (Mineola, N.Y.: Dover Publications, 2002).

<sup>11</sup> Anthony Giddens, *The Transformation of Intimacy: Sexuality, Love and Eroticism in Modern Societies* (Cambridge: Polity Press, 1992).



Тус бүтээл нь сонгодог социологийн онолуудаас эхлээд орчин үеийн онолын хандлагууд болох бүтэц-үүргийн, символик харилцан үйлдэл, феминист, постмодернист болон глобалчлалтай холбоотой, гэр бүлийг судалж болох онолын хүрээнүүдийг багтаасан байдгаараа онцлогтой. Түүнчлэн Европ, Зүүн Ази болон Америк гэх мэт бүс нутгуудын гэр бүлийн онцлог, хөгжил, өөрчлөлт зэрэг өргөн хүрээний цогц мэдээллийг тусгасан байдаг.<sup>12</sup>

Тереза Сиабаттаригийн бичсэн “Гэр бүлийн социологи: Өөрчлөлт, үргэлжлэл, олон талт байдал” (2017) бүтээлд гэр бүлийн олон талт байдал болон өөрчлөлтийн талаар түлхүү өгүүлжээ. Хотжилт, аж үйлдвэржилт гэх мэт эдийн засаг, соёл, нийгмийн өөрчлөлтөд гэр бүл хэрхэн өөрчлөгдсөн түүх, гэр бүлийн хувьслын талаар бичсэн бөгөөд орчин үеийн гэр бүлийн сүүлийн үеийн чиг хандлагууд болох хамтран амьдрахуй, хожуу гэрлэлт, салалт болон дахин гэрлэлтийн талаар авч үзсэн байдаг. Түүнчлэн, гэр бүлийн бүтэц, эрх мэдлийн хуваарилалт, тэгш бус байдлын талаар хөндсөн байдгаараа онцлогтой бүтээл юм.<sup>13</sup>

Социологич Эндрю Черлиний “Нийтийн болон хувийн гэр бүл: Танилцуулга” (Public and Private Families: An Introduction) (2021) бүтээл нь гэр бүл судлалд анхлан суралцагч хэн бүхэнд хэрэгтэй ном болсон. Уншихад ойлгомжтой, энгийн бичиглэлтэй, гэр бүлийн амьдралын өргөн хүрээний асуудлуудыг хамарснаараа онцлогтой. Тэрээр гэр бүлийн судалдаг сүүлийн үеийн онолын чиг хандлагууд, арга зүй болон аргачлалуудыг ч авч үзэхийн зэрэгцээ “нийтийн гэр бүл” болон “хувийн гэр бүл” гэх ойлголтуудыг ялгаж өгсөн нь гэр бүлийг нийгмийн жижиг бүлэг болон нийгмийн институт болох талаас нь тодорхойлжээ. Нийтийн гэр бүлээр нийгмийн институтын үүргийг илэрхийлж буй бол хувийн гэр бүл нь гэр бүл, амраг садан, эцэг, эх, үр хүүхдийн хоорондох харилцаа, сэтгэлийн мэдрэмж, дотно холбоог төлөөлж буй ойлголт юм.<sup>14</sup> Хэдий энэ бүтээл нь Америкийн нийгэм, гэр бүлийн онцлог дээр бичигдсэн бүтээл ч гэр бүлийн сүүлийн үеийн өөрчлөлтүүд, шинэ хэлбэрүүдийг тайлбарлан дүгнэхэд дэмтэй юм.

#### 1.4. Судлагдсан байдал

Монгол гэр бүлтэй холбоотой зарим эх сурвалж, судалгаануудыг авч үзье.

Гэр бүл судлаач Т.Намжил Монгол гэр бүл цувралаар арваад бүтээл туурвисан байдаг. “Монголчуудын гэр бүлийн хүмүүжлийн уламжлал (1996)”, “Монгол ба Зүүн хойд Азийн гэр бүл, Дэд дэвтэр (1996)”, “Монгол, Өрнө, Дорно: Гэр бүлийн зан заншлын уламжлал, холбоо” зэрэг бүтээлийг дурдаж болно.

<sup>12</sup> Judith Treas, Jacqueline Scott, and Martin Richards, *The Wiley Blackwell Companion to the Sociology of Families* (Hoboken, N.J.: Wiley Blackwell, 2017).

<sup>13</sup> Teresa Ciabattari, *Sociology of Families* (SAGE Publications, 2021).

<sup>14</sup> Andrew J Cherlin, *Public & Private Families: An Introduction* (New York, Ny: McGraw-Hill, 2021).



2001 оны “Социологи” сэтгүүлд социологич О.Мөнхбат, Ц.Болд нарын бичсэн “Гэр бүлийн харилцааны зарим асуудалд” өгүүлэл тухайн үеийн Монголын нийгэм, гэр бүлүүдэд хурцаар тавигдаж буй гэр бүлийн эдийн засаг (орлого, өр-авлага), уламжлал-шинэчлэл, гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн харилцаа, гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүл салалтаас үүссэн нийгмийн үр дагавар зэрэг асуудлуудыг хөндөж, судалгааны баримт сэлт дээр тулгуурлан дүн шинжилгээ хийсэн. Энэ судалгаанд гэр бүлийн уламжлал-шинэчлэлийн асуудлыг хөндөхдөө “өрхийн тэргүүн”-д хандах хандлагаар нь Монгол гэр бүлийг гурван хэв шинжид хуваасан байна. Үүнд: (1) Уламжлалт, (2) Феминист, (3) Тэгш эрхт гэж ангилсан бөгөөд эл ангиллаар гэр бүлийн харилцаа, хүчирхийлэлд хандах хандлага, гэр бүл дэх эрх мэдлийн харилцаа зэрэг хүрээнд авч судалжээ.<sup>15</sup>

Судалгааны явцад Монголын нийгмийн суурь өөрчлөлт, тэр дундаа гэр бүлийн тогтолцооны доройтол, хямралын талаар анхлан шинжлэх ухааны үүднээс судалж, олон нийтэд сэрэмжлүүлж байсан социологич Х.Гүндсамбуугийн бүтээлүүд онцгой ач холбогдолтой бөгөөд түүний судалгаанууд нь гэр бүлийн институтын соёл, үнэт зүйл, харилцааны өөрчлөлтийг түүх-социологийн тайлбарын хүрээнд авч үзсэнээрээ үнэ цэнтэй юм. Түүний “Монголын айл гэрийн социологийн асуудлууд” өгүүлэлд дурдсанаар: Сүүлийн жилүүдэд салалт, бэлэвсрэлт нэмэгдсэнээс гадна зарим хүн хоёр дахь, түүгээр ч үл барам гурав дахиа гэрлэж, ахин дахин нөхөрт гарах юм уу эхнэр авч байна. Ийнхүү “бат бэх” насан туршийн айл гэр цөөрч буй нь үндэсний хорио цээрийн алдрал, зан заншил уламжлалын түрэгдэл шахалт....Наад захын танилцах зар, цаад захын оюуны бүтээл хүртэл бизнес агуулгатай, садар самуун, хүчирхийллийн өнгө аястай болчихлоо. Цөөнхийн гудамжны, гаж соёлын элементүүд түрж орж ирээд зогсохгүй байраа эзэлж, нийлэхүй давшилтад орчихлоо. Үүнийг даяаршил эсвэл замбуу тивчлэл гэж ойлговол, ухаарвал, зөнд нь тавивал том эндүүрэл болно. Даяаршил, замбуу тивчлэлийг хүлээн аваад зогсохгүй бас сөрөх чадвартай байх ёстой.<sup>16</sup> гэжээ.

Эдгээр нийгмийн үнэт зүйл, ёс суртахууны өөрчлөлт нь Монголчуудын хувьд хүлцэшгүй, байж боломгүй гажуудал болж байсан нь Х.Гүндсамбуу судлаачийн өгүүлэлд баримт болон үлджээ. Харин эдгээр нь өнөөгийн Монголын нийгэмд хэдий нь хэвийн үзэгдэл, “байдаг л зүйл” болчихсон нь мөн судлаачдын эргэж харах ёстой зүйл мөн.

Социологич Т.Бүрэнжаргалын “Гэр бүлийн социологи (2005)”<sup>17</sup> бүтээл нь гэр бүлийн судалгааны онол арга зүйн өргөн хүрээний мэдээллийг агуулахын сацуу гэр бүлтэй холбоотой нэр томьёо, ойлголтуудын тайлбарыг багтаасан.

<sup>15</sup> О.Мөнхбат, Ц.Болд, “Гэр бүлийн харилцааны зарим асуудалд,” Социологи №1 (2001): 56-75.

<sup>16</sup> Х.Гүндсамбуу “Айл гэрийн социологийн асуудлууд,” Социологи №3 (2003): 46.

<sup>17</sup> Т.Бүрэнжаргал, *Гэр бүлийн социологи*, (Улаанбаатар: МУИС, 2005).



2004 онд НҮБ ХС, НХХЯ (ГБХНХЯ болсон), Гал голомт хөдөлгөөний хамтран гүйцэтгэсэн “Монголын гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал”, 2010 онд ФСЭЗХ-ийн гүйцэтгэсэн “Монгол гэр бүлийн өнөөгийн байдал”<sup>18</sup>, 2019 онд ХНХСИ эрхэлж зохион байгуулсан “Монголын гэр бүлийн харилцааны хэв шинж, өөрчлөлт”<sup>19</sup> судалгаанууд Монгол гэр бүл судлалд хийгдсэн өргөн хэмжээний судалгаануудын нэг мөн.

Эдгээр судалгаанд тоон болон чанарын мэдээлэл цуглуулалтын хосолсон аргыг ашигласан бөгөөд судалгааны онолын хүрээнд социологийн бүтэц-үүргийн, символик интеракционист болон солилцооны онол арга зүйгээр гэр бүлийн асуудлыг тайлбарласан байна. Судалгааг гүйцэтгэхдээ (1) Гэр бүлийн бүтэц, хэв маяг, (2) Гэр бүлийн харилцаа, (3) Гэр бүл дэх нийгэм, орчны нөлөөлөл гэх үндсэн гурван хүрээнд судалжээ. Түүнчлэн “Монголын гэр бүлд эцгийн эрхт ёсны уламжлал аажмаар түрэгдэж, эхнэр нөхөр хоёр тэгш эрхтэй байх эгалитар ёс журам зонхилохын хамт өрхийн гишүүдийн эрх мэдлийн хуваарилалтын соёлын олон хэв маяг үүсэх нөхцөл бүрдээд байна”<sup>20</sup> гэж гэр бүлийн харилцааны өөрчлөлттэй холбоотойгоор дүгнэжээ.

2000 оноос нийгэм, эдийн засгийн өөрчлөлттэй холбоотой Монгол гэр бүлийн өөрчлөлт, харилцааны суурь асуудлыг анхаарч онол, практикийн эрдэм шинжилгээний хурлуудад гэр бүлийн тухай ойлголтуудыг онцгойлон дурдаж, судлагдахуун болгож, тухайлсан судалгаануудыг хийж эхэлсэн байна.

Үүнд:

А.Гэр бүлийн асуудлаар болон холбогдох судалгаанууд:

- Монгол улс дах хүсээгүй жирэмслэлт ба үр хөндөлт. НҮБ-ын ХАС. 2001;
- Гэр бүл дэх хүчирхийллийн тухай эмхэтгэл. 2001;
- Хүн амын гэрлэлтийн байдал. ҮСГ. 2002;
- Гэр бүл дэх хүчирхийллийн талаарх нийгмийн ойлголт, мэдлэг, хандлага. ХЭҮТ, ЗХЖТ. 2002;
- Монгол Улсын хууль тогтоомжид хийсэн жендэрийн дүн шинжилгээ. 2007;
- “Хүн ам хөгжил, жендэр, нөхөн үржихүйн эрүүл мэндийн бодлого, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн байдал, зохицуулалтын механизмын талаар мониторинг үнэлгээ дүгнэлт хийх нь” судалгааны ажил. НҮБХАС. 2007;
- Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа. ҮСГ. 2003, 2008;
- Гэр бүл төлөвлөлт, үр хөндөлтийн үйлчилгээ, олон нийтийн үр хөндөлтөд хандах хандлага. УБ. 2009.

<sup>18</sup> Т.Намжил, et al, *Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал*, (Улаанбаатар: Соёмбо, 2010).

<sup>19</sup> ХНХСИ, *Монголын гэр бүлийн харилцааны хэв шинж, өөрчлөлт*. Улаанбаатар. 2019.

<sup>20</sup> ФСЭЗХ, *Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал*, 2010.



Б. Монгол гэр бүлийн харилцааны талаар хийсэн захиалгат судалгаа:

- Гэр бүлийн харилцаан дах уламжлал, шинэчлэл. НХХЯ, МУИС. 2000;
- Монголын гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал. НХХЯ, НҮБХАС. Гал голомт хөдөлгөөн. 2004;
- Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал. ХНХЯ, НҮБХАС, ФСЭЗХ, УБИС. 2010;
- Монголын гэр бүлийн асуудал, хэрэгцээ, үйлчилгээний хувилбар. ГБХЗХГазар, Дэлхийн зөн Монгол, Нийгмийн бодлого хөгжлийн судалгааны хүрээлэн, 2018;
- Монголын гэр бүлийн харилцааны хэв шинж, өөрчлөлт. ХНХЯ, ХНХСИ. 2019.

В. Онол, эрдэм шинжилгээний хурал:

- Гэр бүл - хүүхдийн хөгжүүлэн төлөвшүүлэх анхдагч орчин. УБ. 1999;
- Өнөөгийн Монгол гэр бүлийн хөгжлийн чиг хандлага I бага хурал. 2002;
- Өнөөгийн Монгол гэр бүлийн хөгжлийн чиг хандлага II бага хурал. 2004;
- Өнөөгийн Монгол гэр бүлийн хөгжлийн чиг хандлага III бага хурал. 2008;
- Гэр бүлийн үнэ цэнэ- Хөгжил, шинэчлэл” үндэсний чуулган. Төрийн ордон. УБ. 2013;
- Гэр бүлийн хөгжлийн тулгамдсан асуудлууд, шийдвэрлэх арга зам. Эрдэм-шинжилгээний бага хурал. УБ. 2016. ХНХЯ, МУИС;
- XXI зууны Монгол гэр бүл” эрдэм-шинжилгээний бага хурал. УБ. 2019. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар. Олон улсын Улаанбаатарын их сургууль;
- Гэр бүлийн ёс зүйн асуудал. Эрдэм-шинжилгээний хурал. МУИС, Шинжлэх ухааны сургууль.

## 1.5. Судалгааны арга зүй

### 1.5.1. Судалгааны аргачлал

Судалгаанд гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, өөрчлөлтийг судлахдаа олон улсад түгээмэл ашиглагддаг онол арга зүй, аргачлалыг ашигласан болно. Үүнд:

1. Монгол гэр бүлийг судлахдаа позитивист болон интерпретив парадигмуудыг хослуулан хэрэглэх бөгөөд нэг талаас бүтэц үүргийн онол (Т.Парсонс, Р.Мертон), системийн онол (Никлас Лукман) болон зөрчилдөөний онол (Р.Дарендорф, Р.Коллинз), символик интеракционист (Ж.Х.Мид, Э.Гоффман) болон солилцооны онолыг (Ж.Хоманс, П.Блау) хэрэглэсэн.





2. Гэр бүлийг бүтэц үүргийн /structural-functionalist/ онолын хандлагаар тайлбарласан бөгөөд гэр бүлийн институт талаасаа нийгэмд гүйцэтгэх үүрэг, түүнийг хангаж чадах, эс чадах эсэх талаар авч үзсэн.
3. Зөрчилдөөний онолын /conflict theory/ хандлагаар гэр бүлийн эрх мэдлийн хуваарилалт болох эрэгтэй, эмэгтэй хүйсийн харилцаа, хөдөлмөрийн хуваарь, өмч хөрөнгийн тэгш бус байдлын талаар шинжлэхэд ашигласан.
4. Гэр бүлийн дотоод харилцаа, итгэл үнэмшил, мэдрэмж, субъектив ертөнц хэрхэн бүрэлдэж буй талаар символик интеракционист /symbolic interactionist/ онолын хандлагаар авч тайлбарласан. Дотоод итгэл үнэмшил, гэр бүл дэх гишүүдийн өөрсдийгөө харилцаа, мэдрэмжийн илрэлийг судлан шинжилсэн.
5. Системийн онолын /systems theory/ хандлагаар гэр бүлийг холистик байдлаар нь авч судлан, гэр бүл нь бие хүмүүсийн цуглуулга бус, гэр бүлийн дотоод бүтэц, гэр бүлийн гишүүн бүрийн үүрэг хариуцлага, уялдаа холбоог судалсан.

Судалгаанд тоон болон чанарын аргыг хослуулан ашиглаж дүн шинжилгээ хийв.

Тоон судалгааны арга: Тоон судалгаа байршил, нас, хүйс, гэр бүлийн бүтцийн онцлогт нийцүүлж, өрхөд суурилан зохион байгуулсан.

Тоон судалгааны асуулгын арга: Гэр бүлийн төрөл, амьжиргаа, өнөөгийн байдал, гэр бүлд нөлөөлж буй хүчин зүйл, тулгамдаж буй асуудлыг тодруулах зорилгоор асуулга судалгааг авсан.

Судалгааны асуулгын төслийг боловсруулахдаа ҮСХ, холбогдох судалгааны байгууллагууд, мөн эрдэмтэн, судлаачдын өмнө нь хийсэн судалгаануудыг лавлагаа материал болгон ашигласан. Мөн 2004, 2010, 2019 онуудад хийсэн гэр бүлийн талаарх судалгаануудын залгамж чанарыг хадгалах зарчмыг баримталсан бөгөөд судалгааны шинэчилсэн загварыг одоогийн баримталж буй хөгжлийн бодлого, хүн ам, гэр бүлийн хөгжлийн бодлогын хэрэгжилттэй уялдуулан боловсруулсан болно. Ингэхдээ судалгааны чанар, үр дүнгийн хэрэглээний түвшинг хангах үүднээс нийгмийн болон статистикийн судалгаанд хэрэглэгддэг олон улсын болон үндэсний түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн ойлголт, тодорхойлолт, асуулгын бүтэц, ангилал, кодчиллын жишгийг ашигласан.

Чанарын судалгааны арга: Гэр бүлийн бүтэц болон амьжиргааны түвшинтэй холбоотой нийгмийн зарим үзэгдлийн мөн чанарыг гүнзгийрүүлэн ойлгох зорилгоор тодорхой өрхүүдийг сонгон авч, ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлагыг зохион байгуулсан. Ийнхүү хэрэгжүүлсэн чанарын судалгаа нь тоон судалгааны үр дүнг баталгаажуулах, тайлбарлах, үнэлэлт дүгнэлт гаргахад чухал эх сурвалж болсон.



Мөн судалгааны хүрээнд хоёрдогч мэдээлэлд шинжилгээ хийсэн ба үүнд холбогдох статистик тоон мэдээлэл, нэгдсэн тайлан, баримт бичгүүдийг хамруулсан. Түүнчлэн 2010, 2019 оны гэр бүлийн харилцааны суурь судалгааны үр дүнтэй харьцуулалт хийж, цаг үеийн өөрчлөлт, хандлагын зөрүү, уялдааг тодорхойлохыг зорьсон болно.

## 1.6. Судалгааны түүвэрлэлт ба хамрах хүрээ

Судалгааны зорилгын хүрээнд гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, өөрчлөлтийг тодруулахын тулд түүврийн дизайныг боловсруулахдаа олон шатлалт, бүлэглэсэн түүврийн аргыг хослуулан боловсруулсан.

Үүнд эх олонлогоос төлөөлөх боломжит өрх, гэр бүлийг олон шатлалт буюу аймаг/нийслэл, сум/дүүрэг, баг/хорооны түвшинд ангилан санамсаргүй түүвэрлэлтээр сонгосон. Судалгаанд оролцогчдыг сонгохдоо байршил, нас, хүйс, гэр бүлийн хэлбэр зэрэг үндсэн үзүүлэлтүүдээс гадна боловсролын түвшин, хөдөлмөр эрхлэлтийн байдлыг нэмэлт шалгуур үзүүлэлт болгон ашигласан.

### 1.6.1. Түүврийн хамрах хүрээ

Тоон судалгааны түүврийн хамрах хүрээг тогтоохдоо Үндэсний статистикийн хорооны 2023 оны жилийн эцсийн байдлаарх улсын хэмжээнд бүртгэгдсэн 983,485 өрхийг судалгааны эх олонлог болно. Нийт эх олонлогоос түүвэрлэн авсан хэсгүүдээр төлөөлүүлэн гэр бүлийн гишүүдийн санал бодлыг тодорхойлно.

Түүврийн хэмжээг улсын хэмжээнд төлөөлөх чадвартайгаар тогтоохын тулд 95 хувийн итгэлцлийн түвшин, 2 хувийн харьцангуй алдааг үндэслэн дараах томъёог ашиглан тооцоолсон.

$$n = \frac{Z^2 \cdot p \cdot (1-p)}{e^2} \cdot \frac{N}{N-1 + \frac{Z^2 \cdot p \cdot (1-p)}{e^2}}$$

- $n$  шаардлагатай түүврийн хэмжээ
- $Z$  итгэлцлийн түвшинд харгалзах стандарт оноо
- $p$  зорилтот үзүүлэлтийн тархалт
- $e$  хүлээн зөвшөөрөх алдааны хэмжээ
- $N$  нийт хүн амын хэмжээ

Томъёоллоос түүврийн хэмжээг 2184 байхаар тооцов.





### 1.6.2. Түүврийн хуваарилалт

Судалгааны түүврийн хэмжээг хоёр үндсэн шалгуураар газарзүйн байршил (нийслэл ба аймгууд) болон гэр бүлийн хэлбэрээр хуваарилсан бөгөөд энэ хүрээнд хосолмол буюу тэгш ба пропорциональ хуваарилалтын аргыг ашигласан. Нийслэл болон аймгуудын түвшинд түүврийг пропорциональ хуваарилалтын аргаар хуваарилж, нийт 2184 өрхөөс нийслэлд 868, аймгуудад нийт 1316 өрх сонгосон. Аймгуудад багцалсан түүврийн хүрээнд тэгш хуваарилалтын зарчмыг баримтлан анхан шатны нэгжийн (сум/баг) тоонд үндэслэн тус бүрд 126-140 өрхийг судалгаанд хамруулсан. Ийнхүү түүврийн төлөөллийг хангах зорилгоор газарзүйн болон гэр бүлийн бүтэц, хэлбэрийн олон төрлийг хамруулсан хуваарилалт хийснээр судалгааны үр дүн нь улс орны хэмжээнд өрх, гэр бүлийн байдал, харилцааны онцлогийг бүрэн төлөөлөх боломжтой болсон.

Гэр бүлийн бүтцийг тодорхойлохдоо ҮСХ-ны 2020 оны Хүн ам, орон сууцны тооллого болон 2010, 2019 онд хийгдсэн гэр бүлийн харилцааны суурь судалгааны үр дүнд үндэслэн боловсруулж, бүлэглэсэн аргаар түүвэрлэсэн. Монгол улсад түгээмэл тохиолддог гэр бүлийн хэлбэрүүдийг сонгон судалгаанд хамруулсан. Ийнхүү гэр бүлийн бүтцийг өмнөх судалгаануудтай уялдуулан авч үзсэн нь судалгааны залгамж чанар, үр дүнгийн харьцуулалт хийх боломжийг бүрдүүлсэн болно. Үүнд:

- **Дан гэр бүл** нь эхнэр нөхөр дангаар, мөн эхнэр, нөхөр болон тэдний халамжид буй хүүхэдтэйгээ өрх тусгаарлан хамт амьдрах хэлбэр юм.
- **Нийлмэл гэр бүл** нь нэг өрх дотор өргөжсөн буюу ургийн хэд хэдэн үе, өөрөөр хэлбэр нэг өрхөд хэд хэдэн гэр бүл хамтдаа амьдрах хэлбэрийг хэлнэ. Тухайлбал, залуу гэр бүл, өөрийн аав ээжтэй хамт амьдрах, өрх толгойлсон эцэг эх, өөрийн аав ээжтэй хамт амьдрахыг хэлнэ.
- **Өрөөсгөл гэр бүл** нь өрх толгойлсон эцэг, эх /бэлэвсэн, цуцалсан/ болон тэдний халамжид буй хүүхэдтэйгээ өрх тусгаарлан хамт амьдрахыг хэлнэ.
- **Ганц биеэр өрх** тусгаарлан амьдарч буй болон гэрлэлтийн насны огт гэрлээгүй 18-40 насны дан, нийлмэл, өрөөсгөл гэр бүлд амьдарч буй хүмүүс.

*Хүснэгт 1.1. Түүврийн хуваарилалт, гэр бүлийн хэлбэрээр*

| Гэр бүлийн төрөл                            | Нийт        | Байршлаар  |             | Насны бүлгээр |            |            |
|---------------------------------------------|-------------|------------|-------------|---------------|------------|------------|
|                                             |             | Хот        | Хөдөө       | 18-34         | 35-49      | 50+        |
| Дан гэр бүл                                 | 570         | 231        | 339         | 250           | 171        | 149        |
| Нийлмэл гэр бүл                             | 553         | 218        | 335         | 241           | 165        | 147        |
| Өрөөсгөл гэр бүл                            | 530         | 217        | 313         | 215           | 164        | 151        |
| Ганц бие                                    | 531         | 216        | 315         | 221           | 161        | 149        |
| <b>Нийт</b>                                 | <b>2184</b> | <b>882</b> | <b>1302</b> | <b>927</b>    | <b>661</b> | <b>596</b> |
| Хилийн чанад дахь гэр бүл                   | 303         | -          | -           | -             | -          | -          |
| Ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлага | 172         | -          | -           | -             | -          | -          |

Түүврийн хамрах хүрээг орон нутагт бүс бүрээс хоёр аймаг, 10 аймаг бүрээс 3 сум нийт 30 сум, Улаанбаатар хотод 9 дүүрэг бүрээс нийт 92 хорооноос түүврийн төлөөллийг хамруулсан. Өрхийн нэгжийг сонгохдоо түүвэрт багтсан баг хорооны мэргэжилтнүүдтэй холбогдон өрхүүдийн мэдээллийн жагсаалтыг үүсгэж, гэр бүлийн төрөл, нас, хүйс, байршил зэрэг үзүүлэлтүүдэд суурилан энгийн санамсаргүй байдлаар хамруулсан. Мөн нас, хүйс, гэрлэлтийн байдлыг харгалзан нийт 172 оролцогчдыг ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлагад хамруулсан.

Хилийн чанад дахь гэр бүлийн судалгаанд Монголын иргэд хамгийн ихээр оршин суудаг АНУ, БНСУ, Казахстан, Япон, Чех зэрэг 5 улсын 303 иргэнийг энгийн санамсаргүй байдлаар хамруулсан.



## Хүснэгт 1.2. Түүврийн хуваарилалт, байршлаар

| Бүс              | Аймаг/дүүрэг   | Сум/хороо                                                                                                   | Эх олонлог<br>Нийт өрх | Түүврийн<br>хэмжээ |
|------------------|----------------|-------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------|--------------------|
| Улаанбаатар      | Хан-уул        | 4, 5, 6, 7, 8, 9, 10, 13, 14, 16, 20, 21, 23, 24, 25, 26                                                    | 72,900                 | 112                |
|                  | Баянгол        | 4, 7, 9, 10, 11, 12, 15, 17, 19, 23, 24, 25, 29, 32, 34                                                     | 69,519                 | 112                |
|                  | Баянзүрх       | 1, 2, 4, 5, 6, 7, 8, 10, 12, 14, 15, 18, 19, 20, 21, 22, 24, 25, 26, 27, 30, 31, 33, 35, 38, 39, 41, 42, 43 | 128,009                | 112                |
|                  | Сонгинохайрхан | 3, 4, 5, 6, 7, 8, 14, 15, 16, 18, 19, 21, 22, 23, 26, 27, 29, 30, 31, 32, 34, 36, 40, 42, 43                | 95,895                 | 112                |
|                  | Сүхбаатар      | 2, 5, 6, 9, 15, 17, 19                                                                                      | 39,984                 | 112                |
|                  | Чингэлтэй      | 2, 5, 6, 7, 8, 10, 18, 20                                                                                   | 37,736                 | 112                |
|                  | Налайх         | 1, 2, 3, 7, 8                                                                                               | 10,838                 | 98                 |
|                  | Багануур       | 1, 2, 3, 5                                                                                                  | 8,880                  | 70                 |
|                  | Багахангай     | 1, 2                                                                                                        | 1,298                  | 28                 |
| Улаанбаатар нийт |                |                                                                                                             | 465,059                | 868                |
| Зүүн бүс         | Дорнод         | Хэрлэн, Баяндун, Цагаан-Овоо                                                                                | 25,347                 | 126                |
|                  | Сүхбаатар      | Баруун-Урт, Дарьгана, Халзан                                                                                | 19,481                 | 126                |
| Хангайн бүс      | Архангай       | Эрдэнбулган, Батцэнгэл, Хайрхан                                                                             | 28,257                 | 140                |
|                  | Хөвсгөл        | Мөрөн, Их-Уул, Баянзүрх                                                                                     | 40,182                 | 112                |
| Төвийн бүс       | Төв            | Зуунмод, Бүрэн, Жаргалант                                                                                   | 28,845                 | 126                |
|                  | Дархан-Уул     | Дархан, Орхон, Шарын гол                                                                                    | 30,434                 | 126                |
| Говийн бүс       | Өмнөговь       | Даланзадгад, Манлай, Цогцэций                                                                               | 25,336                 | 140                |
|                  | Дорноговь      | Сайншанд, Алтанширээ, Замын-Үүд                                                                             | 21,543                 | 140                |
| Баруун бүс       | Баян-Өлгий     | Өлгий, Толбо, Цэнгэл                                                                                        | 26,329                 | 140                |
|                  | Увс            | Улаангом, Баруунтуруун, Бөхмөрөн                                                                            | 22,950                 | 140                |
| Бүсийн нийт      |                |                                                                                                             | 268,704                | 1,316              |
| Нийт             |                |                                                                                                             | 733,763                | 2,184              |



## 1.7. Судалгааны төлөвлөлт, зохион байгуулалт

“Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, өөрчлөлт” суурь судалгааг зохион байгуулах тухай саналыг 2024 оны IV дүгээр улиралд боловсруулан танилцуулсан бөгөөд судалгааг зохион байгуулж, тайлагнах хугацаа нь 2025 оны II дугаар улирал бөгөөд үйл ажиллагааны төлөвлөгөө дараах байдлаар гарган ажиллаа.

Үүнд:

1. Судалгааны бэлтгэл ажлыг хангах: 2025.01-2025.03
2. Мэдээлэл цуглуулалт: 2025.04
3. Боловсруулалт, тайлан бичилт: 2025.05-2025.06

Уг судалгааны ажлыг Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн Хүн ам, гэр бүлийн хөгжлийн судалгааны секторын баг бүрэлдэхүүн ажлын төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн. Судалгааны хөтөлбөр, асуулгыг холбогдох экспертүүд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын удирдлага, мэргэжилтнүүдийн санал зөвлөмжийг авч, боловсруулан зохион байгуулж гүйцэтгэсэн.

Судалгааны мэдээлэл цуглуулалт: Судлаач нарт зориулсан сургалтыг зохион байгуулж, мэдээлэл арга зүйн зөвлөгөө өгч, судалгааны үйл явцыг тогтвортой үргэлжлүүлэх нөхцөлийг бүрдүүлж ажилласан.

Судалгааны мэдээллийг Монгол Улсад оршин сууж буй өрх, гэр бүлийн гишүүнээс тоон болон чанарын мэдээлэл цуглуулалтын аргуудыг хослуулан ашиглан цуглуулсан. Тоон судалгааг үндэсний хэмжээнд өрхөд суурилан зохион байгуулсан бөгөөд түүний үр дүнг бататгах, үнэлэлт дүгнэлт хийх зорилгоор фокус бүлгийн ярилцлага болон болон ганцаарчилсан ярилцлагыг зохион байгуулсан.

Хилийн чанадад оршин сууж буй монгол иргэдээс мэдээлэл цуглуулах зорилгоор цахим холбоос бүхий анкетын асуулгыг үүсгэн илгээсэн. Мэдээлэл цуглуулалтыг тухайн орнуудын консулын газрууд болон ГБХНХЯ-ны харьяа агентлагаар дамжуулан иргэд рүү цахим линкийг түгээх байдлаар зохион байгуулсан. Цугларсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж үр дүнг нэгтгэн гаргасан.



Судалгааны боловсруулалт: Түүвэрт хамаарах 2,184 өрхөөс асуулгын аргаар цуглуулсан дата мэдээллийг SPSS 25.0 программд дата сет үүсгэн, цэвэрлэн хянаж, мэдээллийн үр дүнд корреляци, дундаж бодох, хэв маягчлал үүсгэх, харьцуулах, нөлөөлөгч хүчин зүйлийн шинжилгээ хийх зэргээр боловсруулсан бөгөөд судалгааны мэдээллийг цуглуулах, боловсруулах үйл ажиллагааг ҮСХ-ны “мэдээллийн чанарыг хянах, үнэлэх журам”-ын дагуу үнэлж, уялдуулах үзүүлэлтийн бэлэн байдлыг хангасан.

Мэдээллийн нууцлал: Судалгааны тоон мэдээллийг зөвхөн зорилгын дагуу нэгтгэн, дүн шинжилгээ хийхэд ашиглав. Судалгааны бүх шатны ажилтнууд өрх, хувь хүний талаарх мэдээллийг бусдад задруулахгүй байх үүрэг хүлээсэн.

## 1.8. Судалгааны хязгаарлагдмал байдал

Судалгааны зорилго зорилт, аргазүй болон мэдээлэл цуглуулалтын явцад тулгарсан бэрхшээл, мөн судалгааны явцад урьдчилан төлөвлөөгүй нөхцөл байдал зэргээс шалтгаалан дараах хязгаарлалтууд бий болсон.

- Гэр бүл судлалын хүрээ өргөн Гэр бүлийн бүтэц, хэлбэрүүд олон янз байдаг тул тэдгээрийг бүхэлд нь нэг удаагийн судалгаагаар иж бүрнээр хамрах боломжгүй юм. Энэхүү судалгаанд гэр бүлийн нийтлэг төрлүүдийг хамруулахыг зорьсон боловч зарим онцлог буюу хэвийн бус бүтэцтэй гэр бүлүүд судалгааны түүвэрт багтаагүй байх магадлалтай. Иймд судалгааны дүн нь бүх төрлийн гэр бүлийг бүрэн төлөөлөхгүй байж болохыг анхаарах шаардлагатай.
- Түүврийн төлөөлөлд нөлөөлсөн хүчин зүйлс зарим орон нутаг ястан угсаа, соёл, уламжлалын онцлогоос үүдэн зорилтот түүврийг бүрэн хэмжээнд авах боломж хязгаарлагдсан. Ийм нөхцөлд тухайн бүсийн ижил нийгэм-соёлын шинжтэй ойролцоо багууд болон аймгаас өгөгдлийг нөхөж авсан болно.
- Гэр бүлийн төрөл хоорондын ялгааг харьцуулах зорилгоор түүвэрлэлтийг тэгш хуваарилалтаар хийсэн. Иймд энэхүү өгөгдөл нь нийт гэр бүлийн төрлийн хүн амын бүтцийг бүрэн төлөөлөхгүй гэдгийг анхаарах нь зүйтэй.
- Хилийн чанад дахь Монгол гэр бүлүүдийн судалгааг цахим линкээр авсан бөгөөд төсөв болон цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас үүдэн хяналт хийгдэх боломж хязгаарлагдмал байсан. Иймд судалгааны үр дүнд судлаачдын үл удирдах хүчин зүйлсээс үүдэн судалгааны чанарт нөлөөлөх боломжтой. Мөн санамсаргүй түүвэрлэлтийн аргаар авагдсан тул нийт хилийн чанад дахь иргэдийг төлөөлөхгүй болно.



## 1.9. Судалгааны ёс зүйн асуудал

“Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” хууль: Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль нь 8 бүлэг 32 зүйлтэй бөгөөд хувь хүний мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах зорилготой болно.

“Статистикийн тухай” хууль: Статистикийн тухай хууль нь 6 бүлэг 23 зүйлээс бүрдсэн бөгөөд статистикийн мэдээллийг цуглуулж буй байгууллага болон мэдээллээ өгч буй иргэдийн хоорондын харилцааг зохицуулах, эрх тогтоох, хэрэглэгчдийг мэдээллээр хангах харилцааг зохицуулах зорилготой хууль юм.

Судалгаанд оролцогчдын зөвшөөрлийн хуудас: Судалгаанд оролцогчдоос аман болон зөвшөөрлийн хуудас дээр гарын үсэг зуруулах хэлбэрээр оролцох зөвшөөрлийг авсан. Тоон судалгаанд хамрагдсан оролцогчдоос судалгаа эхлэхээс өмнө зөвшөөрлийн хуудас дээр гарын үсэг зуруулан оролцоог баталгаажуулсан. Чанарын судалгааны фокус бүлгийн ярилцлага болон ганцаарчилсан ярилцлагад оролцогчдоос зөвшөөрлийн хуудас дээр гарын үсэг зуруулах байдлаар оролцоог зохион байгуулсан.

2

ГЭР БҮЛ, ХҮН АМ  
ЗҮЙ, НИЙГЭМ ЭДИЙН  
ЗАСГИЙН БАЙДАЛ







## ХОЁР. ГЭР БҮЛ, ХҮН АМ ЗҮЙ, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

### 2.1. Өрхийн шинж, хүн ам зүйн мэдээлэл

2023 оны жилийн эцсийн байдлаар Монгол улс 3.5 сая хүн амтай, 983.5 мянган өрхтэй байна. “Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, өөрчлөлт” судалгаанд Баян-Өлгий, Увс, Хөвсгөл, Архангай, Дархан-Уул, Төв, Дорноговь, Өмнөговь, Дорнод, Сүхбаатар зэрэг 10 аймаг болон Улаанбаатар хотын 9 дүүргийг хамруулж, нийт 2184 өрхийн төлөөллийг тоон судалгаанд, 172 хүнийг чанарын судалгаанд хамруулсан.


*Зураг 2.1. Судалгаанд хамрагдсан гэр бүлийн түүврийн хамрах хүрээ, хэмжээ*



Судалгаанд хамрагдсан нийт 2184 оролцогчийн 26.1 хувь нь дан өрх буюу эцэг, эх болон хүүхэдтэйгээ амьдардаг гэр бүлийн бүтэцтэй, 25.3 хувь нь нийлмэл өрх буюу ургийн хэд хэдэн үеийнхэн хамт амьдардаг өрхөд хамрагдаж байна. Харин 24.3 хувь нь өрөөсгөл буюу өрх толгойлсон эцэг эсвэл эх хүүхдүүдийн хамт амьдардаг гэр бүлд харьяалагдаж байна. Үлдсэн 24.3 хувь нь ганц биеэр өрх тусгаарлан амьдарч буй болон гэрлэлтийн насны огт гэрлээгүй дан, нийлмэл, өрөөсгөл гэр бүлд амьдарч буй иргэнийг хамруулан судалсан болно.




Зураг 2.2. Судалгаанд хамрагдсан гэр бүлийн хэлбэр




Судалгаанд хамрагдсан өрхийн 40.4 хувь нь Улаанбаатар хотод, 59.6 хувь нь хөдөө орон нутагт оршин суудаг. Орон нутгийн оролцогчдын 21.9 хувь нь аймгийн төвд, 33.4 хувь нь суманд, 4.3 хувь хөдөөгийн баг дээр амьдарч байна.

Зураг 2.3. Судалгаанд хамрагдсан гэр бүл, байршил, хувиар



Судалгаанд хамрагдсан гэр бүлийн төлөөллийн 69.7 орчим хувь нь (эрэгтэй 55.9 хувь, эмэгтэй 44.1 хувь) өрхийн тэргүүн өөрөө, харин 20.7 хувь өрхийн тэргүүний эхнэр эсвэл нөхөр, 6.6 хувь нь өрхийн тэргүүний насанд хүрсэн охин эсвэл хүү, 2.7 хувь нь түүний эцэг, эх, хүү эсвэл бэр болон бусад цусан төрлийн хамаарал бүхий хүмүүс байв.


Зураг 2.4. Судалгаанд хамрагдсан иргэдийн өрхийн тэргүүнтэй ямар хамааралтай эсэх, хувиар






Судалгаанд хамрагдсан гэр бүлийн гишүүдийг насны бүлгээр авч үзвэл 42.4 хувь нь 18-34 настай, 30.3 хувь 35-49 настай, 27.3 хувь нь 50-с дээш насныхан байна. Судалгаанд оролцогчдын 56.2 хувь нь эмэгтэй, 43.8% эрэгтэй байна.

Зураг 2.5. Судалгаанд хамрагдагсдын насны бүлэг, хүйс, хувиар



Судалгаанд оролцогчдын 40.2 хувь нь бүрэн дунд, 34.2 хувь нь бакалавр болон түүнээс дээш, 10.6 хувь нь техникийн болон тусгай дунд боловсролтой, 4.8 хувь нь бага болон боловсролгүй байна. Боловсролын түвшинг насны бүлгээр харвал дээд ба түүнээс дээш боловсролтой 2 хүн тутмын нэг нь 18-34 насны залуучууд байна. Харин боловсролын түвшин буурах тусам залуучуудын буюу 18-34 насны бүлгийн эзлэх хувь буурч байгаа нь залуучууд илүү боловсролдоо анхаарч өндөр боловсрол эзэмшдэг болсон нь харагдаж байна.


Зураг 2.6. Судалгаанд хамрагдсан иргэдийн боловсролын түвшин, насны бүлэг, хувиар






Өрхийн тэргүүний боловсролын түвшинг түүний эхнэр/нөхрийн боловсролын түвшинтэй харьцуулахад хосуудын хувьд ерөнхийдөө өөртэйгөө адил, ойролцоо боловсролын түвшний хүнтэй гэр бүл болох сонирхолтой байгаа нь судалгааны үр дүнгээс ажиглагдаж байна.

**Зураг 2.7 Судалгаанд хамрагдсан өрхийн эхнэр (нөхөр)-ийн боловсролын түвшний харьцуулалт, хувиар**



Судалгаанд хамрагдагсдын 36.5 хувь нь монголчуудын уламжлалт буддын шашинд итгэл үнэмшилтэй бол 50.2 хувь буюу тал нь шашингүй үзлийг илүүд үздэг бол үлдсэн 5.9 хувь нь исламын, 4.7 хувь нь бөө мөргөлийн, 2.2 хувь нь христийн, 0.3 хувь нь бусад шашныг шүтдэг байна. Насны бүлгээр харвал нас залуужих тусам шашин шүтлэггүй хүмүүсийн эзлэх хувь нэмэгдэж, шашин шүтлэгтэй хүмүүсийн эзлэх хувь багасаж байв.


**Зураг 2.8. Судалгаанд хамрагдагсдын шашин шүтлэгийн байдал, насны бүлэг, хувиар**






Судалгаанд хамрагдсан өрхийн ам бүл дунджаар 4 гишүүнтэй. Өрхийн гишүүдийн тоог бүлэглэн авч үзвэл 34.6 хувь нь 1-2 гишүүнтэй, 30.4 хувь нь 3-4 гишүүнтэй, 25.3 хувь нь 5-6 гишүүнтэй, үлдсэн 9.7 хувь нь 7 ба түүнээс дээш гишүүнтэй байна. Эдгээр үзүүлэлт нь 2023 оны жилийн эцсийн статистикийн тоон мэдээлэлтэй харьцуулахад нэг өрхөд ногдох дундаж хүн амын тоо 3.5–3.7 хүн байгаа нь энэхүү судалгааны үр дүнтэй нийцэж байгаа юм.

Зураг 2.9. Судалгаанд хамрагдсан өрхийн ам бүлийн тоо, хувиар



Судалгааны дүнгээс харахад 50 ба түүнээс дээш насны хүмүүсийн хувьд ам бүлийн тоо буурах хандлагатай байгаа бөгөөд дан, өрөөсгөл, ганц бие өрхийн хэлбэр зонхилж байна. Тодруулбал, 50.3 хувь 1-2 гишүүнтэй, 28.0 хувь 3-4 гишүүнтэй дан гэр бүл болон бэлэвсэн, өрх толгойлсон өрөөсгөл, ганц биеэр өрх үүсгэн амьдрах гэр бүл нэлээдгүй байв.


Зураг 2.10. Судалгаанд хамрагдсан өрхийн ам бүлийн тоо, насны бүлэг, хувиар






Судалгаанд оролцогчдын 70.3 хувь нь хөдөлмөр эрхэлдэг бөгөөд эдгээрийн 86.3 хувь нь цалин хөлстэй ажил эрхэлж байна. Харин 29.7 хувь нь хөдөлмөр эрхэлдэггүй бөгөөд тэдний 20.4 хувь нь суралцаж буй, жирэмсэн, тэтгэврийн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг шалтгааны улмаас хөдөлмөр эрхлэх боломжгүй хүмүүс байна. Мөн үлдсэн 9.3 хувь нь хөдөлмөр эрхлэх боломжтой ч одоогоор ажилгүй иргэд байна.

*Зураг 2.11. Судалгаанд хамрагдагсдын хөдөлмөр эрхлэлтийн байдал, хувиар*



Судалгаанд оролцогчдын гэрлэлтийн байдлыг авч үзэхэд 45.7 хувь нь гэрлэсэн, 28.4 хувь нь огт гэрлээгүй, 12.4 хувь нь гэр бүлээ цуцалсан эсвэл тусгаарласан, 13.5 хувь нь бэлэвсэн байв. Гэр бүлтэй оролцогчдын дунд хамтын амьдралаа албан ёсоор бүртгүүлсэн нь 85.2 хувийг эзэлж байгаа бол гэрлэлтээ бүртгүүлээгүй хүмүүс 14.8 хувийг эзэлж байна. Гэр бүл судлаачдын үзэж байгаагаар олон хосууд гэрлэлтээ бүртгүүлээгүйгээр хамт амьдарч байгаа ч өөрсдийгөө хамтран амьдрагч бус, гэрлэсэн гэж үзэх явдал цөөнгүй байдаг гэж тайлбарладаг. Хамтран амьдрагч гэх ойлголтыг үерхэл, тогтвортой бус харилцаатай адилтгах хандлага байдаг тул судалгаанд оролцогчид гэрлэсэн гэж хариулсан ч тэдний дотор гэрлэлтээ батлуулсан, батлуулаагүй гэр бүлүүд байгаа нь ялган үзэх шалтгаан болж байна.


*Зураг 2.12. Судалгаанд оролцогчдын гэрлэлтийн байдал, хувиар*






Гэрлэлтээ батлуулсан болон батлуулаагүй судалгаанд оролцогчдоос гэрлэлтийн болон эд хөрөнгийн асуудлаар ямар нэгэн гэрээ хийсэн эсэхийг тодруулахад батлуулсан оролцогчдын 3.5 хувь тийм, 96.5 хувь үгүй хэмээн хариулжээ. Харин гэрлэлтээ батлуулаагүй гэр бүлийн хувьд 0.4 хувь тийм, үлдсэн 99.5 хувь үгүй гэжээ. Үүнээс гэр бүл болон амьдарч буй хосууд гэрлэлтийн болон эд хөрөнгийн талаар ойлголт болон хэрэгцээ шаардлагыг хараахан чухалчилж үздэггүй нь харагдаж байна.

Зураг 2.13. Судалгаанд хамрагдсан эхнэр/нөхөртэй иргэдийн гэрлэлтийн болон хөрөнгийн асуудлаар ямар нэгэн гэрээ хийсэн эсэх, хувиар



Судалгаанд хамрагдсан гэр бүлийн хамтран амьдарсан дундаж хугацаа 15.9 жил байна. Үүнээс 27.6 хувь нь 1-5 жил, 15.6 хувь нь 6-10 жил, 26.5 хувь нь 10- 20 жил хүртэл, 30.3 хувь нь 20 ба түүнээс дээш жил хамт амьдарсан байна. Гэрлэлтийн дундаж хугацааны талаар албан ёсны статистик мэдээлэл байхгүй ч 2004, 2010 болон 2019 хийгдсэн судалгааны үр дүнгээр гэрлэлтийн дундаж хугацааг 10 ба түүнээс дээш жил байгаа нь тэмдэглэгдсэн. Энэ удаагийн судалгааны үр дүн нь өмнөх судалгаануудын үр дүнтэй харьцуулахад өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд үүнд судалгаанд хамрагдсан гэр бүлийн 64.9 хувь нь 10 ба түүнээс дээш жил хамтран амьдарсан нь голлон нөлөөлсөн байна. (Гэр бүлийн хамтран амьдрах хугацааны дэлгэрэнгүй мэдээллийг Дөрөвдүгээр бүлэгт тусгасан болно).


Зураг 2.14. Судалгаанд оролцсон гэрлэсэн хосуудын хамт амьдарсан хугацаа, өнгөрсөн он, хувиар






Судалгаанд хамрагдагсдын 94.1 хувь нь гэр бүлийн гишүүн нь гадаад улсад амьдарч байгаа гэж хариулсан бол 5.9 хувь нь үгүй гэжээ. Гэр бүлийн гишүүн нь гадаад улсад оршин сууж буй улс орнуудыг авч үзвэл 38.8 хувь нь БНСУ, 20.4 хувь нь Япон, 16.3 хувь нь Австрали, 9.2 хувь нь АНУ-д байна. Түүнчлэн гадаад улсад амьдарч байгаа шалтгааныг тодруулахад 45.9 хувь нь суралцах, 41.2 хувь нь хувиараа болон гэрээгээр ажиллах, 10.2 хувь тухайн улсад суурьших болон цагаачлах, 2.7 хувь нь бусад буюу гадаадын иргэнтэй гэр бүл болох зэрэг шалтгаантай байна.

Зураг 2.15. Гадаадад амьдарч буй иргэдийн оршин суугаа улс, хувиар



Зураг 2.16. Өрхийн гишүүдийн гадаадад амьдарч буй шалтгаан, хувиар



Судалгааны үр дүнгээс үзэхэд Монгол гэр бүлийн гишүүдийн хувьд гадаад улс оронд боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх, цаашлаад тухайн улсад суурьшин амьдрахыг илүүд үзэж байна. Энэ нь хувь хүний хөгжил, сайн сайхан амьдралын эрэлхийлэлтэй холбоотой ч, нөгөө талаас эх орондоо хүссэн боломжоо олж чадахгүй байгааг илтгэх сэтгэл түгшээсэн үзэгдэл юм. Гэр бүлээсээ алс амьдрах сонголт нь зөвхөн хувь хүний шийдвэр төдийгүй, нийгэм, эдийн засгийн тогтолцооны тодорхой асуудлуудыг ч ил гаргаж байна.






## 2.2. Өрхийн амьжиргаа

Өрхийн амьжиргааны тухай ойлголтод өрхийн орлого, зарлага, эдийн засгийн болон нийгмийн нөхцөл, амьдрах орчин, амьжиргааны түвшин зэргийг авч үзсэн болно.

Судалгаанд хамрагдсан нийт өрхийн амьдарч буй орон сууцны төрлөөр нь авч үзэхэд 32.9 хувь монгол гэрт, 35.1 хувь тусдаа хашаа байшинд, 27.4 хувь нь орон сууцанд, 1.7 хувь нь бие даасан тохилог сууцанд, 2.3 хувь нь нийтийн байранд амьдарч байна. Байршлын хувьд авч үзвэл хотын иргэдийн 44.7 хувь нь төвлөрсөн халаалтын системд холбогдсон орон сууцанд амьдардаг бол хөдөө орон нутагт амьдарч буй иргэдийн 39.3 хувь нь тусдаа хашаа байшинд амьдардаг байна.


Зураг 2.17. Судалгаанд хамрагдагсдын сууцны төрөл, байршил, хувиар



Судалгаанд хамрагдсан гэр бүлийн амьдарч буй сууцыг эзэмшлийн хэлбэрээр нь авч үзэхэд 74.6 хувь нь өөрийн эзэмшлийн сууцанд, 15.9 хувь аав ээж, ахан дүүсийнхээ байранд хамтдаа эсвэл дангаар түрээсгүйгээр амьдардаг бөгөөд 8.4 хувь нь бусдын сууцыг түрээсэлж амьдарч байна. Судалгаанд хамрагдсан гэр бүлийн гишүүдийн насны бүлгээр амьдарч буй сууцны төрлийг харьцуулахад 18-34 насны залуу гэр бүлүүдийн хувьд өөрийн эзэмшлийн орон сууцтай болсон хувь харьцангуй бага бөгөөд ихэнх нь бусдын сууцанд түрээслэн эсвэл түрээсгүйгээр амьдарч байгаа нь илүү өндөр үзүүлэлттэй байна.




**Зураг 2.18. Судалгаанд оролцогчдын сууцны эзэмшлийн хэлбэр, насны бүлэг, хувиар**



Өрхийн сарын дундаж орлогын үзүүлэлтээр судалгаанд хамрагдсан гэр бүлийг авч үзэхэд 14.3 хувь нь 660,000 төгрөг хүртэл, 15.3 хувь нь 660,001-1,000,000 төгрөг, 35.3 хувь нь 1,000,001-2,000,000 төгрөг, 17.4 хувь нь 2,000,001-3,000,000 төгрөг, 9.1 хувь нь 3,000,001-4,000,000 төгрөг, харин 8.6 хувь нь 4,000,001-с дээш орлоготой гэж хариулсан байна. Нийт өрхийн сарын дундаж орлого 2,514,020 төгрөг байна.

**Зураг 2.19. Судалгаанд хамрагдсан өрхийн сарын дундаж орлого, төгрөг, хувиар**



Судалгаанд хамрагдсан өрхийн 37.9 хувь нь зөвхөн өндөр настны тэтгэвэр, нийгмийн халамжийн тэтгэмжийн орлогоор амьжиргаагаа залгуулж байгаа бол 48.4 хувь нь цалин хөлсний орлого, 7.1 хувь нь өрхийн үйлдвэрлэл, бизнесийн ашиг орлого, 4.8 хувь бусад орлогоос өрхийн төсвөө бүрдүүлдэг байна.

Өрхийн орлого хэдэн ч эх үүсвэртэй байж болох ч нийт өрхийн 61 хувь нь цалин хөлс эсвэл тэтгэвэр тэтгэмж гэсэн ганц эх үүсвэртэй, 30 хувь нь 2 эх үүсвэр, 8 хувь нь гурваас дээш эх үүсвэрээс өрхийн орлого бүрдүүлж байна.




## Хүснэгт 2.1. Судалгаанд хамрагдсан өрхийн орлогын эх үүсвэр, хувиар

| Орлогын эх үүсвэр                      | Улсын дундаж <sup>21</sup> | Судалгааны үр дүн, хувиар |
|----------------------------------------|----------------------------|---------------------------|
| <b>Дундаж орлого</b>                   | <b>2,567,889</b>           | <b>2,514,020</b>          |
| Цалин хөлс                             | 53.0                       | 48.4                      |
| Тэтгэвэр, тэтгэмж                      | 21.4                       | 37.9                      |
| Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого | 16.3                       | 7.1                       |
| Хандив тусламж                         | 2.4                        | 1.8                       |
| Бусад                                  | 6.9                        | 4.8                       |

Судалгаанд оролцогчдын орлогын эх үүсвэрийг насны бүлгээр харвал 18-34 насныхны хувьд цалин хөлсний эзлэх хувийн жин хамгийн өндөр буюу 81.4 хувь байна. Харин 50 ба түүнээс дээш насныханд 62.1 хувь нь тэтгэвэр, 35-49 насныхны 33.1 хувь нь тэтгэмжийн мөнгөөр орлогын эх үүсвэрээ бүрдүүлж байна.

## Зураг 2.20. Судалгаанд хамрагдсан өрхийн орлогын эх үүсвэр, насны бүлэг, нэмэлт орлоготой эсэх, хувиар



Судалгаанд оролцогчдын хувьд өрхийн үндсэн орлогоос гадна нэмэлт орлоготой эсэхийг тодруулахад 80.2 хувь нь нэмэлт орлого байхгүй гэж хариулсан байна. Харин нэмэлт орлоготой гэж хариулсан оролцогчдын 12.7 хувь нь түр хугацааны, 7.1 хувь нь улирлын чанартай орлого олдог гэжээ.

Судалгаанд хамрагдсан өрхийн сарын дундаж зарлагын бүтцийг харвал хамгийн өндөр буюу 55.2 хувийг хүнс болон хүүхдийн хэрэгцээнд зарцуулж байна. Үүний дараа хувцас хэрэгсэл, өр, зээл, эрүүл мэндийн зардлууд орж байна. Үүнээс харахад өрхийн орлого нь өрхийн хэрэглээний зардал болон өр, зээлийн төлбөрийг л дөнгөж хангаж байгаа бөгөөд хадгаламж, өөрийгөө хөгжүүлэх, аялал зугаалга зэрэг зардалд хүрэлцэхгүй байгааг харуулж байна.



Зураг 2.21. Судалгаанд оролцогчдын орлогын зарцуулалт, давтагдсан тоо, хувиар



Өрхийн зарцуулалтыг өрхийн төрлөөр авч үзвэл ганц бие хүмүүсийн хувьд эрүүл мэнд, хадгаламж, хуримтлал, хобби спортоор хичээллэх, өөрийгөө хөгжүүлэх, шоу цэнгээн гэх мэт зүйлсэд зарцуулж буй зардал дунджаас өндөр байна. Өөрөөр хэлбэл, ганц бие иргэд нь илүү наад захын хэрэгцээнээс гадна өөрийн сонирхол хөгжилд чиглэсэн зардалд илүүтэй мөнгө зарцуулж байгаа нь бусад гэр бүлийн төрлийн өрхүүдтэй харьцуулахад өндөр байна. Дан өрхийн хувьд зардлын ихэнхийг хүүхэд, хувцас хэрэглэл болон өр зээлд зарцуулдаг бол нийлмэл өрхийн хувьд эрүүл мэндийн үйлчилгээ, өр зээлийн төлбөрт илүүтэй зарцуулдаг аж. Харин өрөөсгөл өрхийн хувьд хүүхэд, боловсрол, орон сууцны түрээс зэрэгт дунджаас илүү зардал гаргаж байна.




## Хүснэгт 2.2. Судалгаанд хамрагдсан иргэдийн орлогын зарцуулалт, өрхийн төрөл, давхардсан тоо, хувиар

| Зарлагын төрөл                        | Дундаж | Ганц бие | Дан  | Нийлмэл | Өрөөсгөл |
|---------------------------------------|--------|----------|------|---------|----------|
| Хүнс                                  | 55.1   | 68.4     | 39.8 | 59.3    | 54.2     |
| Хүүхэд                                | 54.8   | 25.3     | 69.6 | 56.2    | 66.9     |
| Хувцас хэрэгсэл                       | 34.0   | 24       | 40.4 | 35.3    | 36.1     |
| Өр, зээл                              | 33.4   | 24.6     | 41.4 | 41.4    | 25.7     |
| Эрүүл мэнд                            | 30.7   | 34.8     | 27.4 | 34.9    | 26.3     |
| Боловсролд                            | 16.8   | 10.0     | 20.5 | 17.9    | 18.5     |
| Хадгаламж, хуримтлал                  | 7.9    | 12.9     | 7.9  | 6.9     | 4.2      |
| Аав ээж, ах, дүүс, хамаатандаа туслах | 3.3    | 9.1      | 2.3  | 0.9     | 1.1      |
| Хобби, спортоор хичээллэх             | 2.5    | 6.4      | 1.4  | 1.3     | 0.9      |
| Аялал жуулчлал                        | 2.0    | 3.2      | 2.1  | 2.5     | 0.2      |
| Өөрийгөө хөгжүүлэхэд                  | 1.5    | 3.8      | 1.1  | 0.4     | 0.8      |
| Шоу цэнгээнд                          | 0.8    | 2.3      | 0.2  | 0.7     | 0.0      |
| Үзвэр үйлчилгээнд                     | 0.5    | 1.1      | 0.4  | 0.4     | 0.0      |
| Тог цахилгаан, ус дулаан              | 4.2    | 5.5      | 2.6  | 4.0     | 4.9      |
| Түрээс                                | 2.5    | 4.5      | 1.8  | 0.4     | 3.6      |
| Түлээ нүүрс                           | 2.2    | 2.3      | 1.1  | 1.8     | 3.6      |
| Бензин түлш                           | 1.5    | 2.3      | 1.1  | 1.3     | 1.3      |

Судалгаанд хамрагдагсдын 25.2 хувь нь өдөр тутмын хэрэгцээгээ хангаж чаддаггүй байгаа бол 38.8 хувь нь өдөр тутмын хэрэгцээгээ хангаж чаддаг, 29.6 хувь нь өдөр тутмын хэрэгцээгээ хангаж, байгаа хэдий ч зээл авах шаардлага үүсдэг гэжээ.

Байршлын хувьд хот болон орон нутгийн иргэдийн хариултыг харвал орон нутагт амьдарч буй судалгаанд оролцогчдын ихэнх нь хэрэгцээгээ хангаж чаддаггүй эсвэл дөнгөн хангаж байна хэмээн хариулсан бол хотод амьдарч буй өрхийн гишүүд үнэтэй зүйл худалдан авахын тулд зээл авдаг гэх хариултыг илүү өндөр хувьтай өгсөн байна.

Зураг 2.22. Судалгаанд хамрагдсан иргэдийн өрхийн амьжиргааг үнэлсэн байдал, байршил, хувиар





Нийт оролцогчдын хувьд хэрэглээнээс давсан зардлаа нөхөхдөө голчлон банкнаас зээл авах, бусдаас мөнгө зээлэх, мөн санхүүгийн аппликейшн ашиглан зээл авах арга замыг түлхүү ашиглаж байна.

Ганц бие иргэдийн дунд хэрэглээнээс давсан зардал гардаггүй тохиолдол хамгийн өндөр буюу 33.3 хувийг эзэлж байгаа бөгөөд илүү зардал гарсан тохиолдолд эцэг эхээсээ санхүүгийн туслалцаа авах, эсвэл өөрийн хуримтлалаа ашиглах хандлага нь бусад өрхийн төрлүүдтэй харьцуулахад өндөр хувьтай байгаа юм. Харин нийлмэл гэр бүлийн хувьд хэрэглээнээс давсан зардлаа нөхөхдөө банк, ломбард болон санхүүгийн аппликейшнээс зээл авах нь түгээмэл байна. Өрөөсгөл гэр бүлийн хувьд найз нөхөд, хамаатан садан зэрэг хувийн хүрээллээсээ зээл авах нь гол эх үүсвэр болж байна.

Насны бүлгээр нь харвал 18-34 насны иргэдийн 28.7 хувь, 35-49 насны иргэдийн 19 хувь, 50 ба түүнээс дээш насныхны 5 хувь нь аппликейшнээс зээл авч байна. Энэхүү үзүүлэлт нь залуучуудын дунд санхүүгийн аппликейшнээр зээл авах хандлага өндөр байгааг харуулж байна.

### *Хүснэгт 2.3. Орлогоос давсан зардал нөхсөн байдал, өрхийн төрөл, давхардсан тоо, хувиар*


| Эх үүсвэр                              | Ганц бие | Дан  | Нийлмэл | Өрөөсгөл |
|----------------------------------------|----------|------|---------|----------|
| Бусдаас зээлдэг (найз нөхөд, хамаатан) | 18.1     | 18.1 | 18.5    | 27.8     |
| Ломбардаас зээл авдаг                  | 2.6      | 6.3  | 8.0     | 6.0      |
| Банкнаас зээл авдаг                    | 35.2     | 55.2 | 61.8    | 43.9     |
| Хуримтлалаасаа зарцуулдаг              | 6.2      | 4.7  | 2.9     | 2.5      |
| ББСБ-аас зээл авдаг                    | 5.3      | 9.5  | 11.6    | 8.5      |
| Эд хөрөнгөө зарж борлуулдаг            | 1.9      | 5.1  | 2.9     | 1.9      |
| Эцэг эхээсээ тусламж авдаг             | 11.2     | 5.6  | 5.3     | 8.9      |
| Аппликейшнээс зээл авдаг               | 17.4     | 17.6 | 27.2    | 14.7     |
| Илүү зардал гардаггүй                  | 33.3     | 16.7 | 10.3    | 20.6     |
| Бусад                                  | 1.7      | 1.8  | 1.1     | 2.5      |

Судалгаанд оролцогчдын 72.1 хувь нь одоогийн байдлаар ямар нэгэн зээлтэй байна. Зээлтэй байх хувь нь хот болон хөдөөгийн иргэдийн хувьд төдийлөн ялгаагүй байгаа бөгөөд хотод амьдардаг оролцогчдын 70.6%, хөдөөд амьдардаг оролцогчдын 73.1% нь зээл авсан байна.

Насны бүлгээр авч үзвэл 18-34 насны иргэдийн 74.8 хувь нь, 35-49 насны иргэдийн 74.1 хувь нь, 50 ба түүнээс дээш насны иргэдийн 65.8 хувь нь зээлтэй байна. Үүнээс харахад иргэдийн дунд байршил, насны бүлгээс үл хамааран зээлтэй байх хувь нь илүү байгаа бол 50-аас дээш настай иргэдийн хувьд зээл авах нь залуу болон дунд насны бүлгийнхнээс 10 пунктээр бага байна.




Зураг 2.23. Зээлтэй иргэд, байршил, насны бүлэг, хувиар



Судалгаанд оролцогчдын авсан зээлийн төрлөөр нь харвал гурван хүн тутмын нэг нь буюу 51.9 хувь цалингийн зээл авсан байна. Байршлаас шалтгаалан иргэдийн зээл авах хэлбэр, төрлүүд тодорхой хэмжээнд ялгаатай байгаа нь ажиглагдаж байна. Тухайлбал, хөдөө орон нутагт амьдарч байгаа оролцогчдын дунд цалингийн, малчны болон тэтгэврийн зээл авах нь харьцангуй өндөр хувьтай байна. Харин нийслэл хотын иргэдийн хувьд санхүүгийн аппликейшн ашиглан зээл авах болон орон сууцны зээл авах тохиолдол илүү түгээмэл байна.

Зураг 2.24. Судалгаанд оролцогчдын авсан зээлийн төрөл, байршил, давхардсан тоо, хувиар




Өрхийн орлого өмнөх онтой харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөн талаар тодруулахад 43.4 хувь нь өөрчлөгдөөгүй, 31.3 хувь нь өссөн, 23.2 хувь нь буурсан гэж үзсэн бол орлогын өөрчлөлтөө мэдэхгүй гэсэн иргэд 2.1 хувийг эзэлж байна.

Байршлын хувьд өрхийн дундаж орлого нь өмнөх онтой харьцуулахад өссөн гэсэн хариултыг хөдөө орон нутгаас судалгаанд оролцогчдын 32.3 хувь нь өгчээ.



Өрхийн орлого өссөн оролцогчдыг насны бүлгээр авч үзвэл 18-34 насны залуучууд хамгийн өндөр буюу 55.1 хувийг, 35-49 насны дунд насныхан 25.6 хувийг, 50-аас дээш насныхан 19.3 хувийг эзэлж байна.

**Зураг 2.25. Өрхийн дундаж орлогын өөрчлөлт, байршил, насны бүлэг, хувиар**



Судалгаанд оролцогчдоос амьдралаа сайжруулахын тулд хийхээр төлөвлөж буй зүйлсийг тодруулахад 50.5 хувь нь өрхийн нэмэгдэл орлоготой болох, 32.6 хувь нь байр худалдан авах, засаж сайжруулах, 25.0 хувь нь өр зээлээ төлөхийг чухалчилж байна.

**Зураг 2.26. Судалгаанд оролцогчдын амьдралаа сайжруулах төлөвлөлт, давхардсан тоо, хувиар**



Амьдралаа сайжруулахын тулд хийхээр төлөвлөж буй зүйлс нь байршил, насны бүлэг үл харгалзан өрхийн нэмэгдэл орлоготой болох, байр худалдан авах, засаж сайжруулах, өрөө төлөх төлөвлөгөө нийтлэг өндөр байгаа ч 18-34 насны залуучууд гадаад улс руу шилжин суурьших, 35-49 насны оролцогчид ажилтай болох харин 50-аас дээш насныханы хувьд бусад насны иргэдээс ялгаатай нь амьдрал харьцангуй тогтворжсон байгаатай холбоотой юм.





Үүнээс үзэхэд дунд насныхан залуучуудтай харьцуулахад амьдралын хэв маяг нь харьцангуй тогтворжсон, цаашдын орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэх, сайжруулахад илүү анхаарч байгаа нь харагдаж байна. Харин залуу насныхан өөрсдийн амьдрах газар, байр сууцаа сонгох, бэлтгэх чиглэлд илүүтэй төлөвлөлт хийж байгаагаар ялгарч байна.

*Хүснэгт 2.4. Судалгаанд оролцогчдын амьдралаа сайжруулах төлөвлөлт, насны бүлэг, хувиар*

| Төлөвлөж буй зүйлс                    | 18-34 нас | 35-49 нас | 50+ нас |
|---------------------------------------|-----------|-----------|---------|
| Гадаадад гарч амьдрах                 | 26        | 18        | 7       |
| Хот суурин газар руу шилжих           | 8         | 5         | 3       |
| Хөдөө орон нутаг руу шилжих           | 5         | 5         | 3       |
| Байр худалдан авах, засах, сайжруулах | 38        | 30        | 28      |
| Эд хогшил авах, солих, өмчтэй болох   | 7         | 8         | 8       |
| Ажилтай болох                         | 19        | 20        | 15      |
| Өрхийн нэмэгдэл орлоготой болох       | 54        | 55        | 40      |
| Өрөө төлөх                            | 24        | 26        | 26      |
| Зээл тусламж авах                     | 5         | 10        | 6       |
| Өөрийн газартай болох                 | 22        | 19        | 19      |
| Бусад                                 | 8         | 9         | 17      |



## БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

“Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, өөрчлөлт” судалгаа нь Монгол улсын хэмжээнд газарзүйн төлөөллийг хангасан байдлаар 10 аймаг, 30 сум, Улаанбаатар хотын 9 дүүрэг, 92 хороонд нийт 2184 өрх, гэр бүлийн гишүүдээс анкетын асуулгын аргаар, 172 гэр бүлийн гишүүнтэй ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлага хийсэн.

Судалгаанд Монгол гэр бүлийн түгээмэл дөрвөн хэлбэр болох дан гэр бүл, нийлмэл гэр бүл, өрөөсгөл гэр бүл, ганц бие гэр бүлийг хамруулсан. Мөн судалгаанд оролцсон өрхүүдийг насны ангиллаар авч үзэхэд: 42.4 хувь нь залуу гэр бүл (18-34 нас), 30.3 хувь нь дунд насны гэр бүл (35-49 нас), 27.3 хувь нь ахмад үеийн гэр бүл (50 ба түүнээс дээш нас) байна.

Судалгаанд хамрагдагсдын 56.2 хувь нь эмэгтэй, 43.8% эрэгтэй байна. Гэр бүлийн гишүүдийн насыг хүйсийг харьцааг харахад 50 наснаас дээш гэр бүлд өрхийн тэргүүн нь эмэгтэйчүүд зонхилж байгаа бөгөөд энэ нь эрэгтэйчүүд дундаж наслалт эмэгтэйчүүдийнхээ бага, зөрүүтэй байгааг нотлон харуулж байна.

Өрхүүдийн 40.4 хувь нь Улаанбаатар хотод, 59.6 хувь нь хөдөө орон нутагт амьдарч байгаа бөгөөд үүнээс 21.9 хувь нь аймгийн төвд, 33.4 хувь нь сумдад, 4.3 хувь хөдөө багт оршин суудаг.

Судалгаанд оролцсон гэр бүлийн гишүүдийн боловсролын түвшний хувьд 47.1 хувь нь бүрэн болон бүрэн бус дунд боловсролтой бол 37.5 хувь бакалавр болон түүнээс дээш боловсрол эзэмшсэн байна. Мөн 10.6 хувь нь техникийн болон тусгай дунд боловсролтой, харин 4.8 хувь нь бага боловсролтой эсвэл боловсролгүй байна. Эхнэр нөхрүүдийн боловсролын түвшин ихэвчлэн ижил байна. Гэр бүлийн гишүүдийн боловсролын түвшин нэмэгдэхийн хэрээр гэр бүлийн хосууд ижил боловсролын түвшинд байх хандлага нэмэгдэж байгаа нь ажиглагдсан бөгөөд энэ нь боловсролын түвшин нь гэр бүлийн харилцаа, сонголтод нөлөөлөх чухал хүчин зүйлсийн нэг болохыг илтгэнэ.

Судалгаанд хамрагдсан гэр бүлүүд нь дунджаар 4 гишүүнтэй, 65 гаруй хувь нь 10 болон түүнээс жил хамтран амьдарч буй гэр бүлүүд байгаа бөгөөд гэр бүл болсон иргэдийн 85 хувь нь гэрлэлтээ албан ёсоор батлуулсан байна. Түүнчлэн гэр бүл бологсдын 98 хувь гэрлэлтийн болон эд хөрөнгийн талаар ямар нэгэн гэрээ хийгээгүй байгаа нь гэрлэлтийн өмнө болон гэрлэлттэй байх хугацаандаа өмч хөрөнгийн харилцаагаа тодорхой болгох, ирээдүйд маргаан гарахаас урьдчилан сэргийлэх зэрэг ач холбогдлыг хараахан чухалчилж үздэггүй байна.



Судалгаанд хамрагдсан оролцогчдын 94.1 хувьд гэр бүлийн гишүүн нь гадаад улсад амьдарч байгааг мэдээлсэн байна. Монгол гэр бүлийн гишүүдийн гадаадад амьдрах, боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх тоо нэмэгдэж байгаа нь нийгэм, эдийн засгийн гүн гүнзгий хүчин зүйлсийн нөлөөтэй байна. Олон залуучууд болон гэр бүлийн гишүүд илүү боломжийг гадаадад эрэлхийлж байгаа нь бодлогын түвшинд авч үзэх асуудал болохыг харуулж байна.

Өрхийн оршин суугаа орон байрны хувьд ихэнх нь монгол гэр (33%) болон тусдаа хашаа байшин (35.1%) зэрэг энгийн сууцанд амьдарч байгаа нь хөдөө орон нутгийн болон хотын гэр хорооллын иргэд давамгайлж буйг харуулна. Харин төвлөрсөн халаалттай орон сууцанд амьдарч буй өрхүүдийн ихэнх нь хотод төвлөрсөн байгаа бөгөөд энэ нь амьдрах орчны ялгааг харуулж байна. Оролцогчдын ихэнх нь өөрийн болон хамаатан садны эзэмшлийн сууцанд амьдардаг бол харин бусдын сууцанд амьдарч буй хүмүүсийн дийлэнх нь 18-34 насны залуучууд байна. Энэ нь залуучуудын орон сууц худалдан авах санхүүгийн чадамж тааруу байгаа учраас түрээсийн болон бусдын сууцанд хамт амьдрах хэлбэрийг илүүд үзэж байна.

Өрхийн орлогын хувьд ихэнх нь 660 мянгаас 2 сая төгрөг хүртэлх өрхийн орлоготой, орлогын гол эх үүсвэр нь цалин байна. Нэмэлт орлогогүй, ганц эх үүсвэрт тулгуурласан орлоготой өрхийн тоо өндөр байгаа нь эдийн засгийн хувьд эмзэг байдалд оруулж байна. Орлогын ихэнх хэсэг нь хоол хүнс, хүүхдийн хэрэгцээ, өр зээл зэрэг зайлшгүй шаардлагатай зүйлд зарцуулагдаж байна. Иймд дундаж Монгол гэр бүл нэг хүүхэд өсгөхөд хэдий хэмжээний зардал гаргадаг тухай судалгаа шинжилгээний ажлыг хийх хэрэгцээ шаардлагатайг харуулж байна. Дан, нийлмэл, өрөөсгөл бүтэцтэй гэр бүлийн эцэг эхчүүд өөртөө зориулан зарцуулалт хийх боломжгүй, зөвхөн амьдралын өдөр тутмын хэрэгцээгээ хангах түвшинд амьдарч байна. Энэ нь өрхийн санхүүгийн тогтвортой байдал болон ирээдүйн хуримтлал үүсгэх бололцоог хязгаарлаж буйг харуулж байна.

Судалгаанд оролцогчдын ихэнх нь (72.1 хувь) ямар нэгэн хэлбэрийн зээлийн дарамттай амьдарч байгаа нь өрхийн санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна. Цалингийн зээл, санхүүгийн аппликейшний зээл, тэтгэврийн зээл зонхилж буй бол 18–34 насны залуучуудын дунд санхүүгийн аппликейшн ашиглан зээл авах хандлага өндөр байгаа нь санхүүгийн мэдлэг, зохистой хэрэглээний асуудал хөндөгдөж байгааг харуулж байна. Мөн албан бус зээлийн хэлбэр болох найз нөхөд, хамаатан саднаасаа зээл авах нь түгээмэл байгаа нь банк,



санхүүгийн байгууллагын зээлийн хүүгийн хэмжээнд асуудал байгааг илэрхийллээ.

Судалгаанд оролцогчдын дундаж орлого өмнөх онтой харьцуулахад буурсан байдал нь бага байгаа ч, хот суурин газарт орлого буурах хандлага илүүтэй ажиглагдаж байна. Иргэдийн хувьд амьдралын чанарыг сайжруулах хамгийн гол хүчин зүйл нь өрхийн орлогыг нэмэгдүүлэх шаардлага бөгөөд энэ нь өөрийн орон сууцтай болох, өр зээлээ барагдуулах хэрэгцээнээс үүдэлтэй байна. Энэ нь иргэдийн санхүүгийн зорилго нь суурь хэрэгцээг хангахад чиглэж буйг харуулж, орлогын тогтвортой байдал, орон сууцны хүртээмжийн асуудал чухал хэвээр байгааг илтгэж байна.

## БҮЛГИЙН ЗӨВЛӨМЖ

Эдгээр бодлогын зөвлөмжүүд нь судалгаагаар тодорхойлогдсон гэр бүлийн бүтцийн өөрчлөлт, эдийн засгийн нөхцөл байдал, амьдралын чанар, нийгмийн оролцоо зэрэг асуудлуудыг оновчтойгоор шийдвэрлэхэд чиглэнэ. Хэрэгжилтийн шатанд орон нутгийн онцлог, насны бүлэг, гэр бүлийн хэлбэр зэргийг харгалзан үзэх нь чухал юм.

### Орон сууцны хүртээмжийг сайжруулах бодлого

- Залуу гэр бүлүүдийн орон сууцтай болох боломжийг нэмэгдүүлэх тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх (түрээсийн орон сууц, урьдчилгааны уян хатан боломж, ипотекийн зээлийн хүртээмж болон зээлийн уян хатан нөхцөл);
- Гэр хорооллын бүсэд амьдрах нөхцөлийг сайжруулах замаар амьдрах орчны ялгааг бууруулах (дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ, ногоон байгууламж).

### Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр

- Залуучуудад зориулсан санхүүгийн боловсролын сургалтыг тогтмол зохион байгуулах, ялангуяа зээлийн зохистой хэрэглээ, хуримтлалын талаар мэдээлэл өгөх;
- Хүүхэд өсгөх зардлын судалгаа нийгэм, эдийн засгийн өөрчлөлттэй холбоотой тогтмол хийх;
- Санхүүгийн аппликейшнээр зээл авч буй хүмүүсийн эрсдэлтэй зан үйл, өрийн дарамтыг бууруулах арга хэмжээ авах, хэрэглээний зээлийн хүү, нөхцөлд хяналт тавих.

### Орлогын эх үүсвэрийг төрөлжүүлэх дэмжлэг

- Өрхийн нэмэлт орлого бий болгох боломжийг нэмэгдүүлэх (гэрээсээ ажиллах боломж, жижиг бизнесийн дэмжлэг, орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн төсөл);



### **Гэр бүлийн харилцаа ба нийгмийн дэмжлэг**

- Гэр бүлийн бүтэц, харилцааны онцлогт тохирсон сэтгэлзүйн зөвлөгөө, дэмжлэгийн тогтолцоог нийслэл орон нутагт бий болгох;
- Өрөөсгөл, нийлмэл, ганц бие гэр бүлийг нийгмийн хамгааллын үйлчилгээ хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, хамруулах.

### **Боловсролын хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх**

- Гэр бүлийн гишүүдийн боловсролын түвшин нь гэр бүлийн дотоод харилцаа, тогтвортой байдалд нөлөөлж буй тул боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах;
- Насанд хүрэгчдийн боловсрол, мэргэжлийн сургалтыг дэмжих замаар гэр бүлийн амьжиргааны түвшинг тогтвортой нэмэгдүүлэх.

### **Гадаад руу чиглэсэн шилжилтийн шалтгааныг бууруулах**

- Гадаад дахь боловсрол, хөдөлмөрийн боломжийг эрэлхийлж буй урсгалыг дотооддоо шингээх боломж, орчныг бүрдүүлэх (дотоодын чанартай боловсрол, хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх);
- Гадаадад байгаа гэр бүлийн гишүүдтэй холбоотой нийгэм, эдийн засгийн үр нөлөөг судалж, бодлогын түвшинд авч үзэх шаардлагатай.

3

## ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ





## ГУРАВ. ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ


### 3.1. Гэр бүл төлөвлөлт

#### 3.1.1. Гэр бүлийн амьдралд бэлтгэх нь

Гэр бүл төлөвлөлт нь орчин үед чухлаар хөндөгдөж буй асуудал бөгөөд жил ирэх тусам залуучууд гэр бүл зохиох, хэзээ хэдэн хүүхэдтэй болох зэрэгт анхаарал хандуулж байна. Гэр бүл төлөвлөснөөр хүүхдийн эндэгдэл болон үр хөндөлт буурах, эх үрсийн эрүүл мэнд сайжрах, үргүйдлээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм.<sup>22</sup> Иймд гэр бүл төлөвлөлтийг дэмжих, гэр бүл төлөвлөлтийн боловсрол олгох зэрэгт онцгойлон анхаарал хандуулах шаардлага үүсээд байна.

Судалгаанд оролцогчдоос өнөөгийн залуучууд гэр бүлийн амьдралд хэр бэлтгэгдсэнийг тодруулахад 80.0 орчим хувь дунд болон муу гэсэн үнэлэлт өгчээ. Тухайлбал, дунд (72.0 хувь) болон ахмад насныхнаас (73.0 хувь) гадна залуучуудын дийлэнх нь (76.0 хувь) гэр бүлийн амьдралд тааруу бэлтгэгдсэн гэж хүлээн зөвшөөрсөн байна. Иймд залуучуудад гэр бүл төлөвлөлтийн талаар зөв ойлголт, мэдлэг, боловсролыг олгох нь чухал байна.

**Зураг 3.1. Өнөөгийн залуучууд гэр бүлийн амьдралд бэлтгэгдсэн эсэх, насны бүлэг, хувиар**



Судалгаанд оролцогчид залуу хүмүүсийг гэр бүлийн амьдралд бэлтгэхэд эцэг эхийн болон гэр бүлийн хүмүүжил чухал нөлөөтэй бөгөөд үүнд хоёр хүн тутмын нэг нь залууст зөв үлгэр дуурайлал үзүүлэх, хүүхдийг бие дааж амьдрах ухаанд сургах ёстой гэж хариулсан бол гурван хүн тутмын нэг нь залуучуудыг ёс суртахуунтай, хариуцлагатай хүн болгож төлөвшүүлэх хэрэгтэй хэмээн үзжээ.




**Зураг 3.2. Залуучуудыг амьдралд бэлтгэх нь, давхардсан тоо, хувиар**



Эрэгтэй болон эмэгтэй хүмүүсийн хувьд хэдэн насандаа гэр бүл зохиоход тохиромжтой талаар судалгаанд оролцогчдын 62.0 хувь нь эрэгтэй хүн 24-29 насандаа, 56.0 хувь нь эмэгтэй хүн харин 18-23 насандаа гэр бүл зохиоход тохиромжтой гэж хариулжээ. Оролцогчдын хариулсан байдлыг насны бүлгээр авч үзвэл нас ахих тусам эмэгтэйчүүдийг илүү залуу насандаа гэр бүл болохыг тохиромжтой гэж үзэж байв. Судалгаанд оролцсон эрэгтэйчүүдийн 62.0 хувь нь эрэгтэй хүн 24-29 насандаа гэрлэхэд тохиромжтой гэж үзсэн бол эмэгтэйчүүдийн 59.0 хувь нь эмэгтэй хүн 24-29 насандаа гэр бүл зохиох нь зүйтэй гэж дийлэнх нь үзжээ. Үүнээс харвал эрэгтэй эмэгтэй хүмүүс ялгаагүй дундаж гэрлэлтийн нас нь 24-29 нас байхад зохимжтой гэдэгтэй санал нэгдэж байна.

**Зураг 3.3. Гэр бүл зохиоход тохиромжтой нас, хүйс, насны бүлэг, хувиар**








Тогтвортой гэр бүл бүрдэхэд ямар нөхцөл шаардлагатай эсэхийг тодруулж асуухад хоёр хүн тутмын нэг нь “Санхүүгийн боломжтой болсон үед”, “Мэдлэг боловсрол, нийгэмд эзлэх байр суурьтай болсон үед” гэр бүл зохиох хэрэгтэй гэж үзсэн байна.

18-34 насны залуучууд нь санхүүгийн боломжтой болсон үедээ (57.6 хувь) болон эцэг эх болоход бэлэн болж (41.5 хувь), эхнэр нөхөртэйгөө тодорхой хугацаанд хамт амьдарч үзсэний (38.6 хувь) дараагаар гэр бүл зохиох нь зөв гэдэгт илүү санал өгчээ. 35-49 насны оролцогчдын хувьд хайртай хүнтэйгээ учирсан байх нь тогтвортой гэр бүл болохын үндэс хэмээн 31.7 хувь нь хариулсан нь бусад насны бүлгээс илүү байна. Харин 50-с дээш насны оролцогчдын үзэж буйгаар боловсрол, мэдлэгтэй, байр суурьтай болох (54.5 хувь), амьдралын ухаантай болсон үедээ (40.9 хувь) гэр бүлтэй болох нь тохиромжтой гэж харж байгаа юм.

Мөн ФБЯ-н хүрээнд оролцогчид гэр бүл болох хүнээ сонгохдоо хамт амьдарч нэгнээ сайн таньж байж гэр бүл болох, муу зуршилгүй, амьдралын төлөө хичээл зүтгэл гаргадаг, халамжтай түшигтэй хүнтэй гэр бүл болох нь чухал гэдгийг онцолж байв. Мөн ар гэрийг нь харах хэрэгтэй ч мөнгө санхүү харж суухаас илүүтэй нэг давхаргын хүнтэй гэр бүл болох нь зүйтэй гэж үзжээ.

Зураг 3.4. Тогтвортой гэр бүл болохын үндэс, нас, давтагдсан тоо, хувиар




Эмэгтэйчүүдийн хувьд боловсрол, мэдлэгтэй, нийгэмд эзлэх байр суурьтай болсон үед (51.9 хувь), сайн эцэг эх болох үед өөрийгөө бэлэн болсон үед (41.5 хувь) гэр бүл болох нь тохиромжтой гэж үзэж байсан бол эрэгтэйчүүд нь санхүүгийн боломжтой болсон үед (56.8 хувь) болон хайртай хүнтэйгээ учирсан үед (30.6 хувь) гэр бүл болох нь тохиромжтой гэж эмэгтэйчүүдээс илүү хариулжээ.




Мөн боловсролын түвшин бага байх тусмаа амьдралын ухаантай байхыг чухалчилж үзэж байхад, боловсролын түвшин ихсэх тусам сайн эцэг эх байхад төлөвшсөн байхыг болон хамт амьдарч нэгнээ танихыг чухалчилжээ.

Зураг 3.5. Залуучуудыг амьдралд бэлтгэх нь, давхардсан тоо, хувиар



Ганц бие оролцогчдоос гэр бүлийн амьдрал зохиоход шаардлагатай бэлтгэлийн талаар тодруулахад ихэнх нь буюу 67.2 хувь нь орон байртай болох, эдийн засгийн хувьд бие даасан байхад илүү ач холбогдол өгч байв.


Зураг 3.6. Ганц бие хүмүүсийн гэр бүл болоход шаардлагатай бэлтгэл, хувиар





Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын олонх буюу 58.0 хувь нь гэр бүл болохоос өмнө бэлгийн харилцаанд орохыг хүлээн зөвшөөрч байгаа нь бэлгийн болон ёс суртахууны талаарх үзэл хандлага нээлттэй болж, нийгмийн уламжлалт хэв загвараас өөрчлөгдөж байгааг харуулж байна. Харин 33.0 хувь нь үүнийг үл зөвшөөрч, уламжлалт үнэт зүйлсийг баримталж буйг илэрхийлж байгаа бөгөөд үлдсэн 9.0 хувь нь тодорхой байр суурьгүй байгаа нь энэ сэдвийн талаар төдийлөн сонирхоогүй анхаарал хандуулаагүй байна. Энэ нь гэр бүлийн боловсрол, бэлгийн хүмүүжил, нийгмийн үнэт зүйлсийн талаарх ойлголтыг цаашид өргөжүүлэх шаардлагатай байна.


*Зураг 3.7. Судалгаанд оролцогчдын гэр бүл болохоос өмнө бэлгийн харилцаанд орох талаарх бодол, нас, хувиар*



Энэ асуудалд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн үзэл бодлыг харвал эрэгтэйчүүдийн 48.0 хувь нь эрэгтэй хүн гэр бүл болохоос өмнө бэлгийн харилцаанд орох нь байж болох зүйл гэж үзэж байна. Харин гэр бүл болохоос өмнө бэлгийн харилцаанд орох нь огт байж болохгүй зүйл гэж үзэхдээ эмэгтэй хүнийг хориглох хандлага (24.2 хувь) нь эрэгтэй хүнийг хориглохоос (17.2 хувь) өндөр байв. Харин эмэгтэй оролцогчдын хариултаас харвал хэдийгээр гэр бүл болохоос өмнө бэлгийн харилцаанд орох нь байж болох зүйл гэж үзэж буй нь 38-41 хувиар харьцангуй их байгаа ч огт байж болохгүй зүйл хэмээн үзэж буй байдал нь эрэгтэйчүүдийн хариултаас өндөр гарчээ. Тухайлбал, гэр бүл болохоос өмнө бэлгийн харилцаанд орох нь эрэгтэйчүүдийн хувьд байж болохгүй 28.8 хувь, эмэгтэйчүүдийн хувьд байж болохгүй нь 37.7 хувь хэмээн эмэгтэй оролцогчид хариулжээ. Үүнээс харвал гэр бүл болохоос өмнөх бэлгийн харилцааны асуудал дээр эмэгтэйчүүд илүү хатуу хориг тавьсан, уламжлалт хандлагатай байна.




Зураг 3.8. Судалгаанд оролцогчдын гэр бүл болохоос өмнө бэлгийн харилцаанд орох талаарх бодол, оролцогчдын хүйс, хувиар



### 3.1.2. Хүүхэдтэй болох төлөвлөгөө

Зураг 3.9. Ойрын 3 жилийн хугацаанд хүүхэдтэй болох төлөвлөгөө, хүйс, хувиар




Ойрын гурван жилийн хугацаанд хүүхэдтэй болох төлөвлөгөөтэй байгаа оролцогчдын эзлэх хувь харьцангуй бага (19.1 хувь) байгаагаас үзэхэд төрөлтийн идэвх буурч байгаа хандлага ажиглагдаж байна. Хүйсийн хувьд шинжилж үзвэл эрэгтэйчүүдийн 25.0 хувь нь, эмэгтэйчүүдийн 14.0 хувь нь хүүхэдтэй болохоор төлөвлөж байна. Таван эмэгтэй тутмын дөрөв нь хүүхэдтэй болохгүй гэж төлөвлөжээ.

Түүнчлэн гэр бүлийн бүтэц нь хүүхэдтэй болох шийдвэрт тодорхой нөлөө үзүүлдэг бөгөөд дан гэр бүлүүдийн хувьд хүүхэдтэй болох хандлага бусад төрлийн гэр бүлтэй харьцуулахад илүү өндөр байна. Энэ нь гэр бүлийн бүтэц, амьдралын нөхцөл байдал, хувь хүний зорилго төлөвлөгөө зэрэг хүчин зүйлс төрөх хүсэлд нөлөөлж байгааг харуулж байна.



Зураг 3.10. Ойрын 3 жилийн хугацаанд хүүхэдтэй болох төлөвлөгөө, гэр бүлийн төрөл, хувиар



Хүүхэдтэй болохоор төлөвлөөгүй гэж хариулсан нийт оролцогчдын хүүхэдтэй болохгүй гэх шийдвэрт нөлөөлж буй хүчин зүйлүүдэд нас ахисан 33.0 хувь, гэр бүлийн хүн нас барсан болон цуцалсан байх 25.0 хувь, ганц бие нас залуу 9.5 хувьтайгаар дараах шалтгаанууд давамгайлж байгаа бол хүүхэдтэй болох боломжтой хүмүүсийн хувьд нас залуу байх, хангалттай хэмжээнд хүүхэдтэй болсон байгаа болон эдийн засгийн хувьд боломжгүй байна зэрэг хариултуудыг өгч байв.

Хүүхэдтэй болохгүй байх шийдвэрт нөлөөлж буй шалтгаан нь эрэгтэй эмэгтэй хүмүүст хэрхэн ялгаатай байгааг шинжлэхэд эрэгтэйчүүдийн хувьд нас ахисан (38.9 хувь), гэрлээгүй, нас залуу (11.0 хувь), ажлын байдлаас болсон (6.7 хувь) зэрэг нь эмэгтэйчүүдээс илүү шалтгаан болж байна. Харин эмэгтэйчүүдийн хувьд бэлэвсэн (17.2 хувь), цуцалсан (14.0 хувь), эрүүл мэндийн хувьд боломжгүй (6.6 хувь) зэрэг нь эрэгтэйчүүдтэй харьцуулахад илүү их хувьтай байгаа шалтгаанууд байна.




Зураг 3.11. Хүүхэдтэй болохгүй байх шалтгаан, хүйс, давтагдсан тоо, хувиар



Судалгаанд хамрагдсан гэр бүлийн эхнэр буюу төрөх насны эмэгтэйчүүдийн 53.8 хувь нь жирэмснээс сэргийлэх ямар нэг арга хэрэгсэл ашигладаггүй, харин жирэмснээс сэргийлэх арга хэрэгсэл ашигладаг оролцогчдын хувьд 28.9 хувь нь ерөндөг, тариа суулгац, 10.8 хувь нь бэлгэвч, хуанли, 1.4 хувь нь мэс заслын аргаар сэргийлдэг гэж хариулсан байна. Жирэмснээс сэргийлэх арга хэрэгсэл ашигладаггүй гэж хариулсан оролцогчдыг 100 хувь гэж үзвэл 30 хувь нь өрөөсгөл гэр бүлийн гишүүд бөгөөд ихэвчлэн бэлгийн идэвхтэй харилцаа байхгүй хэмээн ярьж байв. Хэдийгээр оролцогчдын дунд хүүхэдтэй болох төлөвлөгөө байхгүй ч жирэмснээс хамгаалах арга хэрэгсэл ашиглахгүй байгаа нь бэлгийн боловсрол, гэр бүл төлөвлөлтийн боловсрол дутмаг байгааг харуулж байна.

Зураг 3.12. Жирэмснээс сэргийлэх арга хэрэгсэл ашиглах байдал, хувиар






Эдийн засагч Мукеш Эсваран “Эдийн засагт яагаад жендэр чухал гэж?” номдоо тайлбарлахдаа эдийн засгийн чадамж нь хүмүүсийн хүүхдийг үнэлэх үнэлэмжийг тодорхойлох үзүүлэлт мөн бөгөөд төрөлтийг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг<sup>23</sup> гэжээ. Түүний үзэж буйгаар эдийн засгийн хөгжил өндөр улсад хүүхэдтэй болох шийдвэр нь сэтгэлзүйн хүчин зүйлээс бүрддэг бол хөгжиж буй орнуудад эцэг эхчүүд нийгэмдээ итгэл муутай байдаг тул хүүхдийг өндөр насандаа дэмжүүлэх баталгаа гэж үздэг. Эцэг эх нь үр хүүхдийнхээ бага насанд зардал гаргаж, насанд хүрсэн хойно нь үр шимийг хүртэнэ. Иймд тэтгэвэртээ гарсны дараа хүүхдийн дэмжлэг шаардлагатай гэж үздэг учраас төрөлтийн хэмжээ өндөр байх нь хөгжиж буй орнуудад түгээмэл үзэгдэл юм.

Судалгаанд оролцогчдын 70 орчим хувь нь гэр бүл дунджаар 3-4 хүүхэдтэй байвал зохимжтой гэж үзсэн бөгөөд насны бүлгээс шалтгаалан хэдэн хүүхэдтэй байх нь зохимжтойг тодруулахад хэдийгээр дийлэнх оролцогчид 3-4 хүүхэдтэй байх нь зохимжтой гэдэгтэй санал нэгдэж байсан ч залуучууд илүү бага тооны хүүхэдтэй байхыг (1-2 хүүхэд 18.7 хувь) илүүд үзэж байгаа бол 50-с дээш насныхан илүү олон хүүхэдтэй байх нь зохимжтой (5-6 хүүхэд 16.8 хувь) гэж хариулсан байна. Тус хандлага нь мөн хүйс дээр илэрсэн нь 1-2 хүүхэд зохимжтой гэж үзэж буй эмэгтэйчүүд 15.8 хувь, эрэгтэйчүүд 13.3 хувь, 5-6 хүүхэдтэй байхыг илүүд үзэж буй эмэгтэйчүүд 12.1 хувь, эрэгтэйчүүд 15.3 хувь байна.


Зураг 3.13. Гэр бүлийн зохимжит хүүхдийн тоо, нас, хүйс, хувиар



Мөн боловсролын зэргээс шалтгаалан хүүхэд төлөвлөлтөд тодорхой ялгаа ажиглагдсан. Тухайлбал, боловсролын түвшин ахих тусам зохимжит хүүхдийн тоо багасаж, бүрэн бус дунд болон түүнээс доош боловсролын зэрэгтэй оролцогчдын дунд 5-аас дээш хүүхэдтэй байх гэсэн хариултууд зонхилжээ.




Зураг 3.14. Гэр бүлийн зохимжит хүүхдийн тоо, боловсролын түвшин, хувиар



Төрөлт хоорондын зайн хэдэн жил байвал зохимжтой вэ гэх асуултад нийт оролцогчдын 65 хувь нь 3-4 жил байвал тохиромжтой гэж үзжээ. Үүнээс эмэгтэйчүүдийн 68.2 хувь нь 3-4 жил, 20.7 хувь нь 1-2 жил, 10.4 хувь нь 5-10 жил байх нь зохимжтой гэж үзсэн бол эрэгтэйчүүдийн 60.3 хувь нь 3-4 жил, 31.9 хувь нь 1-2 жил, 7.1 хувь нь 5-10 жил гэх байр суурьтай байв. Үүнээс харвал эмэгтэйчүүд нь хүүхэд хоорондын зайг илүү хол байх тусам тохиромжтой гэж хариулжээ.

Зураг 3.15. Төрөлт хоорондын зай, хүйс, хувиар




Харин боловсролын түвшнээр харьцуулсан үр дүнг харвал дээд ба түүнээс дээш боловсролтой оролцогчдын 18.8 хувь нь 1-2 жил, 69.1 хувь нь 3-4 жил, 11.8 хувь нь 5-10 жил бол бүрэн бус дунд хүртэлх боловсролтой оролцогчдын хувьд 33.3 хувь нь 1-2 жил, 56.9 хувь нь 3-4 жил, 7.8 хувь нь 5-10 жил гэж хариулжээ. Үүнээс харвал боловсрол өндөр байх тусам төрөлт хоорондын зай уртсах хандлага ажиглагдаж байна.





Клиникийн нийгмийн ажилтан, сэтгэл судлаач Эрика Комисар нь “*Being There: Why Prioritizing Motherhood in the First Three Years Matters*”<sup>24</sup> номдоо хүүхдийг 3 нас хүртэл нь өөр хүүхэдтэй нийгмийн харилцаанд оруулах шаардлагагүй бөгөөд эцэг эхээсээ 100 хувь анхаарал халамжийг авч байх ёстой үе гэж тэмдэглэжээ. Учир нь 3 нас хүртлээ хүүхэд эцэг эхээсээ сэтгэлзүйн бүх хэрэгцээгээ авч байдаг ба аюулгүй ээнэгшлийн холбоог үүсгэж байдаг бөгөөд хэрэв эцэг эхээсээ авч буй анхаарал нь хуваагдвал хөгжил нь зогсолтод орох эрсдэлтэй юм. Иймд хүүхэд хоорондын зай багадаа гурван нас байх нь илүү зохимжтой байна.

Зураг 3.16. Төрөлт хоорондын зай, боловсролын түвшин, хувиар



### 3.2. Гэр бүлийн үүрэг, хариуцлага

Гэр бүлийн өрхийн тэргүүн нь аль гишүүн байвал зохимжтой байх талаар асуухад оролцогчид гэр бүлийн төрөл, орлого, боловсролын зэрэг, хүйс, өрхийн байршлаас шалтгаалан ялгаатай үзэл бодолтой байна. Үүнд:

- Өрхийн тэргүүнийг тодорхойлоход гэр бүлийн төрөл нөлөөлж буйг статистикийн шинжилгээнээс харж болно (Хи квадрат тест:  $p=.000$ ). Нөхөр нь өрхийн тэргүүн байхыг дан гэр бүлийн гишүүд илүүд үзэж байгаа бол өрөөсгөл гэр бүлийн гишүүд 24.0 хувиар бага байна. Харин өрөөсгөл гэр бүлийн хувьд эхнэр нь өрхийн тэргүүн байхыг илүү зохимжтой гэж үзсэн тохиолдол өндөр байгаа нь Монгол улсын өрх толгойлсон ганц бие эцэг эсвэл эхийн 82.0 хувийг эмэгтэйчүүд эзэлж буйтай<sup>25</sup> холбоотой юм. Гэр бүлийн ахмад настай гишүүн нь өрхийн тэргүүн байх нь зохимжтой гэж үзэж буй оролцогчдын дунд нийлмэл болон ганц биеэрээ амьдарч буй иргэдийн хувь харьцангуй өндөр байна. Харин өрөөсгөл болон ганц бие өрхийн хувьд хэн ч байж болно, өрхийн тэргүүнийг заавал тодорхойлох шаардлагагүй гэсэн хандлага давамгайлж байна.

<sup>24</sup> Komisar, E. (2017). Being there: Why prioritizing motherhood in the first three years matters.

<sup>25</sup> 1212.mn, Өрх толгойлсон ганц бие эцэг, эх, 2023 он.

[https://www2.1212.mn/tables.aspx?TBL\\_ID=DT\\_NSO\\_3300\\_044V1](https://www2.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_3300_044V1)



- Тухайн өрхийн орлогоос хамаарч өрхийн тэргүүнийг тодорхойлох хандлага ялгаатай байна. Судалгааны үр дүнгээс харвал өрхийн орлого нэмэгдэх тусам өрхийн тэргүүнийг нөхөр байх нь зүйтэй гэж харж байгаа бол эсрэгээрээ өрхийн орлого багасах тусам өрхийн тэргүүнийг эхнэр хүн байвал зохистой гэж үзсэн байна. Тус үзүүлэлтүүдэд нэг талт ANOVA тестээр шалгахад статистикийн хувьд үнэмшилтэй үр дүн гарсан ( $F(5, 2178)=11.338, p=.000$ ). Энэ нь орлогоос хамаарч өрхийн тэргүүнийг хэн байх ёстой гэсэн үзэл бодолд нөлөө үзүүлж байгааг харуулж байна. “Post hoc” шинжилгээгээр аль бүлгүүдийн хооронд ялгаа илэрч байгааг харахад нөхөр гэж сонгосон өрхийн орлого бусад сонголтыг хийсэн өрхүүдээс статистикийн хувьд илүү өндөр байсан бөгөөд энэ нь хи квадрат тестийн үр дүнгээр баталгаажсан (хи квадрат тест  $p=.000$ ) юм.
- Боловсролын зэргээс шалтгаалан өрхийн тэргүүнийг сонгох хандлага ялгаатай байгааг хи квадрат тестээр шалгахад статистикийн хувьд үнэмшилтэй байна (хи тест  $p=.000$ ). Судалгааны үр дүнд боловсролын зэрэг өндөр байх тусам өрхийн тэргүүн нөхөр байх нь зохимжтой гэж үзэж байсан бол эсрэгээрээ боловсролын зэрэг багасах тусам эмэгтэй хүн болон ахмад хүн байх нь зөв гэж үзэх хандлага илүүтэй илэрчээ.
- Хүйсээс хамааран өрхийн тэргүүн хэн байхыг илүүд үзэх хандлага мөн ялгаатай байгаа юм (хи тест  $p=.001$ ). Эрэгтэйчүүд илүүтэйгээр нөхөр хүнийг сонгож байсан бол эмэгтэйчүүд эхнэр хүнийг сонгох нь өндөр байна.




Хүснэгт 3.1. Өрхийн тэргүүн хэн байвал зохимжтой эсэх, хувиар

| Зарлагын төрөл<br>Дундаж |                          | Нөхөр | Эхнэр | Ахмад<br>хүн | Ихэнх<br>орлого<br>олдог | Хэн ч<br>байж<br>болно | Бусад | Нийт |
|--------------------------|--------------------------|-------|-------|--------------|--------------------------|------------------------|-------|------|
| Гэр бүлийн<br>төрөл      | Ганц бие                 | 73    | 4     | 5            | 4                        | 12                     | 1     | 100  |
|                          | Дан                      | 89    | 3     | 1            | 1                        | 6                      | 1     | 100  |
|                          | Нийлмэл                  | 79    | 4     | 7            | 1                        | 9                      | 0.4   | 100  |
|                          | Өрөөсгөл                 | 65    | 13    | 4            | 3                        | 14                     | 1     | 100  |
| Орлого                   | 700 мян хүртэл           | 69    | 10    | 6            | 4                        | 10                     | 1     | 100  |
|                          | 700 мян-1,1 сая          | 72    | 10    | 5            | 3                        | 9                      | 1     | 100  |
|                          | 1,1 сая-2,1 сая          | 76    | 5     | 5            | 2                        | 11                     | 1     | 100  |
|                          | 2,1 сая-4 сая            | 83    | 3     | 3            | 2                        | 9                      | 1     | 100  |
|                          | 4 саяаас дээш            | 85    | 2     | 2            | 1                        | 11                     | 1     | 100  |
| Боловсрол                | Бүрэн бус дунд<br>хүртэл | 68    | 9     | 9            | 1                        | 12                     | 0.4   | 100  |
|                          | Бүрэн дунд               | 77    | 7     | 4            | 2                        | 9                      | 1     | 100  |
|                          | Техник, тусгай           | 75    | 7     | 5            | 3                        | 10                     | 0.4   | 100  |
|                          | Дээд ба түүнээс<br>дээш  | 79    | 3     | 2            | 2                        | 11                     | 1     | 100  |
| Хүйс                     | Эрэгтэй                  | 80    | 4     | 5            | 2                        | 10                     | 1     | 100  |
|                          | Эмэгтэй                  | 75    | 8     | 4            | 3                        | 10                     | 1     | 100  |

Өмнөх жилүүдэд хийгдсэн эл судалгааны үр дүнд өрхийн тэргүүн хэн байвал зохимжтой эсэхийг асуусан бөгөөд 2010 оноос хойш судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь нөхрийг өрхийн тэргүүн байх нь зохимжтой гэж үзсээр байгаа ч энэхүү хандлага өнгөрсөн жилүүдээс харьцангуй буурсан. Харин эхнэр болон хэн ч байж болно гэсэн хандлагууд бага зэрэг өссөн бол ахмад хүн байх нь зөв гэсэн үзэл буурчээ.

Зураг 3.17. Өрхийн тэргүүн хэн байвал зохимжтой эсэх, өнгөрсөн он, хувиар





Судалгаанд оролцогчдын 25.2 хувь нь “өрхийн тэргүүн” нь амьдралын ноён нуруутай, ухаалаг мэдлэг боловсролтой байх ёстой гэж үзсэн бол 21.9 хувь нь гэр бүлдээ халамжтай, гэр бүлийнхээ өмнө үүрэг хариуцлага хүлээх чадвартай байхыг чухалчилсан байна. Харин 8.8 хувь нь өрхийн тэргүүн нь гэрийн ажлын ихэнхийг хийж, орлого олдог, өрхийн асуудлыг шийддэг байх ёстой, гол орлогыг олж, мөнгө санхүүг голлон хуваарилж тооцох үүрэгтэй гэж үзжээ. Үүнээс үзэхэд, монгол гэр бүлийн өрхийн тэргүүнд олон талын үүрэг, хариуцлагыг хүлээлгэдэг, гэр бүлийн тогтвортой байдлыг хангах гол ачааг үүрүүлэх хандлага түгээмэл байгааг харуулж байна.

Сүүлийн 15 жилийн хугацаанд өрхийн тэргүүний голлох үүрэгт иргэдийн үзэл бодол өөрчлөгдсөн эсэхийг харьцуулахад “Амьдралын нуруутай, ухаалаг, овсгоотой байх”, “Гэр бүлдээ хайр халамжтай, нэр хүндтэй байх” чанарууд нь 2010 оноос хойш өндөр хувийг эзэлсээр байгаа бөгөөд гэр бүлдээ хайр халамжтай байх чанар нь өнгөрсөн онуудаас илүү өсөж чухалд тооцогдож эхэлжээ.

**Зураг 3.18. Өрхийн тэргүүний хамгийн гол үүрэг, хувиар**



Нас, хүйс, боловсролын түвшнээр өрхийн тэргүүний гол үүргийн талаар авч үзвэл:

- Боловсролын түвшин нэмэгдэхийн хэрээр өрхийн тэргүүнд тавигдах шаардлагуудын дотор гэр бүлдээ хайр, халамжтай, нэр хүндтэй, мэдлэг боловсрол өндөртэй байх шалгуурууд илүү чухал байр суурь эзэлж байна.
- Боловсролын түвшин бага байх тусам гэр орны ажлыг зохион байгуулж байх нь илүү чухалд тооцогдож байна.
- Насны хувьд залуу оролцогчид өрхийн тэргүүнийг гэр бүлдээ хайр, халамжтай нэр хүндтэй байх хэрэгтэй гэж үздэг бол харин нас ахихын хэрээр гэр орны ажилд түлхүү оролцох, түүнийг зохицуулах үүргийг чухалчлах хандлага ажиглагдаж байна.



- Мөн судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн ихэнх нь өрхийн тэргүүн гэр бүлдээ хайр халамжтай, нэр хүндтэй байх ёстой гэсэн үзэл бодлыг түлхүү илэрхийлжээ.

### Хүснэгт 3.2. Өрхийн тэргүүний гол үүрэг, хувиар

| Өрхийн тэргүүний гол үүрэг |                       | Амьдралын нуруутай, ухаалаг, овсгоотой | Гэр бүлдээ хайр, халамжтай, нэр хүндтэй | Гэр бүлийн өмнө хариуцлага хүлээдэг | Гэр орны ажлыг голлон зохицуулдаг | Өрхийн орлогын ихэнхийг олдог | Өрхийн тооцоог барьдаг | Асуудлыг голлож шийддэг | Мэдлэг боловсрол өндөр | Нийт |
|----------------------------|-----------------------|----------------------------------------|-----------------------------------------|-------------------------------------|-----------------------------------|-------------------------------|------------------------|-------------------------|------------------------|------|
| Боловсрол                  | Бүрэн бус дунд хүртэл | 62                                     | 43                                      | 42                                  | 29                                | 20                            | 20                     | 14                      | 7                      | 100  |
|                            | Бүрэн дунд            | 60                                     | 51                                      | 46                                  | 26                                | 21                            | 16                     | 13                      | 7                      | 100  |
|                            | Техник, тусгай        | 63                                     | 51                                      | 51                                  | 21                                | 20                            | 17                     | 15                      | 5                      | 100  |
|                            | Дээд ба түүнээс дээш  | 64                                     | 62                                      | 51                                  | 15                                | 18                            | 16                     | 12                      | 15                     | 100  |
| Нас                        | 18-34 нас             | 63                                     | 57                                      | 50                                  | 17                                | 18                            | 16                     | 13                      | 13                     | 100  |
|                            | 35-49 нас             | 60                                     | 56                                      | 48                                  | 23                                | 22                            | 16                     | 11                      | 8                      | 100  |
|                            | 50+ нас               | 63                                     | 47                                      | 45                                  | 28                                | 20                            | 18                     | 16                      | 7                      | 100  |
| Хүйс                       | Эрэгтэй               | 61                                     | 50                                      | 47                                  | 24                                | 18                            | 17                     | 14                      | 10                     | 100  |
|                            | Эмэгтэй               | 63                                     | 57                                      | 48                                  | 20                                | 21                            | 16                     | 12                      | 11                     | 100  |

Гэр бүлийн доторх үүргийн хуваарилалт хэрхэн явагддаг, аль гишүүд ялгаатай байдлаар үүрэг хүлээдэг талаар судалсан бөгөөд үүргийн хуваарилалтыг гэр бүлийн төрлөөр харьцуулан шинжиллээ. Судалгаанд гэр бүлийн үүргүүдийг дараах төрлөөр ангилан авч үзсэн. Үүнд:

- Хүүхдийг сурган хүмүүжүүлэх, гэр бүлийн гишүүдийн боловсролд анхаарах үүрэг
- Гэр бүл дэх хөдөлмөрийн хуваарилалт
- Гэр бүл дэх эрх мэдлийн хуваарилалт
- Бусад үүргүүд

Хүүхдийг сурган хүмүүжүүлэх, гэр бүлийн гишүүдийн боловсролд анхаарах үүргүүд

Гэр бүлийн гишүүддээ ёс заншил, уламжлалыг зааж сургах, хүүхэд хүмүүжүүлэх, гэр бүлийн гишүүдийнхээ боловсролд анхаарал тавих үүргүүдийг голчлон эхнэр, нөхрүүд хамтдаа гүйцэтгэж байна. Харин гэр бүлийн төрлөөс шалтгаалан дараах ялгаанууд гарсан. Судалгаанд хамрагдсан дан гэр бүлийн 50 хувь нь заншил, уламжлалыг гэр бүлийн гишүүдэд зааж сургах үүргийг эхнэр нөхөр хамтдаа гүйцэтгэдэг гэж хариулсан бол 26 хувь нь нөхөр, 19 хувь нь эхнэр гэж хариулжээ.



Нийлмэл өрхүүдийн хувьд тус үүргийг 44 хувь нь эхнэр, нөхөр хамтдаа, 23 хувь нь нөхөр, 17 хувь нь эхнэр гүйцэтгэж байна. Өрөөсгөл өрхөд 20 хувь нь эхнэр, 10 хувь нь нөхөр, 35 хувь нь гэр бүлийн гишүүдтэйгээ хамтдаа, 20 хувь нь бусад гишүүд зааж сургаж байна. Үүнээс харахад гэр бүлийнхэндээ ёс заншил, уламжлалыг дан болон нийлмэл гэр бүлийн нөхрүүд эхнэрийг бодвол арай илүүтэйгээр зааж сургаж байгаа бол өрөөсгөл гэр бүлийн эхнэрүүд зааж сургаж байна. Энэ нь өрөөсгөл гэр бүлд өрх толгойлсон эмэгтэйчүүд илүү өндөр хувьтай байгаа холбоотой байж болох юм. Харин гэр бүлийн төрлийн онцлогоос шалтгаалан бусад гишүүд тухайн үүрэгт оролцох байдал нь нийлмэл болон өрөөсгөл гэр бүлүүдэд түлхүү ажиглагдаж байна.

Хүүхэд хүмүүжүүлэх тал дээр дан гэр бүлийн эхнэрүүд илүүтэй оролцдог байдал 43 хувь, нөхрүүд оролцдог нь 9 хувь, эхнэр нөхрүүд хамтдаа оролцдог 44 хувьтай байна. Харин нийлмэл гэр бүлийн хувьд эхнэр нөхрүүд хамтдаа хүүхдээ хүмүүжүүлдэг 43 хувь, эхнэрүүд хүмүүжүүлдэг 40 хувь, нөхрүүд 8 хувь байгаа бол өрөөсгөл гэр бүлийн хувьд өрх толгойлсон эхчүүд 40 хувь, өрх толгойлсон эцэг 15 хувь, бусад гэр бүлийн гишүүд мөн 15 хувь, харин гэр бүл цуцалсан эхнэр нөхрүүд хоёул хүмүүжүүлэхэд оролцдог нь 30 хувь байв. Дээрх үр дүнгээс дүгнэхэд эмэгтэйчүүд гэр бүлийн төрөл харгалзахгүйгээр хүүхэд хүмүүжүүлэх тал дээр өндөр оролцоотой байна. Мөн өрөөсгөл гэр бүлийн хувьд тухайн өрхийн онцлогоос шалтгаалан бусад гишүүд болон эрэгтэйчүүд нь бусад гэр бүлийн төрлүүдээс илүү оролцож байна.

Мөн гэр бүлийн гишүүдийнхээ боловсролд анхаарал хандуулах үүргийг эхнэр нөхрүүд голчлон хамтран гүйцэтгэж буй хэдий ч эмэгтэйчүүд илүү өндөр оролцоотой байна. Тухайлбал, дан гэр бүлүүдийн хувьд эхнэр нөхрүүд хамтдаа 61 хувь байгаа ба эхнэрүүд (29 хувь) нөхрүүдээс (6 хувь) харьцангуй илүү оролцоотой байв. Энэ хандлага нь нийлмэл гэр бүлд мөн ижил ажиглагдаж байгаа нь эхнэр нөхөр хамтдаа 57 хувь, эхнэр 30 хувь, нөхөр 6 хувь юм. Өрөөсгөл гэр бүл нь тодорхой хэмжээнд ялгаатай байгаа буюу өрх толгойлсон эцэг (15 хувь) болон эхчүүдэд (40 хувь) тус үүрэг нь илүү нэмэгдэж ирж байгааатай холбоотой бөгөөд гэр бүл цуцалсан эхнэр нөхрүүд нь хамтдаа оролцох байдал нь 45 хувь байгаа нь бусад гэр бүлүүдээс бага байна.



Зураг 3.19. Сурган хүмүүжүүлэх, боловсролд анхаарах үүрэг, хувиар



### Гэр бүл дэх хөдөлмөрийн хуваарилалт

Аль ч гэр бүлийн төрлүүдэд хоёр гэр бүл тутмын нэгэнд нь эрэгтэй болон эмэгтэй хүмүүс гэр бүлээ тэжээн тэтгэх үүргийг хамтдаа гүйцэтгэж байна. Үүнд, дан гэр бүлүүд 59 хувь, нийлмэл гэр бүлүүдэд 53 хувь, өрөөсгөл гэр бүлд 40 хувь байна. Харин нөхрүүд гэр бүлээ тэжээж буй байдал нь дан гэр бүлд 34 хувь, нийлмэл гэр бүлд 38 хувь, өрөөсгөл гэр бүлд 25 хувь байгаа бол эхнэрүүд харьцангуй бага буюу дан гэр бүлд 6 хувь, нийлмэл гэр бүлд 7 хувь, өрөөсгөл гэр бүлд 20 хувьтай байв. Өөрөөр хэлбэл, гэр бүлүүд голчлон хамтдаа гэр бүлээ тэжээн тэтгэж байгаа ч нөхрүүд нь эхнэрүүдээс илүү өндөр оролцоотой байна. Харин өрөөсгөл гэр бүлийн хувьд өрх толгойлсон эцэг болон эх нар харилцан ялгаагүй оролцоотой байх, мөн бусад гэр бүлийн гишүүдийн оролцоо илүү өндөр хувьтайгаар орж ирж байна.

Гэрийн ахуйн ажлыг хийх үүрэгт хоёр гэр бүл тутмын нэгт нь эхнэрүүд голчлон гүйцэтгэж байгаа нь дан гэр бүлд 49 хувь, нийлмэл гэр бүлд 48 хувь, өрөөсгөл гэр бүлд 50 хувь байгаагаас харагдаж байна. Үүнээс ялгаатайгаар нөхрүүдийн гэрийн ажил дахь оролцоо сул байгаа бөгөөд үүнд дан гэр бүлийн нөхрүүд 6 хувь, нийлмэл гэр бүл 4 хувь, өрөөсгөл гэр бүлд 15 хувь гэж хариулжээ. Харин гэр бүлийн гишүүд хамтдаа гэрийн ажлаа хийж буй байдал дан гэр бүлд 42 хувь, нийлмэл гэр бүлд 43 хувь, өрөөсгөл гэр бүлд 25 хувь байна. Үүнээс харахад, гэрийн ажлыг хийхэд эмэгтэйчүүдийн эзлэх байр суурь харьцангуй өндөр байв.




Зураг 3.20. Хөдөлмөрийн хуваарь, хувиар



Оролцогчдын дийлэнх буюу 84 хувь нь гэр бүл дэх ажил үүргийг хүйсээр ялгалгүйгээр тухайн үед хэн боломжтой нь хийх хэрэгтэй гэж үзэж байна. Гэсэн хэдий ч гэр бүлээ тэжээн тэтгэх, гэрийн ажил хийх зэрэг үүргүүдэд судалгаанд оролцогчдын тал орчим хувь нь хамтран хийдэг гэж хариулсан нь гэрийн ажлыг хэн боломжтой нь хийдэг (Зураг 3.21) гэсэн үзэл бодолтой зөрчилдөж байв. Энэ нь тэдний үзэл бодол болон өдөр тутмын бодит амьдралын хооронд зөрүү байгааг илэрхийлж байна. Хэдийгээр судалгаанд оролцогчид гэрийн ажлыг хүйсээр ангилах шаардлагагүй гэж үзэж байгаа боловч жендэрийн хэвшмэл ойлголт оршсоор байгааг харуулж байна. Тухайлбал, ихэнх тохиолдолд гэрийн ажлыг эмэгтэйчүүд хийдэг, харин гэр бүлээ тэжээн тэтгэх санхүүгийн үүргийг эрэгтэйчүүд гүйцэтгэдэг гэсэн үзэл нь жендэрийн хэвшмэл ойлголт бодит байдалд нөлөөлсөөр байгааг илтгэнэ.

Зураг 3.21. Гэрийн ажлыг хүйсээр ангилах талаар үзэл бодол, хувиар







Зураг 3.22. Фокус бүлгийн ярилцлага, гэр бүл дэх үүргийн хуваарилалт, хүйсээр



ФБЯ-д оролцогчдын үзэж байгаагаар эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд гэрийн ажлыг хэн боломжтой нь хийдэг гэсэн хэдий ч бодит байдалд эмэгтэйчүүд илүү гэрийн ажлын ачааллыг үүрдэг гэдэгтэй санал нийлдэг. Эмэгтэй оролцогчид нөхөр гэрийн ажилд туслахгүйтэй эвлэрсэн, гэрийн үнэлгээгүй ажилд маш их цаг зарцуулдаг, үр хүүхдээ харж хандахаас гадна цалинтай ажлаа хийх зэргээр ачаалалтай байдаг гэж санал бодлоо илэрхийлсэн. Харин эрэгтэйчүүдийн хувьд гэрийн ажлыг асуудал гэж хардаггүй, гэрийн ажлыг амархан ажил, бүх эмэгтэйчүүд хийдэг гэсэн жендэрийн хэвшмэл ойлголтоор хандаж байна.

#### Гэр бүлийн үүргийн хуваарилалт

...Манай нөхөр үнэхээр цаг завгүй ажилладаг. Дасан зохицно гэдэг шиг гэрийн ажилд огт хүрдэггүй. Аяга ер нь л угааж үзээгүй. Суурь хүмүүжил нь тийм байдаг байх. Эхэндээ зөрчилддөг байсан, одоо хүлээн зөвшөөрөөд стрессдэхээ байсан. Эр хүний гүйцэтгэх ёстой, ар гэрийнхээ санхүүг зохицуулах юмаа бүгдийг нь хангалттай хийж байгаа болохоор тэр асуудал дээр гэрт гадаагүй бүх юман дээр дасан зохицсон...

Дан гэр бүлийн эмэгтэй, нас 35, дээд боловсролтой  
Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэл, Дорнод аймаг

...Ажил хийгээд ядраад байна гээд унтаад байна. Хүүхдээ хүргэж өгөх, авах гэхээр ядраад байна гээд унтаад байдаг. Бид нар чинь өглөө цагтай уралдаж босоод хоол цайг нь хийнэ, их ажил хийж байгаа, хүүхдийг нь аваачиж өгнө, буцаж авна, нөгөө хэд чинь юмаа мартаад буцаж гүйж ирнэ. Тэгээд хичээл ном хийнэ. Бүх юмыг нь хийнэ. Нөгөөдүүл чинь орой ирэхэд яг аяга шанагыг нь аваад явчихсан юм шиг байж байна. Тэр гэр орон цэвэрлэхийг бид нар л цэвэрлэнэ. Аяга таваг, тоос гээд...

Дан гэр бүлийн эмэгтэй, нас 47, бүрэн дунд боловсролтой  
Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэл, Улаанбаатар хот




## Гэр бүл дэх эрх мэдлийн хуваарилалт

Гэр бүлийн санхүүг удирдах үүрэг хариуцлагыг эхнэр, нөхрүүд голчлон хамтдаа гүйцэтгэж байна. Тухайлбал, дан гэр бүлүүдийн хувьд хамтдаа гүйцэтгэж буй нь 42 хувь, эхнэрүүд 38 хувь, нөхрүүд 19 хувь, нийлмэл гэр бүл мөн адил хамтдаа санхүүгээ удирддаг 41%, эхнэр удирддаг 39 хувь, нөхөр удирддаг 17 хувь, өрөөсгөл гэр бүлд гэр бүлийн насанд хүрсэн гишүүд хамтдаа удирддаг 45 хувь, өрх толгойлсон эмэгтэйчүүд удирддаг 35 хувь, өрх толгойлсон эрэгтэйчүүд 20 хувь гэж хариулжээ.

Гэр бүлийн чухал шийдвэрийг гаргахад дан гэр бүлд нөхрүүд 25 хувь, эхнэрүүд 12 хувь, хамтдаа 62 хувь, нийлмэл гэр бүлд нөхрүүд 21 хувь, эхнэрүүд 11 хувь, хамтдаа шийдвэр гаргадаг 66 хувь бол өрөөсгөл гэр бүлийн хувьд өрх толгойлсон эрэгтэйчүүд 15 хувь, эмэгтэйчүүд 30 хувь, гэр бүлийн гишүүд хамтдаа 30 хувьтайгаар шийдвэр гаргалтад оролцож байна.

Эмэгтэйчүүд санхүүгээ барих үүргийг хүлээдэг тохиолдол нь эрчүүдээс өндөр байгаа юм. Харин гэр бүл дэх чухал шийдвэрийг гаргахад хамтдаа байх тохиолдол нь их ч санхүүг удирдахаас ялгаатай нь эрэгтэйчүүд чухал шийдвэрийг гаргахад илүү оролцоотой байна. Фокус бүлгийн ярилцлагууд дээр мөн тус тохиолдол нь бататгагдсан бөгөөд эрэгтэй, эмэгтэй хүмүүс харилцан адилгүй байгаа ба чухал шийдвэрийг голчлон нөхөр гаргаж, эхнэрүүд санхүү тооцоог барьдаг байна.

Зураг 3.23. Гэр бүл дэх эрх мэдлийн хуваарилалт, хувиар





### **Гэр бүл дэх эрх мэдлийн хуваарилалт**

*... Манай гэр бүлд ихэвчлэн нөхрийн шийдвэр давамгайлдаг. Томоохон шийдвэрүүдийг нөхөр гаргадаг, тэр нь ч зөв байдаг. Би бол жижиг сажиг асуудал, шийдвэр гаргалтыг дэмждэг. Эцсийн шийдвэрийг манай нөхөр гаргадаг...*

Дан гэр бүлийн эмэгтэй, нас 33, дээд боловсролтой  
Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэл, Дорнод аймаг

*...Гэр бүлийн шийдвэр гаргалтад миний үүрэг, роль бол бараг 80 хувьтай байдаг. Байнгын зохицуулах, ийш тийш гадуур дотуур ажил байвал бүх юмыг зохицуулдаг. Ерөнхийдөө санхүүг эхнэр барьдаг...*

Дан гэр бүлийн эрэгтэй, нас 33, дээд боловсролтой  
Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэл, Улаанбаатар хот

### **Бусад төрлийн үүргүүд**


Судалгаанд оролцогчдын дийлэнх нь амьдрах сууцыг хамтдаа эсвэл нөхөр нь бэлдэх ёстой гэж үзэж байв. Дан болон нийлмэл гэр бүлийн хувьд амьдрах сууцаа хамтдаа бэлдэх нь зөв гэж 2 хүн тутмын нэг нь үзсэн (дан 57 хувь, нийлмэл 55 хувь, өрөөсгөл 40 хувь) байна. Харин нөхөр нь бэлдэх хэрэгтэй гэх үзэл мөн өндөр байгаа нь дан гэр бүлд 39 хувь, нийлмэл гэр бүлд 43 хувь, өрөөсгөл гэр бүлд 55 хувьтай хариулжээ.

Дан (54 хувь) болон нийлмэл (53 хувь) гэр бүлийн гишүүдийн хувьд хоёр хүн тутмын нэг нь, өрөөсгөл (35 хувь) гэр бүлийн хувь гурван хүн тутмын нэг нь нөхрүүд гэр бүлийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй гэж үзжээ. Харин эхнэрүүд аюулгүй байдлыг хангах хэрэгтэй гэж хариулсан нь дан гэр бүлд 10 хувь, нийлмэл гэр бүлд 6 хувь, өрөөсгөл гэр бүлд 20 хувь байна. Эхнэр нөхрүүд хамтдаа аюулгүй байдлыг хангах хэрэгтэй гэж үзэж буй оролцогчид гэр бүлийн төрөл харгалзахгүй адилхан 35-39 хувь хооронд байна.

Гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийг анхаарахад гэр бүлийн хэлбэрээс үл хамааран эхнэр, нөхөр хамтдаа гүйцэтгэх нь дан гэр бүлд 50 хувь, нийлмэл гэр бүлд 51 хувь, өрөөсгөл гэр бүлд 55 хувь гэж хариулжээ. Дан гэр бүлийн хувьд эхнэрүүд 44 хувьтай, нөхрүүд 4 хувь, нийлмэл гэр бүлийн хувьд эхнэр 41 хувь, нөхөр 4 хувь, өрөөсгөл гэр бүлд эмэгтэйчүүд 30 хувь, эрэгтэйчүүд 15 хувь байгаагаас гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндэд анхаарахад эхнэр нь нөхрөөс илүү үүрэг оролцоотой байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байна.




Зураг 3.24. Гэр бүлийн бусад үүрэг, хувиар



Гэр бүлийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэх гэдэгт тухайн хүний гэр бүлийн гишүүний хувьд сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх, гэр бүлийн гишүүдийг ойлгож, тэднийг дэмжиж, хамтдаа асуудлыг даван туулах, гэр бүлийн амьжиргаанд хувь нэмэр оруулах, орлого олох, хүүхдүүддээ зөв хүмүүжил олгох, хайр халамж, боловсрол олгоход анхаарах, гэрийн ажилд оролцох, гэр бүлийн гишүүдийнхээ үзэл бодол, хэрэгцээ шаардлагыг хүндэтгэх, харилцан ойлголцох, хань ижилдээ болон гэр бүлдээ үнэнч байж, итгэлцлийг хадгалах зэрэг өргөн хүрээний ойлголтыг багтаадаг.

Судалгаанд оролцогчдын 59.4 хувь нь гэр бүлийнхээ өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлж чаддаг, 38.8 хувь нь биелүүлэхийг хичээдэг гэж үзэж байна. Эрэгтэйчүүдийн 60.0 хувь нь, харин эмэгтэйчүүдийн 58.7 хувь нь гэр бүлийнхээ өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлж чаддаг гэж хариулсан байна. Харин эрэгтэйчүүдийн 37.7 хувь нь, эмэгтэйчүүдийн 39.9 хувь үүрэг хариуцлагаа биелүүлэхийг хичээдэг гэж үзжээ.


Зураг 3.25. Гэр бүлийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэх байдал, хүйс, хувиар





Дан болон нийлмэл гэр бүлийн гишүүдийн талаас илүү хувь нь бүрэн биелүүлж чаддаг гэж үзэж байсан бол өрөөсгөл гэр бүлийн 30 хувь нь биелүүлж чаддаг байгаа нь бусад гэр бүлээс харьцангуй бага байна. Харин өрөөсгөл гэр бүлийн гишүүдийн дийлэнх буюу 70 хувь нь биелүүлэхийг хичээдэг гэж хариулж буй нь тухайн гэр бүлд үүргийн хуваарилалт, өрх толгойлсон эх, эцэг байх нь үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлдэг байхад хүндрэлтэй байх боломжтой юм.

*Зураг 3.26. Гэр бүлийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэх байдал, гэр бүлийн төрөл, хувиар*



Гэр бүлийн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлж чадахгүй байгаа гэж хариулсан иргэдийн хувьд санхүүгийн бэрхшээл, үүрэг хариуцлагаа хойшлуулах хандлага, туршлага дутмаг байдал зэрэг шалтгаануудыг илүүтэй онцолсон байна. Судалгаанд оролцогчдын амьдарч буй байршил, гэр бүлийн төрөл, нас, хүйсээс шалтгаалан дараах тохиолдлууд гарч байна. Үүнд:

- Хот суурин газар болох нийслэл хот, аймаг сумын төвүүдэд санхүүгийн бэрхшээл болон эрүүл мэндийн асуудал нь илүү их тохиолдож байна. Харин нийслэлийн хувьд ар гэрийн үүрэг хариуцлагаа хойшлуулж байдгаас, цаг зав муутай ажил ихтэй байдгаас гэх шалтгаанууд илүү байна. Харин хөдөө суурьшдаг оролцогчдод “Харилцааны ур чадвар муугаас” болж үүрэг хариуцлагаа хангалттай биелүүлж чадахгүй байна гэжээ.
- Өрөөсгөл гэр бүлүүдэд “Санхүүгийн дутмаг байдал” нь бусад гэр бүлүүдээс илүүтэй их тулгарч буй бэрхшээл бол дан гэр бүлүүдэд “Эрүүл мэндийн асуудал”, “Хойшлуулж байдгаас” зэрэг асуудлууд хамгийн өндөр тохиолддог асуудал аж.
- Эрэгтэйчүүдийн хувьд санхүүгийн бэрхшээл эмэгтэйчүүдээс илүү тулгарч байгаа бол эмэгтэйчүүдэд туршлага дутмаг байх, харилцааны чадвар муу байх, хойшлуулж байдаг зэрэг асуудлууд эрэгтэйчүүдээс илүү хүндрэлтэй байна.
- Санхүүгийн бэрхшээл нь 35-аас дээш насныханд илүү тулгарч байгаа бол эрүүл мэндийн асуудал 50-аас дээш насныханд, харин 34-49 дунд насныханд туршлага, мэдлэг дутмаг байх болон ар гэрийн амьдралаа хойшлуулж байдаг хүндрэлүүд илүүтэйгээр тохиолдож байгаа юм.




### Хүснэгт 3.3. Үүрэг, хариуцлагаа биелүүлж чадахгүй байх шалтгаан, хувиар

| Гэр бүлийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаа хангалттай биелүүлж чадахгүй байхад нөлөөлж буй хүчин зүйлс |                  | Санхүүгийн дутмаг байдлаас | Эрүүл мэндийн асуудлаас | Туршлага дутмагаас | Мэдлэг дутмагаас | Харилцааны ур чадвар муугаас | Хойшлуулж байдгаас | Бусад |
|---------------------------------------------------------------------------------------------------------|------------------|----------------------------|-------------------------|--------------------|------------------|------------------------------|--------------------|-------|
| Байршил                                                                                                 | Нийслэл          | 68                         | 21                      | 34                 | 19               | 12                           | 32                 | 11    |
|                                                                                                         | Аймгийн төв      | 69                         | 21                      | 40                 | 25               | 14                           | 29                 | 7     |
|                                                                                                         | Сумын төв        | 62                         | 18                      | 35                 | 23               | 17                           | 29                 | 8     |
|                                                                                                         | Хөдөө            | 54                         | 12                      | 23                 | 19               | 23                           | 19                 | 4     |
| Гэр бүлийн төрөл                                                                                        | Дан гэр бүл      | 64                         | 21                      | 32                 | 23               | 15                           | 32                 | 11    |
|                                                                                                         | Нийлмэл гэр бүл  | 65                         | 19                      | 39                 | 20               | 14                           | 27                 | 7     |
|                                                                                                         | Өрөөсгөл гэр бүл | 93                         | 7                       | 21                 | 21               | 14                           | 21                 | 7     |
| Хүйс                                                                                                    | Эрэгтэй          | 72                         | 20                      | 30                 | 22               | 12                           | 27                 | 9     |
|                                                                                                         | Эмэгтэй          | 59                         | 19                      | 39                 | 21               | 17                           | 32                 | 9     |
| Нас                                                                                                     | 18-34 нас        | 59                         | 11                      | 45                 | 24               | 15                           | 30                 | 11    |
|                                                                                                         | 35-49 нас        | 72                         | 22                      | 29                 | 22               | 15                           | 33                 | 7     |
|                                                                                                         | 50+ нас          | 74                         | 39                      | 15                 | 10               | 13                           | 22                 | 7     |

Гэр бүл дэх чухал шийдвэрүүдийг гаргахдаа аль гишүүний саналаар ихэвчлэн шийдвэрлэдэг талаар тодруулахад харилцан адилгүй үр дүн гарчээ. Жишээлбэл, дан өрхийн хувьд голчлон эхнэр нөхөр хамтын шийдвэр гаргалт нь хамгийн өндөр буюу 67 хувь, гэр бүлээрээ хамтдаа шийддэг нь 33 хувь, нөхөр шийдвэр гаргах нь 25 хувь байна. Харин өрөөсгөл гэр бүлд гэр бүлээрээ, эхнэр шийдвэр гаргадаг болон ахмад настны үгээр шийдвэрлэх зэрэг тохиолдол нь бусад гэр бүлийн төрлүүдээс илүү өндөр хувьтай байсан.



Зураг 3.27. Чухал асуудлыг гишүүдийн саналаар шийдвэрлэдэг байдал, гэр бүлийн төрөл, хувиар




### 3.3. Гэр бүлийн харилцаа, хандлага

#### 3.3.1. Эхнэр нөхрийн хоорондын харилцаа

Судалгаанд оролцогчдын 85 хувь нь гэр бүлийн эхнэр, нөхрийн хоорондын харилцаандаа сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлж, таван хүн тутмын нэг нь маш сэтгэл ханамжтай гэж хариулжээ. Үүнийг фокус бүлгийн ярилцлагын үр дүнтэй уялдуулан үзэхэд хосуудын хоорондын харилцаа харьцангуй эерэг, тогтвортой байгааг харилцан ойлголцол, итгэлцэл, хамтдаа өнгөрөөх цаг хугацаа зэргийг сэтгэл ханамжийн гол хүчин зүйлс гэж онцолсон байна.

Зураг 3.28. Эхнэр нөхөртөө сэтгэл хангалуун байгаа байдал, хувиар





Эхнэр нөхрийн харилцаа дахь сэтгэл ханамжаа үнэлсэн асуулгыг арифметик дунджаар үндсэн нэг үнэлгээ болгож ( $\alpha=0.94$ ) бусад хүчин зүйлүүдтэй харьцуулж үзэхэд дараах үр дүн гарлаа. Үүнд:

- Independent T-test шинжилгээний үр дүнд эрэгтэй болон эмэгтэй хүйсийн бүлгүүд хооронд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа гарч байна. Энэ нь эрэгтэйчүүд эхнэртэйгээ харилцах харилцаандаа эмэгтэйчүүдээс илүү сэтгэл хангалуун байв. ( $p=.000$ )
- Насны бүлэг, өрхийн төрөл, хамт амьдарсан жил, боловсролын түвшин, амьдарч буй байршил зэргээс хамааран эхнэр нөхөртэйгөө харилцах харилцаанд ялгаа буй эсэхийг One-way ANOVA шинжилгээ хийж үзэхэд ямар нэгэн ялгаа гараагүй. Өөрөөр хэлбэл, нас ( $p=.069$ ), өрхийн төрөл ( $p=.246$ ), хамт амьдарсан жил ( $p=.284$ ), боловсролын түвшин ( $p=.307$ ), байршил ( $p=.130$ ) нь оролцогчдын эхнэр нөхөртэйгөө харилцах харилцааны сэтгэл ханамжид нөлөөлдөггүй байна.
- Өрхийн орлогын хэмжээ нь эхнэр нөхрийн хоорондын харилцаанд сэтгэл ханамжтай байх байдалд статистикийн хувьд ач холбогдолтой нөлөө үзүүлж буй нь ( $p=.000$ ) One-way ANOVA тестээр батлагдсан. Өөрөөр хэлбэл, судалгаанд оролцогчдын орлогын хэмжээ ялгаанаас шалтгаалан хосуудын сэтгэл ханамжийн түвшин харилцан адилгүй байна. Үүнийг тодруулан шалгахад Tukey тест хийв (Хүснэгт 3.5). Үүний үр дүнд 500 мянга хүртэл орлоготой эхнэр нөхрийн харилцааны сэтгэл ханамж нь 4 саяас дээш орлоготой хосуудын сэтгэл ханамжаас бага ( $p = 0.033$ ), мөн 900 мянгаас 1,1 сая төгрөгийн орлоготой эхнэр нөхрийн сэтгэл ханамж нь 1,6 саяас дээш орлоготой хосуудынхаас доогуур байна. Өөрөөр хэлбэл, статистикийн ач холбогдлын түвшинд орлого нэмэгдэхийн хэрээр эхнэр нөхрийн хоорондын харилцаанд сэтгэл ханамж нэмэгдэж байна.

#### Хүснэгт 3.4. Эхнэр нөхрийн сэтгэл хангалуун байдлын шинжилгээ

|                    | Тест               | df   | p value |
|--------------------|--------------------|------|---------|
| Хүйс               | Independent T test | 1014 | .000*   |
| Нас                | One-way ANOVA      | 1015 | .069    |
| Өрхийн төрөл       | One-way ANOVA      | 1015 | .246    |
| Орлого             | One-way ANOVA      | 1015 | .000*   |
| Хамт амьдарсан жил | One-way ANOVA      | 997  | .284    |
| Боловсрол          | One-way ANOVA      | 1015 | .307    |
| Байршил            | One-way ANOVA      | 1015 | .130    |






## Хүснэгт 3.5. Орлого ба сэтгэл ханамжийн хамаарал, Tukey test

| Орлого         | Харьцуулсан орлого | Mean difference | Sig  |
|----------------|--------------------|-----------------|------|
| 500 мян хүртэл | 4 сая-аас дээш     | -.37411*        | .033 |
|                | 1,6 сая – 2,1 сая  | -.31319*        | .018 |
|                | 2,1 сая -3 сая     | -.30595*        | 0.18 |
|                | 3 сая – 4 сая      | -.30434*        | .033 |
|                | 4 сая-аас дээш     | -.45507*        | .000 |

Эхнэр нөхрийн хоорондын харилцаанд ямар шинж чанар, зан үйлийг нэгнээсээ хүсдэг талаар тодруулахад дунджаар 70 гаруй хувь нь бүхий л шинж чанарыг харилцан бие биеэсээ хүсдэг гэж хариулжээ. Гэсэн ч зарим тал дээр эхнэрүүд нөхрөөсөө илүү их зүйл хүсэх хандлага ажиглагдсан. Тухайлбал, архи хэрэглэхгүй байх (21.6 хувь), гэрийн ажилд туслах (15.6 хувь), илүү их мөнгө олох (13.5 хувь), гэр бүлтэйгээ цагийг өнгөрөөх (13.7 хувь) эхнэрээ гомдоохгүй байх (13.1 хувь) зэрэг багтаж байна. Энэ нь эхнэрүүдийн зүгээс гэр бүлийн харилцаанд чухалчилдаг хэрэгцээ, шаардлагууд гэж үзэж болох юм. Харин нөхрүүд эхнэрээсээ уурлахгүй байх (12.5 хувь), эрүүл мэндэд анхаарах (9.8 хувь), гэр бүлтэйгээ цагийг хамт өнгөрөөх (8.2 хувь), найз нөхдийг нь хүлээн зөвшөөрөх (6.8 хувь) зэргийг хүсдэг байна.

## Зураг 3.29. Эхнэр нөхрүүд бие биеэсээ хүсдэг шинж чанар, хувиар





Oneway ANOVA шинжилгээний үр дүнгээс үзэхэд, эхнэр нөхрүүд хоорондоо ярилцдаг байдал нь гэр бүлийн сэтгэл ханамжид статистикийн хувьд ач холбогдолтой нөлөө үзүүлжээ. Тухайлбал, хоорондоо тогтмол ярилцаж чаддаггүй гэр бүлүүдийн сэтгэл ханамжийн үнэлгээ харьцангуй доогуур байна. Харин харилцан ярилцдаг байдал өндөр байх тусам хосуудын сэтгэл ханамжийн үнэлгээ нэмэгджээ. Өөрөөр хэлбэл, эхнэр нөхрүүд хоорондын идэвхтэй харилцаа нь гэр бүлийн харилцаанд эергээр нөлөөлдөг байна.


*Хүснэгт 3.6. Эхнэр нөхөртэйгөө ярилцаж чаддаг эсэх нь сэтгэл ханамжид нөлөөлөх байдал*

|                                             |                                      | Mean difference | Sig  |
|---------------------------------------------|--------------------------------------|-----------------|------|
| <b>Ярилцдаггүй (1)</b>                      | Ярилцахыг хүсдэггүй (2)              | .51361          | .153 |
|                                             | Шаардлагатай зүйлээ л ярилцдаг (3)   | -1.04738*       | .000 |
|                                             | Хааяа ярилцаж чадахгүй үе байдаг (4) | -1.10504*       | .000 |
|                                             | Юу ч болсон ярилцдаг (5)             | -1.46511*       | .000 |
| <b>Ярилцахыг хүсдэггүй (2)</b>              | Шаардлагатай зүйлээ л ярилцдаг (3)   | -1.56099*       | .000 |
|                                             | Хааяа ярилцаж чадахгүй үе байдаг (4) | -1.61864*       | .000 |
|                                             | Юу ч болсон ярилцдаг (5)             | -1.97871*       | .000 |
| <b>Шаардлагатай зүйлээ л ярилцдаг (3)</b>   | Хааяа ярилцаж чадахгүй үе байдаг (4) | -.05766         | .902 |
|                                             | Юу ч болсон ярилцдаг (5)             | -.41773*        | .000 |
| <b>Хааяа ярилцаж чадахгүй үе байдаг (4)</b> | Юу ч болсон ярилцдаг (5)             | -.36007*        | .000 |

Ярилцаж чаддаг байх нь гэр бүлийн харилцаанд эергээр нөлөөлдөг бөгөөд ярилцсанаар асуудлыг амархан шийдэхэд тусалдаг гэж нийт судалгаанд оролцогчдын 71.2 хувь нь үзжээ. Мөн оролцогчдын 23.7 хувь нь зарим үед л тус болдог гэсэн нь дээрх үр дүнтэй нийцэж байна. Харин ярилцаад ч тулгарсан асуудал нь шийдэгдэхгүй байх тохиолдол нь 5.0 хувьтай байна.



Зураг 3.30. Ярилцах нь асуудлыг шийдэхэд тусалдаг эсэх, давхардсан тоо, хувиар




Гэр бүлийн хамтын амьдралын жилүүдэд эхнэр нөхрийн хоорондын харилцаа хандлага хэрхэн өөрчлөгдөж буйг хамт амьдарсан жилүүдээр (Зураг 3.31) болон насны бүлгээр (Зураг 3.32) харьцуулан шинжиллээ.

Хосуудын хамтын амьдралын эхний жилүүдэд улам илүү дотносох байдал ажиглагдаж байгаа ч хамтдаа удаан хугацааг өнгөрүүлэх тусам энэ хандлага нь тогтвортой буюу нэгэн хэвийн байх түвшинд шилжиж байна. Мөн 1-9 жилийн хооронд хосуудын бие биедээ санаа тавих байдал буурах хандлага байна.

Харин насны бүлгийн хувьд 18-34 насны залуу хосууд дотносох түвшин харьцангуй өндөр байгаа ч нас ахихын хэрээр энэ нь тогтворжиж, хэвийн түвшинд шилжих хандлага ажиглагдлаа. Эдгээр үзүүлэлтүүдээс дүгнэхэд залуу хосуудын хувьд харилцаа илүү эрчимтэй, нэгэнтэйгээ илүү дотно болохын зэрэгцээ хөндийрөх эрсдэл өндөр байдаг бол дунд болон ахмад насны хосууд нэгэндээ илүү дасах, харилцаа нь тогтсон хэмнэлд орсон байх боломжтой юм.

Зураг 3.31. Цаг хугацааны явцад харилцаа өөрчлөгдсөн эсэх, хамт амьдарсан хугацаа, хувиар






Зураг 3.32. Цаг хугацааны явцад харилцаа өөрчлөгдсөн эсэх, нас, хувиар



Цаг хугацааны явцад гэр бүлийн дотно байдлаа хадгалж үлдэхэд “Хайр халамжаар дутаахгүй байх”, “Итгэл алдахгүй байх”, “Нэгнээ ойлгож хүндэлдэг” байх зэрэг нь хамгийн чухал гэж үзжээ. Харин эрэгтэйчүүдийн 57 хувь ханиа хайрлаж, халамжаар дутаахгүй байх нь чухал нөлөөтэй гэж үзсэн бол эмэгтэйчүүдийн 57 хувь нь нөхрүүд итгэл алдахгүй байх нь чухал гэж үзжээ. Үүнээс харахад эрэгтэйчүүд илүү хайр, халамжийг чухалчилдаг бол эмэгтэйчүүдийн хувьд итгэлцэл, үнэнч байдал нь харилцааны суурь гэж үздэг байна.


Зураг 3.33. Цаг хугацааны явцад дотно байдлаа хадгалж үлдэх нь, хүйс, хувиар



Судалгаанд оролцогчдоос хадмуудтайгаа харилцах, эхнэр нөхрийн үүргийг хуваарилах, зөрчил маргааныг шийдвэрлэх, өв уламжлалаа хадгалах, боловсрол болон эрүүл мэнддээ анхаарах зэрэг гэр бүлийн харилцаанд чухал нөлөө үзүүлдэг асуудалд сэтгэл ханамжтай байгаа эсэхийг авч үзлээ. Судалгаанд оролцогчдын дийлэнх нь гэр бүлийн харилцаандаа сэтгэл хангалуун байдаг гэжээ. Тухайлбал, эхнэр нөхрийн үүргийн хуваарилалтад 82.0 хувь буюу хамгийн их сэтгэл хангалуун байна. Харин хадмуудтайгаа харилцах харилцаандаа сэтгэл хангалуун бус буюу 7.0 хувьтай байгаа нь бусад үзүүлэлтүүдээс өндөр байна.



Зураг 3.34. Гэр бүлийн харилцаан дахь сэтгэл ханамж, хувиар



### 3.3.2. Хүүхэд ба түүний хүмүүжлийн асуудлууд

Хүүхдийн хүмүүжил, хөгжлийн талаар судалгаанд оролцогчдын 30.2 хувь нь хүүхдээ эрүүл саруул сайн хүн болгох, 28.0 хувь нь боловсрол мэргэжилд нь анхаарах болон 19.3 хувь нь амьдрах ухаанд сургах нь хамгийн чухал гэж үзэж байна.


Судалгаанд оролцсон эрэгтэйчүүдийн 28.6 хувь, эмэгтэйчүүдийн 31.4 хувь нь хүүхдээ эрүүл саруул сайн хүн болгох хамгийн чухалд тооцогдож байгаа хандлага болж байгаа бөгөөд ФБЯ-д оролцогчид хүүхдийн сэтгэцийн тогтвортой байдал, өөртөө итгэх, өөрийгөө ойлгох, хүлээн зөвшөөрөх чадварыг хөгжүүлэх, бие махбодын эрүүл өсөлт, нийгмийн харилцааны эерэг оролцоог дэмжихийг онцолж байна.

Мөн эцэг эхчүүдийн санаа зовоож байгаа нэг асуудал бол хүүхдийнхээ боловсрол мэргэжилд анхаарах асуудал бөгөөд эрэгтэйчүүдийн 26.6 хувь, эмэгтэйчүүдийн 29.1 хувь нь бараг адилхан өндөр ач холбогдол өгч байна. Хүүхдийн боловсрол мэргэжлийн асуудал нь ирээдүйн амьдралын баталгаа, хувь хүний хөгжил, нийгмийн байр суурьтай холбоотой учраас эцэг эхчүүд хүүхдээ бэлтгэгдсэн, мэдлэгтэй, ур чадвартай, зөв хүн болох үндсийг тавихын тулд өөрсдийн боломж бололцоогоороо дэмжихийг хичээдэг талаар судалгаанд оролцсон эцэг эхчүүд илэрхийлж байна.

Судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн 17.9 хувь, эмэгтэйчүүдийн 20.4 хувь нь хүүхдээ амьдрах ухаанд сургах нь чухал гэж үзэхдээ хүүхэд өөрийгөө авч явах, бие даах, хариуцлага хүлээх, цагаа зөв зохион байгуулах, хүнтэй зөв харилцах, шийдвэр гаргах зэрэг амьдралын бодит чадваруудыг төлөвшүүлэх үйл явцыг чухалчилдаг гэж чанарын судалгаанд оролцогчид өгүүлж байна.




**Зураг 3.35. Хүүхэд өсгөж хүмүүжүүлэх эцэг эхчүүдийн үзэл бодол, хүйс, хувиар**



Судалгаанд оролцогчдын амьдарч буй байршлаас хамааран хүүхэд өсгөж хүмүүжүүлэхэд анхаарах асуудлын талаар ялгаа ажиглагдаж байна. Жишээлбэл, хүүхдийг өөрийн хүсэл сонирхлоо даган амьдрах нь зөв гэж үзэж буй эцэг эхчүүдийн хамгийн өндөр хувь (8.8 хувь) нийслэл хотод, удаах нь аймгийн төвүүд, хамгийн бага хувь нь хөдөө орон нутагт оршин суугчид байна. Өөрөөр хэлбэл төвлөрсөн суурин газар амьдардаг хүмүүс хүүхдийн хүсэл сонирхлыг сонсох, эрх чөлөөг илүү дэмжих хандлагатай байна. Харин төвөөс алслагдсан бүс нутгийн оршин суугчдын хувьд хүүхдийг аливаа дутагдал гачигдалгүй өсгөх нь илүү чухал гэж үзэх хандлага харьцангуй өндөр байна.


**Зураг 3.36. Хүүхэд өсгөж хүмүүжүүлэх эцэг эхчүүдийн үзэл бодол, байршил, хувиар**






Хүүхдэдээ өвлүүлж үлдээх зүйлсийн талаар судалгаанд оролцогчдын үзэл бодлыг тодруулахад хамгийн өндөр хувь нь мэдлэг боловсрол, амьдрах ухаан, хүмүүжил зэрэг хувь хүний хөгжлийг дэмжсэн үнэт зүйлсийг нэрлэжээ. Харин эд хөрөнгө зэрэг материаллаг зүйлсийг өвлүүлэх нь харьцангуй бага хувьтай байна. Энэ нь судалгаанд оролцогчдын ихэнх нь хүүхдийн төлөвшил, чадвар, амьдралын ухааныг ирээдүйн хамгийн чухал “өв” гэж үзэж байгааг харуулж байна. Эмэгтэйчүүд илүүтэйгээр боловсрол, хүмүүжил, хайр халамж зэргийг өвлүүлэх сонирхолтой бол эрэгтэйчүүдийн хувьд монгол өв соёл, уламжлал, эд хөрөнгө зэргийг эмэгтэйчүүдээс илүү өвлүүлэх хүсэлтэй байна.

Зураг 3.37. Хүүхдэд өвлүүлэх үнэт зүйлс, хүйс, хувиар



Судалгаанд оролцсон хүүхэдтэй гэр бүлийн хувьд эхнэр буюу ээж нар (65 хувь) хүүхдэдээ илүү анхаарал тавих, үүрэг оролцооны хувьд нөхөр буюу аавуудаас ямар ч гэр бүлийн хэлбэрт байсан илүү байгаа юм. Хамтаар амьдардаг нийлмэл гэр бүл болон өрх толгойлсон эцэг эх буюу өрөөсгөл гэр бүлийн хувьд өвөө эмээгийн туслалцаа их үүрэгтэй байгааг судалгааны үр дүнгээс харж болно.

Зураг 3.38. Хүүхдэд анхаарал илүү тавьдаг гишүүн, гэр бүлийн төрөл, давхардсан тоо, хувиар






Судалгаанд оролцсон эцэг эхчүүд хүүхдэдээ цаг зав гаргаж буй байдлыг нас, хүйсээр харьцуулан харахад залуу ээжүүдийн хувьд ямар ч үед хүүхдэдээ цаг гаргах чадвар залуу аавуудтай харьцуулахад харьцангуй өндөр байна. Үүний гол шалтгаан нь бага насны хүүхдээ асрах, анхаарал халамж тавих, аюулгүй байдлыг хангах, сэтгэлзүйн хувьд ойр байх зэрэг үүрэгтэй холбоотой. Харин залуу аавуудын хувьд хүүхдийн бага насанд харьцангуй бага анхаарал хандуулах хандлага ажиглагдсан нь ихэвчлэн карьераа хөөх, орон гэрээ төвхнүүлэх, гэр бүлээ тэжээн тэтгэх жөндөрийн уламжлалт дүр үүрэгтэй холбоотойг чанарын судалгаанд оролцсон залуу аав ээжүүд илэрхийлж байна.

Хүүхэд өсвөр насанд хүрэхэд дунд болон ахмад насны аав нар хүүхдэдээ илүү цагийг гаргаж байгаа нь ажил, амьдралын тэнцвэрийг олсон, санхүүгийн хувьд тогтвортой болсон, хүүхдийн хүмүүжил, харилцааны ач холбогдлыг илүү ухамсарлаж, хүүхдийнхээ өсөлт хөгжилд оролцох сонирхол, хэрэгцээ нь нэмэгдсэн бол дунд болон ахмад насны ээжүүдийн хувьд ажил төрөлдөө эргэн орох, мэргэжлийн амжилт болон нийгмийн харилцаандаа илүү идэвхтэй оролцох, эрүүл мэнддээ анхаарал тавих хэрэгцээ шаардлагатай холбоотой байгаа нь ажиглагдлаа.

Зураг 3.39. Хүүхдэдээ цаг зав гаргаж буй байдал, нас, хүйс, хувиар



Хүүхэдтэйгээ цагийг өнгөрүүлэхдээ голчлон юу хийдэг талаар оролцогчдоос тодруулахад хамтдаа тоглох, хичээлийг нь давтуулах, хамтдаа гэрийн ажил хийх зэрэг үйл ажиллагаанууд хамгийн өндөр хувийг эзэлсэн байна.

Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хувьд дараах үйл ажиллагаанууд нь харьцангуй ялгаатай байгааг доорх үр дүнгээс харж болно. Жишээлбэл, эрэгтэй хүмүүсийн хувьд эмэгтэйчүүдээс илүү хүүхэдтэйгээ хийдэг зүйлс нь хамтдаа тоглох, салхинд гарч зугаалах, спортоор хичээллэх зэрэг байна. Харин эмэгтэйчүүдийн хувьд хамт гэрийн ажил хийх, хувийн асуудлыг нь сонсох, ном унших, хичээлийг нь давтуулах зэрэг юм.






Үүнээс харахад эрэгтэй хүмүүс илүү бие бялдар хөгжүүлэх үйл ажиллагаа хийдэг бол эмэгтэйчүүд эсрэгээрээ сэтгэлзүйн болон мэдлэг чадварыг нь хөгжүүлэх үйл ажиллагааг хийж байна.

Зураг 3.40. Хүүхэдтэйгээ хийдэг үйл ажиллагаа, хүйс, хувиар



Судалгаанд оролцогчид нь хүүхдийг голчлон тайлбарлах, зөвлөх, урамшуулан сайшаах аргаар хүмүүжүүлдэг гэж хариулжээ. Зөвлөх, урамшуулан сайшаах болон загнах арга барилд эмэгтэйчүүд илүү өндөр хувийг эзэлжээ.

Зураг 3.41. Хүүхэд хүмүүжүүлэх арга барил, хүйс, хувиар





### 3.3.3. Хүүхдийн бэлгийн боловсрол


Хүүхдийн бэлгийн боловсрол гэдэг нь хүүхдийг өөрийн бие махбод, сэтгэл зүй, хүйсийн ялгаа, өсөлт хөгжил, бэлгийн өөрчлөлт, харилцаа, аюулгүй байдал, зөв хандлага, хүндлэл зэрэгт суралцахад чиглэсэн, нас насанд нь тохируулсан мэдлэг, чадвар, үнэт зүйлийг эзэмшүүлэх боловсролын үйл явц юм.

- 0–5 нас: Биеийн хэсгүүдийн нэр, хувийн орон зай, сэтгэл хөдлөлөө таних зэрэг анхан шатны ойлголт.
- 5–8 нас: Бие махбодын өөрчлөлт, найз нөхдийн харилцаа, аюулгүй байдал, итгэлцэл зэргийг заах.
- 9–12 нас: Бэлгийн бойжилт, нөхөн үржихүй, өөрийгөө хамгаалах мэдлэг, зөвшөөрөл (consent)-ийн ойлголт.
- 13+ нас: Илүү гүнзгий сэдвүүд (жишээ нь, хариуцлагатай харилцаа, жирэмслэлт, ХДХВ/ДОХ, жендэрийн тэгш байдал, ёс зүй, өөртөө итгэх итгэл, шийдвэр гаргалт гэх мэт).<sup>26</sup>

Бэлгийн боловсролыг хүүхдэд хэдэн наснаас, хэрхэн, ямар замаар олгох талаар тодруулахад нийт судалгаанд оролцогчдын 1.2 хувь нь 0-5 нас, 12.5 хувь нь 6-10 нас, 55.7 хувь нь 11-15 хүртэлх нас 29.7 хувь нь 16-20 насанд бэлгийн боловсрол олгох нь зохимжтой гэж үзэж байна.

Эрэгтэй болон эмэгтэйчүүдийн хувьд энэ тал дээр үзэл бодол хараахан ихээр зөрөхгүй байгаа ч эмэгтэйчүүдийн хувьд илүү бага насанд буюу 6-15 насанд (72.4 хувь) бэлгийн боловсрол олгохыг илүүд үзэж байгаа бол эрэгтэйчүүдийн хувьд илүү өсвөр насанд нь хүрсэн хойно нь буюу 11-20 насанд (88.4 хувь) хүрэхэд хэмээн хариулжээ.


**Зураг 3.42. Хүүхдэд бэлгийн боловсрол олгоход зохимжтой нас, хүйс, хувиар**






Мөн оролцогчдын боловсролын түшингээс хамааран харьцангуй ялгаатай үр дүн гарсан. 16-20 насанд бэлгийн боловсрол олгох нь зохимжтой гэж үзсэн хүмүүсийн дунд хамгийн өндөр хувийг 43.5 хувьтайгаар бүрэн бус дунд хүртэл боловсролтой хүмүүс эзэлж байгаа ба эсрэгээрээ боловсролын түвшин дээшлэх тусам 11-15 насыг бэлгийн боловсрол хүлээж авахад тохиромжтой нас гэж харж байна.

**Зураг 3.43. Хүүхдэд бэлгийн боловсрол олгоход зохимжтой нас, боловсрол, хувиар**



Оролцогчдын тал гаруй хувь нь хүүхдэд бэлгийн боловсрол олгоход тодорхой хэмжээнд мэдээлэлтэй гэж өөрсдийгөө үзэж байна. Хүйсийн хувьд эрэгтэй эмэгтэй оролцогчдын үзэл бодол харьцангуй адилхан байгаа хэдий ч огт мэдээлэлгүй байх нь эрэгтэйчүүдийн хувьд (17 пунктээр) илүү өндөр байна. Харин эмэгтэйчүүд нь илүү мэдээлэлтэй гэж өөрсдийгөө харж байгаа юм.

**Зураг 3.44. Хүүхдэд бэлгийн боловсрол олгоход хангалттай мэдээлэлтэй эсэх, хувиар**




Боловсролын зэргийн хувьд мэдээлэл сайн хэмээн үзэж буй иргэдийн хамгийн өндөр хувийг техникийн болон дээд боловсролтой хүмүүс эзэлж байгаа юм. Мөн хангалттай сайн мэдээлэлтэй гэж үзэж буй оролцогчдын хамгийн өндөр хувийг 20.6 хувьтайгаар дээд боловсролтой, хамгийн бага хувийг 11.4 хувьтайгаар бүрэн бус дунд хүртэлх боловсролтой хүмүүс эзэлж байна. Үр дүнгээс харвал оролцогчдын боловсролын түвшин ахих тусам хүүхдэд бэлгийн боловсрол олгоход хангалттай сайн мэдээлэлтэй байгаа ба мөн эсрэгээрээ боловсролын түвшин буурах тусам энэ талын мэдээлэл дутмаг байгаа юм.



Бэлгийн боловсролын талаар мэдээлэлтэй байх эсэх нь хүүхэдтэй хэрхэн энэ сэдвийн талаар ярилцах арга барилд нь шууд нөлөөлж буйг Зураг 46-с харж болно. Тухайлбал, мэдээлэл сайн байх тусмаа хүүхэдтэй илүү илэн далангүй чөлөөтэй ярих чадвартай, мэдээлэл дутмаг байх тусам ярилцахгүй байх сонголтыг хийж байгаа нь эцэг эхчүүд, асран хамгаалагч нар бэлгийн боловсролын талаарх мэдлэг мэдээлэлтэй байх хэрэгтэйг харуулж байна. Өөрөөр хэлбэл хүүхдэд бэлгийн боловсролыг олгох хүмүүсийн нэг болох эцэг эх, асран хамгаалагч нар нь өөрсдөө бэлгийн боловсролын талаар мэдлэгтэй байснаар цаашлаад хүүхэдтэй ярилцах, зөвлөх зэрэг бэлгийн боловсрол олгох үйл явцад эергээр хандах нөхцөлийг бүрдүүлэх боломжтой юм.

**Зураг 3.45. Хүүхдэд бэлгийн боловсрол олгоход хангалттай мэдээлэлтэй эсэх, хувиар**



**Зураг 3.46. Хүүхэдтэй бэлгийн боловсролын талаар ярилцдаг байдал, хувиар**




### 3.3.4. Хүүхдийн цахим сүлжээ хэрэглээ

Цахим сүлжээ нь орчин үеийн нийгмийн өдөр тутмын амьдралын салшгүй хэсэг болж, хувь хүн, гэр бүл болон нийгмийн харилцаанд гүнзгий нөлөө үзүүлж байна. Иймээс цахим сүлжээний хэрэглээ нь гэр бүлийн дотоод харилцаанд хэрхэн нөлөөлж буйг судлах, мөн хүүхдүүдийн цахим хэрэглээний нөхцөл байдал, онцлог, үр дагаврыг судлах нь чухал болоод байна.




Судалгаанд оролцогчдын 70.0 гаруй хувь нь хүүхдэдээ цахим сүлжээ ашиглахыг зөвшөөрдөг бөгөөд эрэгтэй (72.2 хувь) болон эмэгтэйчүүдийн (70.5 хувь) хувьд ялгаагүй хүүхдээ цахим сүлжээ хэрэглэхийг зөвшөөрдөг байна.

Зураг 3.47. Хүүхдийн цахим сүлжээний хэрэглээ, хүйс, хувиар



Гэр бүлд цахим сүлжээ ашиглаж буй хамгийн бага насны хүүхдийг авч үзвэл (Зураг 48) 26.0 хувь нь 4-6 настай, 21.0 хувь нь 7-9 настай хүүхдүүд байгаа бөгөөд 3 хүртэлх насны хүүхэд 15.0 хувь байгаа нь хүүхэд хөлд орох, хэлд орох үеэсээ л цахим сүлжээг ашиглаж байгааг харуулж байна.


Зураг 3.48. Цахим сүлжээ хэрэглэж буй хүүхдүүдээс хамгийн бага насны хүүхэд, хувиар



Хүүхдийн өдөрт цахим сүлжээнд зарцуулж буйг хугацааг хэд хэдэн үзүүлэлттэй харьцуулан хамаарлын хи квадратын тест хийж үзэхэд эцэг эхийн наснаас хамааран хүүхдийн цахим сүлжээ хэрэглэх хугацаа нь статистикийн хувьд ялгаатай байна ( $\chi^2 = 31.78$ ,  $p < .001$ ). Тодруулбал, эцэг эхийн нас залуу байх тусам хүүхдийн цахим сүлжээний хэрэглээний хугацаа бага байгаа бол эцэг эхийн нас ахих тусам хүүхдүүдийн цахим орчинд өнгөрүүлэх дундаж хугацаа нь нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.



Зураг 3.49. Хүүхдийн цахим сүлжээ хэрэглэж буй цаг хугацаа, эцэг эхийн нас, хувиар




Судалгаанд оролцогчдоос цахим сүлжээ гэр бүлийн гишүүдэд хэрхэн эерэг болон сөрөг нөлөө үзүүлж буйг тодруулах зорилгоор 10 төрлийн өөрчлөлт бүхий олон сонголттой асуулт тавьсан. Үр дүнгээс үзэхэд оролцогчид сөрөг нөлөөллүүдийг илүү өндөр давтамжаар сонгосон нь цахим сүлжээний хэрэглээ нь нийтлэг сөрөг үр дагавартай гэж үзэж буйг харуулж байна. Тухайлбал, нойргүйдэл (38.2 хувь), цахим сүлжээнд их хугацаа зарцуулах (38.7 хувь), анхаарал төвлөрөл буурах (31.2 хувь), донтолт (30.1 хувь) зэрэг сөрөг өөрчлөлтүүд давамгайлжээ. Ялангуяа, эцэг эхчүүд хүүхдүүдтэйгээ хамт цагийг идэвхтэй өнгөрүүлэхийн оронд бага болон өсвөр насны хүүхдүүдэд гар утас, цахим төхөөрөмж хэрэглүүлэх нь нэмэгдэж байгаа бөгөөд хүүхдийг цахим хэрэглээнд хэт эрт, хяналтгүйгээр өртүүлэх нь хүүхдүүдийн анхаарал төвлөрөл сулрах, хэт хөдөлгөөнтэй болох, уур уцаартай зан авиртай болох, аливаа зүйлд дур сонирхолгүй болох зэрэг сөрөг сэтгэлзүйн болон зан үйлийн үр дагаварт хүргэж байгаа бөгөөд гэр бүлийн дотоод амьд харилцаа эрс муудаж байна хэмээн ФБЯ-д эцэг эхчүүд илэрхийлсэн нь анхаарал хандуулах шаардлагатай асуудал болохыг харуулж байна.

Харин судалгаанд оролцогчдын үнэлснээр цахим сүлжээний эерэг нөлөөлөлд мэдээллийн хүртээмжтэй байдал (24.0 хувь), цахим үйлчилгээг хялбар авах боломж (22.0 хувь), мөн хүн хоорондын харилцааг түргэн шуурхай хялбар болгох (21.4 хувь) зэрэг хүчин зүйлс онцолж байгаа байгаа нь орчин үеийн амьдралын хэмнэлд нийцүүлэн, мэдээлэлд хурдан хугацаанд хүрэх, үйлчилгээ авах үйл явцыг хөнгөвчилж буй цахим сүлжээний үр нөлөөг эцэг эхчүүд тодорхой хэмжээгээр хүлээн зөвшөөрч байгааг илтгэнэ. Гэсэн хэдий ч дээрх хувь хэмжээ нь цахим сүлжээний сөрөг нөлөөллийг үнэлсэн хувьтай харьцуулахад харьцангуй доогуур байгаа нь эерэг талуудыг үл тоомсорлоогүй ч нийт дүнгээрээ сөрөг хандлага давамгайл байгааг харуулж байна.




Зураг 3.50. Цахим сүлжээ ашигласнаар гэр бүлд гарч буй эерэг болон сөрөг өөрчлөлт, хувиар



Иймээс цахим сүлжээний сөрөг нөлөөллөөс хүүхдээ хамгаалах зорилгоор эцэг эхчүүд ямар арга хэмжээг авч буйг тодруулахад судалгаанд оролцогчдын 57.7 хувь нь цахим хэрэглээнд тодорхой цагийн хязгаар тогтоодог, 46.0 хувь нь сөрөг үр дагаврын талаар тайлбарлаж ойлгуулдаг, 38.1 хувь нь шаардлагатай тохиолдолд гар утсыг нь хураан авдаг гэж хариулжээ. Ийнхүү эцэг эхчүүд цахим хэрэглээг зохистой түвшинд байлгахын тулд хосолсон арга барилуудыг ашиглаж байна. Гэвч зарим эцэг эхчүүд хүүхдийн цахим хэрэглээг зохицуулахдаа үр дүн багатай, сөрөг хандлагатай арга барилыг ашиглаж буй нь судалгаанаас харагдаж байна. Тухайлбал, оролцогчдын 13.4 хувь нь цахим хэрэглээг хориглох, загнах замаар хязгаарладаг бол 3.2 хувь нь огт анхаарал хандуулдаггүй, мөн 3.1 хувь нь ямар нэгэн арга хэмжээ авалгүйгээр хүүхдийн хэрэглээг хязгаарлалтгүй зөнд нь орхидог хэмээн хариулсан байна. Ийм төрлийн хяналтгүй эсвэл хатуу арга барил нь хүүхдийн дижитал зан төлөвт сөрөг үр дагавар учруулах эрсдэлтэй бөгөөд илүү тэнцвэртэй, нас сэтгэхүйд нь тохирсон хандлага шаардлагатайг харуулж байна. Тиймээс хүүхдийн цахим хэрэглээг үр дүнтэй зохицуулахын тулд эцэг эхчүүд нь нас сэтгэхүйд нь тохирсон тайлбар, ойлголт өгөх, хэрэглээнд уян хатан хязгаар тогтоох, цахим орчныг хамтдаа ашиглах, өөрсдөө зөв үлгэр дуурайл үзүүлэхийн зэрэгцээ хүүхдийн сэтгэлзүйн хэрэгцээнд анхаарч, харилцаа, дэмжлэгийг тасралтгүй үзүүлэх нь чухал юм.



Зураг 3.51. Хүүхдийн цахим сүлжээний хэрэглээг хязгаарлах арга хэмжээ, хувиар



Судалгаанд оролцогчдын үзэж буйгаар цахим сүлжээ болон олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээс хүүхдүүдэд хамгийн их сөрөг нөлөө үзүүлж буй хүчин зүйлс бол гар утас болон компьютерын тоглоом (45.0 хувь), фейсбүүк нийгмийн сүлжээ (38.0 хувь) байна. Харин хамгийн эерэг нөлөө ихтэй нь телевиз болон энтертайнмент нэвтрүүлгүүд гэжээ. Энэ нь цахим орчин дахь хэрэглээний хэлбэр, агуулгын төрөл, нийгмийн харилцаанд үзүүлэх нөлөөлөл зэргээс хамааран сөрөг үр дагавар ялгаатай илэрч байгааг харуулж байна. Тухайлбал, ФБЯ-д оролцсон эцэг эхчүүд тоглоомын хэт хэрэглээ нь хүүхдийн анхаарал төвлөрөл, унтах хэв маяг, хөдөлгөөний идэвхэд сөргөөр нөлөөлдөг бол Facebook зэрэг сошиал платформ нь насанд тохироогүй контент, цахим дарамт, бусадтай өөрийгөө харьцуулах үзлийг өдөөн сэтгэлзүйн эрсдэл үүсгэх магадлалтай гэж үзэж байна. Иймээс зөвхөн хэрэглээний хугацаа бус, хэрэглэж буй контентын чанар, агуулгад анхаарах нь хамгаас чухал байгаа нь харагдаж байна.

Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын дийлэнх нь телевиз (53.0 хувь) болон түүний энтертайнмент нэвтрүүлгүүдийг (47.0 хувь) эерэг нөлөөтэй гэж үнэлсэн нь энэхүү уламжлалт мэдээллийн хэрэгслийн агуулга, хүрээлэлд үзүүлэх нөлөөлөлтэй холбоотой. Тухайлбал, телевизийн боловсролын болон танин мэдэхүйн чиглэлийн контентууд нь хүүхдийн мэдлэгийн хүрээг тэлэх, ертөнцийг үзэх үзэл, соёлын ойлголтыг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлдэг гэж эцэг эхчүүд үзэж байна. Мөн гэр бүлийн гишүүд хамтдаа үзэх боломжтой контентууд нь харилцааг бэхжүүлэх, хамтын үйл ажиллагааг дэмжих нөхцөл болдог. Харин энтертайнмент буюу зугаа, соёлын хөтөлбөрүүд нь хүүхдийн сэтгэлзүйн тав тух, эерэг сэтгэл хөдлөлийг дэмжих, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх боломжтой тул эергээр үнэлэгдэх хандлагыг бүрдүүлсэн байна.


Үүнээс гадна Instagram, TikTok, Netflix, Telegram, Viber, WhatsApp, Twitter зэрэг гадаадын цахим платформуудын талаар судалгаанд оролцсон эцэг эхчүүдийн 60 гаруй хувь нь мэдээлэлгүй байна.





Үүнийг эцэг эхчүүд өдөр тутамд идэвхтэй ашигладаггүй, агуулга, онцлог, нөлөөллийн талаар хангалттай ойлголтгүй, хэлний бэрхшээлээс шалтгаалан хэрэглээний хүртээмжийг бууруулж, оролцоог хязгаарлах нөхцөл болдог, боловсрол, мэдээлэл хуваалцах идэвхтэй суваг болоогүйтэй холбоотой саад бэрхшээл учруулж байгааг чанарын судалгаанд оролцогчид илэрхийлж байна. Иймээс эдгээр платформууд дахь хэрэглээг үр дүнтэй зохицуулахын тулд эцэг эхчүүдийн дижитал мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх, цахим хэрэглээний талаарх сургалт, зөвлөмжийг өгөх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Зураг 3.52. Цахим сүлжээний хэрэглээний нөлөөлөл, хувиар




### 3.3.5. Садан төрлийн харилцаа

Судалгаанд оролцогчдын дунд аав ээж, өвөө эмээтэйгээ хамт амьдардаг (19.0 хувь) эсвэл өдөр тутам тогтмол холбоотой байдаг (26.0 хувь) тохиолдол түгээмэл ажиглагдсан бөгөөд ялангуяа хөдөө орон нутагт амьдардаг иргэдийн хувьд илүү төрөл садантайгаа холбоотой байдаг байна. Хөдөө орон нутгийн оролцогчид хөдөөгийн хүн амын амьдралын хэв маяг, гэр бүлийн гишүүдийн ойр байршил зэрэг нь үе хоорондын уялдаа холбоог хадгалах, өдөр тутмын харилцааг дэмжих таатай орчныг бүрдүүлдэг гэж үзжээ. Харин нийслэл болон аймгийн төвүүдэд амьдардаг иргэдийн хувьд хол зайд орших, амьдралын хурдтай хэмнэл, ажлын ачаалал зэргээс шалтгаалан ахмад үеийнхэнтэй харилцах давтамж, шууд уулзалтын боломж харьцангуй багасаж буй хандлага ажиглагдаж байна.



Зураг 3.53. Өндөр настай аав ээж, өвөө эмээгээ эргэж тойрдог байдал, байршил, хувиар



Аав ээж, өвөө эмээ нартаа хэрхэн тусалж дэмждэгийг тодруулахад оролцогчид нь эрүүл мэндэд нь анхаарах буюу эм тариаг нь зөөх, эмнэлэгт үзүүлэх (23.0 хувь), хоол хүнсийг нь бэлтгэж өгөх (18.0 хувь), гэр орных нь ажилд туслах (18.0 хувь) зэрэг дэмжлэгийг судалгаанд оролцогчдын ихэнх нь үзүүлж байна. Мөн аав ээж, өвөө эмээтэйгээ хэр тогтмол уулзаж буйгаас шалтгаалан хэрхэн тусламж үзүүлж буйг шинжилбэл аав ээж, өвөө эмээтэйгээ байнга ойр дотно харилцаатай, ойрхон оршин суудаг судалгаанд оролцогчид тэдний эрүүл мэнд, хоол хүнс, гэр ахуйн хэрэгцээнд нь түлхүү дэмжлэг үзүүлэх хандлагатай байна. Харин тогтмол уулзаж харилцах боломж тааруу оролцогчдын хувьд өдөр тутмын болон баяр ёслолын үеийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх хандлага ажиглагдаж байна.

Зураг 3.54. Аав ээж, өвөө эмээдээ тусалдаг байдал, давхардсан тоо, хувиар





Нийт оролцогчдын хувьд аав ээж, өвөө эмээгээсээ мөнгөн тусламж авах болон хүүхдээ харуулах зэрэг туслалцааг голчлон авдаг байна. Мөн 3 хүн тутмын нэг нь огт туслалцаа авдаггүй бөгөөд уулзах болон холбогдох давтамж нь багасахын хэрээр туслалцаа авахгүй байх магадлал өндөр байгаа юм. Харин туслалцаа авдаг оролцогчдыг дэлгэрүүлж харвал эсрэгээрээ ойрхон тогтмол уулзаж, цуг байх тусам илүү их дэмжлэг авч байгааг харж болно. Жишээлбэл, хүүхдээ харуулдаг хүмүүсийн дунд хамгийн өндөр хувь буюу 48.3 хувь нь цугтаа амьдардаг, 38.2 хувь нь өдөр тутам холбоотой байдаг, 35.2 хувь нь долоо хоног бүр эргэж тойрдог, 32.2 хувь нь сар бүр эргэж тойрдог байна.

Зураг 3.55. Аав ээж, эмээ өвөөгөөсөө авдаг тусламж, хувиар



Төрөл садантайгаа холбоо хамааралтай, нэгдмэл буй эсэхийг оролцогчдоос тодруулсан бөгөөд үүнд нийгмийн хүчин зүйлс нөлөөлж буй эсэхийг шинжлэхээр хи квадратын тест хийсэн.

- Төрөл садантайгаа ойр дотно байх нь боловсролын зэрэгтэй хамааралтай байна ( $\chi^2=39.8$ ,  $p=.000$ ). Хэдийгээр дийлэнх оролцогчид нь төрөл садантайгаа холбоотой байдаг ч боловсролын зэрэг дээшлэх тусам дотно байх үзэгдэл буурч байна.
- Мөн өрхийн төрөл нь хамаатан садантайгаа ойр дотно байдалтай хамааралтай байна ( $\chi^2=34.53$ ,  $p=.001$ ). Ганц бие болон өрөөсгөл гэр бүлийн гишүүдэд төрөл садантайгаа холбоо муу байх хандлага илүү ажиглагдаж байна.



- Үүнээс гадна оршин сууж буй байршил нь төрөл садангийн харилцаанд нөлөөлж байна ( $\chi^2=47.62$ ,  $p=.000$ ). Оролцогчдын дийлэнх нь хамаатан садантайгаа холбоо сайн байгаа ч хэд хэдэн тохиолдлуудад ялгаа ажиглагдаж байна. Тухайлбал, амьдарч буй байршил нь илүү төв суурин газар байх тусам төрөл садантайгаа баяр ёслолын үеэр уулздаг байх тохиолдол нь огцом өсөж байгаа юм. Энэ нь төв суурин газарт амьдарч буй хүмүүс илүү индивидуал шинж чанартай байдагтай холбоотой байх магадлалтай. Мөн байнгын дотно харилцаатай байх нь хөдөө суурьшин амьдарч буй иргэдэд хамгийн өндөр 54 хувьтай байгаа бол төв суурин газар байх тусам энэ үзүүлэлт нь багасаж байна.

### Хүснэгт 3.7. Төрөл садантайгаа харилцах харилцаа, хувиар

|              |                       | Ямар ч холбоогүй | Мэддэг, харилцаагүй | Зөвхөн баяр, оршуулгын үеэр уулздаг | Байнгын харилцаагүй ч холбоо-той байдаг | Байнгын, дотно харилцаатай | Хи                           |
|--------------|-----------------------|------------------|---------------------|-------------------------------------|-----------------------------------------|----------------------------|------------------------------|
| Боловсрол    | Бүрэн бус дунд хүртэл | 4                | 3                   | 7                                   | 30                                      | 57                         | $(\chi^2 = 39.8, p = .000)$  |
|              | Бүрэн дунд            | 2                | 4                   | 11                                  | 33                                      | 50                         |                              |
|              | Тусгай, техникийн     | 3                | 3                   | 10                                  | 32                                      | 52                         |                              |
|              | Дээд ба түүнээс дээш  | 2                | 4                   | 13                                  | 41                                      | 41                         |                              |
| Өрхийн төрөл | Ганц бие              | 4                | 5                   | 12                                  | 32                                      | 47                         | $(\chi^2 = 34.53, p = .001)$ |
|              | Дан                   | 1                | 2                   | 11                                  | 40                                      | 47                         |                              |
|              | Нийлмэл               | 1                | 4                   | 12                                  | 37                                      | 47                         |                              |
|              | Өрөөсгөл              | 3                | 6                   | 11                                  | 32                                      | 49                         |                              |
| Байршил      | Нийслэл               | 2                | 5                   | 16                                  | 36                                      | 42                         | $(\chi^2 = 47.62, p = .000)$ |
|              | Аймгийн төв           | 2                | 4                   | 10                                  | 34                                      | 49                         |                              |
|              | Сумын төв             | 2                | 2                   | 8                                   | 36                                      | 53                         |                              |
|              | Хөдөө                 | 2                | 5                   | 6                                   | 32                                      | 54                         |                              |

## 3.4. Гэр бүлийн үнэт зүйлс

### 3.4.1. Гэр бүлийн эрхэмлэн дээдэлдэг зүйлс

Гэр бүл оршин тогтноход шаардлагатай хэрэгцээнүүдээс аль нь өнөөгийн гэр бүлүүдэд хамгийн чухал болохыг тодруулж бөгөөд 2010 оноос хойш 15 жилийн хугацаанд хэрхэн өөрчлөгдөж буйг доорх хүснэгтээр харууллаа.



2025 оны байдлаар судалгаанд оролцогчдын 41 хувь нь бие биеэ ойлгож хүндэлдэг байх нь хамгийн чухал хэрэгцээ, 39 хувь нь өөрийн гэсэн гэр оронтой байх, 30 хувь нь амьдралын ая тухтай байдал гэж хариулжээ. Харин 2019 оны байдлаар элэг бүтэн хамтдаа байх хэрэгцээ 55 хувиар тэргүүлж, улмаар 30 хувь нь амьдралын ая тухтай байдал, 23 хувь нь өөрийн гэсэн гэр оронтой байх, 23 хувь нь гэр бүлийн тогтвортой байдал гэж үзжээ. 2010 оны байдлаар 48 хувь нь амьдралын ая тухтай байдал, 42 хувь нь өөрийн гэсэн гэр оронтой байх, 34 хувь нь бие биеэ хайрлах хэмээн үзсэн байна. Эдгээр үзүүлэлтээс харахад сүүлийн 15 жилийн хугацаанд өөрийн гэсэн гэр оронтой байх болон амьдралын ая тухтай байдал нь гэр бүлүүдийн хувьд хамгийн чухал, тогтвортой хэрэгцээ хэвээр байгааг харуулжээ.

*Хүснэгт 3.8. Гэр бүлд нэн шаардлагатай зүйлс, өнгөрсөн он, хувиар*

| Гэр бүлд шаардлагатай зүйлс                     | 2010 | 2019 | 2025 |
|-------------------------------------------------|------|------|------|
| <b>Материаллаг хэрэгцээ</b>                     |      |      |      |
| Наад захын хэрэгцээний зүйлээр гачигдахгүй байх | 17   | 13   | 17   |
| Өөрийн гэсэн гэр оронтой байх                   | 42   | 23   | 39   |
| Амьдралын ая тухтай байдал                      | 48   | 30   | 30   |
| Эд хөрөнгө мөнгөтэй байх                        | 15   | 9    | 4    |
| <b>Сэтгэл санааны хүчин зүйл</b>                |      |      |      |
| Биеэ ойлгож хүндэлдэг байх                      | 24   | 13   | 41   |
| Бие биеэ хайрлах                                | 34   | 15   | 16   |
| Амьдралын идэвх зүтгэлтэй байх                  | 11   | 11   | 15   |
| Нэг санаа зорилготой байх                       | -    | 12   | 13   |
| Бие биедээ итгэдэг байх                         | -    | 13   | 19   |
| <b>Бэлгийн харилцаа</b>                         |      |      |      |
| Бэлгийн харилцаанд ханамжтай байх               | 8    | 2    | 3    |
| <b>Үр хүүхэд, гэр бүлийн бат бэх байдал</b>     |      |      |      |
| Үр хүүхэдтэй байх                               | 23   | 16   | 28   |
| Гэр бүлийн тогтвортой байдал                    | 15   | 23   | 22   |
| Элэг бүтэн хамтдаа байх                         | 25   | 55   | 25   |

Гэр бүлийн эрхэмлэн дээдэлж буй үнэт зүйлс нь цаг хугацаа, даяарчлал, нийгмийн байдлын эрхэнд хэрхэн өөрчлөгдөж буйг тодруулахаар уламжлалт болон орчин үеийн үзлийн үнэт зүйлүүдийг олон давтамжит сонголттойгоор асуусан билээ. 2010 оноос хойших 15 жилийн хугацаанд иргэдийн эрхэм зүйл нь тодорхой хэмжээнд өөрчлөгджээ. Тухайлбал, уламжлалт ёс заншил, эх орон, эцэг эх, гэр бүлийн халуун дулаан уур амьсгал, зэрэг уламжлалт үнэт зүйлс нь огцом өссөн байгаа ч хайр сэтгэл итгэлцлийг эрхэмлэх мэдрэмж нь 26 хувиар буурсан байна. Харин ажил мэргэжил, нэр хүнд удам угсаа, эрүүл мэнд зэргийг эрхэмлэх мэдрэмж багассан байгаагаас орчин үеийн шинж чанартай үнэт зүйлүүд тийм ч чухал байх суурь эзлэхгүй байгааг харуулж байна.



### Хүснэгт 3.9. Гэр бүлийн эрхэмлэн дээдэлдэг зүйлс, өнгөрсөн он, хувиар


| Эрхэм зүйл                           | 2010 | 2019 | 2025 |
|--------------------------------------|------|------|------|
| <b>Уламжлалт үнэт зүйлс</b>          |      |      |      |
| Төр засаг                            | 1    | -    | 0.4  |
| Уламжлалт ёс заншил                  | 4    | -    | 22   |
| Эх орон                              | 4    | -    | 23   |
| Эцэг эх                              | 15   | -    | 47   |
| Гэр бүлийн халуун дулаан уур амьсгал | 38   | 59   | 45   |
| Хайр сэтгэл, итгэлцэл                | 43   | -    | 17   |
| Үр хүүхэд                            | 44   | -    | 44   |
| <b>Орчин үеийн үнэт зүйлс</b>        |      |      |      |
| Хууль ёс                             | 1    | -    | 2    |
| Үзэл бодол                           | 3    | -    | 6    |
| Хүний эрх чөлөө                      | 5    | 7    | 6    |
| Өв хөрөнгө                           | 1    | -    | -    |
| Мөнгө эд хөрөнгө                     | 9    | 7    | -    |
| Ажил мэргэжил                        | 11   | -    | 5    |
| Нэр хүнд, удам угсаа                 | 21   | -    | 9    |
| Мэдлэг боловсрол                     | 32   | 39   | 11   |
| Эрүүл мэнд                           | 60   | 72   | 30   |

#### 3.4.2. Гэр бүлийн ургийн бичиг, овог

Жил ирэх тусам иргэдийн ургийн бичиг хөтлөх байдал болон энэ талаарх хандлага өөрчлөгдөж байна. 2010 болон 2025 онуудын судалгааны үр дүнг харьцуулж харвал нийт оролцогчдын эзлэх хувьд ургийн бичиг хөтөлдөг хүний тоо өссөн бөгөөд ургийн бичиг хөтөлдөггүй ч хөтлөх бодолтой хүний тоо мөн 10 пунктээр өссөн үзүүлэлттэй байна. Мөн ургийн бичгийг хөтлөх бодолгүй байгаа хүний тоо огцом буурсан (19.0 хувь) байгаа нь ургийн бичиг хөтлөхийн ач холбогдлыг ойлгох, үнэлэх хандлага нийгэмд нэмэгдэж буйг харуулж байна. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд төрийн байгууллагуудаас ургийн бичиг хөтлөхтэй холбоотой хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлсэн нь энэ өсөлтөд нөлөөлсөн байх талтай. Мөн ФБЯ-ын ярилцлагын явцад оролцогчид ажлын шугамаар ургийн бичиг хөтөлж эхэлсэн хэмээн хариулсан нь энэхүү хөтөлбөр үр дүн өгч байгааг харуулж байна. Үүнээс үзэхэд ургийн бичиг хөтлөх хандлага жилээс жилд нэмэгдэж, хувь хүн болон нийгмийн ухамсарт чухал байр суурь эзэлж эхэлжээ.




Зураг 3.56. Ургийн бичиг хөтлөх байдал, өнгөрсөн он, хувиар



Судалгаанд оролцогчдын 75.2 хувь нь ургийн овгоо зөв тодорхойлсон гэж үзсэн бол үлдсэн 24.8 хувь нь энэ тал дээр эргэлзээтэй болон буруу ургийн овгоор бүртгэгдсэн байх магадлалтай гэсэн байр суурьтай байгаагаа илэрхийлжээ. Үүнээс улбаалан оролцогчдын 13.0 хувь нь ямар нэгэн хэмжээнд ургийн овгоо солих хүсэлтэй байгаа бөгөөд ганцаарчилсан ярилцлагын явцад ургийн овгоо солиулахад хэтэрхий төвөгтэй, бичиг баримт бүрдүүлэлт ихтэй байдаг учраас солиулаагүй хэмээн тайлбарлаж байна.


Зураг 3.57. Ургийн овгоо зөв тодорхойлсон ба ургийн овгоо солих бодолтой эсэх, хувиар

Ургийн овгоо зөв тодорхойлсон уу?



■ Тийм ■ Үгүй ■ Мэдэхгүй


Ургийн овгоо солих бодолтой эсэх



■ Байхгүй ■ Маш их ■ Маш бага ■ Дунд зэрэг ■ Мэдэхгүй

Судалгаанд оролцогчдын хувьд эцгийн талын хэдэн үеэ мэддэг болохыг тодруулахад 2 хүн тутмын нэг нь 3-4 үеэ тодорхой хэмжээнд мэддэг гэж хариулсан байна. Харин огт мэдэхгүй хүн хамгийн бага хувийг буюу 1.0 хувийг эзэлж байгаа бөгөөд 9-өөс дээш үеэ мэддэг нь 2.0 хувьтай байна.

Зураг 3.58. Судалгаанд оролцогчдоос хэдэн үеэ мэддэг эсэх, хувиар





### 3.4.3. Гэр бүлийн талаарх үзэл хандлагууд

Гэр бүлийн харилцаанд тогтсон хэвшсэн ойлголт, үзэл хандлагууд цаг хугацааны явцад хэрхэн өөрчлөгдөж буйг шинжилж үзэхэд дараах өөрчлөлтүүд ажиглагдаж байна.

- Уламжлалт хандлагатай санал нийлж буй байдалд тодорхой өөрчлөлт гараагүй ч эсрэг байр суурь илэрхийлэх хандлага буурсан байна. Тухайлбал, гэр бүлд ахмад настны үг мөрдлөг байх ёстой гэдэгтэй санал нийлэхгүй гэж хариулсан хүмүүс нь 2010 онд 31% байсан бол 2025 онд 14% болж багассан байна. Харин уг үзэлтэй санал нийлж буй хариулт нь 2%-иар өссөн бөгөөд санал нийлэхгүй гэж үзэж буй хүмүүсийн бодол илүү дунджаа барих буюу “дунд зэрэг” гэх бүлэг рүү шилжиж байгаа юм. Өөрөөр хэлбэл, 15 жилийн хугацаанд оролцогчдын хувьд илүү уламжлалт хандлагыг эсэргүүцэх хандлага багассан байна.
- Орчин үеийн гэр бүлийн талаарх хандлагуудад олон талт өөрчлөлтүүд харагдаж байна. Тухайлбал, гэр бүлийг заавал төлөвлөх ёстой болон хамтран амьдрагчид нь гэр бүл мөн гэх хандлагыг илүү дэмжиж байна. Харин эсрэгээрээ материаллаг сонирхолд тулгуурласан гэрлэлтийг хүлээн зөвшөөрөхгүй байх хандлага ихэсжээ. Мөн ижил хүйстэн гэр бүл байж болохгүй гэсэн үзэл олонхын байр суурь хэвээрээ байгаа ч судалгаанд оролцогчдын дунд эсэргүүцлийн хувь 7 хувиар буурч, тухайн асуудалд төвийг сахисан хүмүүсийн тоо нэмэгдсэн байна.

#### Хүснэгт 3.10. Гэр бүлийн тухай үзэл хандлага, өнгөрсөн он, хувиар

| Гэр бүлийн тухай үзэл хандлагууд                                         | 2010         | 2025 | 2010            | 2025 |
|--------------------------------------------------------------------------|--------------|------|-----------------|------|
|                                                                          | Санал нийлнэ |      | Санал нийлэхгүй |      |
| Уламжлалт                                                                |              |      |                 |      |
| Эрэгтэй хүн гадаад хүнтэй гэрлэх нь байж болохгүй                        | -            | 36   | -               | 51   |
| Гэр бүлд ахмад настны үг мөрдлөг байх ёстой                              | 70           | 72   | 31              | 14   |
| Эрчүүд гэр бүлээ авч явах ёстой                                          | 76           | 71   | 25              | 18   |
| Эмэгтэйчүүд эрчүүдтэй эхэлж танилцах, гэрлэхийг санал болгох нь зохисгүй | 46           | 42   | 54              | 41   |
| Орчин үеийн                                                              |              |      |                 |      |
| Эмэгтэй хүн гадаад хүнтэй гэрлэх нь байх л зүйл                          | -            | 41   | -               | 48   |
| Гэр бүлийг заавал төлөвлөх ёстой                                         | 76           | 85   | 24              | 8    |
| Ижил хүйстэн гэр бүл байж болно                                          | 21           | 20   | 79              | 70   |
| Хамаатнуудтайгаа ойр дотно байж тусалж байх албагүй                      | 52           | 50   | 48              | 32   |
| Материаллаг сонирхолд тулгуурласан гэрлэлт байж болно                    | 32           | 17   | 68              | 72   |
| Насанд хүрсэн хүмүүст тохиолдлын бэлгийн хавьтал байх л зүйл             | -            | 42   | -               | 41   |
| Гэр бүлийн гишүүд тэгш эрхтэй байх ёстой                                 | 93           | 91   | 7               | 3    |
| Гэрлэлтээ батлуулаагүй хамтран амьдрагчид бол гэр бүл мөн                | 47           | 55   | 53              | 37   |

Жич: 2025 оны дүнд “дунд зэрэг” гэх хариултууд тодорхой хувийг эзэлж буй тул 100%-д баригдахгүй болно.





Фокус бүлгийн ярилцлагын үед гэр бүлийн ойлголт хандлагын талаар илүү дэлгэрүүлэн тодруулахад дараах үр дүн гарсан.

*Зураг 3.59. Фокус бүлгийн ярилцлага, гадаад хүнтэй гэр бүл болох талаар*



Хүүхдээ гадаад иргэнтэй гэр бүл болбол хэрхэн хандах талаар лавлаж асуухад оролцогчид зөвшөөрөх эсэх дээр хоёр талд хуваагдах хандлагатай байна. Гэвч зөвшөөрч буй иргэдэд нийтлэг хандлага ажиглагдсан нь хүүхэд нь европын улс орнуудын иргэнтэй гэр бүл болохыг хүлээн зөвшөөрөх ч хятад улсын иргэн болон ядуу орны иргэнтэй гэр бүл болохыг эсэргүүцэх хандлага байна.

**Гадаад хүнтэй гэр бүл болох талаар - Фокус бүлгийн ярилцлага**

*...Зөвшөөрөхгүй. Гадны хүнтэй гэрлэвэл Монгол улсаас яваад өгнө. Охин хүүхэд бол бүр болохгүй. Эрэгтэй хүүхэд бол яахав гадны хүн ийг авчирч болно...*

Дан гэр бүлийн эрэгтэй, нас 46, дээд боловсролтой  
Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэл, Увс аймаг

*...Асуудалгүй болно. Европ талруугаа хүнтэй суувал зүгээр....*

Дан гэр бүлийн эмэгтэй, нас 23, бүрэн дунд боловсролтой  
Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэл, Улаанбаатар

*...Ер нь эсрэг байр суурьтай байдаг. Монгол соёлыг холдуулна уу гэхээс ойртуулахгүй. Би хүүхдүүддээ хэлдэг ёстой тийм юм байхгүй...*

Дан гэр бүлийн эрэгтэй, нас 49, бүрэн дунд боловсролтой  
Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэл, Дорнод аймаг



Мөн ижил хүйстэн гэр бүлийн талаарх иргэдийн бодлыг асуухад тоон судалгаатай адилаар хүлээн зөвшөөрөхгүй гэх хандлага давамгайлж байсан. Ярилцлагын үеэр энэ хандлагын шалтгааныг тодруулахад, цөөн хүн амтай монгол улсад ижил хүйстэн гэр бүлийг хүлээн зөвшөөрөх нь үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй учир иргэд үүнтэй санал нийлэхгүй байна. Мөн зарим оролцогчид ижил хүйстний гэр бүлийг хувь хүний сонголт гэж үзэх боловч, “нийгэмд сурталчлах, өөхшүүлэх ёсгүй” хэмээн хязгаарлагдмал байдлаар хүлээн зөвшөөрдөг байдал ч ажиглагдсан нь тухайн асуудалд түрэмгий бус, гэхдээ болгоомжлол бүхий төвийн байр суурь давамгайлж байгааг харуулж байна.

### **Ижил хүйстэн гэр бүлийн талаар - Фокус бүлгийн ярилцлага**

*...Зөв ч гэхгүй буруу ч гэхгүй. Тэгэхдээ тэр хүмүүсийг харж байгаа хүүхдүүд нь дөнгөж 25-тай битгий нээх сурталчлаарай л гэвэл. Буруу гэж бодож байна...*

Дан гэр бүлийн эрэгтэй, нас 29, дээд боловсролтой  
Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэл, Улаанбаатар хот

*...Энэ бол байж болохгүй зүйл. Барууны орнууд бол ганц нэгээрээ зөвшөөрөөд эхэлсэн юм байна лээ. Энэ хувь хүмүүсийн ухамсар, бас шашин шүтлэгтэй холбоотой байх. Барууны орнуудад бол их задгай, хүмүүс нь тал талаас цуглараад яг нэг үндэстэн гэж бараг байхгүй. Монголчуудын хувьд бол ерөөсөө байж болохгүй зүйл. Монгол хүн гэдэг бас нэг ондоо, цөөхөн хүн амтай, энэ генээ хамгаалах ёстой, ялангуяа эрчүүдийн хувьд ерөөсөө энэ байж болохгүй зүйл...*

Дан гэр бүлийн эрэгтэй, нас 30 бүрэн дунд боловсролтой  
Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэл, Увс аймаг

*...Хэтэрхий хүний эрх гэж байгаад улс үндэстнээрээ өртчих вий гэж их айдаг болсон. Эрэгтэй хүмүүс янз бүрийн байдлаар сонирхоод өртчих вий гээд их бодогддог болсон. Бусад хэдэн зуун сая хүн амтай улсын хэдэн хувь нь билээ, манай 3 сая хүн амтай улсын хэдэн хувьд байх шал өөр...*

Дан гэр бүлийн эмэгтэй, нас 33, дээд боловсролтой  
Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэл, Дорнод аймаг



## БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал бүлгийн хүрээнд гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн үүрэг хариуцлага, гэр бүлийн харилцаа хандлага, гэр бүлийн үнэт зүйлс зэргийг судалсан. Ингэхдээ иргэдийн гэр бүлийн амьдралд бэлтгэж буй байдал, хүүхэдтэй болох төлөвлөгөө, гэр бүлийн гишүүдийн үүрэг, хариуцлага, эрх мэдэл, хөдөлмөрийн хуваарилалт, эхнэр нөхөр, хүүхэд, садан төрлийн хоорондын харилцаа, хүүхдийн хүмүүжлийн асуудлууд, цахим сүлжээний хэрэглээ, гэр бүлийн үнэт зүйл, эрхэмлэн дээдэлдэг зүйлс, ургийн бичиг хөтлөлт, гэр бүлийн тухай үзэл хандлага зэргийг нарийвчлан авч үзлээ.

Оролцогчид нь өнөөгийн залуусыг гэр бүлийн амьдралд хангалттай бэлтгэгдээгүй гэж үзэж байгаа ба эцэг эхийн зүгээс хүүхдээ бие даах, хариуцлагатай, ёс суртахуунтай байх чадварт суралцуулах хэрэгтэй гэж үзэж байна. Мөн залуусыг 24-29 насандаа гэр бүлээ зохиох нь тохиромжтой гэж үзэж байгаа ба эдийн засгийн чадамжтай байх шаардлагатай хэмээн хариулжээ. Нийт оролцогчдын 70 гаруй хувь нь ойрын жилүүдэд хүүхэдтэй болох төлөвлөгөөгүй ч 53 хувь нь жирэмснээс хамгаалах ямар нэгэн арга хэрэгсэл хэрэглэдэггүй байна. Иргэдийн хувьд дунджаар 3-4 хүүхэдтэй байх, хүүхэд хоорондын зай 3-4 настай байх нь зохимжтой гэж дийлэнхээрээ санал нэгдсэн байна.

Судалгааны үр дүнд гэр бүлийн өрхийн тэргүүн эрэгтэй хүн байх нь зохимжтой гэж 77 хувь нь хариулсан ба энэ нь жил ирэх тусам буурах хандлага ажиглагдаж байгаа юм. Мөн өрхийн тэргүүн хүн нь амьдралын нуруутай, гэр бүлдээ халамжтай, хариуцлагатай байх хэрэгтэй гэсэн шаардлагыг 2 хүн тутмын нэг нь тавьж байна. Гэр бүл дэх аливаа үүрэг хариуцлагын хуваарилалтыг голчлон эхнэр, нөхрүүд хамтдаа гүйцэтгэж байгаа хэдий ч хүүхдэд анхаарах, санхүү удирдах болон гэрийн ажлыг эхнэрүүд илүү хариуцаж байгаа бол ёс заншлыг зааж сургах, гэр бүлээ тэжээх, шийдвэр гаргах зэрэгт нөхрүүд илүү давамгайлж байна. Хэдийгээр үүрэг хариуцлагыг эрэгтэй эмэгтэй хүнийх гэж ангилахгүйгээр хэн боломжтой нь хийх хэрэгтэй хэмээн 5 хүн тутмын 4 нь хариулж байгаа ч бодит байдал дээр эмэгтэйчүүд илүү их үүрэг хариуцлагыг үүрч байгааг ФБЯ-аар тодруулан гаргаж ирсэн. Иргэдийн гэр бүлдээ хүлээж буй үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлж чадахгүй байх нь санхүү болон туршлага дутмаг байдал, мөн ажил төрөл ихтэй хойшлуулж байдгаас шалтгаалж байна.



Оролцогчдын тал гаруй хувь нь эхнэр нөхрийн харилцаандаа сэтгэл хангалуун байгаа ба эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү сэтгэл ханамжтай байгаа аж. Эхнэр нөхрийн харилцаандаа сэтгэл ханамжтай байхад өрхийн орлого, хоорондоо ярилцаж чаддаг байх эсэх нь шууд хамааралтай байна. Үүний шалтгаан нь хосууд хоорондын нэгнээсээ хүсэх зүйлсээс хамаарч байгаа бөгөөд зарим зүйлс дээр эхнэрүүд нөхрөөсөө илүү их хүсэх тохиолдол ажиглагдаж байсан нь эхнэрээ гомдоохгүй байх, гэр бүлтэйгээ цагийг өнгөрөөх, гэрийн ажилд туслах, илүү их мөнгө олох болон архи уухгүй байх зэрэг юм. Үүнээс харахад гэр бүлийн харилцаанд шаардлагатай зүйлсийг нөхрүүд хангалттай хийж чадахгүй байна гэж эхнэрүүд үзэж байгаа юм.

Хүүхэд өсгөхөд эрүүл саруул сайн хүн болгох, боловсрол мэргэжилтэй, амьдрах ухаан суулгах зэрэг нь хамгийн чухал гэж нийт оролцогчид харж байгаа ба цаашлаад эмэгтэйчүүд илүүтэйгээр хүүхдийн хүмүүжил, боловсрол зэрэгт анхаарч байгаа бол эрэгтэйчүүд ерөнхий амьдралын хэрэгцээг нь чухалчилж үзэх хандлага давамгайл байна. Мөн адил хүүхдэд юу өвлүүлж үлдээх хэрэгтэй тал дээр эмэгтэйчүүд илүүтэйгээр боловсрол, хүмүүжил, хайр халамжийг чухалчилсан бол эрэгтэйчүүд монгол өв соёл, уламжлал, эд хөрөнгө зэргийг эмэгтэйчүүдээс илүү үнэлжээ. Хүүхэдтэйгээ цагийг өнгөрүүлэхэд мөн хүйсийн ялгаа гарч байсан нь эрэгтэй хүмүүс илүү бие бялдар хөгжүүлэх байдлаар хүүхэдтэйгээ цагийг өнгөрүүлж байсан бол эмэгтэйчүүд нь сэтгэлзүй, мэдлэг чадварыг нь хөгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Оролцогчдын дийлэнх нь хүүхдэд 11-20 насанд бэлгийн боловсрол олгох хэрэгтэй гэж үзэж байсан ба тал гаруй хувь нь хүүхдэд энэ талаар мэдлэг олгоход тодорхой хэмжээний мэдээлэлтэй гэж үзэж байв. Мөн хүүхдэд бэлгийн боловсрол олгохдоо ямар байдлаар хандах талаар тодруулахад боловсролын түвшин өндөр байх тусам илүү чөлөөтэй ярилцаж чадна гэж хариулснаас харвал хүүхдэд бэлгийн боловсрол олгох эцэг эх, асран хамгаалагч нар нь өөрсдөө энэ тал дээр боловсрол, мэдлэгтэй байх шаардлагатайг харуулж байна.

Дийлэнх оролцогчдын хүүхдүүд нь цахим сүлжээг идэвхтэй ашиглаж байгаа бөгөөд эцэг эхийн наснаас шалтгаалан хүүхдийн цахим сүлжээ ашиглах хугацаа ялгаатай байна. Тухайлбал залуу эцэг эхчүүд илүү хүүхдээ цахим сүлжээг бага ашиглуулж байгаа юм. Иргэдийн үзэж буйгаар цахим сүлжээ нь эергээсээ илүү сөрөг үр дагавартай хэмээн үнэлсэн бөгөөд үүнд нойргүйдэл, цаг хугацаа хэт ихээр зарцуулах зэрэг нь давамгайлж байгаа юм.



Аав ээж, өвөө эмээтэй оролцогчид нь тэдэнтэйгээ байнга холбоотой байж дэмжиж туслах, эсвэл эсрэгээрээ тусламж авах хандлага их байгаа юм. Тухайлбал, настай гэр бүлийн гишүүндээ голчлон эрүүл мэндэд нь анхаарах, хоол хүнсийг нь бэлтгэх, гэр орных нь ажлыг хийх замаар тусалж байгаа бол нөгөө талдаа настай хүмүүсээсээ мөнгөн тусалцаа авах, хүүхдээ харуулах зэрэг дэмжлэг авч байна. Мөн дийлэнх оролцогчид нь төрөл садантайгаа байнгын холбоотой байдаг ч төв суурин газар луу амьдардаг байх тусмаа зөвхөн баяр ёслолоор уулздаг байх хандлага илүү ажиглагдаж байна.

Нийт оролцогчдын хувьд гэр бүлд хамгийн чухал зүйлс нь бие биеэ ойлгож хүндэлдэг байх, өөрийн гэсэн гэр оронтой байх, амьдралын ая тухтай байдал зэрэг бөгөөд эдгээр хэрэгцээнүүд нь сүүлийн 15 жилийн турш өөрчлөгдөөгүй байна. Мөн гэр бүлийн ургийн бичиг хөтлөх байдал нь сүүлийн 15 жилд өсөх хандлагатай байна.

## БҮЛГИЙН ЗӨВЛӨМЖ

**Эцэг эх, асран хамгаалагч нарт чиглэж гэр бүлийн боловсролыг олгох, сэтгэл зүй болон гэр бүлийн зөвлөгөөний хүртээмжийг нэмэгдүүлэх**

- СӨБ, ЕБС-ийн эцэг эхийн хурал, уулзалтыг “сургалт+дадлага” хэлбэрт шилжүүлж, улирал бүр богино хэмжээний эерэг хүмүүжлийн арга, хүүхдийн бэлгийн боловсролын талаарх сургалтыг хэрэгжүүлэх;
- Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Дэлхийн зөнгийн хамтран эрхлэн гаргасан “Хүүхдийг хүмүүжүүлэх эерэг арга” гарын авлагыг олон нийтэд нээлттэй тараах, цахим хэлбэрээр байршуулах.

**Гэр бүлийн дотоод үүргийн хуваарилалтыг тэгш, хамтын оролцоонд үндэслэн зохион байгуулах**

- Гэрийн ажлыг зөвхөн эмэгтэйчүүдийн үүрэг гэж үзэх хандлагыг бууруулах зорилгоор нийгмийн ухамсар, хэвшмэл ойлголтод нөлөөлөх бодлого хэрэгжүүлэх;
- Эцэг, эхийн үүрэг хариуцлагын ялгаатай байдлыг багасгах чиглэлд хөтөлбөр, урамшууллын тогтолцоо (жишээ нь: эцгийн чөлөө авах боломж, дэмжлэг) хэрэгжүүлэх.



## **Үнэлгээгүй хөдөлмөрийг үнэлэх талаарх нийгмийн ойлголтыг нэмэгдүүлэх**

- Гэрийн ажил, хүүхэд асрах хөдөлмөрийг үнэлэх, ач холбогдлыг олон нийтэд таниулах, үнэлдэггүй хөдөлмөрийн эдийн засаг дахь хувь нэмрийг судалгаа, мэдээллээр дамжуулан танилцуулах.

## **Эрэгтэйчүүдийн оролцоог идэвхжүүлэх**

- Эцэг хүний оролцоо, үүргийг сурталчлах, эерэг дүр төрх бий болгох хөтөлбөр хэрэгжүүлэх, эрэгтэйчүүдийн дунд жендерийн мэдрэмжтэй хандлага төлөвшүүлэх сургалт, уулзалт зохион байгуулах.

## **Гэр бүлийн харилцааны боловсрол, сургалтыг дэмжих**

- Эхнэр нөхрийн хоорондын харилцаанд хамгийн их нөлөөлдөг хүчин зүйл болох харилцан ярилцах чадварыг сайжруулах сургалт, зөвлөгөө өгөх хөтөлбөрийг өргөжүүлэх;
- Гэр бүлийн гишүүдийн үүргийн хуваарилалт, хамтын амьдралын үнэ цэнийг олон нийтэд сурталчлах кампанит ажил явуулах, эцэг, эхийн үүрэг хариуцлагын талаар зөв ойлголт өгөх, гэр бүлийн гишүүд бие биеэ ойлгож, дэмжихийн ач холбогдлыг таниулах.

## **Гэр бүлийн үнэт зүйл, уламжлалыг хадгалах, шинэчлэх**

- “Хайр, халамж, итгэлцэл” зэрэг гэр бүлийн харилцааны суурь үнэт зүйлсийг шинэ үеийн гэр бүлүүдэд сурталчлах, хүүхэд залуусын хүмүүжилд тусгах, уламжлалт гэр бүлийн харилцааны эерэг жишээг хадгалах, орчин үеийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх бодлого хэрэгжүүлэх.

## **Хүүхдийн хүмүүжлийн арга барилд зөвлөгөө өгөх**

- Эерэг хүмүүжлийн аргыг түгээн дэлгэрүүлэх, хүчирхийлэлгүй арга барилыг дэмжих бодлого хэрэгжүүлэх.

## **Цахим хэрэглээний чанар, агуулгад онцгой анхаарах**

- Контентын нас тохиромжтой байдал, боловсролын болон танин мэдэхүйн ач холбогдол дээр төвлөрөх;
- Хүүхдийг насанд хүрэгчдийн контент, хүчирхийлэл, цахим дарамт зэрэг сөрөг агуулгад өртөхөөс сэргийлэх фильтр, хамгаалалтын систем ашиглах.

## **Ургийн бичиг, овгийн талаарх ойлголтыг гүнзгийрүүлж, дэмжих**

- Ургийн бичиг хөтлөх хандлага нэмэгдэж, түүнийг үнэлэх үнэлэмж дээшилж буй нь үндэсний ухамсар, түүх, угсаа гарлын боловсролыг дэмжих, олон нийтийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх.



4

ГЭР БҮЛИЙН  
ХАРИЛЦААНД  
ТУЛГАМДАЖ БУЙ  
АСУУДЛУУД







## ДӨРӨВ. ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦААНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

### 4.1. Гэр бүлийн зөрчил, маргаан

Хосууд гэр бүл болох шийдвэр гарган хамтын амьдралаа эхэлснээс хойш олон сорилтуудыг хамтдаа туулдаг. Гэр бүлийн орчин дахь зөрчил, маргаан нь хамгийн түгээмэл тохиолддог үзэгдлийн нэг бөгөөд энэ нь зөвхөн харилцааны асуудал төдийгүй гэр бүлийн тогтвортой байдал, гишүүдийн сэтгэл зүйн болон нийгмийн эрүүл мэндэд шууд болон шууд бусаар нөлөөлдөг. Гэр бүлийн зөрчил, маргааныг судлахдаа түүний үүсэх суурь шалтгаан, хамрах хүрээ, нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлон судлах нь чухал ач холбогдолтой.

Гэр бүлийн хүрээнд үүсэж буй зөрчил, маргаан нь олон хүчин зүйлээс хамааран бий болдог. Тухайлбал, судалгаанд оролцогчдын 29.2 хувь нь үзэл бодлын зөрчлөөс, 24.4 хувь нь согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэснээс, 22.8 хувь нь харилцан ойлголцдоггүйгээс, 21.5 хувь нь мөнгө санхүүгийн хомсдолоос гэр бүлийн зөрчил, маргаан үүсдэг гэж үзжээ. Гэр бүлийн зөрчил, маргааны шалтгааныг хот болон хөдөөгөөр тодруулахад судалгаанд хамрагдсан хотын гэр бүлүүдийн хувьд харилцан үл ойлголцол (25.3 хувь), мөнгө санхүүгийн хомсдол (24.7 хувь) голлох шалтгаан болж байгаа бол хөдөөгийн гэр бүлүүд архидалтаас (26.1 хувь), харилцан ойлголцдоггүйгээс (21.1 хувь) үүдэлтэйгээр зөрчил маргаан гардаг байна.




### Хүснэгт 4.1. Гэр бүлийн зөрчил, маргааны шалтгаан, байршил, давхардсан тоо, хувиар

| Зөрчил маргааны шалтгаан                   | Нийт | Байршил |       |
|--------------------------------------------|------|---------|-------|
|                                            |      | Хот     | Хөдөө |
| Нийгэм эдийн засгийн хүчин зүйл            |      |         |       |
| Мөнгө санхүүгийн хомсдолоос                | 21.5 | 24.7    | 19.4  |
| Архидалтаас                                | 24.4 | 21.8    | 26.1  |
| Тусдаа ажиллаж, амьдарч байгаагаас         | 4.0  | 3.6     | 4.3   |
| Соёлын ялгаанаас                           | 0.7  | 0.5     | 0.8   |
| Шашны ялгаанаас                            | 0.8  | 1.2     | 0.5   |
| Хосуудын хувийн хүчин зүйл                 |      |         |       |
| Боловсрол мэдлэгийн ялгаанаас              | 6.4  | 5.6     | 7.0   |
| Үзэл бодлын зөрчлөөс                       | 29.2 | 29.7    | 28.9  |
| Насны зөрүүтэй байдлаас                    | 2.4  | 2.2     | 2.5   |
| Хүмүүжил, өссөн орчны ялгаанаас            | 9.0  | 9.2     | 8.8   |
| Гэр бүлийн гишүүдийн харилцааны хүчин зүйл |      |         |       |
| Харилцан ойлголцдоггүйгээс                 | 22.8 | 25.3    | 21.1  |
| Хардалтаас                                 | 16.0 | 14.5    | 17.0  |
| Хайр, халамж дутсанаас                     | 8.9  | 8.9     | 8.9   |
| Итгэл эвдэж мэхэлснээс                     | 5.7  | 7.6     | 4.6   |
| Хүний эрх чөлөөг үгүйсгэх                  | 5.8  | 7.3     | 4.8   |
| Бэлгийн таарамжгүй харилцаанаас            | 1.4  | 1.2     | 1.5   |
| Дэлгэцийн хамаарлаас                       | 13.0 | 14.2    | 12.2  |
| Бусад хүмүүсээс хамаарах хүчин зүйл        |      |         |       |
| Хүүхдийн асуудлаас                         | 19.0 | 21.5    | 17.3  |
| Эцэг, эх болон хадмуудын оролцооноос       | 7.9  | 8.3     | 7.6   |

Судалгаанд оролцсон нөхрүүдийн 27.6 хувь нь үзэл бодлын зөрчил, 25.4 хувь нь архидалт, 22.8 хувь нь мөнгө санхүүгийн хомсдол, 27.6 хувь нь харилцан үл ойлголцлоос болж гэр бүлийн зөрчил, маргаан үүсдэг гэсэн бол эхнэрүүдийн хувьд 30.5 хувь нь үзэл бодлын зөрчил, 23.2 хувь нь харилцан үл ойлголцол, 19.9 хувь нь хүүхдийн асуудал, 15.2 хувь нь дэлгэцийн хамаарал гэр бүлийн зөрчил, маргааны шалтгаан болж байна гэжээ. ФБЯ-д оролцогчид эхнэр нөхөр нэг нэгнээ хардах явдал ихэссэн нь харилцан итгэлцлийг үгүй хийж, хамтын амьдралд сэв суулган, гэр бүлийн тайван байдлыг алдагдуулж байгаа гэж үзэхийн зэрэгцээ гэр бүлийн материаллаг хэрэгцээг хангах санхүүгийн хүндрэл бэрхшээл нь зөрчил маргааны шалтгаан болж байгааг дурджээ. Мөн сүүлийн үед хүүхдийн гар утасны хяналтгүй хэрэглээ, дэлгэцийн хамаарал, донтолттой холбоотойгоор гэр бүлийн зөрчил, маргаан үүсэж байгаагаас харахад хүүхдийн дэлгэцийн зохистой хэрэглээ болон гар утасны хор уршгийн талаарх мэдлэг ойлголтыг залуу эцэг эхчүүдэд өгөх шаардлагатай байна.



Зураг 4.1. Гэр бүлийн зөрчил, маргааны шалгаан, давхардсан тоо, хүйсээр



### Гэр бүлд үүсдэг зөрчил, маргааны шалтгаан

...Хардалтын асуудал маш хэцүү байдаг. Гэртээ байдаг миний хувьд хэнтэй яах ч билээ дээ уг нь, тэгээд чимээгүй хардуулаад л байж байдаг. Эрэгтэй хүмүүс их сонин, хүүхэд хүргэж өгчхөөд хаачив гэнэ, хүүхдээ хүргэж өгчхөөд буцах замд байнга залгана. Тухайн үед нь утсаа авахгүй бол “хүүхэд хүргэж өгөхөөр явахаараа утсаа авахаа больчихдог” гээд л үг хаяна. Тэгээд л маргаан үүсдэг...

Дан гэр бүлийн эмэгтэй, нас 47, бүрэн дунд боловсролтой  
Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэл, Улаанбаатар хот


...Өчигдөр манай гэрт тулгарсан асуудал нь чиний хүүхэд утас их оролдож байна, гэхээр нь зөрүүлээд чиний ч гэсэн хүүхэд адилхан хариуцлагаа хүлээх хэрэгтэй гээд л маргаан үүссэн...

Дан гэр бүлийн эмэгтэй, нас 41, дээд боловсролтой  
Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэл, Улаанбаатар хот

Судалгаанд оролцогчдын хариултаас үзэхэд гэр бүлийн зөрчил, маргаан нь ихэвчлэн эхнэр, нөхрийн хооронд (82.0 хувь), хадмууд болон хүргэн, бэрүүдийн хооронд (32.2 хувь), мөн эцэг, эх, хүүхдүүдийн хооронд (29.6 хувь) үүсдэг гэжээ. Чанарын судалгааны үр дүнгээс харахад гэр бүлийн зөрчил, маргаан ихэвчлэн хүчтэй нь хүчгүйгээ, эрх мэдэлтэй нь эрх мэдэл багатай гишүүн рүү чиглэсэн байдлаар илэрдэг бөгөөд гэр бүлд захиран тушаах, хатуу ширүүн харилцаа давамгайлах, гэр бүлийн дотоод харилцаанд эцэг эх, төрөл садны хэт оролцоо гэр бүлийн зөрчил маргааныг улам хүндрүүлж, хурцатгах хүчин зүйл болдог байна.



Зураг 4.2. Гэр бүлийн зөрчил, маргаан үүсдэг гишүүд, давхардсан тоо, хувиар



Гэр бүлийн зөрчил, маргааныг илрэх хэлбэрээр нь авч үзэхэд хот болон хөдөөгийн ялгаа төдийлөн ажиглагдахгүй бөгөөд архидаж агсам тавих (54.2 хувь), хардах (44.0 хувь), маргалдах (44.8 хувь), нэгэндээ тоомсоргүй, хүндэтгэлгүй хандах (31.2 хувь), хэрэлдэх (30.6 хувь), хүч хэрэглэх, зодолдох (30.3 хувь), мөрийтэй тоглохоос үүдэлтэй (22.9 хувь) зөрчил, маргаан илэрдэг байна. Архидалт, агсам тавих нь гэр бүлийн зөрчил, маргааны гол шалтгаан болж буй нь хүний сэтгэл хөдлөлөө хянах чадвар алдагдаж, уур бухимдлаа хүчирхийлэл, ширүүн харилцаагаар илэрхийлдэгтэй холбоотой. Мөн архидалт нь гэр бүлийн үүрэг, хариуцлагаа умартах, санхүүгийн хямрал үүсгэх, харилцааны итгэлцэл алдагдахад хүргэдэг бөгөөд гэр бүлийн тогтвортой байдал, сэтгэл зүйн аюулгүй байдалд ноцтой заналхийлэл учруулдаг гэж чанарын судалгаанд оролцогчид илэрхийлж байна.

Харин тулгамдсан асуудал байхгүй хэмээн хариулж буй оролцогчдыг авч үзвэл эрэгтэйчүүд болон залуу насны оролцогчид илүүтэйгээр сонгосон байна.




Хүснэгт 4.2. Гэр бүлийн зөрчил, маргааны илрэх хэлбэр, байршил, давхардсан тоо, хувиар

| Зөрчилдөөний хэлбэр                        | Нийт | Байршил |       |
|--------------------------------------------|------|---------|-------|
|                                            |      | Хот     | Хөдөө |
| Маргалдах                                  | 40.7 | 37.6    | 42.9  |
| Хэн нэг нь тоомсоргүй, хүндэтгэлгүй хандах | 31.2 | 33.8    | 29.4  |
| Хэрэлдэх                                   | 30.6 | 28.4    | 32.1  |
| Хүчирхийлэх                                | 30.3 | 29.5    | 30.9  |
| Удаан хугацаагаар хөндий байх              | 17.8 | 15.9    | 19.1  |
| Түр хугацаагаар салах                      | 6.8  | 6.3     | 7.1   |
| Хардах                                     | 44.0 | 44.2    | 43.9  |
| Хүссэнээ худалдаж авч чадахгүй байх        | 11.2 | 11.0    | 11.3  |
| Хүсээгүй бэлгийн харилцаа                  | 4.0  | 5.4     | 3.0   |
| Айдас түгшүүртэй байх                      | 10.0 | 9.5     | 10.4  |
| Хамт олон найз, нөхөдтэй уулзахыг хориглох | 12.8 | 14.1    | 11.9  |
| Сургуульд сурахыг зөвшөөрөхгүй байх        | 1.5  | 1.1     | 1.7   |
| Ажил хийхийг зөвшөөрөхгүй байх             | 7.4  | 6.8     | 7.8   |
| Архидаж, агсам тавих                       | 54.2 | 54.3    | 54.2  |
| Мөрийтэй тоглох                            | 22.9 | 25.0    | 21.5  |

Судалгаанд хамрагдсан нөхрүүд ихэнхдээ архидаж, агсам тавих (54.7 хувь), маргалдах (41.4 хувь), харин эмэгтэйчүүд хардах (53.9 хувь), хэрэлдэх (45.2 хувь), нэгэндээ тоомсоргүй, хүндэтгэлгүй хандах (34.5 хувь) байдлаар гэр бүлийн зөрчил маргаан илэрч байгаа нь ажиглагдаж байна. ФБЯ-д оролцогчдын зарим нь гэр бүлийн зөрчил, маргаан нь гэр бүлийн дотоод асуудал учраас өөрсдөө зохицуулах боломжтой, бусдыг асуудалдаа татаж оролцуулснаас улам л зөрчил маргааныг даамжруулна гэж үзсэн бол нөгөө хэсэг нь гэр бүлийн зөрчил, маргаан хурцадмал байдалтай бол гуравдагч этгээдийг ялангуяа цагдаа дуудаж асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй гэж үзэж байна.

Зураг 4.3. Гэр бүлийн зөрчил, маргааны илрэх хэлбэр, хүйс, хувиар





### Гэр бүлийн харилцааны зөрчил

*...Хоёр талтай асуудал. Оролцох үедээ бол оролцох л ёстой. Хэдий олгой хагарсан ч тогоо дотроо гэдэг ч байнгын зодолдоод, асуудал нь хурцадмал болоод байвал чимээгүй өнгөрч болохгүй. Харин жижиг сажиг зөрчилдөөн бол тэд өөрсдөө зохицуулах хэрэгтэй...*

Дан гэр бүлийн эмэгтэй, нас 33, дээд боловсролтой  
Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэл, Дорнод аймаг

*...Тулгамдсан асуудал нь даамжраад зөрчилдөөн үүслээ гэж бодоход цагдаа ирээд ямар ч шийдэлд хүрэхгүй. Би СӨХ-д ажилладаг. Саяхан манай байранд нэг кейс гарсан. 2 хүн маргалдаад эхлэнгүүт хөрш нь цагдаа дуудчихаж байгаа юм. Нөхөр нь архи уучихсан байсан болохоор авч яваад л торгосон. Тэгсэн ч тухайн айлын асуудал нь огт шийдэгдээгүй, харин ч нэмээд үл ойлголцол, торгуулсан мөнгө санхүүгээс үүдсэн маргаан үүснэ. Иймд төр оролцоод, хөрш оролцоод асуудлыг бүр хүндрүүлнэ. Оролцсоноосоо бүр эсрэг үр дүн авчирч байна...*

Дан гэр бүлийн эрэгтэй, нас 48, дээд боловсролтой  
Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэл, Улаанбаатар хот

2010 онд хийсэн “Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал” судалгааны үр дүнгээр гэр бүлийн мөнгө санхүүгийн болон орон байрны асуудал тулгамдаж байсан бол энэхүү судалгаанд оролцогчид гэр бүлийн амьдралд тохиолдож буй бэрхшээлийг мөн л мөнгө санхүүгийн гачигдал, байр, орон сууцны асуудал гэж онцолсон байна. 15 жилийн өмнө хийсэн судалгааны дүнтэй харьцуулахад өнөөдөр ажил олдохгүй байх, эрүүл мэндийн асуудлыг нэн тэргүүний бэрхшээл гэж үзэх явдал буурсан нь ажлын олдоц нэмэгдэж, эрүүлийн мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж харьцангуй сайжирсан байх талтай. Нөгөөтэйгүүр, хүмүүсийн ажил амьдралын ачаалал нэмэгдсэн байна.

Харин тулгамдсан асуудал байхгүй хэмээн хариулж буй оролцогчдыг авч үзвэл эрэгтэйчүүд болон залуу насны оролцогчид илүүтэйгээр сонгосон байна.




## Хүснэгт 4.3. Гэр бүлийн амьдралд тохиолдож буй бэрхшээлтэй асуудал, хувиар

| Зөрчилдөөний хэлбэр                                                      | 2010 он | 2025 он | Өөрчлөлт |
|--------------------------------------------------------------------------|---------|---------|----------|
| <b>Нийгэм эдийн засгийн хүчин зүйлээс үүдэлтэй бэрхшээлтэй асуудлууд</b> |         |         |          |
| Санхүү мөнгө                                                             | 67.7    | 54.2    | -13.5    |
| Байр, орон сууц                                                          | 31.8    | 30.9    | -0.9     |
| Гэртэй болох                                                             | 0.1     | -       | -0.1     |
| Ажил олдохгүй байх                                                       | 21.6    | 10.3    | -11.3    |
| Ажил, ажлын ачаалал                                                      | 10.4    | 19.9    | 9.5      |
| Архидалт                                                                 | 4.8     | 4.4     | -0.4     |
| Тусдаа ажиллаж, амьдарч байгаагаас                                       | 1.1     | 3.4     | 2.3      |
| <b>Гэр бүлийн гишүүдийн харилцааны хүчин зүйлээс үүдсэн бэрхшээл</b>     |         |         |          |
| Үзэл бодлын зөрчил                                                       | 5.3     | 10.7    | 5.4      |
| Хардалт, үл итгэлцэл                                                     | 3.0     | 4.5     | 1.5      |
| Бэлгийн харилцаа                                                         | 1.2     | 1.6     | 0.4      |
| Гэр бүлээс гадуурх харилцаа                                              | 1.0     | 2.0     | 1        |
| <b>Хосуудын хувийн хүчин зүйлээс шалтгаалсан бэрхшээл</b>                |         |         |          |
| Эрүүл мэндийн асуудал                                                    | 15.1    | 9.8     | -5.3     |
| Үр хүүхдийн асуудал                                                      | 9.6     | 11.3    | 1.7      |
| Байр суурь, нэр хүнд                                                     | 1.1     | 1.5     | 0.4      |
| Хүүхэдтэй болох                                                          | 0.2     | -       | -0.2     |
| <b>Бусад хүмүүсээс хамаарах хүчин зүйлээс үүдэлтэй бэрхшээл</b>          |         |         |          |
| Хүүхэд эцэггүй өсөж байгаа нь                                            | 0.1     | -       | -0.1     |
| <b>Бэрхшээлтэй асуудал байхгүй</b>                                       | 0.1     | 22.7    | 22.6     |

Гэр бүлд хамгийн их тулгамдаж буй асуудлуудыг хот болон хөдөөгөөр харахад хотод байр орон сууцны асуудал (42.0 хувь), ажлын ачаалал (29.7 хувь), ажил олдохгүй байх (7.6 хувь) бол хөдөөд санхүү мөнгө (74.3 хувь), эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийн асуудал (14.3 хувь) болж байна. ФБЯ-д оролцогчдын үзэж байгаагаар хотын хүн амын төвлөрөл их, амьдралын өртөг өндөр байдаг тул байр орон сууцны хомсдол, түрээсийн дарамт, үл хөдлөх хөрөнгийн үнэ зэрэг нь гэр бүлд санхүүгийн дарамт үзүүлдэг. Мөн ажлын ачаалал өндөр, цаг зав багатай амьдралын хэв маяг нь гэр бүлийн харилцаанд сөргөөр нөлөөлж, маргаан, зөрчлийн шалтгаан болдог. Нөгөө талаас, зарим хотын иргэдийн хувьд ажлын байр олдохгүй байх, тогтворгүй хөдөлмөр эрхлэлт ч бас амьжиргааны түвшинд нөлөөлдөг. Харин хөдөөгийн гэр бүлүүдийн хувьд санхүүгийн хомсдол нь тогтмол орлогогүй, ажилгүйдэл ихтэйн улмаас үүсдэг хэмээн үзжээ. Үүн дээр нэмэгдээд эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмж тааруу асуудал нь гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийн эрсдэлийг нэмэгдүүлж, санаа зовнилыг бий болгодог.



Зураг 4.4. Гэр бүлийн амьдралд тулгамдаж буй бэрхшээлтэй асуудал, байршил, хувиар



### Гэр бүлд тулгамдаж буй асуудал

...Санхүү л байна. Ажил хийж чадахгүй нь хэцүү. Гэртээ байхаар уйдаад. Уйдахаас гадна гэрийнхээ ажлыг амжихгүй. Хүүхдийн сургууль гээд хичээлийг нь зааж өгнө. Жаахан хүүхэд нь уйлна. Туслалцаа байхгүй болохоор өөрөө л болгодог...

Дан гэр бүлийн эмэгтэй, нас 31, бүрэн дунд боловсролтой  
Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэл, Дорнод аймаг

...Хэрүүл, маргаан хүүхдүүдээс болж үүсдэг байсан. Хүүхэд үгэнд орохгүй үед маргаан үүсдэг. Хүүхдээ хүмүүжүүлж чадахгүй байна гэх маргаан...

Дан гэр бүлийн эрэгтэй, нас 46, бүрэн дунд боловсролтой  
Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэл, Увс аймаг

...Хүүгийн маань эрүүл мэндийн асуудал л байна. Би ихэвчлэн хувийн эмнэлэгт үзүүлдэг. Ингэхээр санхүүгийн асуудал тулгарч байна. Яах вэ бид 2 тэтгэврээрээ болгож байна. Би нөхрөө ч байр, СӨХ-ийн мөнгөө төл гээд тулгачихсан. Миний тэтгэвэр бол эм, тарианд л явж байна. Хааяа ломбардад юм тавина. Хавар хүүгээ эмчлүүлэхэд маш үнэтэй туссан...


Дан гэр бүлийн эмэгтэй, нас 57, бүрэн бус дунд боловсролтой  
Фокус бүлгийн ярилцлагын тэмдэглэл, Улаанбаатар

Гэр бүлийн амьдралд хамгийн их тулгамдаж буй асуудал болох байр, орон сууц болон санхүү мөнгөний асуудал нь 18-34 насныханд нэн тэргүүний асуудал болоод байна. Залуу гэр бүлтэй хийсэн ФБЯ-аар залуучууд боловсрол мэргэжил эзэмших, хөдөлмөрийн гараагаа эхлэх, хамт олны дунд орж ажиллах, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх зэрэг олон чухал асуудлыг шийдвэрлэх, мөн гэр орны хувьд тохижих, амьдрах баталгаагаа бий болгох, эцэг эхийн хараат байдлаас ангижрах нийгмийн шинжтэй асуудлыг зохицуулах шаардлагатай байгаагаа илэрхийлж байна.





Зураг 4.5. Гэр бүлийн амьдралд тулгамдаж буй бэрхшээлтэй асуудал, байршил, насны бүлэг, хувиар



Судалгаанд оролцогчдоос гэр бүлийн асуудлаар хэнтэй санал бодлоо хуваалцаж шийдвэрлэдэг талаар тодруулахад ганц бие хүмүүсийн хувьд ихэвчлэн найз нөхөдтэйгөө ярилцах (51.3 хувь) болон өөрөө бие даан шийддэг (50.6 хувь) гэсэн бол дан болон нийлмэл өрхийн хувьд дийлэнхдээ эхнэр, нөхөр хоорондоо асуудлаа ярилцдаг байна. Харин өрөөсгөл өрхийн хувьд гэр бүлийн асуудлыг дийлэнхдээ өөрөө бие даан шийддэг (50.2 хувь) бөгөөд бусад өрхийг бодвол гэр бүлийнхээ асуудлыг үр хүүхдүүдтэйгээ ярилцаж шийддэгээс харахад өрхийн хэлбэрээс хамаарч гэр бүлийн асуудлаа хэнтэй хуваалцдаг нь харилцан адилгүй байна.


Хүснэгт 4.4. Гэр бүлийн асуудлаа хэнтэй хуваалцдаг эсэх, өрхийн хэлбэр, давхардсан тоо, хувиар

|                                     | Ганц бие | Дан өрх | Нийлмэл өрх | Өрөөсгөл өрх |
|-------------------------------------|----------|---------|-------------|--------------|
| Эхнэр, нөхөртэйгөө ярилцдаг         | -        | 64.7    | 54.9        | -            |
| Эцэг, эхтэйгээ ярилцдаг             | 36.0     | 25.1    | 29.9        | 34.0         |
| Хүүхдүүдтэйгээ ярилцдаг             | 2.3      | 1.9     | 4.0         | 11.3         |
| Ах, эгч, дүү нартайгаа ярилцдаг     | 5.1      | 1.1     | 1.3         | 5.8          |
| Найз нөхөдтэйгөө ярилцдаг           | 51.3     | 33.3    | 28.6        | 39.2         |
| Өөрөө бие дааж шийддэг              | 50.6     | 35.6    | 36.4        | 50.2         |
| Гэр бүлд зөвлөгөө өгөх төвд ханддаг | 4.5      | 5.4     | 5.3         | 4.2          |
| Сэтгэл зүйчид ханддаг               | 7.6      | 4.0     | 4.2         | 5.5          |
| Лам, бөө, үзмэрчид ханддаг          | 2.8      | 3.0     | 1.8         | 4.2          |
| Бусад                               | 1.3      | 0.7     | 0.4         | 5.0          |



Судалгаанд хамрагдсан эхнэр болон нөхрүүдийн ихэнх нь гэр бүлийн аливаа асуудлыг өөрөө бие даан шийдэх хандлагатай байна. Нөхрүүдийн 39.1 хувь нь эхнэртэйгээ, 34.2 хувь нь найз нөхөдтэйгөө зөвлөлдөж гэр бүлийн асуудлаа шийдвэрлэдэг бол эхнэрүүдийн 40.8 хувь нь найз нөхөдтэйгөө санаа бодлоо хуваалцах, 35.1 хувь нь эцэг, эхтэйгээ асуудлаа ярилцдаг болох нь харагдаж байна. Үүнээс харахад нөхрүүд ихэнхдээ асуудлаа эхнэртэйгээ ярилцаж шийдвэрлэдэг гэдгээ хамтдаа шийдвэр гаргах, итгэлцэл, хүндлэлийг нэмэгдүүлэх, үл ойлголцлоос сэргийлэхтэй холбон тайлбарласан бол эхнэрүүд эцэг, эх болон найз, нөхөдтэйгөө зөвлөлдөж шийдвэр гардаг нь алдаа гаргах магадлалыг бууруулах, сэтгэл санааны дэмжлэг авах, туршлага, мэдлэгийг ашиглахтай холбоотой гэж үзсэн байна.

Зураг 4.6. Гэр бүлийн асуудлаа хэнтэй хуваалцдаг эсэх, хүйс, хувиар



Мөн бухимдаж гунигласан үедээ хэрхэн тайвширдаг болохыг тодруулахад өөрөө дотроо л тунгаан боддог (59.6 хувь), найз нөхөдтэйгөө зөвлөлддөг (34.9 хувь) гэсэн бол гурван хүн тутмыг нэг нь стресс тайлах арга буюу дуулах, уйлах, спортоор хичээллэх, ганцаараа ууланд алхах зэрэг аргыг хэрэглэдэг гэсэн байна.

Зураг 4.7. Бухимдсан үедээ хэрхэн тайвширдаг эсэх, давхардсан тоо, хувиар






## 4.2. Гэр бүл цуцлалт, шалтгаан, үр дагавар

Гэр бүл салалт нь аль ч улс оронд, аль ч цаг үед нийгмийн тогтвортой байдлыг алдуулагч хүчин зүйл болж байдаг. Монгол улсад 2024 оны байдлаар 14,225 гэрлэлт бүртгэгдсэн ба өмнөх оноос 18.3 хувиар буурсан бол гэр бүл цуцлалт нь 4,463 бүртгэгдэж өмнөх оноос мөн адил 6.6 хувиар буурчээ. Гэрлэлт нь 2020-2022 онд өссөн боловч 2022-2024 онд эргээд буурсан. Харин гэр бүл цуцлалт нь 2020 оноос хойш өсөх хандлагатай байна. Сүүлийн жилүүдийн гэрлэлт, цуцлалтын статистик үзүүлэлтийн динамикаас харахад гэрлэлт буурч, цуцлалт өссөөр байгаа хандлага ажиглагдаж байна.


Зураг 4.8. Гэрлэлт, цуцлалтын тоо, жилээр



Эх сурвалж: [www.1212.mn](http://www.1212.mn). YCX

Гэр бүл цуцлалтыг хосуудын хамт амьдарсан жилээр шинжилбэл нэг жил хүртэлх хугацаанд амьдарсан хосуудын гэр бүл цуцлалтын тохиолдол бага байна. Харин хамтын амьдралын жилүүд уртсах тусам гэр бүл цуцлалт нэмэгджээ.


Зураг 4.9. Гэр бүл цуцлалтын тоо, хамт амьдарсан хугацаагаар



Судалгаанд оролцогчдын хувьд гэрлэлтээ цуцлах үедээ 1-2 хүүхэдтэй байх тохиолдол хамгийн их (34.8 хувь) байна. Харин хүүхдийн тоо нэмэгдэх тусам цуцлалтын тоо буурч байна.




Зураг 4.10. Гэрлэлтээ цуцлуулагсдын хүүхдийн тоо, хувиар



Нийт судалгаанд оролцогчдын хариултаас харахад гэр бүл цуцлахад нөлөөлж буй хүчин зүйлс нь гэр бүлийн хэлбэрээс үл хамааран санхүүгийн бэрхшээлээс, хууран мэхлэлт, хардалт, муу зуршил буюу архи, тамхи, мөрийтэй тоглоом болон хадмуудын оролцоо нь гэр бүлийг цуцлахад нөлөөлдөг гэсэн байна. Гэр бүлийн хэлбэрээр авч үзвэл, нийлмэл гэр бүлийн хувьд санхүүгийн бэрхшээл (37 хувь), хууран мэхлэлт (42.8 хувь) нь бусад хэлбэртэй харьцуулахад харьцангуй өндөр байгаа бол өрөөсгөл гэр бүлд анхаарал халамж дутах (17.0 хувь), хадмуудын хэт оролцоо (29.3 хувь) нь илүү нөлөөтэй хүчин зүйлсээр тодорч байна.


Зураг 4.11. Гэр бүл цуцлалтад нөлөөлдөг хүчин зүйлс, өрхийн хэлбэр, хувиар



Гэрлэлтээ цуцалсан судалгаанд оролцогчдоос гэрлэлт цуцлахыг хэн санаачилсан болохыг тодруулахад 52.4 хувь буюу 2 хүн тутмын нэг нь эхнэр санаачилсан гэсэн бол 21.4 хувь нь тухайн шийдвэрийг хамтдаа гаргасан гэсэн нь 2019 оны судалгааны үр дүнгээс 3.5 хувиар өссөн байна. Цуцалсан оролцогчдын 21.0 хувь нь нөхөр санаачилсан гэсэн бол 0.9 хувь нь бусад хүмүүсийн зөвлөгөөгөөр шийдвэрлэсэн байна.



Зураг 4.12. Гэрлэлт цуцлуулах санаачлагч, хувиар



Гэр бүл цуцлалтыг эхнэр, нөхөр эсвэл хамтдаа ярилцаж тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэсэн гэж хариулсан оролцогчдоос шалтгааныг тодруулахад эхнэрийн санаачилгаар гэрлэлтээ цуцалсан тохиолдолд голлох шалтгаан нь архидалт (38.2 хувь), гэр бүлээс гадуурх бэлгийн харьцаа (32.7 хувь) болсон байна.

Харин нөхрийн санаачилгаар гэрлэлтээ цуцалсан гэж хариулсан судалгаанд оролцогчдын талаас илүүхувь нь гэр бүлээс гадуурх харьцаанаас, үзэл бодол таараагүйгээс (34.1 хувь) болон хадмуудын оролцооноос (25.0 хувь) шалтгаалсан гэжээ. Хамтдаа ярилцаж шийдвэрлэсэн оролцогчдын нэн тэргүүний шалтгаан нь үзэл бодол таараагүйгээс (53.3 хувь) үүдсэн байна. Мөн үр хүүхэдгүй учраас гэрлэлтээ цуцлах талаар хамтдаа ярилцаж шийдвэрлэсэн нь 11.1 хувь, эхнэрийн санаачилгаар шийдвэрлэсэн 0.9 хувь, нөхрийн санаачилгаар шийдвэрлэсэн 2.3 хувь байгаа нь хамтдаа ярилцаж шийдвэрлэсэн тохиолдол илүү өндөр хувийг эзэлж байна.



### Хүснэгт 4.5. Гэр бүлээ цуцлуулсан шалтгаан, цуцлалт санаачлагч, давхардсан тоо, хувиар

|                                        | Эхнэрийн<br>санаачилгаар | Нөхрийн<br>санаачилгаар | Хамтдаа<br>шийдвэрлэсэн |
|----------------------------------------|--------------------------|-------------------------|-------------------------|
| Үзэл бодол таараагүйгээс               | 31.8                     | 34.1                    | 53.3                    |
| Үр хүүхэдгүй учраас                    | 0.9                      | 2.3                     | 11.1                    |
| Амьдралын түвшин харилцан адилгүй      | 2.7                      | 2.3                     | 8.9                     |
| Боловсрол соёлын түвшин таараагүйгээс  | 4.5                      | 4.5                     | 8.9                     |
| Найз нөхдийн зөвлөснөөр                | 1.8                      | 4.5                     | 4.4                     |
| Санхүүгийн асуудлаас болж              | 13.6                     | 11.4                    | 15.6                    |
| Эрүүл мэндийн асуудлаас болж           | 1.8                      | 4.5                     | 4.4                     |
| Нийгэмд эзлэх байр суурийн ялгаанаас   | 3.6                      | 2.3                     | -                       |
| Анхаарал халамжгүй болсноос            | 21.8                     | 20.5                    | 22.2                    |
| Хадмуудын оролцооноос                  | 16.4                     | 25.0                    | 20.0                    |
| Гэр бүлийн хүчирхийллийн улмаас        | 29.1                     | 15.9                    | 8.9                     |
| Гэр бүлийн боловсрол                   | 2.7                      | -                       | -                       |
| Гэр бүлээс гадуурх бэлгийн харьцаанаас | 32.7                     | 50.0                    | 22.2                    |
| Эцэг эхийн шахалтаас                   | 2.7                      | 2.3                     | 4.4                     |
| Архидалтаас болж                       | 38.2                     | 22.7                    | 20.0                    |

#### Чанарын судалгаа: Гэрлэлт цуцлалтын шалтгаан

...Салах шийдвэрийг би гаргасан. Салах болсон шалтгаан нь олон жилийн архидалт байсан. Түүнийг тэвчээгүй. Дээрээс нь маш халамжгүй байдал, гэр бүлээс гадуурх харилцаа нь миний салах шийдвэрт нөлөөлсөн...

Гэрлэлтээ цуцалсан эмэгтэй, нас 34, бүрэн дунд боловсролтой  
Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэл, Увс аймаг

...Архи уучхаад намайг болон хүүхдүүдээ зоддог байсан. Би маш их тэсвэр, тэвчээрийг гаргаж байсан. Даанч үр дүн гараагүй. Хүүхдүүд томроод дунд ангид ороход нь л салах шийдвэрийг гаргасан. Ер нь архинаас болж салсан...

Гэрлэлтээ цуцалсан эмэгтэй, нас 47, дээд боловсролтой  
Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэл, Улаанбаатар хот

...Миний ажлын онцлог, нөхцөл байдлаас болж салсан гэж боддог. Өмнө нь цалин өгч л байвал ажлаа хийгээд мөнгө олж байгаа гэдэг бодлоор л ажилладаг байсан. Намайг ажил ихтэй явж байхад өөр хүнтэй нийлсэн байсан. Салах шийдвэрийг би өөрөө гаргасан. Гэр орондоо байж байх ёстой юм байна лээ...


Гэрлэлтээ цуцалсан эрэгтэй, нас 50, бүрэн дунд боловсролтой  
Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэл, Дорнод аймаг



Гэр бүл цуцлалт нь архидалт, гэр бүлээс гадуурх харилцаа, үзэл бодлын зөрчил, гэр бүлийн хүчирхийлэл зэргээс шалтгаалж үүсэж байгаа ба ФБЯ-д оролцогчид дурдахдаа архидалтыг маш олон жил тэвчсэн ч түүнийг дагаад хайр халамжгүй хүйтэн хөндий байдал, гэр бүлийн хүчирхийллийг давхар тэвчиж байсан гэжээ. Мөн гэр бүл цуцлалтад хол зай буюу тусдаа ажиллаж, амьдрах нь бие холдвол, сэтгэл холддог гэгчээр маш их нөлөөтэйг дурдаж байв. Өөрөөр хэлбэл гэр бүл цуцлалтад ихээр нөлөө үзүүлдэг нэг хүчин зүйлээс улбаалан бусад нөлөөлөгч хүчин зүйлсийн суурь тавигддаг байна. Тухайлбал, архидалтаас гэр бүлийн хүчирхийлэл, анхаарал халамж дутах, хүндлэлгүй харьцах зэрэг асуудлууд урган гардаг.

Гэр бүл цуцлалтын хамгийн том хохирогч нь хүүхэд бөгөөд гэр бүл цуцлалт хүүхдэд эмзэг тусч, сэтгэлийн зовуурийг бий болгодог. Энэ нь хүүхдийн суурь хүмүүжил, төлөвшилд нь сөргөөр нөлөөлдөг. Гэр бүл цуцалснаас хойш хүүхдэд тавих анхаарал халамж багасах, тэднийг үл хайхрах явдал ихсэх хандлага ажиглагддаг. Тиймээс гэрлэлтээ цуцлуулснаас хойш эцэг, эхчүүд хүүхдэдээ анхаарал, халамж тавьж байгаа эсэх талаар тодруулахад аавуудын 23.3 хувь нь хангалттай сайн анхаарал хандуулдаг, 27.1 хувь нь анхаарал халамж сул гэж хариулжээ. Харин хоёр аав тутмын нэг нь гэрлэлтээ цуцлуулснаас хойш хүүхдэдээ огт анхаарал халамж тавиагүй гэжээ. Ээжүүдийн 78.6 хувь анхаарал халамж сайн тавьдаг, 21.4 хувь нь анхаарал халамж сул болон огт хайхардаггүй гэжээ. Үүнээс үзэхэд гэр бүл цуцлалтын дараа ээжүүд хүүхдэдээ илүү анхаарал хандуулдаг нь харагдаж байна.


Зураг 4.13. Гэр бүл цуцлуулснаас хойш эцэг, эхийн анхаарал, халамж, хувиар





Гэр бүлээ цуцлуулсны дараа эцэг, эх нь хүүхэдтэйгээ холбоотой байдаг эсэхийг тодруулахад судалгаанд хамрагдсан эхнэр, нөхрүүдийн дийлэнх нь “хүүхэдтэйгээ холбоотой байх нь зайлшгүй хэрэгтэй” гэж үзсэн бол хүйс үл харгалзан 5 хүн тутмын 1 нь эргэж уулзаад байх шаардлагагүй гэж үзжээ. Эцэг, эхтэйгээ холбоотой байх ёстой гэсэн хүмүүсийн нөхөр нь эхнэрээсээ 10.7 хувиар өндөр байна. Харин хааяа л нэг уулзаж байсан дээр гэж үзсэн эхнэрүүд (30.6 хувь) нь эрчүүдээс (18.9 хувь) давамгайл байна.

*Зураг 4.14. Гэр бүлээ цуцлуулснаас хойш эцэг эх нь хүүхэдтэйгээ холбоотой байдаг эсэх, хүйс, хувиар*




Гэр бүл цуцлалт нь зөвхөн хосуудын харилцааны төгсгөл төдийгүй хувь хүн, хүүхэд, гэр бүлийн гишүүд болон нийгмийн түвшинд олон талт, эерэг ба сөрөг үр дагаврыг дагуулдаг нийгмийн үзэгдэл юм. Энэ үйл явц нь тухайн хувь хүний амьдралын чанар, сэтгэл зүйн төлөв, эдийн засгийн нөхцөл байдал болон нийгмийн харилцаанд гүнзгий нөлөө үзүүлдэг. Тухайлбал, сэтгэл зүйн хувьд дарамт зовлонгоос ангижирсан (60.0 хувь), бусдаас хараат бус чөлөөтэй болсон (45.2 хувь), ажил, мэргэжлийн хувьд ахиц гарган өөрийгөө хөгжүүлэх боломж бүрдсэн (22.4 хувь) зэрэг эерэг өөрчлөлт гарчээ. Нөгөөтээгүүр, сөрөг үр дагаврууд ч мөн ажиглагдсан нь хариуцлага ачаалал нэмэгдсэн (54.8 хувь), сэтгэл санааны дарамттай байдал (26.2 хувь), ажил амьдралын тэнцвэрийг хадгалахад хүндрэлтэй болсон (25.7 хувь) гэж дурдсан байна.





Зураг 4.15. Гэр бүлээ цуцлуулснаар амьдралд гарч буй эерэг болон сөрөг өөрчлөлт, давхардсан тоо, хувиар



Түүнчлэн, гэрлэлт цуцлалтын үр дагавар болгон гарч буй эерэг болон сөрөг өөрчлөлтүүдийг оршин суугаа байршлаар авч үзэхэд тодорхой ялгаа ажиглагдаж байна. Орон нутгаас судалгаанд оролцогчдын хувьд бусдаас хамааралгүй, чөлөөтэй болсон (49.6 хувь), үүрэг хариуцлагаас үүдэлтэй дарамтаас чөлөөлөгдсөн (17.9 хувь) зэрэг эерэг өөрчлөлтүүд гарсан байна. Харин хотынхны хувьд өөрийгөө хөгжүүлэх боломж нэмэгдсэн (26.4 хувь), хувийн амьдралаа дээшлүүлэх бололцоо бий болсон (31.0 хувь), амьдралаа дахин шинээр эхлэх боломжтой болсон (19.5 хувь) зэрэг эерэг өөрчлөлтүүд гарчээ.

Сөрөг өөрчлөлтийн хувьд амьжиргаа доройтсон (29.3 хувь) гэж хариулсан орон нутгийн оролцогчдын хувь хотынхоос өндөр байна. Харин сэтгэл санааны дарамттай байдал үүссэн (29.9 хувь) нь эсрэгээрээ хотод илүү байна. Хариуцлага ачаалал (59.9 хувь) болон аливаа асуудлын өмнө ганцаардах нь (59.9 хувь) эмэгтэйчүүдэд илүү байгаа бол эрчүүдэд ажил, амьдралаа зохицуулахад нь хүндрэл үүсэх (34.0 хувь), амьдрах итгэлгүй болох (20.8 хувь) зэрэг сөрөг үр дагаврууд гарч байна.

Мөн эдгээр өөрчлөлтүүдийг хүйсээр үзэхэд эмэгтэйчүүд сэтгэл санааны дарамтгүй болсон (66.9 хувь), бусдаас хамааралгүй чөлөөтэй болсон (47.1 хувь), хүүхдийн хүмүүжилд сайнаар нөлөөлсөн (19.7 хувь) зэрэг эерэг өөрчлөлтүүд гарсан нь эрчүүдийнхээс өндөр байна. Харин эрчүүдийн хувьд хувийн амьдралаа өөдөн татах боломж бий болсон (24.5 хувь), амьдралаа дахин шинээр эхлэх боломжтой болсон (22.6 хувь) гэж хариулсан нь эмэгтэйчүүдийнхээс өндөр байна. Гэвч эрэгтэйчүүдийн 20.8 хувь нь эерэг өөрчлөлт гараагүй гэжээ. Үүнээс үзэхэд гэр бүл цуцлалт нь эрэгтэйчүүдэд сөрөг үр дагавруудыг түлхүү авч ирдэг байна.




Хүснэгт 4.6. Гэр бүл цуцалснаар амьдралд гарч буй өөрчлөлтүүд, хүйс, байршил, хувиар

| Өөрчлөлтүүд                                              | Байршил |       | Хүйс    |         |
|----------------------------------------------------------|---------|-------|---------|---------|
|                                                          | Хот     | Хөдөө | Эрэгтэй | Эмэгтэй |
| <b>Эерэг өөрчлөлт</b>                                    |         |       |         |         |
| Сэтгэл санааны дарамт, зовлонгүй болсон                  | 58.6    | 61.0  | 39.6    | 66.9    |
| Бусдаас хамааралгүй, чөлөөтэй болсон                     | 39.1    | 49.6  | 39.6    | 47.1    |
| Үүрэг хариуцлагаас үүдэлтэй дарамтаас чөлөөлөгдсөн       | 11.5    | 17.9  | 9.4     | 17.2    |
| Ажилдаа ахиц гаргаж, өөрийгөө хөгжүүлэх боломж нэмэгдсэн | 26.4    | 19.5  | 20.8    | 22.9    |
| Хувийн амьдралаа өөдөн татах бололцоо бий болсон         | 31.0    | 12.2  | 24.5    | 18.5    |
| Амьдралаа шинээр дахин эхлэх боломж бий болсон           | 19.5    | 12.2  | 22.6    | 12.7    |
| Хүүхдийн хүмүүжил сурлагад сайнаар нөлөөлсөн             | 18.4    | 14.6  | 5.7     | 19.7    |
| Эерэг өөрчлөлт гараагүй                                  | 3.4     | 10.6  | 20.8    | 3.2     |
| <b>Сөрөг өөрчлөлт</b>                                    |         |       |         |         |
| Хариуцлага ачаалал нэмэгдсэн                             | 56.3    | 53.7  | 39.6    | 59.9    |
| Амьжиргаа доройтсон                                      | 14.9    | 29.3  | 22.6    | 23.6    |
| Ажил, амьдралаа хэвийн зохицуулахад хүндрэл үүссэн       | 27.6    | 24.4  | 34.0    | 22.9    |
| Аливаа асуудлын өмнө ганцаардаж, хүчин мөхсөдөх болсон   | 21.8    | 24.4  | 18.9    | 24.8    |
| Амьдралд итгэх итгэлгүй болсон                           | 5.7     | 17.1  | 20.8    | 9.6     |
| Сэтгэл санааны дарамттай байдал үүссэн                   | 29.9    | 23.6  | 41.5    | 21.0    |
| Хүүхдийн хүмүүжил, сурлага муудсан                       | 14.9    | 13.8  | 9.4     | 15.9    |
| Сөрөг өөрчлөлт гараагүй                                  | 16.1    | 13.8  | 15.1    | 14.6    |

Гэрлэлтээ цуцлуулсан оролцогчдоос дахин гэрлэх бодол байгаа эсэх талаар тодруулахад эмэгтэйчүүдийн 56.7 хувь нь дахин гэрлэх бодолгүй, эрэгтэйчүүдийн 50.9 хувь нь санаа нийлэх хүн байвал дахин гэрлэнэ гэж үзжээ. ФБЯ-д оролцогчдын өгсөн ярилцлагаар эмэгтэй хүмүүсийн хувьд үр хүүхэдтэй бол дахин гэрлэх талаар их бодоод байдаггүй учир нь үр хүүхдээ хойд эцэгтэй болгохоос бага зэргийн айдастай байдаг гэжээ.



Зураг 4.16. Дахин гэрлэх бодол байгаа эсэх, хүйс, хувиар



#### Чанарын судалгаа: Дахин гэрлэх бодол байгаа эсэх

...Дахин гэрлэх бодолтой байгаа. Гэхдээ саяхан салсан учир одоогоор бэлэн биш байна. Сэтгэл зүйн хувьд эдгэрэх хугацаа хэрэгтэй байна...

Гэрлэлтээ цуцалсан эрэгтэй, нас 25, бүрэн дунд боловсролтой  
Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэл, Улаанбаатар хот

...Гэрлэх бодолгүй байна. Би өөрөө 12-р ангийн охинтой учраас хойд эцэг эзэд сайн, муу юм их сонсогдох юм. Уг нь санхүү мөнгөө бодвол хэрэгтэй л юм. Гэхдээ цаашдаа ганцаараа амьдарна л гэж бодож байна...

Гэрлэлтээ цуцалсан эмэгтэй, нас 47, дээд боловсролтой  
Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэл, Улаанбаатар хот

...Би бага хүүхдээ оюутан болоод ажлын байран дээр гарсны дараа дахин амьдрал зохиохоор төлөвлөж байна. 4,5 жилийн дараа гэрлэх бодолтой байна...

Гэрлэлтээ цуцалсан эрэгтэй, нас 50, бүрэн дунд боловсролтой  
Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэл, Дорнод аймаг


### 4.3. Гэр бүлээс гадуурх харилцаа, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс

Өнөөгийн гэр бүлийн харилцаанд түгээмэл тулгарч буй асуудлуудын нэг нь гэр бүлээс гадуурх харилцаанаас үүдсэн гэр бүлийн зөрчил, маргаан болж байна. Гэр бүлээс гадуурх харилцаа нь гэр бүл цуцлалтад нөлөөлж буй голлох хүчин зүйлүүдийн нэг болж байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байна. Үүнтэй холбоотой гэр бүлээс гадуурх харилцаа үүсэхэд нөлөөлдөг хүчин зүйлийг авч үзэхэд, эмэгтэйчүүдийн хувьд анхаарал халамж дутах (67.0 хувь), үл ойлголцох (49.5 хувь), бэлгийн харилцаанд таарамжгүй байх (27.2 хувь) зэрэг нь гэр бүлээс гадуурх харилцаа үүсэхэд ихээхэн нөлөөлдөг гэж үзжээ.




Харин эрэгтэйчүүдийн хувьд гэр бүлээс гадуурх харилцаа үүсэхэд нөлөөлдөг хүчин зүйлс нь ерөнхийдөө эмэгтэйчүүдийнхтэй ижил боловч тодорхой ялгаа ажиглагдаж байна. Тухайлбал, анхаарал, халамж дутагдсанаас үүдэлтэй гэж үзсэн эрэгтэйчүүдийн хувь нь эмэгтэйчүүдийнхээс 9.7 нэгжээр бага, харилцан үл ойлголцлоос шалтгаалсан гэж үзсэн нь 6.4 нэгжээр бага байжээ. Харин эхнэр, нөхрийн хоорондын зай хол байдал гэр бүлээс гадуурх харилцаа үүсэхэд нөлөөлдөг гэж үзсэн эрэгтэйчүүдийн хувь эмэгтэйчүүдээс 4.1 хувиар илүү байгаа нь энэ асуудалд ханддаг хүйсийн үзэл, хандлагын ялгааг илтгэж байна.

**Зураг 4.17. Гэр бүлээс гадуурх харилцаанд нөлөөлж буй хүчин зүйлс, хүйс, хувиар**



Гэр бүлээс гадуурх харилцааны талаар судалгаанд оролцогчдын 72.3 хувь нь огт байж болохгүй зүйл, 16.5 хувь нь хэлж мэдэхгүй, 11.2 хувь нь байж болох зүйл гэж үзсэн. Насны бүлгийн хувьд харахад нас ахих тусам гэр бүлээс гадуурх бэлгийн харилцаа байж болох зүйл гэж үзэх нь тодорхой хэмжээнд ихэсч байгаа бол харин залуу байх тусам огт байж болохгүй гэдэг үзэл бодол илүү давамгайлж байна.

**Зураг 4.18. Гэр бүлээс гадуурх харилцаа байж болох эсэх, насны бүлэг, хувиар**





Үүнтэй холбоотой гэр бүлээс гадуурх харилцаанд гуравдагч этгээдэд хариуцлага тооцох нь зөв гэж судалгаанд оролцогчдын 63.0 хувь нь хариулсан бол 17.9 хувь нь хариуцлага тооцох нь буруу гэсэн байна. Харин судалгаанд оролцогчдын 19.1 хувь нь гэр бүлээс гадуурх харилцаанд хариуцлага тооцох нь зөв эсвэл буруу эсэх талаар тодорхой байр суурь илэрхийлээгүй буюу тодорхой хариулт өгч чадаагүй байна. Хариуцлага тооцох нь зөв гэж хариулсан оролцогчдын дийлэнх нь эмэгтэй оролцогчид байгаа бол хариуцлага тооцох нь буруу гэж хариулсан оролцогчдын дийлэнх нь эрэгтэй оролцогчид байна.

Зураг 4.19. Гэр бүлээс гадуурх харилцаанд хариуцлага тооцох эсэх, хүйс, хувиар



#### 4.4. Гэр бүлд нөлөөлж буй нийгмийн хүчин зүйл

Судалгаанд оролцогчдын үзэж байгаагаар гэр бүлийн орчинд нийгмээс хамгийн ихээр нөлөөлж буй тулгамдсан асуудлуудыг тодруулахад хэд хэдэн хүчин зүйлийг онцгойлж болно. Тухайлбал, оролцогчдын 61.7 хувь нь ажилгүйдэл, 39.2 хувь нь үнийн өсөлт, 37.9 хувь нь архидалт, 34.7 хувь нь ядуурал, 20.9 хувь нь нийгмийн стрессийг гэр бүлийн харилцаанд сөргөөр нөлөөлж буй гол хүчин зүйлүүд хэмээн үзжээ. Эдгээр үзүүлэлтүүд нь нийгэм, эдийн засгийн орчны тогтворгүй байдал нь гэр бүлийн тогтвортой байдалд хэрхэн нөлөөлж байгааг харуулж байна.

Судалгааны үр дүнг оршин суугаа байршлаар харьцуулан авч үзэхэд, нийгмийн сөрөг нөлөөллүүдийн нөлөөлөл өөр өөр байдалтайгаар илэрч байна. Тухайлбал, нийслэл хотод амьдарч буй иргэдэд нийгмийн стресс, хотжилт орчны сөрөг нөлөөлөл, гэр бүлийн хүмүүс гадаад улсад тусдаа амьдрах явдал, татварын ачаалал зэрэг нь өндөр түвшинд нөлөөлж байна. Харин орон нутагт амьдарч буй иргэдэд ажилгүйдэл, гэмт хэргийн өсөлт, архидалт зэрэг нь нийгмийн сөрөг хүчин зүйлүүд илүү их хүндрэл, дарамт учруулж байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байна.




### Хүснэгт 4.7. Нийгмээс нөлөөлж буй зүйлс, байршил, давхардсан тоо, хувиар

| Үзүүлэлт                                             | Байршил |       | Нийт |
|------------------------------------------------------|---------|-------|------|
|                                                      | Хот     | Хөдөө |      |
| Ажилгүйдэл                                           | 54.9    | 66.3  | 61.7 |
| Ядуурал                                              | 32.6    | 36.2  | 34.7 |
| Гэмт хэргийн өсөлт                                   | 4.9     | 7.2   | 6.3  |
| Үнийн өсөлт                                          | 39.8    | 38.7  | 39.2 |
| Нийгмийн бухимдал стресс                             | 24.4    | 18.4  | 20.9 |
| Хотжилт, орчны сөрөг нөлөөлөл                        | 7.3     | 2.2   | 4.3  |
| Гадаадад удаан хугацаагаар тусдаа амьдрах нь ихэссэн | 10.1    | 4.2   | 6.6  |
| Татварын ачаалал                                     | 14.0    | 10.1  | 11.7 |
| Улс төрийн тогтворгүй байдал                         | 8.4     | 6.3   | 7.1  |
| Авлига                                               | 1.6     | 1.5   | 1.5  |
| Архидалт                                             | 32.1    | 41.7  | 37.9 |
| Эргэн тойрны хүмүүсийн таагүй уур амьсгал            | 6.6     | 6.6   | 6.6  |
| Мэдээллийн хэрэгслийн сөрөг нөлөөлөл                 | 2.8     | 1.9   | 2.3  |
| Хуулийн хэрэгжилт муу                                | 5.2     | 5.4   | 5.3  |
| Төрийн үйлчилгээний чанар хүртээмж муу               | 5.9     | 4.9   | 5.3  |
| Нийгмийн таагүй уур амьсгал                          | 6.6     | 7.2   | 7.0  |
| Бусад                                                | 2.6     | 1.7   | 2.1  |

Судалгаанд оролцогчдын 58.6 хувь нь ажил дээрээ болон гэр бүлээс гадуурх орчинд үүссэн таагүй нөхцөл байдал нь гэр бүлийн харилцаанд сөргөөр нөлөөлж байгаагүй гэж хариулсан бөгөөд энэ үзүүлэлт эрэгтэйчүүдийн дунд илүү өндөр байна. Харин оролцогчдын 30.0 хувь нь ийм нөхцөл үүссэн ч гэр бүлдээ сөрөг нөлөө үзүүлэхгүй байхыг хичээдэг гэж хариулжээ. Харин 10 орчим хувь нь маш таагүй зүйл тохиолдсон үед л дээрх үйлдлийг гаргадаг гэсэн ба 1.3 хувь нь өдөр тутмын бухимдал, стрессээс болж дийлэнхдээ гэр бүлийнхэнтэйгээ үл зохицолтой харьцдаг гэжээ. Эдгээр сөрөг хандлага эмэгтэйчүүдийн дунд эрчүүдээс харьцангуй өндөр хувьтайгаар илэрч байна.

Зураг 4.20. Бухимдлаа гэр бүлдээ гаргаж буй байдал, хүйс, хувиар



Судалгаанд оролцогчдоос өөрсдийн амьдралын нөхцөл байдлыг сайжруулахын тулд төр засгаас ямар бодлого, үйлчилгээний дэмжлэг хэрэгтэй байгааг тодруулсан.



Судлагдсан таван хүн тутмын нэг нь ажиллах боломж, ажлын байр, нөхцөл сайжруулах, 7 хүн тутмын нэг нь эрүүл аюулгүй амьдрах орчин, амьдралын баталгаа, 6 хүн тутмын нэг нь боловсролын систем, хүүхдийн хөгжил боловсролд анхаарах зэрэг хариултуудыг өгсөн байгаа нь хамгийн өндөр саналыг авчээ.

Судалгаанд оролцогчдын оршин сууж буй байршлаас хамааран тулгамдаж буй асуудал болон хэрэгцээт үйлчилгээ, дэмжлэгийн шинж чанар харилцан адилгүй байна. Жишээлбэл, ажиллах боломж, ажлын байрны хүртээмжийг нэмэгдүүлэх хэрэгцээ нь аль ч орон нутагт хамгийн өндөр хувиар илэрч байгаа бол Улаанбаатар хотод амьдарч байгаа судалгаанд оролцогчдын хувьд эрүүл аюулгүй амьдрах орчин бүрдүүлэх, амьдралын баталгааг хангах, гэр бүлийн эрх зүйн орчныг сайжруулах, орон сууцны зээлийн дэмжлэг үзүүлэх шаардлагууд илүү давамгайлж байна.

*Хүснэгт 4.8. Хэрэгжүүлэхийг хүсэж буй бодлого, байршил, давхардсан тоо, хувиар*

| Төрөөс хэрэгжүүлэхийг хүсэж буй бодлого                                         | Байршил |       |
|---------------------------------------------------------------------------------|---------|-------|
|                                                                                 | Хот     | Хөдөө |
| Ажиллах боломж, ажлын байр, нөхцөл сайжруулах                                   | 51.8    | 58.6  |
| Эрүүл аюулгүй амьдрах орчин, амьдралын баталгаа                                 | 46.6    | 36.9  |
| Боловсролын систем, хүүхдийн хөгжил боловсролд анхаарах                         | 48.4    | 45.6  |
| Гэр бүлийн хуулийг сайжруулах                                                   | 33.7    | 22.4  |
| Эдийн засаг, төрийн тогтвортой байдал, эх орноо хөгжүүлэх, дэд бүтэц сайжруулах | 25.7    | 24.2  |
| Орон сууцны хөнгөлөлттэй зээл, орон байраар дэмжих, уян хатан зээл              | 27.8    | 19.2  |
| Халамж, татвар, даатгалын тогтолцоог сайжруулах                                 | 14.6    | 11.1  |
| Санхүүгийн дэмжлэг                                                              | 12.7    | 10.4  |
| Залуу гэр бүлийг дэмжих                                                         | 10.4    | 9.4   |
| Цалин нэмэх                                                                     | 10.7    | 7.6   |
| Сургууль цэцэрлэг, эмнэлгийн хүртээмжийг нэмэх                                  | 7.1     | 1.5   |
| Уян хатан зээлийн нөхцөл                                                        | 6.7     | 6.2   |
| Төрөөс хүүхдийн өдөр өнжүүлэх төвийг зохицуулах                                 | 5.6     | 4.6   |
| Гэр бүлийг хамт амьдрах боломжоор хангах                                        | 0.2     | 0.3   |
| Өрх толгойлсон эцэг, эхэд дэмжлэг үзүүлэх                                       | 3.9     | 2.8   |
| Нэмэлт орлого олох боломжийг сайжруулах                                         | 2.7     | 1.5   |
| Ахмадад зориулсан төв, сувилал                                                  | 2.8     | 2.7   |
| Ажлын цагийг уян хатан байлгах                                                  | 2.5     | 1.6   |
| Малчин өрхийг дэмжих                                                            | 0.0     | 3.1   |
| Архидалт, тамхидалтыг бууруулах                                                 | 2.4     | 1.8   |
| Төрийн бүх үйлчилгээг цахимжуулах                                               | 0.7     | 0.2   |
| Цахим мөрийтэй тоглоомыг хорих                                                  | 0.1     | 0.1   |
| Соёл урлагийн спортын төвүүдийг байгуулах                                       | 1.6     | 0.2   |
| Төрөлтийг дэмжих                                                                | 0.1     | 0.2   |



Судалгаанд оролцогчдыг насны бүлгээр нь хэрэгцээт бодлого, дэмжлэгийн чиглэлүүдийг авч үзэхэд 50 ба түүнээс дээш насны иргэд нь ажлын байрыг нэмэгдүүлэх, эдийн засгийг дэмжих, эх орны хөгжилд хувь нэмэр оруулах, дэд бүтэц сайжруулах болон цалин хөлс нэмэгдүүлэх зэрэг асуудлыг илүү түлхүү онцлон дэмжжээ. Харин залуу болон дунд насны оролцогчид гэр бүлийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, ялангуяа гэр бүлийн хуулийг сайжруулах хэрэгцээг илүү өндөр хувиар онцолсон байна.

#### Хүснэгт 4.9. Хэрэгжүүлэхийг хүсэж буй бодлого, насны бүлэг, хувиар

| Төрөөс хэрэгжүүлэхийг хүсэж буй бодлого                                         | Насны бүлэг |       |      |
|---------------------------------------------------------------------------------|-------------|-------|------|
|                                                                                 | 18-34       | 35-49 | 50+  |
| Ажиллах боломж, ажлын байр, нөхцөл сайжруулах                                   | 18.3        | 18.7  | 21.0 |
| Эрүүл аюулгүй амьдрах орчин, амьдралын баталгаа                                 | 14.3        | 14.6  | 13.1 |
| Боловсролын систем, хүүхдийн хөгжил боловсролд анхаарах                         | 16.2        | 16.8  | 15.0 |
| Гэр бүлийн хуулийг сайжруулах                                                   | 9.5         | 9.2   | 6.3  |
| Эдийн засаг, төрийн тогтвортой байдал, эх орноо хөгжүүлэх, дэд бүтэц сайжруулах | 7.8         | 9.3   | 11.4 |
| Орон сууцны хөнгөлөлттэй зээл, орон байраар дэмжих, уян хатан зээл              | 7.9         | 7.4   | 8.0  |
| Халамж, татвар, даатгалын тогтолцоог сайжруулах                                 | 4.3         | 4.2   | 4.4  |
| Санхүүгийн дэмжлэг                                                              | 3.2         | 4.6   | 4.3  |
| Залуу гэр бүлийг дэмжих                                                         | 4.2         | 2.5   | 3.1  |
| Цалин нэмэх                                                                     | 3.1         | 2.2   | 3.8  |
| Сургууль цэцэрлэг, эмнэлгийн хүртээмжийг нэмэх                                  | 1.2         | 2.1   | 0.7  |
| Уян хатан зээлийн нөхцөл                                                        | 0.9         | 0.7   | 0.3  |
| Төрөөс хүүхдийн өдөр өнжүүлэх төвийг зохицуулах                                 | 2.4         | 1.5   | 1.0  |
| Гэр бүлийг хамт амьдрах боломжоор хангах                                        | 0.2         | 0.1   | 0.1  |
| Өрх толгойлсон эцэг, эхэд дэмжлэг үзүүлэх                                       | 1.1         | 1.4   | 0.8  |
| Нэмэлт орлого олох боломжийг сайжруулах                                         | 0.9         | 0.8   | 0.2  |
| Ахмадад зориулсан төв, сувилал                                                  | 0.2         | 0.2   | 2.9  |
| Ажлын цагийг уян хатан байлгах                                                  | 0.9         | 0.7   | 0.3  |
| Малчин өрхийг дэмжих                                                            | 0.5         | 0.7   | 0.8  |
| Архидалт, тамхидалтыг бууруулах                                                 | 0.2         | 1.1   | 0.7  |
| Төрийн бүх үйлчилгээг цахимжуулах                                               | 0.3         | 0.0   | 0.0  |
| Цахим мөрийтэй тоглоомыг хорих                                                  | 0.0         | 0.0   | 0.0  |
| Соёл урлагийн спортын төвүүдийг байгуулах                                       | 0.3         | 0.2   | 0.0  |
| Төрөлтийг дэмжих                                                                | 0.0         | 0.0   | 0.0  |





Гэр бүлийн төрлөөс хамааран иргэдийн хэрэгжүүлэхийг хүсэж буй бодлого нь харилцан адилгүй байна. Ганц бие иргэд нь ажиллах боломж, ажлын байр, нөхцөлийг сайжруулах шаардлагатай байна гэж илт давуу хувиар, дан өрхийн гишүүд эрүүл аюулгүй амьдрах орчин, амьдралын баталгаа, санхүүгийн дэмжлэг, цалин нэмэхийг илүү хувиар, нийлмэл гэр бүлийн гишүүд боловсролын систем, хүүхдийн хөгжилд анхаарахыг, харин өрөөсгөл гэр бүлийн гишүүд гэр бүлийн хуулийн сайжруулах, эдийн засгийн тогтвортой байдал, эх орноо хөгжүүлэх, өрх толгойлсон хүнд дэмжлэг үзүүлэх зэрэгт өндөр хувиар саналаа өгсөн байна.

*Хүснэгт 4.10. Хэрэгжүүлэхийг хүсэж буй бодлого, гэр бүлийн хэлбэр, хувиар*

| Төрөөс хэрэгжүүлэхийг хүсэж буй бодлого                                         | Гэр бүлийн хэлбэр |      |         |          |
|---------------------------------------------------------------------------------|-------------------|------|---------|----------|
|                                                                                 | Ганц бие          | Дан  | Нийлмэл | Өрөөсгөл |
| Ажиллах боломж, ажлын байр, нөхцөл сайжруулах                                   | 48.1              | 10.3 | 10.8    | 10.8     |
| Эрүүл аюулгүй амьдрах орчин, амьдралын баталгаа                                 | 5.5               | 37.9 | 4.7     | 4.8      |
| Боловсролын систем, хүүхдийн хөгжил боловсролд анхаарах                         | 5.7               | 10.1 | 41.8    | 7.1      |
| Гэр бүлийн хуулийг сайжруулах                                                   | 6.1               | 4.7  | 4.2     | 22.1     |
| Эдийн засаг, төрийн тогтвортой байдал, эх орноо хөгжүүлэх, дэд бүтэц сайжруулах | 4.0               | 4.3  | 4.2     | 21.5     |
| Орон сууцны хөнгөлөлттэй зээл, орон байраар дэмжих, уян хатан зээл              | 7.8               | 7.8  | 9.2     | 6.4      |
| Халамж, татвар, даатгалын тогтолцоог сайжруулах                                 | 4.9               | 3.9  | 4.2     | 4.1      |
| Санхүүгийн дэмжлэг                                                              | 2.5               | 5.4  | 3.7     | 3.8      |
| Залуу гэр бүлийг дэмжих                                                         | 3.5               | 3.2  | 3.8     | 3.1      |
| Цалин нэмэх                                                                     | 2.7               | 3.8  | 3.1     | 2.4      |
| Сургууль цэцэрлэг, эмнэлгийн хүртээмжийг нэмэх                                  | 0.9               | 1.7  | 1.7     | 0.9      |
| Уян хатан зээлийн нөхцөл                                                        | 2.5               | 1.9  | 2.9     | 1.7      |
| Төрөөс хүүхдийн өдөр өнжүүлэх төвийг зохицуулах                                 | 0.8               | 1.8  | 2.0     | 2.3      |
| Гэр бүлийг хамт амьдрах боломжоор хангах                                        | 0.1               | 0.0  | 0.0     | 0.3      |
| Өрх толгойлсон эцэг, эхэд дэмжлэг үзүүлэх                                       | 0.3               | 0.1  | 0.4     | 3.6      |
| Нэмэлт орлого олох боломжийг сайжруулах                                         | 1.0               | 0.5  | 0.7     | 0.6      |
| Ахмадад зориулсан төв, сувилал                                                  | 1.3               | 0.7  | 0.4     | 1.3      |
| Ажлын цагийг уян хатан байлгах                                                  | 0.3               | 0.7  | 0.7     | 0.8      |
| Малчин өрхийг дэмжих                                                            | 1.2               | 0.5  | 0.5     | 0.4      |
| Архидалт, тамхидалтыг бууруулах                                                 | 0.3               | 0.5  | 0.8     | 1.7      |
| Төрийн бүх үйлчилгээг цахимжуулах                                               | 0.1               | 0.1  | 0.1     | 0.1      |
| Цахим мөрийтэй тоглоомыг хорих                                                  | 0.0               | 0.0  | 0.0     | 0.0      |
| Соёл урлагийн спортын төвүүдийг байгуулах                                       | 0.3               | 0.1  | 0.1     | 0.1      |
| Төрөлтийг дэмжих                                                                | 0.1               | 0.0  | 0.0     | 0.1      |



Судалгаанд оролцогчдын хувьд төр засгаас ямар үйлчилгээг үзүүлэх шаардлагатай эсэхийг тодруулахад 50 хувь нь гэр бүлийн хөгжлийн төв, 40 хувь нь гэр бүлд зөвлөгөө өгөх төв, 31 хувь нь залуучуудын чөлөөт цагаа өнгөрөөх төвийг байгуулах нь хамгийн хэрэгцээтэй байгааг дурджээ.

Гэр бүлийн хөгжлийн төв нь гэр бүл, хосуудад чиглэсэн эрхзүйн мэдлэг түгээх, олгох, үйлчилгээ үзүүлдэг байх, гэр бүлийн боловсрол олгоход чиглэсэн сургалтууд, мэдээллийг түгээх чиглэлээр ажиллах юм. Харин гэр бүлд зөвлөгөө өгөх төв нь илүү гэр бүлийн гишүүдэд чиглэсэн сэтгэлзүйн зөвлөгөө, үйлчилгээ, сургалтыг ороход анхаарна.

Хэрэгцээт үйлчилгээнүүдийг байршлаар шүүн харвал нийслэл хотод залуучуудын чөлөөт цаг өнгөрөөх төв, гэр бүлийн хөгжлийн төв, эрүүл мэндийн цогц үйлчилгээ, ногоон байгууламж зэрэг нь орон нутгаас илүү шаардлагатай байна.

#### Хүснэгт 4.11. Хэрэгжүүлэхийг хүсэж буй үйлчилгээ, байршил, хувиар

| Төрөөс хэрэгжүүлэхийг хүсэж буй үйлчилгээ          | Байршил |       |
|----------------------------------------------------|---------|-------|
|                                                    | Хот     | Хөдөө |
| Залуучуудын чөлөөт цаг өнгөрөөх төв                | 18.8    | 17.9  |
| Гэр бүлд зөвлөгөө өгөх төв                         | 21.5    | 25.3  |
| Гэр бүлийн хөгжлийн төв                            | 29.8    | 29.5  |
| Эрүүл мэндийн цогц үйлчилгээ                       | 12.4    | 12.2  |
| Мэргэжил, боловсрол олгох богино хугацааны сургалт | 6.2     | 8.6   |
| Гэр бүлээрээ чөлөөт цагаа өнгөрөөх төв             | 5.0     | 3.7   |
| Хүүхэд хөгжлийн төв                                | 2.2     | 1.6   |
| Ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн              | 3.7     | 0.4   |
| Хүүхэд хамгаалах байр                              | 0.3     | 0.4   |
| Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан төв         | 0.1     | 0.4   |

Наснаас шалтгаалан хэрэгцээт үйлчилгээ нь ялгаатай эсэхийг харвал 50 ба түүнээс дээш насны иргэд нь мэргэжил боловсрол олгох богино хугацааны сургалтыг залуучуудаас илүү сонирхож байгаа бол 18-49 насны иргэд нь гэр бүлд зөвлөгөө өгөх төв, гэр бүлийн хөгжлийн төв, эрүүл мэндийн цогц үйлчилгээ зэргийг авахыг хүссэн байна.



Хүснэгт 4.12. Хэрэгжүүлэхийг хүсэж буй үйлчилгээ, насны бүлэг, хувиар

| Төрөөс хэрэгжүүлэхийг хүсэж буй үйлчилгээ          | Насны бүлэг |       |      |
|----------------------------------------------------|-------------|-------|------|
|                                                    | 18-34       | 35-49 | 50+  |
| Залуучуудын чөлөөт цаг өнгөрөөх төв                | 18.1        | 17.3  | 19.8 |
| Гэр бүлд зөвлөгөө өгөх төв                         | 24.3        | 23.2  | 22.9 |
| Гэр бүлийн хөгжлийн төв                            | 29.8        | 30.0  | 28.8 |
| Эрүүл мэндийн цогц үйлчилгээ                       | 13.5        | 12.5  | 10   |
| Мэргэжил, боловсрол олгох богино хугацааны сургалт | 4.4         | 7.5   | 13   |
| Гэр бүлээрээ чөлөөт цагаа өнгөрөөх төв             | 4.7         | 4.7   | 3    |
| Хүүхэд хөгжлийн төв                                | 1.9         | 2.0   | 1.6  |
| Ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн              | 2.6         | 2.3   | 0.7  |
| Хүүхэд хамгаалах байр                              | 0.6         | 0.1   | 0.1  |
| Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан төв         | 0.1         | 0.4   | 0.1  |

Мөн өрхийн төрлөөс хамааран хэрэгцээт үйлчилгээ ихээхэн ялгаатай байна. Тухайлбал, залуучуудын чөлөөт цагаа өнгөрөөх төв нь ганц бие иргэдэд илүү шаардлагатай байгаа бол дан гэр бүлүүдэд гэр бүлд зөвлөгөө өгөх төв хэрэгцээтэй байгаа юм. Харин нийлмэл өрхүүдэд гэр бүлийн хөгжлийн төв, өрөөсгөл өрхүүдэд эрүүл мэндийн цогц үйлчилгээ, мэргэжил боловсрол олгох богино хугацааны сургалт шаардлагатай хэмээжээ.

Хүснэгт 4.13. Хэрэгжүүлэхийг хүсэж буй үйлчилгээ, гэр бүлийн хэлбэр, хувиар

| Төрөөс хэрэгжүүлэхийг хүсэж буй үйлчилгээ          | Ганц бие | Дан  | Нийлмэл | Өрөөсгөл |
|----------------------------------------------------|----------|------|---------|----------|
| Залуучуудын чөлөөт цаг өнгөрөөх төв                | 62.9     | 3.4  | 4.2     | 4.7      |
| Гэр бүлд зөвлөгөө өгөх төв                         | 9.7      | 67.7 | 6.7     | 7.2      |
| Гэр бүлийн хөгжлийн төв                            | 17.0     | 13.0 | 73.7    | 13.8     |
| Эрүүл мэндийн цогц үйлчилгээ                       | 3.5      | 6.2  | 5.8     | 34.6     |
| Мэргэжил, боловсрол олгох богино хугацааны сургалт | 0.7      | 0.3  | 0.4     | 30.0     |
| Гэр бүлээрээ чөлөөт цагаа өнгөрөөх төв             | 3.0      | 5.3  | 4.3     | 4.4      |
| Хүүхэд хөгжлийн төв                                | 1.1      | 1.2  | 2.1     | 3.0      |
| Ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн              | 1.6      | 2.6  | 2.3     | 1.6      |
| Хүүхэд хамгаалах байр                              | 0.3      | 0.2  | 0.2     | 0.6      |
| Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан төв         | 0.2      | 0.1  | 0.3     | 0.1      |



## БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Энэхүү бүлгийн хүрээнд гэр бүлд тулгамдаж буй асуудалд гэр бүл дэх зөрчил маргаан, гэр бүл цуцлалт, түүний шалтгаан үр дагавар, гэр бүлээс гадуурх харилцаа, гэр бүлийн амьдралд нөлөөлж буй нийгмийн хүчин зүйлсийг авч судлав.

Гэр бүлд үүсэж буй зөрчил маргаан нь голчлон үзэл бодлын зөрчил, согтууруулах ундааны хэрэглээ, харилцан ойлголцдоггүйгээс, болон мөнгө санхүүгээс болж үүсэж байна. Энэ нь байршлаас шалтгаалан ялгаатай байгаа ба нийслэл хотын хувьд үл ойлголцол, мөнгө санхүү нь голлох шалтгаан бол хөдөө орон нутагт архидалт, харилцан ойлголцдоггүй зэрэг нь өндөр хувьтай байгаа юм. Мөн ФБЯ-н оролцогчид хардалт болон хүүхдийн хүмүүжлийн асуудлыг онцолж байсан бөгөөд эхнэр нөхрүүд нэгнээ хардах, итгэлцэл эвдрэх, хүүхдийн дэлгэцийн хамаарал зэрэг нь тулгамдсан асуудлууд болж байна.

Гэр бүл дэх зөрчил маргаан нь голчлон эхнэр нөхөр хооронд болон хадмууд хүргэн бэрийн хооронд, эцэх эх хүүхэд хооронд хамгийн их тохиолдож байна. Эдгээр зөрчилдөөн нь олон янзаар илэрч байгаагаас архидаж агсам тавих, хардах, маргалдах, нэгэндээ хүндэтгэлгүй хандах зэрэг асуудлууд нь хамгийн өндөр хувийг эзэлжээ. ФБЯ-н үр дүнгээр эдгээр гэр бүлийн асуудалд бусдыг оролцуулах нь асуудлыг улам дордуулдаг гэж харж байсан бол зарим хэсэг нь гэр бүлийн маргаан хурцадмал байдалд хүрвэл нийгмээс оролцох шаардлагатай гэж үзжээ.

Оролцогчдын үзэж буйгаар Монгол гэр бүлүүдэд хамгийн их тулгамдаж буй бэрхшээлүүд нь санхүү мөнгө, байр орон сууц, ажлын ачаалал, ажилгүйдэл зэрэг байна. Байршлын хувьд хот суурин газарт байр орон сууцны асуудал, ажлын ачаалал, ажилгүйдэл байгаа бол хөдөө орон нутагт мөнгө санхүү, эрүүл мэндийн хүртээмжийн асуудлууд нь нэн тэргүүний тулгамдаж буй асуудлууд болж байна. ФБЯ-н үр дүнгээр залуучуудад байр, орон сууц, боловсрол мэргэжил, хүүхэд хүмүүжүүлэх гэх мэт нь хамгийн тулгамдаж буй асуудал байгааг дахин нотлон ярьж байв.

Гэр бүл цуцалсан иргэдийн хувьд 1-2 хүүхэдтэй байх үедээ гэрлэлтээ цуцалсан байна. Гэр бүл цуцалж буй голлох шалтгаануудад санхүүгийн бэрхшээл, хууран мэхлэлт, хардалт, муу зуршил зэрэг нь давамгайл нөлөөлжээ. Гэр бүл цуцлалтыг санаачилж буй хүн нь 2 хүн тутмын нэг нь эхнэрүүд байсан бөгөөд эмэгтэйчүүдийн цуцлах болсон шалтгаанд архидалт, гэр бүлээс гадуурх харилцаа зэрэг нь өндөр хувьтай байв. Харин эрэгтэйчүүдийн гэр бүл цуцлах санаачилгыг гаргахад нөлөөлж буй хүчин зүйлсэд гэр бүлээс гадуурх харилцаа, үзэл бодлыг зөрчил, хадмуудын оролцоо зэрэг өндөр хувийг эзэлж байна.



Гэр бүл цуцлалтын үр дүнд гарч буй эерэг өөрчлөлтүүдээс дурдвал сэтгэл санааны дарамгүй болсон, эрх чөлөөтэй болсон зэрэг нь хамгийн ихээр гарсан бол хариуцлагын ачаалал нэмэгдсэн, сэтгэл санааны дарамттай байдал үүссэн зэрэг нь хамгийн их тохиолдож буй сөрөг өөрчлөлтүүд юм. Эдгээр өөрчлөлтүүд нь хүйсийн хувьд харьцангуй ялгаатай илэрч байгаагаас эрэгтэй хүмүүст хувийн амьдралаа өөдөн татах боломжтой болсон, эерэг өөрчлөлт гараагүй гэх өөрчлөлтүүд давамгайл байгаа бол эмэгтэйчүүдэд сэтгэл санааны дарамтгүй болсон, эрх чөлөөтэй болсон зэрэг нь илүү өндөр хувьтай байгаа эерэг өөрчлөлтүүд байна. Харин сөрөг өөрчлөлт нь эрэгтэйчүүдэд хариуцлага нэмэгдсэн, ганцаардаж хүчин мөхөстөх байдлаар илэрч байгаа бол эмэгтэйчүүдэд ажил амьдралаа зохицуулахад бэрхшээл үүссэн, амьдрах итгэлгүй болсон зэрэг нь ихээр тохиолджээ.

Гэрлэлтээ цуцлуулсан эмэгтэйчүүдийн хувьд хоёр хүн тутмын нэг нь дахин гэрлэх бодолгүй байгаа бол эрэгтэйчүүдийн хувьд хоёр хүн тутмын нэг нь санаа нийлэх хүн гарч ирвэл дахин гэрлэх бодолтой байгаа аж.

Нийт оролцогчдын 73.2 хувь нь гэр бүлээс гадуурх харилцааг огт байж болохгүй зүйл, 11 гаруй хувь нь байж болох зүйл хэмээн харж байгаа бөгөөд залуучууд илүү эсэргүүцэх хандлагатай байхад нас ахих тусам гэр бүлээс гадуурх харилцааг хүлээн зөвшөөрөх хандлага бага зэргээр нэмэгдэж байгаа үзэгдэл ажиглагдаж байна. Гэр бүлээс гадуурх харилцаа үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлүүдэд анхаарал халамж дутах, үл ойлголцол, хол зай зэрэг нь хамгийн өндөр хувиар нөлөөлж байгаа гэж оролцогчид үзжээ. Харин гэр бүлээс гадуурх харилцаа үүсэхэд гуравдагч этгээдэд хариуцлага тооцох шаардлагатай эсэхийг тодруулахад оролцогчдын 63 гаруй хувь нь тооцох ёстой гэж үзсэн бөгөөд үүнд эмэгтэйчүүд илүү санал нийлж, санал нийлэхгүй байгаа хэсэгт эрэгтэйчүүд илүү өндөр буюу 21 хувьтай байна.

Нийгэмд тулгамдаж буй олон бэрхшээл асуудлаас гэр бүлүүдэд хамгийн тулгамдаж буй асуудалд ажилгүйдэл, үнийн өсөлт, архидалт зэрэг нь өндөр хувийг эзэлж байгаа бөгөөд хот суурин газарт нийгмийн бухимдал стресс, гадаад улсад тусдаа амьдрах зэрэг асуудлууд илүү байгаа бол хөдөө орон нутагт ажилгүйдэл, архидалт зэрэг нь давамгайлж байна.

Иргэдийн хувьд төрөөс хэрэгжүүлэхийг шаардаж буй бодлогуудаас авч үзвэл нийт оролцогчдын хувьд 5 хүн тутмын нэг нь ажиллах боломж, ажлын байр, нөхцөл сайжруулах, 7 хүн тутмын нэг нь эрүүл аюулгүй амьдрах орчин, амьдралын баталгаа, 6 хүн тутмын нэг нь боловсролын систем, хүүхдийн хөгжил боловсролд анхаарах зэргийг хүссэн байна. Дэлгэрүүлбэл, хотын оршин суугчдын хувьд эрүүл аюулгүй амьдрах орчин, амьдралын баталгаа, гэр бүлийн хуулийг сайжруулах, орон сууцны зээл дэмжлэг зэрэг, орон нутгийн оршин суугчдын хувьд ажлын байр, ажиллах боломжоор хангах зэрэг нь илүү олон хүний саналыг авчээ.



Мөн насны бүлгийн хувьд 50-с дээш насны иргэд нь ажлын байр, эдийн засаг эх орноо хөгжүүлэх, дэд бүтэц сайжруулах, цалин нэмэх зэрэгт илүү давамгайлсан санал өгсөн бол залуу болон дунд насны иргэд нь гэр бүлийн хуулийг сайжруулахыг илүү өндөр хувиар онцолжээ.

Харин төрөөс хэрэгжүүлэхийг хүсэж буй үйлчилгээнүүдэд гэр бүлийн зөвлөгөө өгөх төв, гэр бүлийн хөгжлийн төв, залуучуудын чөлөөт цагаа өнгөрөөх төвийг байгуулахыг илүү ихээр шаардаж байсан ба 50-с дээш насны иргэд нь мэргэжил боловсрол олгох богино хугацааны сургалтыг залуучуудаас илүү сонгосон байгаа бол 18-49 насны иргэд нь гэр бүлд зөвлөгөө өгөх төв, гэр бүлийн хөгжлийн төв, эрүүл мэндийн цогц үйлчилгээ зэргийг авахыг хүссэн байна.

## БҮЛГИЙН ЗӨВЛӨМЖ

### **Гэр бүлийн харилцаа, харилцан ойлголцлыг сайжруулах сургалт, хөтөлбөр хэрэгжүүлэх**

- Харилцааны ур чадвар, сэтгэл хөдлөлөө зөв илэрхийлэх, сонсох хүндэтгэх чадварыг хөгжүүлэх, маргааныг зөв зохистой шийдвэрлэх арга барил, гэр бүлийн үүрэг, хариуцлагын тэнцвэртэй хуваарилалт хийх чадварт сургах сургалт, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх.

### **Архидалттай тэмцэх, урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээ авах**

- Архины хэт хэрэглээний сөрөг нөлөөний талаарх олон нийтийн боловсролыг нэмэгдүүлэх;
- Архи согтууруулах ундааны хэрэглээтэй холбоотой гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэх механизмыг сайжруулах;
- Архины хамааралтай иргэдэд зориулсан эмчилгээ, зөвлөгөө, нөхөн сэргээлтийн төвүүдийг дэмжих.

### **Санхүүгийн боловсрол болон дэмжлэгийн хөтөлбөр хэрэгжүүлэх**

- Өрхийн төсвийн төлөвлөлт, хэмнэлтийн талаар сургалт явуулах;
- Залуу гэр бүлд чиглэсэн жижиг зээл, орон сууцтай болох дэмжлэг үзүүлэх (түрээсийн хөнгөлөлт, ипотекийн уян хатан нөхцөл), хөдөө орон нутагт тогтвортой орлоготой ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн хөгжлийн бодлого хэрэгжүүлэх.

### **Хүүхдийн дэлгэцийн хэрэглээ, донтолтод анхаарах**

- Эцэг эхчүүдэд хүүхдийн дэлгэцийн хэрэглээг зохицуулах мэдлэг, арга зүй олгох сургалт зохион байгуулах;
- Сургуулийн өмнөх болон сургуулийн насны хүүхдэд зориулсан дэлгэцийн хэрэглээний хэм хэмжээний талаар гарын авлага, хөтөлбөр боловсруулах;
- Дэлгэцийн хамааралтай хүүхдүүдэд сэтгэл зүйн болон зан үйлийн зөвлөгөө өгөх үйлчилгээг өргөжүүлэх.



**Гэр бүлээ цуцлуулсан эцэг, эхчүүдийн үүрэг хариуцлагыг сайжруулах**

- Хүүхдийн халамж, тэтгэмжийн тогтолцоог сайжруулах, гүйцэтгэлд хяналт тавих, мэдээллийн систем бий болгох;
- Салсан эцэг эх хүүхэдтэйгээ холбоотой байх нөхцөлийг хууль, бодлогоор дэмжих.

**Гэр бүл цуцлалтын талаарх судалгаа, мониторингийг тогтмолжуулах**

- Үр дагаврын мониторингийн тогтолцоог хөгжүүлэх, гэр бүл цуцлалтын дараах нийгмийн, сэтгэл зүйн, эдийн засгийн үр дагаврыг тогтмол судалж, бодлогод тусгах, бодлогын шийдвэрт суурь мэдээлэл ашиглах, аймаг, нийслэлийн түвшинд гэр бүл цуцлалттай холбоотой мэдээлэл, шалтгаан, үр дагаврын нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх.

**Гэр бүлийн харилцааг дэмжих, гэр бүлээс гадуурх харилцааг бууруулах бодлого**

- Гэр бүлийн маргаан, салалттай холбоотой хууль зүйн үйлчилгээ үзүүлэх төвүүдээр дамжуулан нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, хуульчийн зөвлөгөө үйлчилгээг өргөжүүлэх.

5

## ХИЛИЙН ЧАНАД ДАХЬ ГЭР БҮЛҮҮДИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ








## ТАВ. ХИЛИЙН ЧАНАД ДАХЬ ГЭР БҮЛҮҮДИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

### 5.1 Хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн шинж байдал

Хилийн чанад дахь Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, өөрчлөлтийг тодорхойлох судалгаанд монголчууд хамгийн ихээр оршин сууж буй АНУ, БНСУ, Казахстан, Япон, Чех зэрэг 5 улсын 303 иргэнийг хамруулсан. Тус судалгаанд хамрагдсан иргэдийн 45.5 хувь нь эрэгтэйчүүд, 54.5 хувь нь эмэгтэйчүүд байна. Судалгаанд оролцогчдыг насны бүлгээр авч үзвэл 18-35 насны залуучууд 47.9 хувь, 35-49 насны дунд насны оролцогчид 43.6 хувь, 50-с дээш насны ахмадууд 8.6 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 5.1. Судалгаанд оролцогчид, хүйс, насны бүлэг, хувиар



Судалгаанд оролцогчдын 38.7 хувь нь суралцах болон суурьших, 40.0 хувь нь гэрээгээр хөдөлмөр эрхлэх болон хувиараа ажиллах, 5.6 хувь нь цагаачлах зорилгоор гадаад улс руу явсан байна. Эрэгтэйчүүдийн 38.4 хувь нь гэрээгээр хөдөлмөр эрхлэх, эмэгтэйчүүдийн 38.2 хувь суралцахаар явсан байна.

Хүснэгт 5.1. Оролцогчдын гадаад улс руу явсан зорилго, хүйс, хувиар


| Гадаад улс руу явсан зорилго | Хүйс         |              | Нийт         |
|------------------------------|--------------|--------------|--------------|
|                              | Эрэгтэй      | Эмэгтэй      |              |
| Суралцах                     | 13.8         | 38.2         | 27.1         |
| Суурьших                     | 11.5         | 11.5         | 11.5         |
| Томилолт                     | 5.1          | 10.9         | 8.3          |
| Гэрээгээр хөдөлмөр эрхлэх    | 38.4         | 17.6         | 27.1         |
| Цагаачлах                    | 8.0          | 3.6          | 5.6          |
| Гэр бүлийн шалтгаанаар       | 5.1          | 7.9          | 6.6          |
| Хувиараа ажиллах             | 18.1         | 8.5          | 12.8         |
| Бусад                        | -            | 1.8          | 1.0          |
| <b>Нийт</b>                  | <b>100.0</b> | <b>100.0</b> | <b>100.0</b> |



Судалгаанд хамрагдсан иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг харахад 91.0 хувь нь хөдөлмөр эрхэлдэг ба үүнээс 74.2 хувь нь цалин хөлстэй ажиллагч, 7.9 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 6.0 хувь нь ажил олгогч байна. Цалин хөлстэй ажиллагчдын 73.7 хувь нь байнгын ажиллагч, 20.7 хувь нь цагаар ажиллагч байгаа бол ажил олгогчдын 75.0 хувь нь ажилтантай, 25.0 ажилтангүй ажил олгогчид байна.

Хөдөлмөр эрхлэлтийг хүйсээр авч үзэхэд цалин хөлстэй ажиллагчдын 49.3 хувь нь эрэгтэй, 50.7 хувь нь эмэгтэй байна. Хувиараа худалдаа эрхлэгчийн 42.9 хувь нь эрэгтэй, 57.1 хувь нь эмэгтэй байна худалдаа эрхлэгчид байна. Харин ажил олгогчдын 56.3 хувь нь эрэгтэй, 43.7 хувь нь эмэгтэй ажил олгогчид байна.

*Зураг 5.2. Судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлтийн байдал, хувиар*



Судалгаанд оролцогчдыг ажиллаж буй салбарын хувьд хүйс болон боловсролын түвшингээр нь харьцуулж харахад ажиллаж буй салбараас хамааран харилцан адилгүй байгаа ба эрэгтэйчүүд (17.1%) дийлэнхдээ боловсруулах үйлдвэрт, эмэгтэйчүүд зочид буудал, байр, орон сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт (17.5%) ажиллаж байна.

Хилийн чанадад ажиллаж буй хүмүүсийн хувьд боловсролын түвшнээс үл хамааран ажиллаж буй салбар нь ижил байгаа нь доорх хүснэгтээс ажиглагдаж байна. Тухайлбал, боловсруулах үйлдвэрт ажиллаж буй нийт хүмүүсийн 33.3 хувь нь бүрэн бус дунд болон түүнээс доош, 21.2 хувь нь бүрэн дунд, 17.6 хувь нь техник мэргэжлийн болон тусгай мэргэжлийн, 10.5 хувь нь дипломын болон түүнээс дээш боловсролтой байна.



Хүснэгт 5.2. Хөдөлмөр эрхлэлтийн байдал, үйл ажиллагааны салбар, хүйс, боловсролын түвшин, хувиар

| Үйл ажиллагааны салбар                                                                                     | Хүйс         |              | Боловсролын түвшин                |              |                                           |                             |
|------------------------------------------------------------------------------------------------------------|--------------|--------------|-----------------------------------|--------------|-------------------------------------------|-----------------------------|
|                                                                                                            | Эрэгтэй      | Эмэгтэй      | Бүрэн бус дунд болон түүнээс доош | Бүрэн дунд   | Техник мэргэжлийн болон тусгай мэргэжлийн | Дипломын болон түүнээс дээш |
| ХАА, ойн аж ахуй, загас ан/агнуур                                                                          | 9.4          | 0.8          | -                                 | 9.1          | 5.9                                       | 4.1                         |
| Уул уурхай, олборлолт                                                                                      | 4.3          | 0.8          | -                                 | 3.0          | 17.6                                      | 1.1                         |
| Боловсруулах үйлдвэр                                                                                       | 17.1         | 8.7          | 33.3                              | 21.2         | 17.6                                      | 10.5                        |
| Барилга                                                                                                    | 4.3          | -            | -                                 | -            | -                                         | 3.2                         |
| Цахилгаан, хий, уур, агааржуулалт                                                                          | 4.3          | 1.6          | -                                 | 3.0          | 11.8                                      | 2.1                         |
| Ус хангамж сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа | 1.7          | -            | -                                 | -            | -                                         | 1.1                         |
| Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээ                                          | 6.8          | 2.4          | -                                 | 6.2          | -                                         | 4.7                         |
| Тээвэр, агуулахын үйл ажиллагаа                                                                            | 8.5          | 4.0          | -                                 | 18.2         | -                                         | 4.7                         |
| Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ                                                    | 4.3          | 17.5         | 33.4                              | 12.1         | 11.8                                      | 10.5                        |
| Мэдээлэл, холбоо                                                                                           | 2.6          | 4.8          | -                                 | 3.0          | -                                         | 4.2                         |
| Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа                                                                   | 1.7          | 5.6          | -                                 | 3.0          | 5.9                                       | 3.7                         |
| Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа                                                                          | 1.7          | 0.7          | -                                 | 3.0          | -                                         | 1.1                         |
| Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа                                                    | 3.4          | 0.8          | -                                 | 3.0          | -                                         | 2.1                         |
| Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа                                                             | 1.7          | 0.8          | -                                 | -            | -                                         | 1.1                         |
| Боловсрол                                                                                                  | 2.6          | 9.5          | -                                 | 6.1          | -                                         | 6.8                         |
| Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа                                                       | 2.6          | 7.1          | -                                 | -            | 11.8                                      | 5.3                         |
| Урлаг, үзвэр, тоглоом наадам                                                                               | 0.9          | -            | -                                 | -            | -                                         | 0.5                         |
| Үйлчилгээний бусад үйл ажиллагаа                                                                           | 22.1         | 34.9         | 33.3                              | 9.1          | 17.6                                      | 33.2                        |
| <b>Нийт</b>                                                                                                | <b>100.0</b> | <b>100.0</b> | <b>100.0</b>                      | <b>100.0</b> | <b>100.0</b>                              | <b>100.0</b>                |

Судалгаанд оролцогчид өрхийн амьжиргаагаа үнэлэхдээ 39.6 хувь нь өдөр тутмын хэрэгцээгээ л хангадаг, 37.0 хувь нь өдөр тутмын хэрэгцээгээ хангадаг ч үнэтэй зүйл худалдан авахад заавал зээл авах шаардлага үүсдэг, 6.9 хувь нь үнэтэй зүйлийг ч худалдан авдаг гэж хариулжээ. Мөн хүссэн бүхнээ авч чаддаг гэж 9.9 хувь нь хариулсан байна. Харин нийт оролцогчдын 6.6 хувь нь өдөр тутмын хэрэгцээгээ хангаж чаддаггүй гэсэн байна.




Зураг 5.3. Оролцогчдын өрхийн амьжиргаагаа үнэлсэн байдал, хувиар



Нийт судалгаанд оролцогчдын 64.0 хувь нь орон сууцанд, 12.9 хувь нь бие даасан тохилог сууцанд, 13.6 хувь нь нийтийн байранд, 3.1 хувь нь хажуу өрөөнд, 4.4 хувь нь дотуур байранд амьдарч байна. Сууц өмчлөлийн хувьд бие даасан тохилог сууцанд амьдарч байгаа иргэдийн 65.8 хувь нь өөрийн, орон сууцанд амьдарч байгаа иргэдийн 67.5 хувь, нийтийн байранд амьдарч буй иргэдийн 95.0 хувь нь тус тус бусдын сууцанд түрээс төлж амьдардаг байна. Үүнээс харахад гадаадад амьдарч буй монгол иргэдийн дийлэнх нь бусдын сууцанд түрээс төлж амьдарч байна.


Зураг 5.4. Оролцогчдын сууцны төрөл, эзэмшлийн хэлбэр, хувиар



Судалгаанд хамрагдсан иргэдийн гэрлэлтийн байдлыг тодруулахад нийт оролцогчдын 65 хувь нь анхны болон дахин гэрлэсэн, 1.7 хувь нь гэрлээгүй хамтран амьдрагчид, 3.6 хувь нь бэлэвсэн болон цуцалсан, тусгаарласан, 29.7 хувь нь огт гэрлээгүй иргэд байна.



Зураг 5.5. Судалгаанд хамрагдсан иргэдийн гэрлэлтийн байдал, хүйс, хувиар



Анхны болон дахин гэрлэсэн иргэдийг гэрлэлтээ албан ёсоор батлуулсан эсэхийг тодруулахад анхны гэрлэсэн хосуудын 93.7 хувь нь гэрлэлтээ албан ёсоор батлуулсан бол дахин гэрлэсэн хосуудын 27.3 хувь гэрлэлтээ батлуулаагүй байна.


Зураг 5.6. Гэрлэлтээ албан ёсоор батлуулсан эсэх, хувиар



Гэрлэлтээ албан ёсоор батлуулаагүй оролцогчдын шалтгааныг тодруулахад 41.2 хувь нь бүртгүүлж амжаагүй, 5.9 хувь нь хамт амьдардаггүй буюу хол амьдардгаас, 11.8 хувь нь өмнөх гэрлэлтээ цуцлуулж чадаагүй байгаагаас шалтгаалсан байна. Харин ямар ч шалтгаангүйгээр гэрлэлтээ батлуулаагүй оролцогчид 41.2 хувийг эзэлжээ.



Зураг 5.7. Гэрлэлтээ албан ёсоор бүртгүүлээгүй байгаа шалтгаан, хувиар




## 5.2. Хилийн чанад дахь гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал

### 5.2.1. Гэр бүл дэх эрх мэдлийн хуваарилалт

Судалгаанд оролцогчдын 69.3 хувь нь буюу дийлэнх нь өрхийн тэргүүн эрэгтэйчүүд байх нь тохиромжтой гэж хариулсан бол 21.5 хувь нь өрхийн тэргүүн хэн ч байж болно гэсэн байна. Харин судалгаанд оролцогчдын 0.7 хувь нь өрхийн тэргүүн эмэгтэй хүн байвал тохиромжтой гэж үзжээ.

Зураг 5.8. Өрхийн тэргүүн хэн байвал зохимжтой эсэх, хүйс, хувиар



Эрэгтэйчүүдийн дунд нөхөр нь өрхийн тэргүүн байх ёстой гэж үзэгсэд эмэгтэйчүүдээс давамгайл байгаа бол гэр бүлийн хамгийн ахмад хүн болон гэр бүлийн орлогын дийлэнхийг бүрдүүлж буй гишүүн нь өрхийн тэргүүн байвал тохиромжтой гэсэн хариултыг эмэгтэйчүүд илүүтэй өгчээ.




Судалгаанд оролцогчид “Амьдралын нуруутай, ухаалаг, овсгоотой байдал”, “Гэр бүлдээ хайр халамжтай байдал”, “Хариуцлага хүлээх чадвартай байдал”-ыг өрхийн тэргүүний хамгийн чухал үүрэг гэж онцолсон байна. Эрэгтэй оролцогчид өрхийн орлогыг бүрдүүлдэг (27.5%), өрхийн мөнгө тооцоог барьдаг (26.1%), гэр орны орны ажлыг голлож зохицуулж хийдэг (18.8%) байх нь өрхийн тэргүүний гол үүрэг гэсэн бол эмэгтэйчүүдийн хувьд хайр, халамжтай (27.5%), гэр бүлд тулгамдаж буй бүхий л асуудлыг голлож шийддэг байх ёстой гэжээ.

Хүснэгт 5.3. Өрхийн тэргүүний хамгийн гол үүрэг, хүйс, давхардсан тоо, хувиар

| Өрхийн тэргүүний үүрэг                                                | Хүйс    |         | Хувь |
|-----------------------------------------------------------------------|---------|---------|------|
|                                                                       | Эрэгтэй | Эмэгтэй |      |
| Амьдралын нуруутай, ухаалаг, овсгоотой байх                           | 65.2    | 66.7    | 66.0 |
| Гэр бүлдээ хайр халамжтай, нэр хүндтэй байх                           | 58.0    | 64.8    | 61.7 |
| Гэр бүлийн гишүүдийн өмнө илүү өндөр хариуцлага хүлээх чадвартай байх | 46.4    | 47.9    | 47.2 |
| Өрхийн орлогын ихэнхийг нь олдог байх                                 | 27.5    | 25.5    | 26.4 |
| Өрхийн мөнгө, тооцоог барьдаг байх                                    | 26.1    | 18.8    | 22.1 |
| Мэдлэг боловсрол өндөртэй байх                                        | 21.7    | 22.4    | 22.1 |
| Гэр орны ажлыг зохицуулж голлож хийдэг байх                           | 18.8    | 10.3    | 14.2 |
| Бүхий л асуудлыг голлож шийддэг байх                                  | 10.1    | 12.7    | 11.6 |
| Бусад                                                                 | 2.2     | 1.8     | 2.0  |

Өнөөгийн залуус гэр бүлийн амьдралд бэлтгэгдэж чадсан эсэх талаар тодруулахад аль ч насны оролцогчид маш муу бэлтгэгдсэн гэж үзэж байна. Үүнд хамгийн өндөр буюу 37.2 хувийг 18-34 насны залуучууд эзэлж байгаа бөгөөд тэд өөрсдийгөө амьдралд хангалттай бэлтгэгдээгүй гэж үзжээ. Харин залуучуудыг гэр бүлийн амьдралд хангалттай сайн бэлтгэгдсэн гэсэн оролцогчдын 13.6 хувийг 35-49 насныхан эзэлж байна.


Зураг 5.9. Өнөөгийн залуус гэр бүлийн амьдралд бэлтгэгдсэн эсэх, насны бүлэг, хувиар





Гэр бүл зохиоход хамгийн тохиромжтой насыг тодруулахад 18-34 насны залуучууд эрэгтэй болон эмэгтэй хүмүүсийг 24-29 насандаа, 35-с дээш насны оролцогчид эрэгтэйчүүдийг 30-35, эмэгтэйчүүдийг 24-29 насандаа гэр бүл зохиоход илүү тохиромжтой гэж үзсэн байна.

Зураг 5.10. Гэр бүл зохиоход тохиромжтой нас, хүйс, насны бүлэг, хувиар



Судалгаанд оролцогчдын хувьд залуучуудыг “санхүүгийн боломжтой болсон үедээ”, “Сайн эцэг, эх болоход өөрийгөө бэлэн болж төлөвшсөн гэж үзэх үедээ”, “Нийгэмд эзлэх байр суурьтай болсон үедээ” гэрлэвэл илүү тогтвортой гэр бүл болно гэж үзжээ.

Зураг 5.11. Тогтвортой гэр бүл болохын үндэс, давхардсан тоо, хувиар



### 5.2.2. Гэр бүлийн үнэт зүйлс, ураг төрлийн харилцаа

Гэр бүлийн хамгийн эрхэмлэн дээдэлдэг зүйлсийг тодруулахад судалгаанд оролцогчдын 54.1 хувь буюу 2 хүн тутмын нэг нь гэр бүлийн халуун дулаан уур амьсгал гэж хариулсан бол 37 хувь нь эцэг эх, 34.3 хувь нь хайр сэтгэл, итгэлцэл болон үр хүүхэд гэсэн байна.





*Хүснэгт 5.4. Гэр бүлийн эрхэмлэн дээдэлдэг зүйлс, хүйс, давхардсан тоо, хувиар*

| Эрхэмлэн дээдэлдэг зүйлс             | Хүйс    |         | Нийт |
|--------------------------------------|---------|---------|------|
|                                      | Эрэгтэй | Эмэгтэй |      |
| Уламжлалт ёс заншил                  | 23.9    | 21.8    | 22.8 |
| Эцэг, эх                             | 44.2    | 30.9    | 37.0 |
| Эх орон                              | 39.9    | 28.5    | 33.7 |
| Гэр бүлийн халуун дулаан уур амьсгал | 51.4    | 56.4    | 54.1 |
| Хайр сэтгэл, итгэлцэл                | 29.0    | 38.8    | 34.3 |
| Үр хүүхэд                            | 31.2    | 37.0    | 34.3 |
| Хууль ёс                             | 7.2     | 3.0     | 5.0  |
| Үзэл бодол                           | 8.0     | 7.3     | 7.6  |
| Хүний эрх чөлөө                      | 11.6    | 17.0    | 14.5 |
| Ажил мэргэжил                        | 10.9    | 8.5     | 9.6  |
| Удам угсаа                           | 8.7     | 1.8     | 5.0  |
| Эрүүл мэнд                           | 24.6    | 34.5    | 30.0 |
| Төр засаг                            | -       | 1.2     | 0.7  |
| Мэдлэг боловсрол                     | 9.4     | 13.3    | 11.6 |

Эрэгтэйчүүдийн хувьд эцэг, эх (44.2%), эх орон (39.9%), хууль ёс (7.2%), удам угсаа (8.7%) нь хамгийн эрхэм зүйлс гэсэн бол эмэгтэйчүүдийн эрхэмлэл нь хайр сэтгэл (38.8%), үр хүүхэд (37.0%), эрүүл мэнд (34.5%), мэдлэг боловсрол (13.3%) гэжээ.

Судалгаанд оролцогчдын 33.3 хувь нь өөрийн гэр оронтой байх, 33.0 хувь нь амьдралын ая тухтай байдал, 26.4 хувь нь наад захын хэрэгцээний зүйлээр гачигдахгүй байх гэсэн материаллаг хэрэгцээ давамгайлж байхад 55.8 хувь нь бие биесээ ойлгож, хүндэтдэг байх гэж үзсэн нь хамгийн чухал сэтгэл санааны хэрэгцээ болж байгааг илэрхийлжээ.




**Хүснэгт 5.5. Гэр бүлд нэн хэрэгцээт зүйлс, давтамж, давхардсан тоо, хувиар**

|                                                 | Давтамж | Хувь |
|-------------------------------------------------|---------|------|
| <b>Материаллаг хэрэгцээ</b>                     |         |      |
| Наад захын хэрэгцээний зүйлээр гачигдахгүй байх | 80      | 26.4 |
| Өөрийн гэсэн гэр оронтой байх                   | 101     | 33.3 |
| Амьдралын ая тухтай байдал                      | 100     | 33.0 |
| Эд хөрөнгө мөнгөтэй байх                        | 12      | 4.0  |
| <b>Сэтгэл санааны хэрэгцээ</b>                  |         |      |
| Бие биесээ ойлгож, хүндэлдэг байх               | 169     | 55.8 |
| Бие биеэ хайрлах                                | 44      | 14.5 |
| Бие биедээ итгэдэг байх                         | 51      | 16.8 |
| Нэг санаа зорилготой байх                       | 37      | 12.5 |
| Итгэл, зүтгэл, санаа зорилгыг эрхэмлэх          | 8.7     | 1.8  |
| Амьдралын идэвх зүтгэлтэй байх                  | 88      | 29.0 |
| <b>Бэлгийн харилцаа</b>                         |         |      |
| Бэлгийн харилцаанд ханамжтай байх               | 34      | 11.2 |
| <b>Үр хүүхэд, гэр бүлийн бат бэх байдал</b>     |         |      |
| Үр хүүхэдтэй байх                               | 70      | 23.1 |
| Гэр бүлийн тогтвортой байдал                    | 76      | 25.1 |
| Элэг бүтэн хамтдаа байх                         | 46      | 15.2 |

Нийт судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 66.0 хувь өөрсдийн гэр бүлийг 3-4 хүүхэдтэй байхад хамгийн тохиромжтой гэж үзжээ. Харин эрэгтэйчүүдийн 15.2 хувь, эмэгтэйчүүдийн 6.7 хувь 5-аас дээш хүүхэдтэй байвал зохимжтой хэмээн үзсэнээс харихад эрчүүд олон хүүхэдтэй байхыг илүүд үзсэн байна.


**Зураг 5.12. Гэр бүл дэх хүүхдийн зохимжит тоо, хүйс, хувиар**





Судалгаанд оролцогчдын 64.0 хувь нь боловсрол, 52.5 хувь нь амьдралын ухаан, 51.8 хувь нь хүмүүжил, 42.6 хувь нь хайр, халамж, 36.6 хувь нь монгол өв соёлыг хүүхдэдээ өвлүүлэх нь нэн чухал гэж үзсэн байна.

Зураг 5.13. Хүүхдэд өвлүүлэх үнэт зүйлс, давхардсан тоо, хувиар



### 5.3. Гэр бүлийн зөрчил, цуцлалт

#### 5.3.1. Гэр бүлийн зөрчил, маргаан

Гэр бүлд нийтлэг тохиолддог зөрчил нь гэр бүлийн гишүүдийн харилцааны хүчин зүйлээс шалтгаалсан зөрчлүүд давамгайл байгаа ба 32.7 хувь нь харилцан ойлголцдоггүйгээс, 23.4 хувь нь хардалтаас, 20.5 хувь нь хайр халамж дутсанаас болдог. Мөн үзэл бодлын зөрчил болон мөнгө санхүүгийн хомсдол нь судалгаанд оролцогчдын гэр бүлийн амьдралд хамгийн их бэрхшээл учруулж байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байна.

Хүйсийн харьцаагаар харьцангуй ялгааг харвал эрэгтэй хүмүүсийн хувьд архидалт, хардалт, хайр халамж дутсанаас зөрчил хамгийн их үүсдэг гэсэн бол эмэгтэй хүмүүсийн хувьд үзэл бодлын зөрчлөөс, хүмүүжил өссөн орчны ялгаанаас болж зөрчил гарах нь илүү байна гэж үзжээ.




*Хүснэгт 5.6. Гэр бүлийн зөрчил, маргааны шалтгаан, хүйс, давхардсан тоо, хувиар*

| Зөрчлийн шалтгаан                          | Хүйс    |         | Нийт |
|--------------------------------------------|---------|---------|------|
|                                            | Эрэгтэй | Эмэгтэй |      |
| Нийгэм эдийн засгийн хүчин зүйл            |         |         |      |
| Мөнгө санхүүгийн хомсдолоос                | 21.7    | 22.4    | 22.1 |
| Архидалтаас                                | 21.7    | 12.7    | 16.4 |
| Тусдаа ажиллаж, амьдарч байгаагаас         | 5.1     | 6.1     | 5.6  |
| Соёлын ялгаанаас                           | 6.5     | 5.5     | 5.9  |
| Шашны ялгаанаас                            | 2.9     | 1.8     | 2.3  |
| Хосуудын хувийн хүчин зүйл                 |         |         |      |
| Боловсрол мэдлэгийн ялгаанаас              | 10.9    | 13.9    | 12.5 |
| Үзэл бодлын зөрчлөөс                       | 39.1    | 45.5    | 42.6 |
| Насны зөрүүтэй байдлаас                    | 5.8     | 6.7     | 6.3  |
| Хүмүүжил, өссөн орчны ялгаанаас            | 8.0     | 14.5    | 11.6 |
| Гэр бүлийн гишүүдийн харилцааны хүчин зүйл |         |         |      |
| Харилцан ойлголцдоггүйгээс                 | 34.1    | 31.5    | 32.7 |
| Хардалтаас                                 | 27.5    | 20.0    | 23.4 |
| Хайр, халамж дутсанаас                     | 25.4    | 16.4    | 20.5 |
| Итгэл эвдэж мэхэлснээс                     | 8.0     | 8.5     | 8.3  |
| Хүний эрх чөлөөг үгүйсгэх                  | 15.2    | 13.9    | 14.5 |
| Бэлгийн таарамжгүй харилцаанаас            | 2.9     | 2.4     | 2.6  |
| Дэлгэцийн хамаарлаас                       | 8.0     | 10.9    | 9.6  |
| Бусад хүмүүсээс хамаарах хүчин зүйлс       |         |         |      |
| Хүүхдийн асуудлаас                         | 13.0    | 13.9    | 13.5 |
| Эцэг, эх болон хадмуудын оролцооноос       | 7.2     | 8.5     | 7.9  |

Гэр бүлд үүсэж байгаа зөрчил, маргаан ихэвчлэн гэр бүлийн аль гишүүдийн хооронд үүсдэг талаар судалгаанд оролцогчоос тодруулахад эхнэр-нөхрийн хооронд (78.5%), хадам-хүргэн, бэрүүдийн (61.7%) хооронд зонхилж байна.



Зураг 5.14. Гэр бүлийн зөрчил маргаан үүсдэг гишүүд, давхардсан тоо, хувиар



Судалгаанд оролцогчдоос Монгол гэр бүлд түгээмэл тохиолддог асуудлын талаар тодруулахад 55.4 хувь нь нэгэндээ тоомсоргүй, хүндэтгэлгүй хандах, 46.5 хувь нь хардах, 38.6 хувь нь архидаж, агсам тавих, 36.6 хувь нь хэрэлдэх гэх мэт асуудлууд тэдний эргэн тойронд байгаа гэр бүлүүдэд нийтлэг ажиглагддаг гэсэн байна.

Эрэгтэйчүүдийн хувьд монгол гэр бүлүүдэд маргалдах (39.1%), түр хугацаагаар салах (23.2%), хүсээгүй бэлгийн харьцаа (13.8%) зэрэг асуудлууд нь түгээмэл тохиолддог гэж хариулсан бол эмэгтэйчүүд бие биеэ үл тоох буюу тоомсоргүй, хүндэтгэлгүй хандах (57.6%), хамт олон, найз нөхөдтэй нь уулзахыг хориглох (25.5%), архидаж агсам тавих (41.2%) тохиолдлууд түгээмэл ажиглагддаг гэжээ.

Хүснэгт 5.7. Монгол гэр бүлүүдэд түгээмэл тохиолддог асуудал, хүйс, давхардсан тоо, хувиар

| Түгээмэл тохиолддог асуудлууд              | Хүйс    |         | Нийт |
|--------------------------------------------|---------|---------|------|
|                                            | Эрэгтэй | Эмэгтэй |      |
| Маргалдах                                  | 39.1    | 32.1    | 35.3 |
| Хэн нэг нь тоомсоргүй, хүндэтгэлгүй хандах | 52.9    | 57.6    | 55.4 |
| Хэрэлдэх                                   | 35.5    | 37.6    | 36.6 |
| Хүчирхийлэх                                | 33.3    | 34.5    | 34.0 |
| Удаан хугацаагаар хөндий байх              | 28.3    | 26.7    | 27.4 |
| Түр хугацаагаар салах                      | 23.2    | 13.9    | 18.2 |
| Хардах                                     | 46.4    | 46.7    | 46.5 |
| Хүссэнээ худалдаж авч чадахгүй байх        | 24.6    | 20.0    | 22.1 |
| Хүсээгүй бэлгийн харилцаа                  | 13.8    | 6.7     | 9.9  |
| Айдас түгшүүртэй байх                      | 15.9    | 15.8    | 15.8 |
| Хамт олон найз, нөхөдтэй уулзахыг хориглох | 15.9    | 25.5    | 21.1 |
| Сургуульд сурахыг зөвшөөрөхгүй байх        | 8.7     | 4.2     | 6.3  |
| Ажил хийхийг зөвшөөрөхгүй байх             | 7.2     | 7.9     | 7.6  |
| Архидаж, агсам тавих                       | 35.5    | 41.2    | 38.6 |
| Мөрийтэй тоглох                            | 29.7    | 26.1    | 27.7 |
| Бусад                                      | 2.9     | 1.8     | 2.3  |



### 5.3.2. Гэр бүл цуцлалт

Гэр бүл цуцлахад санхүүгийн бэрхшээл, гэр бүлийн хүчирхийлэл, хууран мэхлэлт, хардалтын асуудал хамгийн их нөлөөлдөг гэж үзжээ. Мөн хадмуудын оролцоо болон муу зуршил буюу архи, тамхи, мөрийтэй тоглоомын асуудал нь гэр бүл цуцлалтад багагүй нөлөөтэй байгаа харагдаж байна.

*Зураг 5.15. Гэр бүл цуцлалтад нөлөөлдөг хүчин зүйлс, давхардсан тоо, хувиар*




### 5.3.3. Гэр бүлээс гадуурх харилцаа, нөлөөлдөг хүчин зүйлс

Судалгаанд оролцогчдын танилын хүрээнд гэр бүлээс гадуурх харилцаатай хүн байгаа эсэх талаар тодруулахад 3 хүн тутмын 1 нь тийм гэж хариулжээ.

Гэр бүлээс гадуурх харилцаа нь байж болох л зүйл гэж судалгаанд оролцогчдын 14.5 хувь нь хариулсан бол 52.1 нь огт байж болохгүй зүйл гэжээ. Байж болох зүйл гэж хариулсан иргэдийн 63.6 хувь нь эрэгтэй, байж болохгүй зүйл гэж хариулсан иргэдийн 57.6 хувь нь эмэгтэй байна.




Зураг 5.16. Танилын хүрээнд гэр бүлээс гадуурх харилцаатай хүн байгаа эсэх, мөн гэр бүлээс гадуурх харилцаа байж болох эсэх, хүйс хувиар



Гэр бүлээс гадуурх харилцаа үүсэхэд анхаарал, халамж дутах, бэлгийн харилцааны таарамжгүй байдал, үл ойлголцол зэрэг нь хамгийн ихээр нөлөөлдөг гэж үзжээ.


Зураг 5.17. Гэр бүлээс гадуурх харилцаа үүсэхэд нөлөөлдөг хүчин зүйлс, давхардсан тоо, хувиар



Гэр бүлээс гадуурх харилцаанд гуравдагч этгээдэд хариуцлага тооцох нь зөв эсэх талаар судалгаанд оролцогчдоос тодруулахад 38.9 хувь нь зөв, 46.2 хувь нь энэ талаар сайн мэдэхгүй гэсэн байна.



Зураг 5.18. Гэр бүлээс гадуурх харилцаанд гуравдагч этгээдэд хариуцлага тооцох нь зөв эсэх, хувиар




## 5.4. Шилжин суурьшилт, ирээдүйн төлөвлөгөө

### 5.4.1. Ирээдүйн төлөвлөгөө

Судалгаанд оролцсон иргэдийн 50.8 хувь нь эх орон руугаа буцах төлөвлөгөөтэй байгаа бол 20.1 хувь нь буцахгүй, 29.0 хувь нь буцах эсэхээ мэдэхгүй гэсэн байна.

Буцах төлөвлөгөөтэй байгаа оролцогчдын хувьд шийдвэрт нь юу нөлөөлсөн эсэхийг тодруулахад 39.6 хувь нь төрсөн нутагтаа суурьших, 26.0 хувь нь зорилгоо биелүүлж чадсан, 12.3 хувь нь визний зөвшөөрлөөс болж буцахаар төлөвлөсөн байна.

Зураг 5.19. Эх орон руугаа буцах шийдвэрт нөлөөлсөн хүчин зүйлс, хувиар








Нөгөөтээгүүр, буцахгүй байх гол шалтгааныг нь тодруулахад эх орондоо амьдрах баталгаагүйгээс, хүүхдүүдийнхээ ирээдүйг бодож байгаагаас, амьдралын нөхцөл нь амьдарч буй улсдаа илүү таатай байгаагаас шалтгаалж байна гэжээ.

Зураг 5.20. Эх орон руугаа буцахгүй байх шалтгаан, хувиар



Эх оронд нь юу өөрчлөгдвөл буцах талаар дахин бодох эсэхийг тодруулахад бүх насны оролцогчдын хувьд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээ сайжруулбал буцах талаар дахин бодно гэсэн бол 18-49 насны залуучуудын хувьд цалин хөлсийг нь амьдралд хүрэлцэхүйц болгох, бизнес эрхлэх боломжийг бүрдүүлбэл энэ талаар дахин бодох шийдвэрт нөлөөлнө гэсэн байна.

Зураг 5.21. Монгол буцах талаар дахин бодоход нөлөөлөх хүчин зүйлс, нас, хувиар





## БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Хилийн чанад ажиллаж амьдарч буй Монгол иргэдийн хувьд Монголчууд хамгийн ихээр оршин сууж байгаа БНСУ, Казакстан, БНЧУ, Япон, АНУ зэрэг 5 улсаас 303 иргэдийг хамруулсан болно. Судалгаанд хамрагсдын хувьд 18-49 настай иргэд дийлэнх хувийг эзэлж байна. 64.0 хувь нь орон сууцанд, 12.9 хувь нь бие даасан тохилог сууцанд, 13.6 хувь нь нийтийн байранд амьдрах байдал зонхилж байна. Харин сууц өмчлөлийн хувьд бие даасан тохилог сууцанд амьдарч байгаа иргэдийн 65.8 хувь нь өөрийн, орон сууцанд амьдарч байгаа иргэдийн 67.5 хувь, нийтийн байранд амьдарч буй иргэдийн 95.0 хувь нь тус тус бусдын сууцанд түрээс төлж амьдардаг байна. Үүнээс харахад гадаадад амьдарч буй монгол иргэдийн дийлэнх нь бусдын сууцанд түрээс төлж амьдарч байна.

Түүнчлэн, тэдний гадаад улс руу явах болсон шалтгааныг тодруулахад 38.7 хувь нь суралцах, суурьших, 40.0 хувь гэрээгээр хөдөлмөр эрхлэх болон хувиараа ажиллах, 5.6 хувь нь цагаачлах зорилгоор явжээ. Тухайлбал, тэдний ажиллаж буй салбарын хувьд эрэгтэйчүүдийн 17.1 хувь боловсруулах үйлдвэрт, эмэгтэйчүүдийн 17.5 хувь зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт ажиллаж байна.

Гэр бүл зохиоход хамгийн тохиромжтой насыг 18-34 насны залуучуудын бодлоор эрэгтэй болон эмэгтэй хүмүүс 24-29 насандаа, 35-49 дунд насныхан 50-аас дээш насныхан эрэгтэйчүүдийг 30-35 насандаа, эмэгтэйчүүдийг 24-29 насандаа гэр бүл зохиоход илүү тохиромжтой гэж үзсэн байна. Түүнчлэн, тогтвортой гэр бүл болохын үндсийг залуучуудыг “санхүүгийн боломжтой болсон үедээ”, “Сайн эцэг, эх болоход өөрийгөө бэлэн болж төлөвшсөн гэж үзэх үедээ”, “Нийгэмд эзлэх байр суурьтай болсон үедээ” гэрлэвэл илүү тогтвортой гэр бүл болно гэж үзжээ. хариуцлагуудыг түлхүү үүрч байна.

Судалгаанд оролцогчдын 33.3 хувь нь өөрийн гэр оронтой байх, 33.0 хувь нь амьдралын ая тухтай байдал, 26.4 хувь нь наад захын хэрэгцээний зүйлээр гачигдахгүй байх гэсэн материаллаг хэрэгцээ давамгайлж байхад 55.8 хувь нь бие биесээ ойлгож, хүндэтгэдэг байх гэж үзсэн нь хамгийн чухал сэтгэл санааны хэрэгцээ болж байгааг илэрхийлжээ.

Нийт судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 66.0 хувь өөрсдийн гэр бүлийг 3-4 хүүхэдтэй байхад хамгийн тохиромжтой гэж үзжээ. Харин эрэгтэйчүүдийн 15.2 хувь, эмэгтэйчүүдийн 6.7 хувь 5-аас дээш хүүхэдтэй байвал зохимжтой хэмээн үзсэнээс харилах эрчүүд олон хүүхэдтэй байхыг илүүд үзсэн байна.



Өнөөгийн залуучуудын амьдралд бэлэн эсэх талаар тодруулахад 18-34 насны залуучуудын 37.2 хувь нь өөрсдийгөө амьдралд бэлтгэгдээгүй гэж үзэж байна.

Судалгаанд хамрагсдын 20.1 хувь нь эх орондоо буцах төлөвлөөгүй, 29.9 хувь буцах эсэхээ тодорхой мэдэхгүй байгаа бол үлдсэн 50.8 хувь Монгол Улс руу буцах төлөвлөөгөөтэй байна. Хэдийгээр анх гадаад орон руу явсан зорилгоо хэдийн биелүүлсэн ч эх орондоо буцаж ирэх төлөвлөгөөгүй байгаа иргэд байгаа нь цалин өндөр, амьдрах таатай орчин нөлөөлж байна. Нөгөөтээгүүр, Монгол Улс руу буцахгүй байх гол шалтгааныг тодруулахад эх орондоо амьдрах баталгаагүйгээс, хүүхдүүдийнхээ ирээдүйг бодож, амьдралын нөхцөл амьдарч буй улсдаа илүү таатай байгаагаас шалтгаалж байна гэжээ.

Түүнчлэн, Монгол Улсад юу өөрчлөгдвөл буцах талаар дахин эргэцүүлэхийг тодруулахад бүх насныхан хувьд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээ сайжруулбал буцах талаар дахин бодно гэсэн бол 18-49 насны залуучуудын хувьд цалин хөлсийг нь амьдралд хүрэлцэхүйц болгох, бизнес эрхлэх боломжийг бүрдүүлбэл энэ талаар дахин бодож үзэх шийдвэрт нөлөөлнө гэжээ.

## БҮЛГИЙН ЗӨВЛӨМЖ

Хилийн чанадад амьдарч буй Монголчуудын хувьд эх орондоо суурьшин амьдрах хүсэлтэй байгаа бөгөөд тэдний Монголдоо буцаж ирэх нөхцөл боломжийг хангахад анхаарах нь хамгийн чухал байна. Үүнд:

### **Гэр бүлийн харилцаа, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих бодлого хэрэгжүүлэх**

- Элчин сайдын яам, консулын хэлтсүүдийн шугамаар гэр бүлийн эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл түгээх тогтолцоо бий болгох;
- Гадаадад амьдарч буй гэр бүл, хосуудад зориулсан гэр бүлийн боловсрол, зөвлөгөө, гэр бүлийн амьдралд бэлтгэхэд чиглэсэн сэтгэл зүй, харилцааны боловсрол, ёс суртахууны сургалтын хөтөлбөр боловсруулж цахим болон танхимын хэлбэрээр олгох.

### **Ажил эрхлэлтийн чанар, боловсролын уялдаа холбоог нэмэгдүүлэх**

- Гадаад орнуудад ажиллаж буй иргэдийн боловсрол, ур чадварт нийцсэн ажлын байрны мэдээлэл түгээх, мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ хэрэгжүүлэх;
- Гадаадад хөдөлмөр эрхэлж буй иргэдэд зориулсан мэргэшлийг дээшлүүлэх сургалт, хэлний сургалт, онлайн сургалтын хөтөлбөрүүдийг дэмжих;



- Тухайн орон дахь ажиллах эрх, хөдөлмөрийн эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх зөвлөмж, гарын авлага гаргах.

### **Гадаадад амьдарч буй монгол гэр бүлийн амьдралын нөхцөл байдлыг сайжруулах**

- Гадаадад ажиллаж, амьдарч буй иргэдэд зориулсан санхүүгийн зөвлөх үйлчилгээ, хуримтлалын сургалт, хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Буцах иргэдэд зориулсан бизнес эхлүүлэх, нийгмийн даатгалын урамшуулалтай бодлого боловсруулж хэрэгжүүлэх.

### **Гэр бүлийн үнэт зүйл, уламжлалын талаарх мэдлэгийг сайжруулах**

- Ургийн бичиг, ураг төрлийн боловсролын цахим хөтөлбөр боловсруулах;
- Хэл соёл, өв уламжлалыг хүүхдэдээ өвлүүлэхэд эцэг эхэд зориулсан зөвлөмж, сургалт, гарын авлага бий болгох.

### **Ирээдүйн төлөвлөгөө, Монгол руу буцах хандлагыг дэмжих**

- Эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах бодлого нь хилийн чанадад амьдарч буй монгол иргэдийг эх орондоо буцах урам зоригтой болгох;
- Иргэдийн шилжин суурьшихад чиглэсэн мэдээллийн нэгдсэн платформ, дэмжих багц хөтөлбөр (татвар, бизнес, даатгал, сууцны бодлого) хэрэгтэй.



## НЭГДСЭН ДҮГНЭЛТ

“Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, өөрчлөлт” сэдэвт судалгааны үр дүнгээс үзэхэд, Монгол Улсын гэр бүлийн бүтэц, үүрэг, харилцааны хэв маяг нь нийгэм, эдийн засаг, соёлын шилжилт, хүн амын дотоод ба гадаад хөдөлгөөн, мэдээллийн технологийн хурдтай хөгжлийн нөлөөгөөр эрчимтэй өөрчлөгдөж байна.

### **1. Санхүүгийн тогтворгүй байдал - Орлогын хязгаарлагдмал байдал, өр зээлийн ачаалал, байр орон сууцны асуудал**

- Гэр бүлүүдэд санхүүгийн тогтворгүй байдал элбэг тохиолдож байна. Тухайлбал, өрхийн орлого голчлон цалин болон тэтгэвэр тэтгэмжийн эх үүсвэрээс бүрдэж байгаа нь эдийн засгийн эмзэг байдлыг бий болгож, орлогын зарцуулалт нь зөвхөн хүнс, хүүхэд, өр зээл, хувцас хэрэглэлд зарцуулагдаж, өдөр тутмын хэрэгцээгээ л хангаж байна;
- Судалгаанд хамрагсдын 70 гаруй хувь нь ямар нэгэн байдлаар зээл төлдөг бөгөөд амьдралаа сайжруулахын тулд нэмэлт орлоготой болох, орон сууц худалдан авах, өр зээлээ дарах зэрэг төлөвлөлт нь байршил, нас, хүйс, гэр бүлийн хэлбэр үл харгалзан өндөр хувьтай байна;
- Судалгаанд хамрагдсан гэр бүлийн 68.0 хувь нь хашаа байшинд амьдарч байгаа бөгөөд бусдын сууцанд түрээстэй амьдарч буй оролцогчдыг насны бүлгээр харахад 18-34 насныхан хамгийн өндөр буюу 12.5 хувьтай байна.

### **2. Гэр бүлийн харилцааны ур чадвар, харилцан ойлголцол**

- Өрхийн орлого их байх болон хосууд хоорондоо ярилцаж чаддаг байх нь эхнэр, нөхрийн сэтгэл ханамжид шууд нөлөөлж байна. Мөн судалгааны үр дүнгээс харахад эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү гэр бүлийн харилцаанд сэтгэл ханамж өндөр байна;
- Дийлэнх оролцогчид ойрын гурван жилд хүүхэдтэй болох төлөвлөгөөгүй байгаа ч жирэмснээс хамгаалах арга хэрэгсэл ашиглахгүй байгаа нь иргэдийн дундах гэр бүл төлөвлөлт, бэлгийн боловсролын мэдлэг хангалтгүй байгааг илтгэж байна;
- Нийт оролцогчдын тал гаруй хувь нь гэр бүлийн үүрэг хариуцлагыг тэнцүү хуваарилан хийдэг ч үлдсэн хувь нь гэр бүлийн үүрэг хариуцлагыг тэгш бусаар хуваарилж байна. Үүнд, эрэгтэйчүүд илүүтэйгээр гэр бүлээ тэжээн тэтгэх хариуцлагыг үүрдэг бол эмэгтэйчүүд ар гэрийн ажил, хүүхэдтэй холбоотой хариуцлагуудыг түлхүү үүрч байна.



### **3. Хүүхдийн хүмүүжил болон дэлгэцийн хэрэглээ**

- Эцэг эхчүүд хүүхдээ эрүүл саруул, сайн хүн болгох, боловсрол мэргэжилд нь анхаарахыг чухалчилж үзсэн бөгөөд ээжүүд хүүхдэдээ илүү их анхаарал хандуулж, цаг зав гаргадаг байна;
- Хүүхдийн дэлгэцийн хэрэглээ нь улам нас залуужиж байгаатай холбогдуулан эцэг эхийн хяналт, зөв хүмүүжлийн аргад анхаарах шаардлагатай байна;
- Хүүхдийн хүмүүжил, төлөвшил, хүүхдэд цаг гаргах, гарын ажил зэрэгт аавууд оролцоо хангалтгүй байна.

### **4. Гэр бүлийн зөрчил маргаан, цуцлалтын шалтгаан**

- Гэр бүлийн зөрчил маргаан нь эхнэр-нөхрийн хооронд (82.0 хувь), хадмууд-хүргэн, бэрийн хооронд (32.2 хувь), эцэг, эх-хүүхдийн хооронд (29.6 хувь), хойд эцэг, эх-хүүхдийн хооронд (20.8 хувь) үүсэж байна;
- Гэр бүл цуцлалтын гол шалтгаанууд нь санхүүгийн дарамт, хардалт, гэр бүлээс гадуурх харилцаа, архи, согтууруулах ундаанаас үүдэлтэй байна;
- Эмэгтэйчүүд (52.4 хувь) илүүтэйгээр гэр бүл цуцлалтыг санаачилдаг байна;
- Судалгаанд оролцогчдын дунд гэрлэлт болон эд хөрөнгийн гэрээ хийх талаарх мэдлэг, мэдээлэл тун хомс байна;
- Гэр бүлийн харилцаанд эхнэр нөхрүүдийн үзэл бодлын зөрчил, харилцааны доголдол, гэр бүл дэх үүрэг хариуцлагын тэгш бус хуваарилалт, хардалтаас үүдэлтэй зөрчил маргаан давамгайлж байна.

### **5. Гэр бүлд тулгамдаж буй асуудлууд**

- Гэр бүлд хамгийн их тулгамдаж буй асуудлуудыг хот болон хөдөөгөөр харахад, хотод байр орон сууцны асуудал, ажлын ачааллын асуудлууд тулгамдаж байгаа бол хөдөөд санхүү мөнгө, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, ажил олдохгүй байх нь нэн тэргүүний асуудлууд болж байна. Тулгамдаж буй асуудлыг насны бүлгээр харахад, 18-34 насныхан хувьд байршил үл харгалзан байр орон сууц, санхүү мөнгөний асуудал тулгамдаж байна;
- Гэр бүлээс гадуурх харилцааг олон нийт сөргөөр үнэлдэг ч бодит амьдрал дээр ил болон далд хэлбэрээр түгээмэл оршсоор байна. Анхаарал, халамж дутмаг байх, харилцан ойлголцлын доголдол, хол зайд амьдрах зэрэг хүчин зүйлс нь ийм харилцаа үүсэх гол шалтгаануудын нэг болж байна;



- Архидалт нь гэр бүлийн харилцааг хямраах гол нөлөөлөгчдийн нэг бөгөөд түүнтэй холбоотойгоор хайр халамжгүй хүйтэн хөндий байдал, гэр бүлийн хүчирхийлэл, нэгэндээ тоомсоргүй хандах зэрэг асуудлууд урган гарч байна.
- Сүүлийн 15 жилд гэр бүлүүдэд тулгамдаж буй асуудалд тодорхой өөрчлөлтүүд гарсан. Үүнд санхүү мөнгөний асуудал, ажилгүйдэл, эрүүл мэндийн асуудлууд нь тус тус өнгөрсөн жилүүдээс буурсан эерэг үзүүлэлттэй байна. Үүнийгээ дагаад ажлын ачаалал, үзэл бодлын зөрчлүүд тодорхой хэмжээнд нэмэгдэж буй нь шинээр урган гарч буй асуудал болж байна. Мөн гэр бүлд тулгамдсан асуудал байхгүй хэмээн хариулж буй тохиолдол нь 22%-иар өссөн нь эерэг үзүүлэлт болж байна.

#### **6. Төрийн бодлого, үйлчилгээний хэрэгцээ**

- Гэр бүл рүү чиглэсэн төрийн бодлого, үйлчилгээний хэрэгцээ шаардлага өндөр байна. Тухайлбал, ажиллах боломж, ажлын байрны хүртээмжийг нэмэгдүүлэх хэрэгцээ нь аль ч орон нутагт хамгийн өндөр хувиар илэрч байгаа бол Улаанбаатар хотод амьдарч байгаа судалгаанд оролцогчдын хувьд эрүүл аюулгүй амьдрах орчин бүрдүүлэх, амьдралын баталгааг хангах, гэр бүлийн эрх зүйн орчныг сайжруулах, орон сууцны зээлийн уян хатан нөхцөлийг бүрдүүлэх хэрэгцээтэй байна.

### **НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ**

Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн нөхцөл байдал, тэдэнд тулгамдаж буй асуудлууд нь нийгэм, эдийн засаг, соёлын олон талын хүчин зүйлтэй нягт холбоотой бөгөөд урт хугацааны бодит, тогтвортой бодлого шаардсан асуудал болохыг судалгааны үр дүн харуулж байна. Иймд гэр бүлийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, харилцааны ур чадварыг дэмжих бодлого, үйлчилгээг дараах чиглэлээр хэрэгжүүлэхийг санал болгож байна.

#### **1. Эдийн засгийн баталгаат орчинг бэхжүүлэх бодлого**

- Гэр бүлийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор хөдөлмөр эрхлэлтийн нэмэгдүүлэх, ур чадварын сургалт, бичил болон жижиг бизнес эрхлэх уян хатан нөхцөл болон олон нийтэд түгээн дэлгэрүүлэх;
- Залуучууд болон залуу гэр бүлд зориулсан орон сууцны хүртээмж, санхүүжилтийн уян хатан нөхцөл (түрээсийн орон сууц, шатлалтай зээл, хөнгөлөлттэй зээл)-ыг өргөжүүлэх;
- Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх (зээлийн зохистой хэрэглээ, хуримтлал, орлого, зарлагын зарцуулалт гэх мэт);
- Хүүхэд өсгөх зардлын судалгааг нийгэм эдийн засгийн байдалтай уялдуулан тогтмол хийх.



## **2. Гэр бүлийн харилцааны ур чадварыг сайжруулах, сэтгэлзүйн дэмжлэгийг нэмэгдүүлэх**

- Гэр бүлд зориулсан зөвлөгөө өгөх, харилцааны ур чадварын сургалтыг (сэтгэлзүйн анхан шатны боловсрол, эерэг харилцааны арга, зөрчил шийдвэрлэх ур чадвар) тогтмол, хүртээмжтэй хэлбэрээр бий болгох;
- Аймаг дүүргүүд дэх Хүүхэд хөгжлийн газар, гэр бүлийн төвүүдэд мэргэжлийн сэтгэл зүй болон гэр бүлийн зөвлөгөөний хэсгийг бүрдүүлж, олон нийтэд сэтгэл зүй, гэр бүлийн зөвлөгөөний ач холбогдлыг таниулан сурталчлах, хүртээмжтэй болгох;
- Эхнэр нөхрийн хооронд үүрэг хариуцлагыг тэгш хуваарилах талаар олон нийтийн ойлголт нэмэгдүүлэх, нийгмийн компанит ажлыг үе шаттайгаар зохион байгуулах, зөв хандлагын төлөвшлийг дэмжих.

## **3. Хүүхдийн хүмүүжил, боловсролд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх**

- Хүүхдийн хөгжил, хүмүүжлийн талаар эцэг эхийн мэдлэгийг нэмэгдүүлэх сургалт, цахим хөтөлбөр, гарын авлага хөгжүүлэх;
- Хүүхдийн дэлгэцийн хэрэглээний стандартыг (насны ангилалд нийцсэн зөвлөмж, хяналт) олон нийтэд хүргэх, сургуулиуд болон эрүүл мэндийн байгууллагуудын оролцоог тодорхойлох;
- Аав нарын оролцоог дэмжих бодлого (ажлын байран дахь уян хатан нөхцөл, тэгш асаргааны чөлөө, олон нийтийн мэдээлэл) хэрэгжүүлэх.

## **4. Гэр бүл цуцлалтын шалтгааныг бууруулах, урьдчилан сэргийлэх бодлого**

- Архидалт, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт, үйлчилгээ, хор хөнөөлийн талаарх олон нийтийн мэдээлэл сурталчилгааг нэмэгдүүлэх;
- Гэр бүл цуцлалтай холбоотойгоор гэр бүлийн дундын өмчийн маргаан ихээхэн гардаг бөгөөд үүнээс сэргийлэх үүднээс гэрлэлт болон эд хөрөнгийн гэрээ хийх нь ач холбогдолыг олон нийтэд таниулах;
- Салалттай холбоотой хууль, үйлчилгээний системийг (зуучлал, эвлэрүүлэн зуучлах үйлчилгээ) сайжруулах замаар сөрөг үр дагаврыг бууруулах;
- Сэтгэлзүйн болон харилцааны хямралын үед ханддаг шуурхай үйлчилгээ, тусламжийн утсыг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх.





## **5. Гэр бүлд тулгамдаж буй асуудлууд**

- Архины хэрэглээг бууруулах төрийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх (татвар, худалдааны зохицуулалт);
- Хөдөө орон нутагт архидалттай холбоотой эрсдэл бууруулах хөтөлбөр (хөдөлмөр эрхлэлтийн дэмжлэг, нийгмийн үйлчилгээ, зөвлөгөө) өргөн хүрээтэй хэрэгжүүлэх.

## **6. Гэр бүлийн бодлогыг салбар хоорондын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх**

- Боловсрол, нийгмийн хамгаалал, хөдөлмөр, эрүүл мэнд, соёлын бодлого хоорондын уялдааг хангах замаар гэр бүлийг дэмжих бодлогын үр нөлөөг дээшлүүлэх, нягт хамтын ажиллагаатай ажиллах;
- Судалгаа, мэдээллийн нэгдсэн сан, тогтмол мониторинг, үнэлгээний тогтолцоог бий болгож, нотолгоонд суурилсан бодлогын шийдвэр гаргалтыг дэмжих.

## **7. Олон нийтийн соёл, үнэт зүйлийн өөрчлөлтийг дэмжих**

- Гэр бүлийн эерэг харилцаа, хүүхэд төвтэй хүмүүжил, тэгш хариуцлагын талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх мэдээллийн кампанит ажлуудыг тасралтгүй хэрэгжүүлэх;
- Уламжлалт үнэт зүйлсийг орчин үеийн харилцааны соёлтой уялдуулсан боловсролын агуулга, сургалт, контент хөгжүүлэх;
- Залуучуудад зориулсан гэр бүл төлөвлөлт, харилцааны боловсролыг сургууль, их сургууль, олон нийтийн төвүүдэд нэвтрүүлэх.



## ЭХ СУРВАЛЖ, АШИГЛАСАН МАТЕРИАЛУУД

- Гэр бүлийн тухай хууль. (1999 оны 6 сарын 11). Монгол Улс. <https://legalinfo.mn/mn/detail/226>
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. (2025). Төрөлтийн ерөнхий коэффициент, 2024 он. Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцох аргачлал – ҮСХ. 2025 оны 4 дүгээр сарын 11-ний байдлаар [https://www2.1212.mn/tables.aspx?TBL\\_ID=DT\\_NSO\\_0300\\_029V1](https://www2.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_0300_029V1)
- Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага. (1948). Хүний эрхийн түгээмэл тунхаглал: 16-р зүйл. Нэгдсэн Үндэстний Байгууллага. <https://www.un.org/en/about-us/universal-declaration-of-human-rights>
- Бүрэнжаргал, Т. (2005). Гэр бүлийн социологи. Улаанбаатар.
- Durkheim, É. (1893). The division of labor in society. New York, NY: Free Press.
- Durkheim, É. (1897). Suicide: A study in sociology. London, UK: Routledge.
- Engels, F. (2017). The origin of the family, private property and the state (Classic reprint). London, UK: Forgotten Books.
- Tönnies, F., & Loomis, C. P. (2002). Community and society. Mineola, NY: Dover Publications.
- Giddens, A. (1992). The transformation of intimacy: Sexuality, love and eroticism in modern societies. Cambridge, UK: Polity Press.
- Treas, J., Scott, J., & Richards, M. (2017). The Wiley Blackwell companion to the sociology of families. Hoboken, NJ: Wiley Blackwell.
- Ciabattari, T. (2021). Sociology of families. Thousand Oaks, CA: SAGE Publications.
- Cherlin, A. J. (2021). Public & private families: An introduction. New York, NY: McGraw-Hill.
- Мөнхбат, О., & Болд, Ц. (2001). Гэр бүлийн харилцааны зарим асуудалд. Социологи, (1), 56-75.
- Гүндсамбуу, Х. (2003). Айл гэрийн социологийн асуудлууд. Социологи, (3), 46.
- ФСЭЗХ. (2010). Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал. Улаанбаатар: Соёмбо.
- ХНХСИ. (2019). Монголын гэр бүлийн харилцааны хэв шинж, өөрчлөлт. Улаанбаатар.
- Үндэсний статистикийн хороо. (2024). Нэг өрхийн сарын дундаж орлого, бүсээр. [https://www.1212.mn/mn/statistic/statcate/48171310/table-view/DT\\_NSO\\_1900\\_020V1](https://www.1212.mn/mn/statistic/statcate/48171310/table-view/DT_NSO_1900_020V1)
- Eswaran, M. (2014). Why gender matters in economics. Princeton University Press.



- Komisar, E. (2017). Being there: Why prioritizing motherhood in the first three years matters.
- UNESCO. (2018). International technical guidance on sexuality education: An evidence-informed approach (Revised edition). Paris: UNESCO.
- Үндэсний статистикийн хороо. (2024). Гэрлэлт, цуцлалтын тоо. [https://www2.1212.mn/tables.aspx?TBL\\_ID=DT\\_NSO\\_0300\\_018V2](https://www2.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_0300_018V2)



